




ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ
2020 ОНЫ УЛСЫН ЭЭЛЖИТ ТООЛЛОГО

НИЙСЛЭЛИЙН НЭГДСЭН ДҮН



Улсын ээлжит тооллогогийн үндэсний статистик төв



ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ
2020 ОНЫ УЛСЫН ЭЭЛЖИТ ТООЛЛОГО

НИЙСЛЭЛИЙН НЭГДСЭН ДҮН

УЛААНБААТАР ХОТ
2020 ОН

ННА 72
ДАА 001.4
Н-28

ТАЙЛАН БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД

НЭГ. ХЯНАСАН

Төмөрбаатарын БОЛОР-ЭРДЭНЭ

Эдийн засагч-Хүн ам зүйч

ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны ахлах статистикч

Цэрэндуламын ЗАЯХҮҮ

Социологич, нийгмийн сэтгэл зүйч

НСГ-ын дарга, Хүн ам, орон сууцны нийслэлийн тооллогын комиссын орлогч дарга

Ичинноровын ЦЭРЭНДУЛАМ

Эдийн засагч-Статистикч

ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны статистикч

ХОЁР. БИЧИЖ БОЛОВСРУУЛСАН

Төмөрийн Навч

Эдийн засагч-Статистикч, Хүн ам зүйн ухааны магистр

Өлзийбүрэнгийн Нандинцэцэг

Математикч-Статистикч

НСГ-ын Хүн ам, нийгмийн салбар хариуцсан мэргэжилтэн

Өлзийбатын ГАН-ОД

Программист

НСГ-ын Мэдээллийн технологийн асуудал хариуцсан зохион байгуулагч

Цогбаярын ХУЛАН

Эдийн засагч-Математик загварчлагч

НСГ-ын гэрээт ажилтан

ISBN: 978-9919-20-946-9

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

АГУУЛГА

ТАЙЛАН БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД.....	2
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	8
ТАЛАРХАЛ	11
ӨМНӨХ ҮГ	13
ТОВЧ ДҮГНЭЛТ	15
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ	
ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН ОНЦЛОГ, УДИРДЛАГА	25
ХОЁРДУГААР БҮЛЭГ	
ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ, НАС ХҮЙСИЙН БҮТЭЦ	37
ГУРАВДУГААР БҮЛЭГ	
ХҮН АМЫН ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ, ҮНДЭС, УГСАА, ШАШИН	45
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ	
ХҮН АМЫН СУУРЬШИЛ, НЯГТРАЛ	55
ТАВДУГААР БҮЛЭГ	
ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН	61
ЗУРГААДУГААР БҮЛЭГ	
БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, БОЛОВСРОЛ	71
ДОЛООДУГААР БҮЛЭГ	
ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ.....	83
НАЙМДУГААР БҮЛЭГ	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, БҮТЭЦ.....	107
ЕСДҮГЭЭР БҮЛЭГ	
ГАР УТАС, ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИД	117
АРАВДУГААР БҮЛЭГ	
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	135
АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ	
ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД.....	145
АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ	
ӨРХИЙН ОРОН СУУЦНЫ ТӨРӨЛ, НӨХЦӨЛ	
ХАВСРАЛТ	165

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 2.1.	УЛААНБААТАР ХОТЫН НИЙТ ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНООР	40
ХҮСНЭГТ 2.2.	ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТ, 2010-2019 ОН	41
ХҮСНЭГТ 2.3.	СУУРИН ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2010, 2020 ОН	42
ХҮСНЭГТ 2.4.	ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХҮЙСИЙН ХАРЬЦААГААР, 2010, 2020 ОН	43
ХҮСНЭГТ 3.1.	МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН ТОО, ҮНДЭС УГСАА, ХУВИАР, 2010, 2020 ОН	47
ХҮСНЭГТ 3.2.	ХҮН АМЫН ТОО, ҮНДЭС УГСАА, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 2020 ОН	48
ХҮСНЭГТ 3.3.	УЛААНБААТАР ХОТЫН 10, ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ҮНДЭС УГСАА, ХУВИАР, 2020 ОН	49
ХҮСНЭГТ 3.4.	НИЙСЛЭЛ ХОТЫН СУУРИН ХҮН АМ, ГАДААДЫН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, ХУВИАР, 2020 ОН	50
ХҮСНЭГТ 3.5.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ШАШИН ШҮТЛЭГИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	51
ХҮСНЭГТ 3.6.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТДЭГ ХҮН АМЫН, ШАШНЫ ТӨРӨЛ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	52
ХҮСНЭГТ 3.7.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИНТАН, НАСНЫ БҮЛЭГ, ШАШНЫ ТӨРӨЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	53
ХҮСНЭГТ 4.1.	ХҮН АМЫН ТОО, ДҮҮРЭГ, ХОРООГООР, 2010, 2020 ОН	58
ХҮСНЭГТ 4.2.	ХҮН АМЫН ТОО, ДҮҮРЭГ, ӨСӨЛТ, ХУВИАР, 2010, 2020 ОН	58
ХҮСНЭГТ 4.3.	ХҮН АМЫН ТОО, НЯГТРАЛ, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2010, 2020 ОН	59
ХҮСНЭГТ 5.1.	ХҮН АМЫН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦСОН БАЙДАЛ, СУУРЬШСАН ХУГАЦАА, ХҮЙС, ХУВИАР 2020 ОН	65
ХҮСНЭГТ 5.2.	ХҮН АМЫН ТОО, ТӨРСӨН ГАЗАР, ХУВИАР, 2010, 2020 ОН	66
ХҮСНЭГТ 5.3.	ТАВАН ЖИЛИЙН ӨМНӨ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧДЫН ТОО, 2010, 2020 ОН	67
ХҮСНЭГТ 5.4.	СҮҮЛИЙН НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН СУУРИН ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН	70
ХҮСНЭГТ 6.1.	АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН	74
ХҮСНЭГТ 6.2.	АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2020 ОН	75
ХҮСНЭГТ 6.3.	АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР, 2020 ОН	76
ХҮСНЭГТ 6.4.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН	77
ХҮСНЭГТ 6.5.	ЗУРГААГААС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, НАС, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН	79
ХҮСНЭГТ 6.6.	ЗУРГААГААС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2020 ОН	81
ХҮСНЭГТ 6.7.	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ, НАС, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН	82

ХҮСНЭГТ 6.8.	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ, НАС, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2020 ОН.....	82
ХҮСНЭГТ 7.1.	ӨРХ, ӨРХ ҮҮСГЭЭГҮЙ НЭГЖИД ТООЛОГДСОН ХҮН АМЫН ТОО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	85
ХҮСНЭГТ 7.2.	ӨРХИЙН ТОО, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2010, 2020 ОН.....	86
ХҮСНЭГТ 7.3.	ӨРХИЙН ТОО, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2010, 2020 ОН.....	87
ХҮСНЭГТ 7.4.	ӨРХИЙН ТОО, ДҮҮРЭГ, ӨРХИЙН ХЭЛБЭР, ХУВИАР, 2020 ОН.....	87
ХҮСНЭГТ 7.5.	ӨРХИЙН ТОО, ДҮҮРЭГ, АМ БҮЛИЙН ТОО, ХУВИАР, 2020 ОН	88
ХҮСНЭГТ 7.6.	ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙС, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХУВИАР, 2020 ОН	88
ХҮСНЭГТ 7.7.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН	89
ХҮСНЭГТ 7.8.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН	90
ХҮСНЭГТ 7.9.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН.....	91
ХҮСНЭГТ 7.10.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН.....	92
ХҮСНЭГТ 8.1.	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН	95
ХҮСНЭГТ 8.2.	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ДҮҮРЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН	97
ХҮСНЭГТ 8.3.	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХҮЙС ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭР, ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН.....	98
ХҮСНЭГТ 8.4.	УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМЫН ТОО, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭРЭЭР, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН.....	99
ХҮСНЭГТ 8.5.	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ДҮҮРЭГ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН.....	100
ХҮСНЭГТ 8.6.	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ДҮҮРЭГ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН.....	101
ХҮСНЭГТ 8.7.	АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ХЭЛБЭР, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	102
ХҮСНЭГТ 8.8.	АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ХЭЛБЭР, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	102
ХҮСНЭГТ 8.9.	АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ХЭЛБЭР, ДҮҮРГЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	104
ХҮСНЭГТ 8.10.	АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ДАВХАРДЛААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	104
ХҮСНЭГТ 8.11.	АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ЭСЭХ, ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ХЭЛБЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	105
ХҮСНЭГТ 9.1.	ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН.....	115

ХҮСНЭГТ 10.1.	АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ДҮҮРЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН	121
ХҮСНЭГТ 10.2.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН	122
ХҮСНЭГТ 10.3.	АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН.....	124
ХҮСНЭГТ 10.4.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ДҮҮРЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН	124
ХҮСНЭГТ 10.5.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН (МЯН.ХҮН)	124
ХҮСНЭГТ 10.6.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН.....	125
ХҮСНЭГТ 10.7.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН.....	126
ХҮСНЭГТ 10.8.	АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН	128
ХҮСНЭГТ 10.9.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН.....	129
ХҮСНЭГТ 10.10.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН.....	130
ХҮСНЭГТ 10.11.	АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ДҮҮРЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН	131
ХҮСНЭГТ 10.12.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМЫН ТОО, АЖИЛ ЭРХЛЭХГҮЙ БАЙГАА ШАЛТГААН, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН /МЯН.ХҮН/	132
ХҮСНЭГТ 10.13.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, АЖИЛ ЭРХЛЭЭГҮЙ ШАЛТГААНААР, 2020 ОН.....	133
ХҮСНЭГТ 10.14.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, АЖИЛ ЭРХЛЭЭГҮЙ ШАЛТГААНААР, 2020 ОН.....	133
ХҮСНЭГТ 10.15.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМЫН ТОО, ДҮҮРЭГ, НАСНЫ БҮЛГЭЭР, 2020 ОН.....	133
ХҮСНЭГТ 11.1.	ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН	138
ХҮСНЭГТ 11.2.	ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, БАЙНГА СУУЖ БАЙСАН ДҮҮРЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	139
ХҮСНЭГТ 11.3.	ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ТОО, ОРШИН СУУГАА УЛС, ОРШИН СУУГАА ХУГАЦАА, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	140
ХҮСНЭГТ 11.4.	ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, ЯВСАН БОЛОН ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	141
ХҮСНЭГТ 11.5.	ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, ЯВСАН БОЛОН ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	142
ХҮСНЭГТ 11.6.	ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	143
ХҮСНЭГТ 12.1.	ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦ, ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019, 2020 ОН.....	149
ХҮСНЭГТ 12.2.	ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2010, 2020 ОН.....	149
ХҮСНЭГТ 12.3.	ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2020 ОН	150

ХҮСНЭГТ 12.4.	ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ӨМЧИЙН ХЭЛБЭР, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН	151
ХҮСНЭГТ 12.5.	ӨРХИЙН ТОО, ӨМЧИЙН ХЭЛБЭР, СУУЦНЫ ТӨРӨЛ, ДҮҮРГЭЭР, 2020 ОН ...	151
ХҮСНЭГТ 12.6.	ӨӨРИЙН ЭЗЭМШЛИЙН СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ХУВЬ, СУУЦНЫ ТӨРӨЛ, ДҮҮРГЭЭР, 2020 ОН	153
ХҮСНЭГТ 12.7.	ӨРХИЙН ТОО, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2020 ОН.....	153
ХҮСНЭГТ 12.8.	ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТОО, ГЭРИЙН ХАНЫН ТОО, ХУВИАР, 2010, 2020 ОН.....	154
ХҮСНЭГТ 12.9.	ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АХУЙН НӨХЦӨЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2010, 2020 ОН	155
ХҮСНЭГТ 12.10.	БАЙШИН СУУЦНЫ ТОО, ХАНЫН ҮНДСЭН МАТЕРИАЛ, ХАНЫН ӨНГӨЛГӨӨ-НИЙ МАТЕРИАЛ, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, МЯНГА, 2019 ОН	158
ХҮСНЭГТ 12.11.	БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТОО, СУУЦНЫ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, ХУВИАР, 2020 ОН.....	159
ХҮСНЭГТ 12.12.	БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТОО, ӨРӨӨНИЙ ТОО, ХУВИАР, 2020 ОН	159
ХҮСНЭГТ 12.13.	БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ХУВЬ, ДҮҮРЭГ, ӨРӨӨНИЙ ТООГООР, 2020 ОН	160
ХҮСНЭГТ 12.14.	БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ХАЛААЛТЫН ТӨРӨЛ, ХУВИАР, 2010, 2020 ОН	161
ХҮСНЭГТ 12.15.	БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ХАЛААЛТЫН ТӨРӨЛ, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2020 ОН	161
ХҮСНЭГТ 12.16.	БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН УСАН ХАНГАМЖИЙН ТӨРӨЛ, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2010, 2020 ОН.....	162
ХҮСНЭГТ 12.17.	БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН УСАН ХАНГАМЖИЙН ТӨРӨЛ, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2020 ОН.....	162
ХҮСНЭГТ 12.18.	БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ОНГОЦ ШҮРШҮҮРИЙН ТӨРӨЛ, ХУВИАР, 2010, 2020 ОН	163
ХҮСНЭГТ 12.19.	БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ОНГОЦ ШҮРШҮҮРИЙН ӨРӨӨТЭЙ ЭСЭХ, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2020 ОН	163

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 2.1.	УЛААНБААТАР ХОТЫН НИЙТ ХҮН АМЫН ТОО, 2020 ОН	39
ЗУРАГ 2.2.	ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР*	41
ЗУРАГ 2.3.	ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН	44
ЗУРАГ 3.1.	ХҮН АМЫН ТОО, ИРГЭНИЙ ХАРЬЯАЛЛААР, 2020 ОН	47
ЗУРАГ 3.2.	НИЙСЛЭЛД ОРШИН СУУГАА ГАДААДЫН ХАРЬЯАТ ИРГЭД, УЛСААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	50
ЗУРАГ 3.3.	ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ГАДААДЫН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР, 2010, 2020 ОН	51
ЗУРАГ 3.4.	ШАШИНТНУУДЫН НАСНЫ БҮЛЭГ ДЭХ НИЙТ ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН	52
ЗУРАГ 3.5.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД ШАШИНТНУУДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ДҮҮРГЭЭР 2020 ОН	52
ЗУРАГ 3.6.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИНТАН, ДҮҮРЭГ, ШАШНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН	53
ЗУРАГ 4.1.	МОНГОЛ УЛСЫН СУУРИН ХҮН АМД УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР	57
ЗУРАГ 4.2.	НИЙСЛЭЛИЙН ХҮН АМЫН СУУРЬШИЛ, ДҮҮРГЭЭР, 2010, 2020 ОН	57
ЗУРАГ 4.3.	ХҮН АМЫН НЯГТРАЛ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГЭЭР, 2020 ОН	59
ЗУРАГ 5.1.	ТӨРСНӨӨС ХОЙШИХ ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, 2020 ОН	64
ЗУРАГ 5.2.	ШИЛЖИГЧДИЙН ТОО, ХУГАЦААГААР, 2010, 2020 ОН	64
ЗУРАГ 5.3.	ШИЛЖИН ИРСЭН ХҮН АМЫН ТОО, ШИЛЖИН ИРЭЭД СУУЖ БУЙ ХУГАЦАА, ХУВИАР, 2020 ОН	65
ЗУРАГ 5.4.	ХҮН АМ, ТӨРСӨН БҮС НУТГААР, ХУВИАР, 2010, 2020 ОН	66
ЗУРАГ 5.5.	ШИЛЖИН ИРЭГЧИД, ШИЛЖИН ИРСЭН АЙМГААР, 2020 ОН	67
ЗУРАГ 5.6.	ШИЛЖИН ЯВАГЧИД, АЙМГААР, ШИЛЖИН ОЧСОН 2020 ОН	67
ЗУРАГ 5.7.	СҮҮЛИЙН ТАВАН ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧИД, ЯВАГЧДЫН ТОО БҮС, ХУВИАР, 2020 ОН	68
ЗУРАГ 5.8.	УЛААНБААТАР ХОТОД СҮҮЛИЙН ТАВАН ЖИЛИЙН ЦЭВЭР ШИЛЖИЛТ, 2020 ОН (ШИЛЖИН ИРСЭН БОЛОН ЯВСАН ХҮНИЙ ЗӨРҮҮ), БҮС НУТГААР	68
ЗУРАГ 5.9.	СҮҮЛИЙН НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ТОО, АЙМГААР, 2020 ОН	69
ЗУРАГ 5.10.	СҮҮЛИЙН НЭГ ЖИЛД ШИЛЖИН ЯВАГЧДЫН ТОО, АЙМГААР, 2020 ОН	69
ЗУРАГ 5.11.	СҮҮЛЧИЙН НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧИД, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН	70
ЗУРАГ 6.1.	ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ ХҮН АМЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, УЛСЫН ДУНДАЖ, НАСНЫ БҮЛГЭЭР, 2020 ОН	77
ЗУРАГ 6.2.	ХҮН АМЫН ТОО, БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГЭЭР*, 2020 ОН	77
ЗУРАГ 6.3.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД БИЧИГ ҮСЭГ МЭДДЭГГҮЙ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛГЭЭР, 2020 ОН	78
ЗУРАГ 6.4.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2020 ОН	78
ЗУРАГ 6.5.	НИЙСЛЭЛИЙН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, УЛСЫН ДУНДАЖ, НАСНЫ БҮЛГЭЭР, 2020 ОН	80

ЗУРАГ 7.1.	ӨРХ, ӨРХӨД ХАМААРАЛГҮЙ ТООЛОГДСОН ХҮН АМЫН ТОО, 2020 ОН.....	85
ЗУРАГ 7.2	ӨРХИЙН ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН	86
ЗУРАГ 7.3.	АНХНЫ ГЭРЛЭЛТИЙН ДУНДАЖ НАС, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР.....	90
ЗУРАГ 7.4.	ГЭР БҮЛЭЭ ЦУЦАЛСАН ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН	92
ЗУРАГ 8.1.	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН .	96
ЗУРАГ 8.2.	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ДҮҮРГЭЭР, НИЙТ ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	97
ЗУРАГ 8.3.	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН	98
ЗУРАГ 8.4.	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010, 2020 ОН.....	99
ЗУРАГ 8.5.	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХЭЛБЭР, ХУВИАР, 2020 ОН.....	100
ЗУРАГ 8.6.	ҮЙЛДЛИЙН ЧАДВАР, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	103
ЗУРАГ 8.7.	АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛТЭЙ ХҮМҮҮС, ДАВХАРДЛААР, НАСНЫ БҮЛГИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	103
ЗУРАГ 8.8.	АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ОГТ ХҮНДРЭЛГҮЙ ХҮМҮҮСИЙН СУУРИН ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙСЭЭР, 2020 ОН	103
ЗУРАГ 9.1.	ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, 2020 ОН	109
ЗУРАГ 9.2.	ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР 2010, 2020 ОН.....	110
ЗУРАГ 9.3.	ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧ ХҮН АМ, ДҮҮРГЭЭР, 2020 ОН	110
ЗУРАГ 9.4.	ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ СУУРИН ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ДҮҮРГЭЭР, 2020 ОН.....	111
ЗУРАГ 9.5.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС НАСНЫ ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТЭЭР, 2020 ОН	111
ЗУРАГ 9.6.	ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХУВИАР, 2020 ОН.....	112
ЗУРАГ 9.7.	АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХГҮЙ БАЙГАА ШАЛТГААН, ХУВИАР, 2010, 2020 ОН.....	112
ЗУРАГ 9.8.	ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, 2010, 2020 ОН.....	113
ЗУРАГ 9.9.	ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧ ХҮН АМ, ДҮҮРГЭЭР, 2020 ОН	114
ЗУРАГ 9.10.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТЭЭР, 2020 ОН ..	114
ЗУРАГ 9.11.	ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ДҮҮРГЭЭР, 2010, 2020 ОН.....	115
ЗУРАГ 10.1.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮВЧ, 2020 ОН	120
ЗУРАГ 10.2.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХУВИАР, 2020 ОН	121

ЗУРАГ 10.3. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН.....	122
ЗУРАГ 10.4. ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХУВИАР, 2020 ОН.....	123
ЗУРАГ 10.5. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХУУЧИН БОЛОН ШИНЭ СТАТУСЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ.....	127
ЗУРАГ 10.6. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ДҮҮРГЭЭР, 2020 ОН.....	131
ЗУРАГ 10.7. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, ХУВИАР, 2020 ОН	132
ЗУРАГ 11.1. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2020 ОН ..	138
ЗУРАГ 11.2. ГАДААДАД ОРШИН СУУГАА НИЙСЛЭЛИЙН ИРГЭД БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН ДҮҮРГЭЭР, 2020 ОН.....	139
ЗУРАГ 11.3. ГАДААДАД ОРШИН СУУГАА НИЙСЛЭЛИЙН ИРГЭД, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ХУВИАР, 2010, 2020 ОН.....	141
ЗУРАГ 11.4. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, НАСНЫ БҮЛЭГ, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН ..	143
ЗУРАГ 12.1 ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ НИЙТ СУУЦ БОЛОН ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, ТӨРЛӨӨР, 2019 ОН (БАЙШИН ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН ДҮН)	148
ЗУРАГ 12.2. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2020 ОН	149
ЗУРАГ 12.3. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН	152
ЗУРАГ 12.4. ГЭРИЙН ДЭЭВЭР, ТУУРГА, ШАЛНЫ ҮНДСЭН МАТЕРИАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН	154
ЗУРАГ 12.5. БАЙШИН СУУЦНЫ АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОН, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН	157
ЗУРАГ 12.6. АМИНЫ СУУЦНЫ БАЙШИНГИЙН ШАЛНЫ ҮНДСЭН БОЛОН ХУЧИЛТЫН МАТЕРИАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН	158
ЗУРАГ 12.7. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ХАТУУ ХОГ, ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАЛТЫН ХЭЛБЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	164
ЗУРАГ 12.8. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН БОХИР УС ЗАЙЛУУЛТЫН ХЭЛБЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	164

ТАЛАРХАЛ



Монгол Улсын Хүн ам, орон сууцны 11 дэх удаагийн тооллогыг бид нийслэл хотод амжилттай зохион байгуулж явуулав.

Энэхүү томоохон ажлыг нийслэл хотод амжилттай зохион байгуулж, ажил үүрэг, хариуцлагаа ухамсарлан, ажилдаа чин сэтгэлээсээ хандаж, зүтгэл чармайлт гарган ажилласан нийслэл, дүүргийн тооллогын комисс, түр товчоодын ажилтнууд, тоологч, шалгагч Та бүхэнд чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлье.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, бүх шатны Засаг дарга нар хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу тооллогын ажилд онцгой ач холбогдол өгч идэвхтэй оролцлоо.

Тооллогын ажлыг нийслэл хотод нэгдсэн удирдлага, аргачлал, заавраар хангаж, өндөр зохион байгуулалттай явуулахад гол үүрэг гүйцэтгэсэн нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн удирдлага, ажилтнууд, ялангуяа тооллогын дүнг богино хугацаанд чанарын өндөр түвшинд боловсруулан гаргаж, танилцуулж байгаа Нийслэлийн Статистикийн газрын хамт олонд халуун баяр хүргэж, ажлын амжилт хүсье.

Тооллогын ажлыг амжилттай явуулахад манай нийслэлийн иргэдийн оролцоо, эх оронч сэтгэл нэн чухал хувь нэмэр оруулсныг тэмдэглэн хэлэхийг хүсч байна.

Хүн ам, орон сууцны тооллогын нэгдсэн үр дүнгээр нийслэл хотын хүн ам, өрхийн талаарх бүхий л үнэн бодит, хамгийн дэлгэрэнгүй мэдээллийг бидэнд өгч байна. Хүн ам, орон сууцны тооллого нь хүн амын тоо, нас хүйсийн бүтэц, бүрэлдэхүүн, байршил, боловсрол, эдийн засгийн идэвх, орон сууцны төрөл, нөхцөл зэрэг нийгэм, эдийн засгийн маш дэлгэрэнгүй тоо баримтыг агуулдаг цорын ганц мэдээллийн эх үүсвэр билээ.

Хүн ам, орон сууцны энэ удаагийн тооллогоор нийт хүн амын тоо, нас хүйсийн бүтэц, ажил эрхлэлт, шилжилт хөдөлгөөн зэрэг хүн амтай холбоотой бүхий л үзүүлэлтээс гадна хүн амын амьдарч буй орон сууцны нөхцлийн өнөөгийн байдлыг гаргаж, энэ хүрээнд өмнөх 10 жилийн хугацаанд гаргасан хөгжил дэвшлийг тодорхойлж, нийслэл, хороо, өрх нэг бүрийн мэдээллийн баазыг бий болголоо.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнд үндэслэн нийслэл хотын нөхцөл байдалд нийцсэн, амьдрах чадвар бүхий хөгжлийн зохистой загвар, үзэл баримтлалыг тодорхойлох сайхан боломж нээгдэж байна. Ялангуяа шинээр барьж байгуулах нийгэм соёлын газрууд, сургууль, эмнэлгийг хаана ямар багтаамжтай, хүчин чадалтай байлгах, орон сууцны нөхцөл, хангамжийг зөв төлөвлөж, хэрэгжүүлэхэд тооллогын дүн үндэслэл болох учиртай.

Түүнчлэн хүн ам зүйн олон үзүүлэлтүүд үүний дотор хүн амын суурьшил, байршлыг зөв оновчтой зохицуулах, төвлөрлийг сааруулах талаарх бодлого, хөтөлбөрийг боловсруулахад тооллогын дүн чухал ач холбогдолтой юм.

Тооллогын дүнг төр засаг, аж ахуйн нэгж, байгууллага, ард иргэдэд өргөн хүртээмжтэй тархах нь Нийслэлийн тооллогын комисс, түр товчоонд ногдох эрхэм үүрэг мөн.

Хүн ам, орон сууцны тооллогод амжилттай ажилласан бүх хүмүүст талархал илэрхийлж, ажлын амжилтыг хүсэн ерөөе.

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ**



Д.СУМБЯАБАЗАР

ӨМНӨХ ҮГ



Бид Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогыг “Хүмүүнд төр эрхэм, төрд хүмүүн эрдэнэ” уриан дор нийслэл хотод амжилттай зохион байгуулж, нэгдсэн үр дүнг Та бүхэнд хүргэж байна.

Монгол Улсын Засгийн газар нь Нэгдсэн Үндэсний Байгууллагын гишүүний хувьд өөрийн нутаг дэвсгэр дээрх хүн амын тоог гаргаж өгөх үүрэгтэй.

“Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29.1.1.г-д “харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрт заасан тайлан мэдээг хугацаанд нь хариуцан гаргуулж, хяналт тавих, хүн ам, орон сууц, газар, мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого явуулах ажлыг зохион байгуулах” гэж заасны дагуу Нийслэлийн Засаг

даргаар ахлуулсан тооллогын комисс энэ удаагийн “Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого”-ыг удирдлагаар хангаж ажиллав.

Нийслэлийн Засаг дарга, дүүрэг болон хорооны Засаг дарга нар “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 28.1.10, 29.1.1.г дэх зүйлд заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын өмнө хүн ам, орон сууцны тооллого явуулах үндсэн үүргээ бодитой биелүүлсэн. Ингэхдээ 2020 оны ээлжит тооллогыг “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хууль болон НҮБ-ын Статистикийн Комиссын “Хүн ам, орон сууцны тооллогын зарчим, зөвлөмж III”-ийн дагуу амжилттай зохион байгууллаа.

Монгол Улсын Хүн ам, орон сууцны тооллогын Улсын комиссын 2018 оны 02-р сарын 22-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Нийслэлийн тооллогын комиссыг Нийслэлийн засаг даргаар ахлуулан байгуулсан. Тооллогын ажлыг нийслэл хотод нэгдсэн удирдлага, аргачлал, заавраар ханган, өндөр зохион байгуулалттай явуулахад шат шатны тооллогын комисс, түр товчоод хүлээсэн үүргээ амжилттай биелүүлж, ялангуяа тооллогын үр дүнг богино хугацаанд боловсруулан гаргаж, тайланг бэлэн болгов.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогыг анх удаа бүртгэл болон уламжлалт тооллогын аргуудыг хосолсон хэлбэрээр зохион байгуулсан. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын онцлог нь 1969 оноос хойш хийгдээгүй байсан Байшин, орон сууцны тооллогыг зохион байгуулав. Тооллогын үйл ажиллагааны бүх үе шатанд орчин цагийн мэдээллийн дэвшилтэт технологи, газар зүйн мэдээллийн систем, ялангуяа Байшин орон сууцны тооллогын мэдээлэл цуглуулалтад таблет төхөөрөмжийг ашиглаж, төрийн байгууллагуудын мэдээллийн санг уялдуулж ажиллалаа.

Хүн ам, орон сууцны тооллого нь хүн амын тоо, нас хүйсийн бүтэц, угсаатны бүрэлдэхүүн, байршил, боловсрол, эдийн засгийн идэвх, орон сууцны төрөл, нөхцөл зэрэг эдийн засаг, нийгмийн талаарх суурь мэдээллийг цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, үнэлэх, хэвлэн нийтлэх, нийтэд тархаах цогц үйл ажиллагаа юм.

Энэхүү ном нь 12 бүлэг, тооллогын нэгдсэн үр дүнгийн гол гол үзүүлэлтийг хамарсан хавсралтаас бүрдэнэ. Хүн амын тоо, өсөлт, улсын харьяалал, үндэс угсаа, нягтрал, шашин, суурьшил, хотжилт зэрэг хүн ам зүйн гол үзүүлэлтийг 2-4 дүгээр бүлэгт, хүн амын дотоод шилжих хөдөлгөөн, боловсрол, бичиг үсгийн мэдлэг, өрх, гэр бүлийн байдал, гар утас, интернэт хэрэглэгчид, эдийн засгийн идэвх, гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн талаарх мэдээллийг тус бүрд нь бүлэг болгосноос гадна тооллогод шинэ аргачлалаар тусгасан үйлдлийн чадварын хүндрэл болон Байшин, орон сууцны тооллогын мэдээллийг бүлэг болгож оруулав.

Тооллогын дүнг хэвлэмэл бүтээгдэхүүнээс гадна сүүлийн үеийн дэвшилтэт технологийн ашиглан өргөн тархах болно.


**НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗРЫН
ДАРГА, ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ НИЙСЛЭЛИЙН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА**


Ц.ЗАЯХҮҮ

УХА0 86 9517308
11161 0187

ТОВЧ ДҮГНЭЛТ


ӨРХИЙН ТОО



- ¹ Хоорондоо хамааралтай хэд хэдэн ам бүл хамтран өрх үүсгэн амьдарч байгаа тохиолдлыг нийлмэл өрх гэнэ.
- ² Ураг төрлийн хамааралтай болон хамааралгүй хүмүүс өрх үүсгэн амьдарч байгаа тохиолдлыг холимог өрх гэнэ.

БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

10, түүнээс дээш насны хүн амын хувьд




15, түүнээс дээш насны хүн амын тоо, бичиг үсгийн мэдлэгээр түвшин


Бичиг үсэг мэддэг **99.5%**

Бичиг үсэг мэддэггүй **0.5%**


ХҮН АМ
1 466 125



**БАЙШИН ОРОН СУУЦ,
ӨРХИЙН ТОО**



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ
дүнд эзлэх хувь



ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭ



ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ, НАС ХҮЙСИЙН БҮТЭЦ

2020 оны ээлжит тооллогоор Улаанбаатар хотод 1 539 810 Монгол Улсын харьяат хүн ам тоологдлоо. Үүнээс 1 448 642 нь нийслэлийн нутаг дэвсгэрт оршин суугаа Монгол Улсын харьяат иргэн, 91 168 нь гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын харьяат иргэн байна.

Нийслэлийн хүн ам 2010-2020 оны хоорондох хугацаанд 24.2 хувиар өсөж, жилийн дундаж өсөлт 2.7 хувь болж, 2000-2010 оны жилийн дундаж өсөлтөөс ойролцоогоор 2 дахин буураад байна. Жилийн дундаж өсөлт буурсан гол шалтгаан нь хотын хүн амын өсөлтийн дийлэнхийг бүрдүүлэгч шилжилт хөдөлгөөн буурсан явдал юм.

Улаанбаатар хотын дүүргүүдийн хүн амын өсөлт харилцан адилгүй байна. Тухайлбал, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн хувьд хүн ам 0.2-1.4 хувиар буюу хамгийн бага өсөлттэй байхад Хан-Уул дүүргийн хүн амын өсөлт 7.8 хувь байгаа нь Улаанбаатар хотын дунджаас 2.6 дахин өндөр өсөлт. Энэ нь сүүлийн жилүүдэд Хан-Уул дүүрэгт орон сууцны хорооллууд ихээр баригдсантай холбоотой.

Улаанбаатар хотын хүн амын насны бүтцэд 2010 онтой харьцуулахад зарим өөрчлөлт гарсан нь нийт хүн амд эзлэх 0-9 насныхны хувийн жин өсөж, 2011 оноос төрөлтийн түвшин нэмэгдсэнтэй холбоотой. Харин 15-29 насны бүлэг дэх хүн амын дүнд эзлэх хувь бага байгаа нь 1990-ээд оны эхэн үеэс 2006 он хүртэлх хугацаанд төрөлтийн түвшин бага байснаар тайлбарлагдана.

Хүйсийн харьцаа 1963 оны хүн амын тооллогоор 108.7 байснаа тогтмол буурсаар 2010 онд 92.9, 2020 онд 92.8 болсон нь нийт хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь илүү байгааг илэрхийлнэ. Дүүргүүдээр авч үзвэл 2020 онд хүйсийн харьцаа Баянгол дүүрэгт хамгийн бага буюу 89.7, Багахангай дүүрэгт хамгийн өндөр буюу 101.9 байна. Энэхүү үзүүлэлтийг 2010 онтой харьцуулахад Багануур, Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн хүн амын хүйсийн харьцаа бага зэрэг нэмэгдэж, харин Багахангай, Налайх, Хан-Уул, дүүргийн хүн амын хүйсийн харьцаа өмнөх тооллогын үеийнхээс бага зэрэг буурчээ.

Голч насыг тооцож үзэхэд ерөнхийдөө залуу хандлагатай байна. Сүүлийн 30 жилд хүн амын голч нас 20.6-аас 28.7 болж 8 жилээр хойшилсон нь төрөлтийн бууралтаас гадна дундаж наслалт нэмэгдэж байгаатай холбоотой.

Хүн ам зүйн ачаалал 2020 онд 58.3 болж 1989 оноос 9.3 пунктээр буурч, 2010 оноос 19.1 пунктээр өсжээ. Хөдөлмөрийн насны хүн амын тоо их байгаа буюу хүн ам зүйн цонх үеийг ашиглан урт хугацааны бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, ялангуяа ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарснаар улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд эерэгээр нөлөөлөх юм.

ХҮН АМЫН ИРГЭНИЙ ХАРЬЯЛАЛ, ҮНДЭС, УГСАА, ШАШИН

ХҮН АМЫН ИРГЭНИЙ ХАРЬЯЛАЛ

2020 оны хүн ам, орон сууцны тооллогоор Улаанбаатар хотод 1 466 125 оршин сууж байгаагаас 1 448 642 (98.8%) нь Монгол Улсын харьяат, 17 456 (1.2%) нь гадаадын харьяат иргэн, 27 нь аль нэг улсын харьяалалгүй хүн байна.

Гадаадын харьяат иргэдийн дотор Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэн 7.1 мянга (40.8%), Оросын Холбооны Улсын иргэн 2.2 мянга (12.6%), Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэн 2.0 мянга (11.5%), Америкийн Нэгдсэн Улсын иргэн 2.1 мянга (12.0%) байгаа нь бусад орнуудаас харьцангуй олон байв. Ялангуяа 6, түүнээс дээш сарын хугацаагаар, хамгийн олон хүн оршин суугаа гадаадын харьяат иргэдийн тоог 2010 онтой харьцуулахад Бүгд Найрамдах

Хятад Ард Улсын иргэдийн тоо 1.9 дахин, Оросын Холбооны Улсын иргэдийн тоо 1.4 дахин, Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдийн тоо 1.4 дахин, Америкийн Нэгдсэн Улсын иргэдийн тоо 5.2 дахин нэмэгджээ.

Улаанбаатар хот нь Монгол Улсын нийгэм, улс төр, хөгжлийн гол төв болон хөгжиж байгаагаар уялдан дэлхийн 120 гаруй орны иргэн оршин сууж байна.

Нийслэл хотод тоологдсон гадаадын харьяат иргэдийн хүйсийн харьцаа 140.5 байна. Эндээс харахад гадаадын харьяат иргэдийн дийлэнх нь хөдөлмөрийн насны, эрэгтэйчүүд байна гэж дүгнэж болно.

ХҮН АМЫН ҮНДЭС УГСАА

Монгол Улсын харьяат суурин хүн амын 91.2 хувийг Халхчууд эзэлж, өмнөх тооллогоос 0.7 пунктээр өссөн байна. Өнгөрсөн арван жилийн хугацаанд халхуудаас гадна өсөлт үзүүлсэн угсаатан бол Дарьгангачууд (0.2 пункт) байлаа. Ерөнхийдөө Монгол Улсын харьяат хүн амд үндэс угсаатны эзлэх хувь хоёр тооллогын хооронд маш бага өөрчлөлттэй байсан гэж дүгнэж болно.

Улаанбаатар хотод амьдарч байгаа угсаатнуудыг боловсролын түвшнээр ангилан авч үзвэл, Дарьгангачуудын 45.7 хувь, Өөлдүүдийн 40.5 хувь, Буриадуудын 38.9 хувь, Баядуудын 38.6 хувь нь дээд боловсролтой байгаа нь нийслэлийн дунджаас 6.3-13.4 пунктээр өндөр байна.

ШАШИН

Улаанбаатар хотын 15, түүнээс дээш насны хүн амын 46.3 хувь нь шашин шүтдэггүй, 53.7 хувь нь ямар нэгэн шашин шүтдэг гэж хариулсан ба 2010 оны тооллогын үетэй харьцуулахад шашин шүтдэг гэж хариулсан хүний хувь 7.7 пунктээр буурчээ.

Шашин шүтдэг хүмүүсийн 89.1 хувь нь Буддын шашинтан байна. Христийн болон бусад шашны сүм хийд Улаанбаатар хотод олноор баригдаж, түүнийг даган сүсэгтний тоо нэмэгдэж, хүн амын шашин шүтдэг хэсэг нь шашин шүтлэгийн хувьд нэгэн төрөл биш болж байгаа нь энэ удаагийн тооллогоор илүү тод харагдаж байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор нийслэлийн арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын 2.9 хувийг христийн шашин шүтэгчид эзэлж байна.

Хүн амын нас ахих тутам тухайн насны нийт хүн амд шашин шүтдэг хүн амын эзлэх хувь нэмэгдэж байна.

Арван тав, түүнээс дээш насны шашинтнуудыг шүтдэг шашных нь төрлөөр, дүүрэг тус бүрээр авч үзвэл Багахангай дүүрэгт 95.5 хувь, Баянгол дүүрэгт 91.6 хувь, Сонгинохайрхан дүүрэгт 90.3 хувь нь Монголын уламжлалт бурхны шашин шүтдэг байна. Налайх дүүргийн шашинтнуудын 13.6 хувь нь христийн шашин шүтдэг нь бусад дүүргүүдээс нэлээд ялгаатай байна. Энэ нь тус дүүрэгт Казахууд олноороо амьдарч байгаагаар холбоотой.

ХҮН АМЫН СУУРЬШИЛ, НЯГТРАЛ

Монгол Улсын хүн амын суурьшлыг бүсээр ангилж үзэхэд нийт хүн амын 45.9 хувь нь буюу 2 хүн тутмын нэг нь Улаанбаатар хотод, 18.7 хувь нь Хангайн бүсэд, 15.8 хувь нь Төвийн бүсэд, 12.6 хувь нь Баруун бүсэд, 7.0 хувь нь Зүүн бүсэд оршин сууж байна.

1990-ээд оны эхэн үеэс эхэлсэн төв, суурин газар луу шилжих шилжилт сүүлийн 30 жилд үргэлжилсэн хэвээр байна.

Улаанбаатар хотын хүн амын нягтрал 2000 онд нэг квадрат километр нутаг дэвсгэрт 162 хүн, 2010 онд 245 хүн, 2020 онд 312 болж өссөн нь орон нутгаас шилжин ирэлт их байгааг

харуулна. Хүн амын нягтрал 2020 онд 2010 оноос 66 хүнээр өссөн нь шилжих хөдөлгөөнтэй шууд холбоотой байна.

Төв, суурин газруудын дэд бүтцээр хангагдсан байдал, боловсрол, эрүүл мэндийн чанартай үйлчилгээ авах боломж, ялангуяа ажил, орлоготой болох найдвартай эх үүсвэр болж байгаа нь иргэдийг ихээр татаж хотжих үйл явцыг улам бүр өргөжүүлсээр байна.

Дүүргүүдийн нийслэлийн нийт хүн амд эзлэх хувь 2010 онтой харьцуулахад алслагдсан гурван дүүрэг болох Багануур, Багахангай, Налайх дүүргийн нийт хүн амд эзлэх хувь өөрчлөгдөөгүй 10 жилийн хугацаанд хадгалагдан үлджээ. Харин төвийн дүүргүүдийн хувьд өөрчлөлт гарсан байна. Тухайлбал, Хан-Уул дүүрэг бусад дүүргүүдийг бодвол хамгийн их буюу 3.2 пунктээр өссөн нь сүүлийн жилүүдэд Хан-Уул дүүрэгт орон сууц ихээр баригдаж, Улаанбаатар хотын дүүрэг хоорондын шилжих хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотой.

Байршлын ялгаатай байдлаас шалтгаалан хүн амын нягтрал дүүргүүдэд харилцан адилгүй байна. Хүн амын нягтрал хамгийн ихтэй дүүрэг Баянгол (9 254), харин хамгийн их хүн амтай нь Баянзүрх дүүрэг байна.

ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Улаанбаатар хотын суурин хүн амын 947 117 (64.6%) хүн төрснөөсөө хойш нийслэлд амьдарч байгаа бол 519 008 (35.4%) хүн шилжин ирж суурьшсан, үүний дотор 511 678 (34.9%) хүн өөр аймаг хотоос, 7 330 (0.5%) нь гадаадаас шилжин иржээ. Шилжин ирж суурьшсан хүн амын 55.0 хувь нь эмэгтэй, 45.0 хувь нь эрэгтэйчүүд байв.

Нийслэл хотод сүүлийн 5 жилд 72.9 мянган хүн шилжин ирсэн нь 2010 оноос 2.5 дахин, сүүлийн нэг жилд шилжин ирэгчдийн тоо 55.3 мянгад хүрч, өмнөх тооллогоос 6 мянган хүнээр тус тус буурчээ.

Улаанбаатар хотод нийт шилжин ирэгчдийн 13.1 хувь нь 20, түүнээс дээш жилийн өмнө, 14.1 хувь нь 10-19 жилийн өмнө, 8.2 хувь нь 2020 оны тооллогоос өмнөх 9 жилийн хугацаанд ирж суурьшсан байна.

2010 онд нийслэл хотод амьдарч байгаа хоёр хүний нэг нь шилжин ирэгч байсан бол 2020 онд гурван хүний нэг нь шилжин ирэгч болсон байна. Нийслэл хотын гурван иргэн тутмын нэг нь өөр аймагт төрсөн байгааг бүс нутгаар авч үзвэл, 10.8 хувь нь хангайн бүсэд, 11.0 хувь нь баруун бүсийн аймагт төрсөн нь бусад бүсээс өндөр байна.

Нийслэлд 2020 оны тооллогоор байнга оршин суугаа тав, түүнээс дээш насны хүн амын 94.3 хувь нь сүүлийн 5 жилийн хугацаанд шилжих хөдөлгөөнд ороогүй бол үлдсэн 5.7 хувь нь бусад аймгаас шилжин ирсэн байна.

Сүүлийн 5 жилд Улаанбаатар хот руу шилжин ирсэн урсгалыг бүс нутгаар харахад нийт шилжин ирэгчдийн 30.8 хувь нь төвийн бүсээс, 29.2 хувь нь Хангайн бүсээс иржээ.

Улаанбаатар хотод 2020 оны хүн ам, орон сууцны тооллогын товоос өмнөх нэг жилд нийт 69.2 мянган хүн шилжих хөдөлгөөнд оролцсон нь 2010 оны тооллогын үеэс 32.0 мянган хүнээр буурсан байна.

БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, БОЛОВСРОЛ

БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Монгол Улсын хэмжээнд арав, түүнээс дээш насны хүн амын 95.1 хувь нь ямар нэгэн боловсролын түвшин эзэмшиж байгаа бол Улаанбаатар хотод энэ үзүүлэлт 95.9 хувь болж, өмнөх тооллогын үеэс 0.4 пунктээр буурсан байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор 10, түүнээс дээш настай хүн амын дотор бага боловсролтой хүн 9.2 хувь, суурь боловсролтой хүн 9.4 хувь, бүрэн дунд боловсролтой хүн 32.7 хувь, техникийн болон мэргэжлийн дунд боловсролтой хүн 3.0 хувь, тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн 5.3 хувь, дээд боловсролтой хүн 36.3 хувь байна.

Арав, түүнээс дээш насны нийт хүн амд боловсролгүй хүн амын эзлэх хувь 2020 онд өмнөх тооллогоос эрэгтэйчүүд 0.5 пункт, эмэгтэйчүүдийн 0.3 пунктээр өсөв.

БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Монгол Улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны хүн амын 98.7 хувь нь бичиг үсэг тайлагдсан бол нийслэлд энэ үзүүлэлт 99.5 хувьтай байгаа нь улсын дунджаас 0.8 пунктээр өндөр, өмнөх тооллогоос 0.1 пунктээр нэмэгджээ.

Арван тав, түүнээс дээш насны хүн амын 0.5 хувь нь бичиг үсэг мэдэхгүй байгаа нь нийслэл хотынхон маань бүгд бичигтэн болсныг харуулж байна.

СУРГУУЛЬ, СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах нас буюу 2-оос 5 насны нийт 123.2 мянган хүүхдийн 82.2 хувь нь цэцэрлэгт хүмүүжиж байгаа нь 2010 оны тооллогоос 16.1 пунктээр өсжээ.

ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор Монгол Улсад нийт 897.4 мянган өрх тоологдсоноос 411.4 мянга (45.8%) нь нийслэл хотод амьдарч байна. Нийслэлд амьдарч байгаа өрхийн тоо 2010 оноос 109.2 мянган (36.1%) өрхөөр өсөв.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр 411.4 мянган өрхөд суурин хүн амын 97.3 хувь буюу 1 426 085 хүн, өрх үүсгээгүй нэгжид 2.7 хувь буюу 40 040 хүн тус тус тоологдов. Өрх үүсгээгүй хүмүүст цэрэг хоригдол, оюутан зэрэг хүмүүс багтана. Өрхөд тоологдсон хүний хувь өмнөх тооллогын үеийнхээс 0.7 пунктээр нэмэгдсэн байна.

Тооллогоор нийслэлийн нийт өрхийн 52.4 хувийг ам бүлээрээ байгаа өрх, 28.9 хувийг нийлмэл өрх, 14.6 хувийг ганц бие өрх, 4.1 хувийг холимог өрх эзэлж байна. Энэ үзүүлэлтийг өмнөх тооллоготой харьцуулахад ам бүлээрээ байгаа өрх 1.4 пункт, нийлмэл өрх 5.2 пунктээр буурсан бол ганц бие өрх 5.1 пункт, холимог өрх 1.5 пунктээр өсжээ.

Улаанбаатар хотын хэмжээнд ам бүлийн дундаж тоо 3.6 болсон нь улсын дүнтэй ижил, өмнөх тооллогоос 0.1 пунктээр буурчээ.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор Улаанбаатар хотын арван тав ба дээш насны нийт хүн амын дотор гэр бүлтэй хүн амын эзлэх хувь 61.4 болж 2010 оныхоос 4.7 пунктээр өсжээ.

Арван тав, түүнээс дээш насны хүн амын 34.0 хувийг огт гэр болоогүй эрэгтэйчүүд эзэлж байхад, эмэгтэйчүүд 28.0 хувийг буюу 6.0 пунктээр бага байна. Энэ зөрүү 2010 онд 4.7 пункт байсан бол энэ удаагийн тооллогоор 1.3 дахин нэмэгджээ. Үүнийг нэг талаас эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол харьцангуй залуудаа нөхөрт гардаг, нөгөө талаас гадаадад ажил эрхлэхээр явж байгаа хүмүүсийн дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр, түүнчлэн уул уурхайн хөгжлийг дагаад эрэгтэйчүүд олон сараар хөдөө орон нутагт суурьшиж ажилладаг гэх мэт олон хүчин зүйл нөлөөлдөг.

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллогын дүнгээр улсын дунджаар эмэгтэйчүүд 26.7 насандаа, нийслэлд 27.2 насандаа, эрэгтэйчүүд 28.6 насандаа, нийслэлд 28.5 насандаа анх гэр бүл болж байна.

Анхны гэрлэлтийн дундаж нас хамгийн ихээр нэмэгдэж байсан үе бол 1989-өөс 2000 оны хооронд 4-5 насаар нэмэгдэж байсан бол 2010-аас 2020 оны хооронд ойролцоогоор хоёр насаар хойшилжээ. Харин эрэгтэй, эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж насны ялгаа ойролцоогоор нэг нас байгаа нь сүүлчийн гуч гаруй жилд өөрчлөгдсөнгүй.

Гэр бүлээ цуцалсан хүний тоог хүйсээр ангилж үзэхэд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс аль ч насны бүлэгт ойролцоогоор хоёр дахин их, ялангуяа 45-54 насанд хамгийн их зөрүүтэй байна. Эндээс дүгнэхэд эрэгтэйчүүдийн дахин гэрлэлт эмэгтэйчүүдийнхээс харьцангуй өндөр байдгийг харуулж байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, БҮТЭЦ

Нийслэл хотын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 36.7 мянган хүн байгаа нь суурин хүн амын 2.5 хувийг эзэлж байна. Энэ нь улсын дундажтай харьцуулахад 0.8 пунктээр бага үзүүлэлт юм. Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүний 20.2 мянга (55.1%) нь эрэгтэй, 16.5 мянга (44.9%) нь эмэгтэйчүүд байна.

Тооллогоор нийт 18.3 мянган төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн тоологдсон нь өмнөх тооллогоос 72.8 хувиар өссөн байна. Харин олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс 18.4 мянга байгаа нь өмнөх тооллогоос 31.4 хувиар буурсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүдийн 52.8 хувь нь төрөлхийн, 57.3 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байгаа бол хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн 47.2 хувь нь төрөлхийн, 42.7 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд нийслэлийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрөлд ихээхэн өөрчлөлт оржээ. Тодруулбал, төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эзлэх хувь 2010 оноос 21.6 пунктээр өссөн бол эсрэгээр мөн тийм хэмжээгээр олдмол хөгжлийн бэрхшээл буурсан аж. Үүнд агаар, хөрсний бохирдол, хүнсний бүтээгдэхүүний чанар, иргэдийн эрүүл мэнд гэх мэт олон хүчин зүйл нөлөөлсөн нь лавтай. Иймээс цаашид үүсээд буй нөхцөл байдлыг гүнзгийрүүлэн судалж, баталгаажуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хөгжлийн бэрхшээлийн төрлийг хэлбэрээр нь ангилж үзвэл ярианы бэрхшээлтэй хүмүүсийн дийлэнх буюу 86.0 хувь нь, сэтгэцийн болон сонсголын бэрхшээлтэй гурван хүн тутмын хоёр нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй байна.

ГАР УТАС, ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИД

Мэдээллийн технологийн хурдацтай хөгжлийн энэ цаг үед гар утас, интернэт нь хүн амын өдөр тутмын өргөн хэрэглээ болоод байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллогоор Улаанбаатар хотын 6, түүнээс дээш насны 1 136.6 мянган (91.2%) хүн гар утас, 947.2 мянган (76.0 %) хүн интернэт хэрэглэж байна.

Эдийн засгийн идэвхтэй хүн амын 99.5 хувь нь гар утас, 90.5 хувь нь интернет хэрэглэж байгаа бол эдийн засгийн идэвхгүй хүн амын 96.0 хувь нь гар утас, 70.8 хувь нь интернет хэрэглэж байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Арван тав, түүнээс дээш насны хүн амын 59.3 хувь буюу 587.2 мянган хүн ажиллах хүчинд багтаж, 2010 оны үетэй харьцуулахад 7.4 пунктээр өссөн байна.

Ажил эрхэлдэг хүн амын тоо 501.9 болж 2010 оноос 110.4 мянган хүнээр (28.2%) өссөн нь эерэг үр дүн байлаа. Хүйсээр нь авч үзвэл эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн хувь өмнөх тооллогоос 34.0 хувиар өссөн байна.

Хүйсийн хувьд эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо бүх дүүрэгт эмэгтэйчүүдийнхээс өндөр байна.

Арван тав, түүнээс дээш насны хүн амын 50.7 хувь нь ажил эрхэлж байгаа нь улсын дунджаас 3.1 пунктээр доогуур байна. Энэ нь нэгдүгээрт, нийслэлд их, дээд сургууль олноор төвлөрч, суралцагсдын тоо байнга нэмэгдэж байгаа, хоёрдугаарт, хүн ам хэт төвлөрснөөс үүдэн ажлын байрны олдоц ховор байгаа, гуравдугаарт, хэдийгээр сүүлийн гурван жилд Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгалыг тодорхой хэмжээгээр хязгаарласан боловч өмнөх он жилүүдэд шилжин ирэгчдийн тоо өндөр байсан зэрэгтэй холбоотой.

Улаанбаатар хотын хүн ам улсын хүн амын 45.9 хувийг эзэлж, хувийн жин нь жилээс жилд нэмэгдэж байгаа боловч ажил эрхэлдэг хүний хувийн жин хүн амын өсөлтөө даган төдийлэн хурдацтай нэмэгдэж чадахгүй байна.

Өнгөрсөн гурван тооллогын дүнгээс харахад 15-19 насны ажил эрхэлдэг хүний тоо тогтмол буурч байна. Үүнийг энэ насныхны сургуульд хамрагдалтын түвшин нэмэгдсэнтэй холбон тайлбарлаж болно.

Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын 18.3 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 10.5 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн, 10.0 хувь нь боловсролын салбарт ажиллаж байгаа нь бусад салбараас хамгийн өндөр юм.

Улаанбаатар хотын хэмжээнд 2020 онд ажилгүйчүүдийн тоо 85.2 мянгад хүрч, өмнөх тооллогын үеэс 24.5 мянган (40.3%) хүнээр нэмэгджээ. Арван тав, түүнээс дээш насны хүн амд ажилгүйчүүдийн эзлэх хувь 14.5 болж, улсын дүнгээс 4.6 пунктээр өндөр, өмнөх тооллогын үеийнхээс 1.1 пунктээр өссөн дүн гарав.

Нийслэлд 2020 оны тооллогоор ажиллах хүчнээс гадуурх 402.2 мянган хүн тоологдож, 2010 онтой харьцуулахад 4.1 пунктээр буурсан эерэг үр дүн гарчээ.

Ажиллах хүчнээс гадуурх хүн амын шалтгааныг 2010 онтой харьцуулахад тэтгэвэрт гарсан хүний тоо 31.0 хувь, бусад шалтгаанаар ажил эрхлээгүй хүн 24.2 хувь, ажиллах сонирхолгүй хүний тоо 4.6 хувиар өссөнөөс бусад шалтгаан бүгд буурсан байна.

ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр 6, түүнээс дээш сарын хугацаагаар гадаадад оршин суугаа 91 168 иргэн тоологдож 2010 оноос 6.3 хувиар өсжээ.

Тооллогын үед гадаадад байнга оршин суугаа хүмүүсийн 45.4 хувь нь суралцахаар, 8.0 хувь нь суурьшихаар, 13.4 хувь нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллах, 2.2 хувь нь албан томилолтоор, 14.9 хувь нь ажиллахаар, 13.6 хувь нь гэр бүлийн шалтгаанаар, 2.5 хувь нь бусад шалтгаанаар гадаадад оршин сууж байна.

Гадаадад тоологдсон иргэдийн 2 хүн тутмын 1 нь буюу 53.1 хувь нь Ази, Номхон далайн бүс нутагт, 4 хүн тутмын 1 нь буюу 25.7 хувь нь Европ тивд суугаагаар тоологдсон байна.

ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, НӨХЦӨЛ

Монгол Улсад хүн ам орон сууцны тооллогоор нийт 897.4 мянган өрх тоологдсоноос 411.4 мянган өрх буюу нийт өрхийн 45.8 хувь нь нийслэл Улаанбаатар хотод амьдарч байгаа нь өмнөх үеийн тооллоготой харьцуулахад 109.2 мянган өрхөөр буюу 36.1 хувиар нэмэгджээ.

Нийт өрхийн 22.2 хувь нь Монголын ард түмний уламжлалт сууц болох гэрт, 77.3 хувь нь байшинд, 0.5 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Улсын дунджаас гэрт амьдардаг

өрхийн хувь 16.0 пунктээр доогуур бол байшинд амьдардаг өрхийн хувь 16.4 пунктээр дээгүүр байна.

Гэрт амьдардаг өрхийн хувь өмнөх тооллогын үеийнхээс 6.8 пунктээр буурсан бол байшинд амьдардаг өрхийнх 7.7 пунктээр нэмэгджээ. Энэ нь сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотод гэр хорооллыг дахин төлөвлөх, орон сууцжуулах ажил хийгдэж байгаа, мөн өнгөрсөн арван жилд шинээр орон сууцны хорооллууд ихээр баригдаж байгаатай холбоотой юм. Тооллого хооронд нийтийн байранд амьдардаг өрхийн тоо 2.6 дахин буурчээ. Мөн сууцны тусдаа байшин багагүй өссөн нь иргэд өөрсдөө байшин барьж суух хандлагатай болсны нэг илрэл юм.

Улаанбаатар хотын нийт өрхийн 99.4 хувь нь хувийн өмчийн (99.0 хувь нь иргэний, 0.4 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын) сууцанд амьдарч байгаа нь 2010 оныхоос 0.7 пунктээр нэмэгджээ

Нийслэлийн хэмжээнд амьдарч байгаа нийт 411.4 мянган өрхийн 10.3 хувь буюу 42.3 мянган өрх өөрийн гэсэн сууцгүй байна. Үүнээс 5.5 хувь нь бусдын сууцанд түрээстэй, 4.4 хувь нь бусдын сууцанд түрээсгүй амьдарч байна.

Улаанбаатар хотын нийт өрхийн 99.5 хувь нь төвлөрсөн систем, 0.3 хувь нь сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж болон бага оврын цахилгаан үүсгүүрээр цахилгааны хэрэгцээгээ хангаж байна.

Улаанбаатар хотод 91.2 мянган өрх гэрт амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеэс 4.2 хувиар буюу 3.7 мянган өрхөөр нэмэгджээ. Гэрт амьдардаг өрхийн 83.0 хувь нь 5 ханатай гэрт амьдарч байна. Эндээс монголчууд таван ханатай гэрт түгээмэл амьдардаг нь харагдаж байна.

Гэрт амьдардаг 91.2 мянга өрхийн 96.6 хувь нь энгийн нүхэн жорлон хэрэглэдэг нь хамгийн өндөр хувьтай байна.

Гэрт амьдардаг өрхийн 96.6 хувь нь хатуу хог хаягдлаа үйлчилгээний байгууллагаар зөөвөрлөдөг гэсэн хариулт өгсөн ба энэ хариултын хувь өмнөх тооллогоос 8.9 пунктээр нэмэгдсэн эерэг үр дүн гарчээ. Гэхдээ хатуу хог хаягдлаа хаях тогтсон цэггүй өрх 1.9 хувь, шатаадаг болон булдаг 86 өрх (0.1 хувь) байна.

Нийслэлийн гэрт амьдардаг өрхийн 86.5 хувь нь зориулалтын цооногт бохир усаа асгадаг бол 13.5 хувь нь задгай асгадаг аж.

Гэрт амьдардаг өрхийн 99.8 хувь нь шаардлага хангасан ундны эх үүсвэрээс ундны усаа авч байгаа нь 2010 оны тооллогын дүнгээс 6.7 пунктээр нэмэгджээ. Эндээс Улаанбаатар хот өнгөрсөн арван жилийн хугацаанд өрхийг шаардлага хангасан усаар хангах ажлыг бараг шийдэж чадсан гэж дүгнэж болохоор байна.

Байшинд амьдардаг 317.8 мянган өрхийн 68.0 хувь нь 40-өөс дээш квадрат метр талбайтай сууцанд амьдарч байгаа нь байшинд амьдардаг өрхийн хамгийн их хувийг эзэлж байгаа ба өмнөх тооллогын дүнгээс даруй 20.2 пунктээр өссөн байна

Байшинд амьдардаг өрхийн 62.5 хувь төвлөрсөн халаалтын системд холбогдсон байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 7.5 пунктээр өссөн байна.

Байшинд амьдардаг өрхийг усан хангамжийн төрлөөр авч үзэхэд нийт өрхийн 62.2 хувь нь төвлөрсөн усан хангамжид холбогдсон. Үүнээс 61.6 хувь нь халуун, хүйтэн устай тохилог нөхцөлд амьдарч байна.



ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН ОНЦЛОГ, УДИРДЛАГА

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН ОНЦЛОГ

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогыг зохион байгуулж явуулахдаа Монгол Улсын “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг мөрдөж тооллогын үе шат бүрд мэдээллийн технологийн ололт, дэвшлийг өргөн ашигласан төдийгүй уг хуулийн 4.1.1 болон 4.1.2 заалтуудад заасан аргуудыг хослуулан явуулсан. Нийт өрхийн 10 хувийн мэдээллийг дэлгэрэнгүй асуулгын маягтаар сонгогдсон өрх бүрд орж (уламжлалт арга), үлдсэн 90 хувийн мэдээллийг богино асуулга буюу Хүн ам, өрхийн мэдээллийн сан болон төрийн байгууллагуудын мэдээллийн санд тулгуурлан бүртгэлд суурилан цуглуулсан.

Монгол Улсад статистикийн байгууллагын үндэс суурь тавигдсан 1924 оноос хойш 1935, 1944, 1956, 1963 онуудад хүн амын тооллого хийсэн бол улс хоршооллын байгууллагын орон сууцны фондын тооллогыг 1969 онд явуулсан байдаг. Олон улсын нийтлэг аргачлалын дагуу хүн ам болон орон сууцны тооллогыг нэгтгэн 1969 оноос хойш 10 жилийн давтамжтайгаар хийх болж 1979, 1989, 2000, 2010, 2020 онуудад явуулсан бол Байшин, орон сууцны тооллогыг 2019 онд тусад нь зохион байгууллаа.

Байшин, орон сууцны тооллогоор хүн амьдран суух зориулалттай бүх байшин, орон сууцны сан хөмрөгийг бүрэн тодорхойлж, орон сууцны хийц, ашиглалт, хүчин чадал, дэд бүтцийн хүртээмжийн талаарх хаягт суурилсан дэлгэрэнгүй мэдээллийн сантай болсон. Өөрөөр хэлбэл төрийн болон төрийн бус байгууллага, үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчид, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн судлаачдад нэн хэрэгцээтэй олон улсын түвшинд зэрэгцүүлж харьцуулагдах зарчмыг хангасан, шаардлагад нийцсэн мэдээллийн нарийвчилсан эх үүсвэрийг шинэчлэн гаргаснаар ихээхэн онцлогтой тооллого байлаа.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 76

Төрийн ордон, Улаанбаатар хот

Тооллогын тов тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хүн ам, орон сууцны улсын ээлжит тооллогын товыг 2020 оны 01 дүгээр сарын 08-наас 09-нд шилжих шөнийн "00" /тэг тэг/ цагаар тогтоосугай.



М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 77

Төрийн ордон, Улаанбаатар хот

Улсын комисс байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хүн ам, орон сууцны ээлжит тооллогыг зохион байгуулж явуулах Улсын комиссыг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Комиссын дарга:

Монгол Улсын Ерөнхий сайд

Комиссын орлогч дарга:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
Үндэсний Статистикийн хорооны дарга

Улсын комиссын гишүүд:

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
Барилга, хот байгуулалтын сайд
Батлан хамгаалахын сайд
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
Гадаад харилцааны сайд
Зам, тээврийн хөгжлийн сайд
Сангийн сайд
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
Хууль зүй, дотоод хэргийн сайд
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
Эрчим хүчний сайд
Эрүүл мэндийн сайд
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч

Нарийн бичгийн дарга:

Орон тооны албан хаагч /Хүн ам, орон сууцны тооллогын тухай хуулийн 13.4-т заасан шаардлагыг хангасан/

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН
ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ
ТООЛЛОГЫН УЛСЫН КОМИССЫН
ТОГТООЛ

2018 оны 2 сарын 22 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Аймаг, нийслэлийн тооллогын комиссын
бүрэлдэхүүнийг томилох тухай

Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 13.5.2-д заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогыг зохион байгуулж явуулах аймаг, нийслэлийн тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

1.1 Аймагийн тооллогын комиссын бүрэлдэхүүн:

Тооллогын комиссын дарга:	Засаг дарга
Тооллогын комиссын орлогч дарга:	Статистикийн хэлтсийн дарга
Гишүүд:	ИТХ-ын Нарийн бичгийн дарга Засаг даргын тамгын газрын дарга ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга ЗДТГ-ын Олон нийттэй харилцах албаны дарга ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн дарга ЗДТГ-ын Цэргийн штабын дарга Автотээврийн төвийн дарга Боловсрол, соёл, урлагийн газрын дарга Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Онцгой байдлын хэлтсийн дарга Оюуны өмч, улсын бүртгэлийн хэлтсийн дарга Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Цагдаагийн хэлтсийн дарга Эрүүл мэндийн газрын дарга Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга* Гаалийн албаны дарга* Гадаадын иргэн, харьяатын хэлтсийн дарга* Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга* Аймагийн төвийн сумын Засаг дарга

0000004

Нарийн бичгийн дарга: Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

* Тухайн аймгийн онцлогоос хамаарч нэмж оруулж болно.

1.2 Нийслэлийн тооллогын комиссын бүрэлдэхүүн:

Тооллогын Улсын
комиссын гишүүн
бөгөөд нийслэлийн
тооллогын комиссын
дарга:

Нийслэлийн Засаг дарга

Тооллогын комиссын
орлогч дарга:
Гишүүд:


Нийслэлийн Статистикийн газрын дарга
НИТХ-ын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын
албаны дарга
Хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн
ажлын албаны дарга
Нийслэлийн Засаг даргын тамгын газрын дарга
Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын дарга
Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газрын
дарга
Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга
Нийслэлийн Байгаль орчны газрын дарга
Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын
хорооны дарга
Нийслэлийн Боловсролын газрын дарга
Нийслэлийн Газрын албаны дарга
Нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газар
Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газрын дарга
Нийслэлийн Мэдээллийн технологийн газрын дарга
Нийслэлийн Нийгмийн халамжийн газрын дарга
Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын дарга
Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга
Нийслэлийн Тээврийн газрын дарга
Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга
Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий
төлөвлөгөөний газрын дарга
Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга
Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын
дарга
Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын
дарга
Нийслэлийн Цагдаагийн газрын дарга
Нийслэлийн Цэргийн штабын дарга

Нийслэлийн Нийгмийн даатгалын газрын дарга
Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга

Нарийн бичгийн
дарга:

Нийслэлийн Статистикийн газрын ахлах
мэргэжилтэн

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН
УЛСЫН КОМИССЫН ДАРГА,
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



У.ХҮРЭЛСҮХ

НИЙСЛЭЛИЙН ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

НИЙСЛЭЛИЙН ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

Тооллогын комиссын гишүүн
Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын
асуудал хариуцсан нэгдүгээр орлогч



С.АМАРСАЙХАН

Нийслэлийн тооллогын комиссын дарга
Нийслэлийн Засаг дарга бөгөөд
Улаанбаатар хотын Захирагч



Ш.АНХМАА

Тооллогын комиссын гишүүн
Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил,
нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч

НИЙСЛЭЛИЙН ТООЛЛОГЫН КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА



Ц.ЗАЯХҮҮ

Нийслэлийн тооллогын комиссын орлогч,
түр товчооны дарга
Нийслэлийн Статистикийн газрын дарга



Н.БАЙГАЛМАА

Нийслэлийн тооллогын комиссын
нарийн бичгийн дарга
Нийслэлийн Статистикийн газрын ахлах мэргэжилтэн

НИЙСЛЭЛИЙН ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮД



Т.ГАНТӨМӨР

Хотын Ерөнхий менежер бөгөөд
Захирагчийн ажлын албаны
дарга



Б.БАТБЯМБА

НИТХ-ын Тэргүүлэгчдийн
нарийн бичгийн дарга бөгөөд
Ажлын албаны дарга



М.ОТГОНБАЯР

Нийслэлийн Засаг даргын
Тамгын газрын дарга



Ж.БОЛДБААТАР

НЗДТГ-ын Цэргийн штабын
дарга



Ц.ТУЛГА

Нийслэлийн Хот байгуулалт,
хөгжлийн газрын даргын үүрэг
гүйцэтгэгч



Д.ЯДАМДОРЖ

Нийслэлийн Цагдаагийн
газрын дарга



Ж.ГАНТУЛГА

Нийслэлийн Боловсролын
газрын дарга



Ж.ТОГТОХБАЯР

Нийслэлийн Авто замын
хөгжлийн газрын дарга

НИЙСЛЭЛИЙН ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮД



Э.БОЛОРЧУЛУУН

Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны даргын үүрэг гүйцэтгэгч



О.ЧИНЗОРИГ

Нийслэлийн Мэдээлэл, технологийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч



Ч.БАТБИЛЭГ

Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч



Ж.ЧҮЛТЭМСҮРЭН

Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга



Г.АНХНЫБАЯР

Нийслэлийн Бүртгэлийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч



Т.ОЮУНЧИМЭГ

Нийслэлийн Нийгмийн халамжийн газрын дарга



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга



Б.ЦАЦРАЛ

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын даргын үүрэг гүйцэтгэгч



Х.БУЛГАА

Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газрын даргын үүрэг гүйцэтгэгч



П.БАТХҮЛЭГ

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга



Г.БОЛОРСҮХ

Нийслэлийн Нийгмийн даатгалын газрын дарга



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Спортын хорооны даргын үүрэг гүйцэтгэгч



Х.ЭРДЭНЭБИЛЭГ

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын даргын үүрэг гүйцэтгэгч



Р.ЭНХТАЙВАН

Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны дарга



Л.ТӨМӨРБААТАР

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Байгаль орчны газрын дарга

ДҮҮРГИЙН ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



Ж.АЛДАРЖАВХЛАН

ХУД-ийн тооллогын комиссын дарга
Хан-Уул дүүргийн Засаг дарга



Ж.ЭРДЭНЭБАТ

ЧД-ийн тооллогын комиссын дарга
Чингэлтэй дүүргийн Засаг дарга



С.ОДОНТУЯА

БГД-ийн тооллогын комиссын дарга
Баянгол дүүргийн Засаг дарга



Х.БОЛОРМАА

СБД-ийн тооллогын комиссын дарга
Сүхбаатар дүүргийн Засаг дарга



Т.БАЯСАХ

БЗД-ийн тооллогын комиссын дарга
Баянзүрх дүүргийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгч



Ж.САНДАГСҮРЭН

СХД-ийн тооллогын комиссын дарга
Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга



Ч.РАДНААБАЗАР

НД-ийн тооллогын комиссын дарга
Налайх дүүргийн Засаг дарга



Ц.САНДАГ-ОЧИР

БНД-ийн тооллогын комиссын дарга
Багануур дүүргийн Засаг дарга



С.ЭРДЭНЭБАЯР

БХД-ийн тооллогын комиссын дарга
Багахангай дүүргийн Засаг дарга

ТООЛЛОГЫН УЛСЫН КОМИСС

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Нийслэлийн тооллогын
комисс:

Нийслэлийн Засаг дарга

Аймгийн тооллогын
комисс:

Аймгийн Засаг дарга

Яамдын тооллогын
комисс

Нийслэлийн тооллогын
түр товчоо:

Нийслэлийн
статистикийн газрын
дарга

Аймгийн тооллогын түр
товчоо:

Аймгийн статистикийн
хэлтсийн дарга

Яамдын тооллогын
комисс

Дүүргийн тооллогын
комисс:

Дүүргийн Засаг дарга

Сумын тооллогын
комисс:

Сумын Засаг дарга

Дүүргийн тооллогын түр
товчоо:

Дүүргийн статистикийн
хэлтсийн дарга

Сумын тооллогын түр
товчоо:

Сумын Засаг даргын
орлогч

Хорооны тооллогын түр
товчоо:

Хорооны засаг дарга

Багийн тооллогын түр
товчоо:

Багийн Засаг дарга


ШАЛГАГЧ

ШАЛГАГЧ

ТООЛОГЧ

ТООЛОГЧ

ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ



ХҮН АМЫН ТОО, ХҮЙСИЙН ХАРЬЦАА

Хүн амын тоо гэдгийг энгийнээр хэлвэл, тодорхой хугацаанд тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа нийт хүмүүсийн тоо гэж ойлгож болох боловч НҮБ-ын аргачлалаар бэлэн болон суурин хүн амын тоо гэсэн хоёр өөр ойлголтоор тодорхойлдог. Нийт хүн ам буюу бэлэн хүн ам гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа болон гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын харьяат хүн амыг хамруулна. Харин суурин хүн амын тоо гэдэгт Монгол Улсын засаг захиргааны нэгжид 183 хоног буюу түүнээс дээш хугацаагаар оршин сууж байгаа хүн амыг ойлгоно.

Хүн амын тооны өөрчлөлт нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, ард түмний аж байдлын түвшин, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж зэрэг олон хүчин зүйлтэй уялдан хүн амын үндсэн үзүүлэлт болох төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөнөөр тодорхойлдог.

2020 оны ээлжит тооллогоор Улаанбаатар хотод 1 539 810 Монгол Улсын харьяат хүн ам тоологдлоо. Үүнээс 1 448 642 нь нийслэлийн нутаг дэвсгэрт оршин суугаа Монгол улсын харьяат иргэн, 91 168 нь гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын харьяат иргэн байна.

ЗУРАГ 2.1. УЛААНБААТАР ХОТЫН НИЙТ ХҮН АМЫН ТОО, 2020 ОН



Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр Улаанбаатар хотод Монгол Улсын харьяат хүн амын тоо 1 539.8 мянга болсон нь 2010-2020 оны хооронд буюу 10 жилийн хугацаанд 299.8 мянган хүнээр өсжээ. Энэ нь 2000-2010 оны тооллого хоорондын өсөлтөөс 1.6 дахин буурсан байна. Тооллого хоорондын хүн амын тооны өсөлт 1989-2000 онд 211.7 мянган хүн байсан бол 2000-2010 онд 479.9 мянган хүн болж 2.3 дахин нэмэгдэж байжээ. Сүүлийн 10 жилийн хүн амын өсөлтийн бууралтыг агаар орчны бохирдол, нийгмийн дэд бүтцийн хүртээмжгүй байдлыг харгалзан нийслэлийн Засаг даргын захирамжаар хүн амын шилжилт хөдөлгөөнийг 2017 оноос хязгаарласантай холбон тайлбарлаж болно. Учир нь тухайн үеийн нийслэлийн хүн амын өсөлтийн 50 гаруй хувийг орон нутгаас шилжин ирсэн хүн амын шилжилт хөдөлгөөн буюу механик өсөлт эзэлж байжээ.

ХҮСНЭГТ 2.1. УЛААНБААТАР ХОТЫН НИЙТ ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНООР

Тооллого явагдсан он	Хүн амын тоо (мян.хүн)			Хүйсийн харьцаа
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
1944	41.0	19.3	21.7	88.9
1956	118.4	62.9	55.5	113.3
1963	223.7	116.5	107.2	108.7
1969	267.4	133.3	134.1	99.4
1979	402.3	198.6	203.7	97.5
1989	548.4	271.2	277.2	97.8
2000	760.1	369.1	391.0	94.4
2010	1 240.0	597.3	642.7	92.9
2020	1 539.8	741.2	798.6	92.8

Улаанбаатар хотын хүн амын 48.1 хувь нь эрэгтэйчүүд, 51.9 хувь нь эмэгтэйчүүд байна. Хүйсийн харьцаа нь 100 эмэгтэйд ногдох эрэгтэй хүн амын тоог харуулдаг. Улаанбаатар хотын хувьд 2020 оны хүн ам, орон сууцны тооллогын дүнгээс харахад эрэгтэй, эмэгтэй хүн амын тоо ойролцоо түвшинд байгаа боловч хүйсийн харьцаа 2010 оны тооллогоос ялимгүй буурсан нь харагдаж байна.

Хүснэгтээс харахад 100 эмэгтэйд ногдох эрэгтэй хүн амын тоо 1956, 1963 оны тооллогоор хамгийн өндөр түвшинд байсан бол ялангуяа 1989 оноос хойш өнөөг хүртэл тасралтгүй буурсаар байна. Үүнд эрэгтэй, эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүүтэй байдал, гадаад, дотоод шилжих хөдөлгөөн зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг. Тодруулбал, гадаад руу явж байгаа ажиллах хүчний шилжих хөдөлгөөнд эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байдаг бол хот руу орон нутгаас суралцахаар ирэгчдийн дийлэнх хувийг эмэгтэйчүүд эзэлдэг ба тэдний ихэнх нь хотод үргэлжлүүлэн суурьшдаг байна. Түүнчлэн Монгол Улсын эдийн засгийн бас нэг гол тулгуур болох уул уурхайн хөгжилтэй уялдан ажиллах хүчний шилжилт явагдан, улмаар орд газруудыг түшиглэсэн хүн амын төвлөрөл үүсч, тэнд ажиллагчдын дийлэнх нь эрэгтэйчүүд байгаа нь ч нийслэлийн хүйсийн харьцаа буурахад нөлөөлсөн байж болох юм.


ХҮН АМЫН ӨСӨЛТ

Хүн амын тооны өөрчлөлтийг цэвэр өсөлт (төрөлт, нас баралтын зөрүү) болон механик өсөлт (шилжих хөдөлгөөн)-өөр тодорхойлдог. Нийслэлийн хүн ам 2010-2020 оны хоорондох хугацаанд 24.2 хувиар өсөж, жилийн дундаж өсөлт 2.7 хувь болж, 2000-2010 оны жилийн дундаж өсөлтөөс ойролцоогоор 2 дахин буурчээ.

Тооллого хоорондын хүн амын өсөлт нь тухайн үеийн нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн бодлого, хөгжлөөс ихээхэн хамаардаг. Улаанбаатар хотын хүн амын жилийн дундаж өсөлт 1940-өөд оноос 1960-аад оны дунд үе хүртэл 7.1-17.2 хувь хүртэл огцом өсөж байснаа 1960-аад оны дунд үеэс 2000 он хүртэл 2.8-4.6 хувийн хооронд тогтворжиж, 2000-2010 оны хооронд дахин нэмэгдэж 5.7 хувь хүрч байв. Нийгмийн хөгжлийн зүй тогтлоос үүдэн хүн ам шилжин суурьших нь хотын хүн амын өсөлттэй салшгүй холбоотой. 1940-өөд оны аж үйлдвэржилтийн үеэс эхлэн хотын хүн ам тасралтгүй нэмэгдсээр ирсэн. Ялангуяа 1960-аад оноос Улаанбаатар хотын үйлдвэржилт эрчимжиж, 20 гаруй жилд 150 мянган хүн Улаанбаатарт шилжин ирж байжээ. 1990-ээд оноос эхлэн Монгол Улс нийгэм, эдийн засаг, улс төрийн шинэ тогтолцоонд шилжиж нийгэм, хувь хүмүүсийн амьдралд ихээхэн өөрчлөлт орж, улмаар хотын хүн амын өсөлт, хотжилтын үйл явцад нөлөөлөгч хүчин зүйлс нэлээд өөрчлөгдсөн. Үндсэн хуулиараа Монголын иргэн суурьших газраа өөрөө сонгох эрхтэй болсон.

Нийслэлийн хүн ам 1998 оноос огцом өссөний гол шалтгаан нь байгалийн гамшигт үзэгдлүүд малчдад хүндээр тусч, малгүй болсон, мөн боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хөдөөд тааруу байдгаас улбаалан хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн улам эрчимжсэн гэдгээр тайлбарлагдана.

ЗУРАГ 2.2. ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР*



*Гадаадад 6, түүнээс дээш хугацаагаар оршин суугаа Монгол Улсын харьяат иргэдийн тоо орсон.

Жилийн дундаж өсөлт 2010-2020 онд өмнөх 2000-2010 оныхоос 3.0 пунктээр буурсан нь дээр хэлсэнчлэн шилжих хөдөлгөөнийг хязгаарласантай холбоотой. Өөрөөр хэлбэл, Улаанбаатар хотын хүн амын өсөлтийн дийлэнхийг бүрдүүлэгч шилжилт хөдөлгөөн буурсан нь тооллого хоорондын жилийн дундаж өсөлт буурах гол шалтгаан болжээ.

Хүн амын жилийн дундаж өсөлтийг тодорхойлогч дараагийн хүчин зүйл бол хүн амын ердийн өсөлт буюу төрөлт, нас баралтын түвшин юм. Улаанбаатар хотод 2010-2019 онд нийтдээ 357.8 мянган хүүхэд төрж, 77.5 мянган хүн нас барж, ердийн хөдөлгөөний цэвэр өсөлт 280.3 мянган хүн болсон байна.

ХҮСНЭГТ 2.2. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТ, 2010-2019 ОН

Он	Ерөнхий коэффициент		
	Төрөлт	Нас баралт	Цэвэр өсөлт
2010	23.7	6.2	17.5
2011	23.9	6.1	17.7
2012	27.4	6.2	18.3
2013	29.9	5.3	24.6
2014	27.5	5.6	21.9
2015	31.0	5.3	25.8
2016	27.5	5.1	22.4
2017	24.7	5.2	19.5
2018	23.9	5.1	18.8
2019	23.4	5.1	18.3

Эх үүсвэр: Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2019 он

Төрөлтийн ерөнхий коэффициент 2015 оноос хойш тогтмол бага хэмжээгээр буурч байгаа бол нас баралтын ерөнхий коэффициент нэг хэвэндээ, онцын өөрчлөлтгүй байна. Засгийн газраас авч хэрэгжүүлж буй бодлогууд тухайлбал, тэтгэмж болон нийгмийн халамжийн арга хэмжээнүүд төрөлтийн түвшинг огцом бууруулахгүй байхад эерэгээр нөлөөлж байна.

ХҮСНЭГТ 2.3. СУУРИН ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Дүүрэг	Хүн амын тоо (мян.хүн)		2010/2000 (%)	2020/2010 (%)	Жилийн дундаж өсөлт (%)	
	2010	2020			2000-2010	2010-2020
БҮГД	1 154.3	1 466.1	151.9	127.0	4.7	3.0
Багануур	22.4	28.6	106.1	127.7	0.6	3.1
Багахангай	3.4	4.1	96.4	122.6	-0.3	2.3
Баянгол	178.7	225.8	130.0	126.4	2.7	2.9
Баянзүрх	277.5	361.7	188.2	130.3	8.0	3.4
Налайх	30.2	37.6	127.7	124.9	2.5	2.8
Сонгинохайрхан	257.5	327.6	166.9	127.2	6.1	3.0
Сүхбаатар	127.8	144.4	138.6	113.0	3.5	1.4
Хан-Уул	110.3	187.3	154.4	169.8	4.9	7.8
Чингэлтэй	146.5	149.0	140.4	101.7	3.7	0.2

Тооллого хооронд Улаанбаатар хотын дүүргүүдийн хүн амын өсөлт харилцан адилгүй байна. Тухайлбал, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн хувьд хүн ам 0.2-1.4 хувь буюу хамгийн бага өсөлттэй байхад Хан-Уул дүүргийн хүн амын өсөлт 7.8 хувь байгаа нь Улаанбаатар хотын дунджаас 2.6 дахин өндөр өсөлттэй байна. Үүнийг сүүлийн жилүүдэд Хан-Уул дүүрэгт орон сууцны хорооллууд ихээр баригдсантай холбон тайлбарлаж болно.

Энэ удаагийн тооллогыг 2010 онтой харьцуулахад хүн амын жилийн дундаж өсөлт Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдэд 2.1-4.6 пунктээр буурсан бол Багануур, Багахангай, Хан-Уул дүүрэгт 2.5-2.9 пунктээр нэмэгдсэн байна.

ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Хүн амын нас, хүйсийн бүтцийг судлах нь хүн ам, нийгэм, эдийн засгийн бодлого боловсруулах, хүн амын хүчин зүйлсийг нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинжилгээнд тусгахад чухал ач холбогдолтой. Хүн амын нас, хүйсийн байдал нь нийгэм, эдийн засаг, соёлын асуудлуудтай нягт холбоотой учраас түүнийг шинжлэх шаардлагатай байдаг. Тухайлбал, сургуульд хамрагдалт, ажиллах хүчний нөөц, гэрлэх, төрөх, шилжих гэх мэт. Түүнчлэн зарим нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ нь нас хүйсийн бүтцээс хамааран өөр өөр байдаг. Нас хүйсийн бүтцийн мэдээлэл нь нийгмийн чиг хандлагыг тайлбарлах, зах зээлийг тодорхойлох, ирээдүйн төлөвлөлт хийхэд чухал ач холбогдолтой. Мөн нийгмийн мөн чанар, функцийг ойлгоход чухал байдаг. Үүний зэрэгцээгээр хүн амын түүхэн хөгжил хувьслыг болон ирээдүйн хэтийн төлвийг тодорхойлно.

Хүн амын бүтэц нь хүн амын өсөлт, өөрчлөлтийн бүрэлдэхүүн хэсгүүд болох төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөнөөс хамаардаг.

Хүн амын тоонд насны бүлэг бүрийн хүн амын эзлэх хувийн жин 2020 онд 2010 оныхоос зарим насанд ялангуяа хүүхэд, залуучуудын хувьд нэлээд өөрчлөлт гарсан нь харагдаж байна. Тодруулбал, 0-9 насанд 2010 оныхоос эрэгтэйчүүд 7.5 пункт, эмэгтэйчүүд 6.5 пунктээр тус тус өссөн байна. Энэ нь өнгөрсөн арван жилийн хугацаанд төрөлтийн хэмжээ 2016 он хүртэл өндөр байсан, түүнээс хойших жилүүдэд ч хэдийгээр төрөлтийн ерөнхий коэффициент бага зэрэг буурсан ч бодит тоогоор нэмэгдэж байсантай холбон тайлбарлаж болно. Мөн 30-39 насанд аль ч хүйсийн хувьд бага зэрэг өссөн дүнтэй байна. Үүнийг орон нутгаас шилжин ирж, суралцаж улмаар суурьшин амьдарч байгаа залуучуудын шилжин ирэлттэй холбон гэж үзэж байна.

Хүйсийн харьцаа насны бүлэг ахих тутам мэдэгдэхүйцээр буурч байгаа нь эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалт харьцангуй ялгаатай (2019 оны байдлаар дундаж наслалт эрэгтэй- 67.06, эмэгтэй 75.11) байдагтай холбоотой. Дэлхийн улс орнуудын хувьд ч энэ зүй тогтол адил байдаг боловч тухайн орны хүн амын насжилттай холбоотойгоор хүйсийн харьцаа буурч эхлэх нас харилцан адилгүй байдаг. Хүйсийн харьцааг төрсөн хүүхдийн хувьд авч үздэг бөгөөд дэлхийн бусад орны нэгэн адил Улаанбаатар хотод сүүлийн таван жилд 100 эмэгтэй хүүхэд тутам 104-108 эрэгтэй хүүхэд мэндэлж байна.

Насны бүлгээр авч үзвэл нийслэлд 2020 оны тооллогоор 0-19 насанд 100 эмэгтэй хүүхэд ногдох эрэгтэй хүүхэд, өсвөр насныхны тоо 100-аас дээш байснаа нас ахих тусам аажмаар буурч байна. Гэхдээ энд анхаарал татсан нэг зүйл бол 30-39 насанд хүйсийн харьцаа бага зэрэг нэмэгджээ.

ХҮСНЭГТ 2.4. ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХҮЙСИЙН ХАРЬЦААГААР, 2010, 2020 ОН


Насны бүлэг	2010		2020		Хүйсийн харьцаа ¹	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	2010	2020
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	92.9	92.8
0-4	10.9	9.9	12.6	11.1	102.6	105.3
5-9	7.3	6.6	12.4	11.0	104.4	104.6
10-14	7.5	6.9	8.5	7.6	102.3	104.1
15-19	10.5	10.5	6.1	5.5	94.0	103.4
20-24	13.8	13.8	6.5	6.2	93.7	96.5
25-29	10.1	10.0	8.7	8.7	94.3	92.8
30-34	8.5	8.4	10.6	10.5	95.6	93.8
35-39	7.6	7.4	8.2	8.3	95.6	92.1
40-44	6.3	6.5	6.8	7.1	91.5	88.3
45-49	5.7	6.0	5.7	6.2	89.2	86.0
50-54	4.3	4.8	4.4	5.2	84.0	80.1
55-59	2.5	2.9	3.7	4.6	80.1	75.8
60-64	1.8	2.1	2.5	3.2	76.5	70.1
65-69	1.3	1.6	1.4	1.9	78.3	65.2
70+	1.9	2.6	1.9	2.9	66.3	60.7

¹ 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо

Хүн амын нас, хүйсийн бүтцийг хүн амын суваргаар харуулах нь хамгийн тохиромжтой арга юм. Энэ нь насны бүлэг бүр дэх эрэгтэй, эмэгтэй хүн амыг хүвийн жин буюу тоогоор харуулдаг хэвтээ байрлалтай тэгш өнцөгт дүрслэл юм. Суурь хэсэгт залуу насны бүлгийн хүн амыг, зүүн гар талд эрэгтэй хүн ам, баруун гарт эмэгтэй хүн амыг байрлуулах зарчимтай. Хүн амын насны бүтцээс хамааран суварга нь өөр өөр хэлбэртэй байж болно.

Хүн амын нас, хүйсийн 2020 оны суваргыг 2010 онтой харьцуулан харахад, суурь хэсгээрээ өргөссөн буюу төрөлтийн түвшин өсөж, нас баралтын түвшин буурч байгааг харж болно. Түүнчлэн 2020 оны суваргын 15-29 насанд нарийсч байгаа нь 1990-ээд он, мөн 1997-2002 оны үеийн төрөлтийн бууралттай холбоотой юм. Харин 2020 оны суваргын 30-34 насанд нэлээд өргөн байгаа нь нэг талаас 2010 онд өргөн байсан 15-24 насныхны шилжилтээс, нөгөө талаар дээд сургуульд суралцах, ажлын байртай болох зорилгоор 15-24 насны хүн ам шилжих хөдөлгөөнд орж, сургуулиа дүүргэсний дараа Улаанбаатарт хотод суурьшин ажиллаж, амьдрах нь түгээмэл байгаатай холбоотой. Суваргаас 50, түүнээс дээш насны эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдийнхээс харьцангуй бага байна. Энэ нь монгол эрэгтэйчүүдийн нас баралт залуужиж байгаагийн нэг илрэл юм.


ЗУРАГ 2.3. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН




Нийслэлийн хүн амын хүйсийн харьцаа 2010 оноос 0.1 пунктээр буурсан байна. Дүүргүүдээр авч үзвэл 2020 онд хүйсийн харьцаа Баянгол дүүрэгт хамгийн бага буюу 88.1% байгаа нь Улаанбаатар хотын дунджаас 4.7 пунктээр доогуур, Багахангай дүүрэгт хамгийн өндөр буюу 101.1 нийслэлийн дунджаас 8.3 пунктээр өндөр байна. Энэхүү үзүүлэлтийг 2010 онтой харьцуулахад Багануур, Сонгинохайрхан дүүргийн хүн амын хүйсийн харьцаа бага зэрэг нэмэгдэж, харин Багахангай, Баянгол, Сүхбаатар, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн хүн амын хүйсийн харьцаа өмнөх тооллогын үеийнхээс бага зэрэг буурсан байна.

УЛСЫН ХАРЬЯАЛАЛ, ҮНДЭС, УГСАА, ШАШИН

НИЙСЛЭЛД СУУГАА
МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ **1 448 642**
98.8%



НИЙСЛЭЛД СУУГАА
ГАДААДЫН ХАРЬЯАТ **17 456**
1.2%



ХАЛХ
91.2%



ЗАХЧИН
0.8%



ДӨРВӨД
2.0%



КАЗАК
0.7%



БАЯД
1.5%



ДАРЬГАНГА
0.6%



БУРИАД
1.1%



УРИАНХАЙ
0.5%

ХҮН АМЫН ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ

Улаанбаатар хотод 2020 оны хүн ам, орон сууцны тооллогоор 1 466 125 хүн тоологдсоноос 1 448 642 (98.8%) нь Монгол Улсын харьяат, 17 456 (1.2%) нь гадаадын харьяат иргэн, аль нэг улсын харьяалалгүй 27 хүн байна.

ЗУРАГ 3.1. ХҮН АМЫН ТОО, ИРГЭНИЙ ХАРЬЯАЛЛААР, 2020 ОН



ХҮН АМЫН ҮНДЭС УГСАА

Монгол Улсын харьяат иргэдийн үндэс угсааны талаарх мэдээллийг өмнөх тооллогод 29 бүлгээр цуглуулж байсан бол 2020 оны тооллогоор 31 бүлэг болгон өргөжүүлсэн. Энэхүү бүлэгт гадаадад оршин суугаа Монгол Улсын харьяат иргэд ороогүй бөгөөд “Бусад” гэсэн бүлэгт 100-аас цөөн хүнтэй үндэс угсаатныг оруулж нэгтгэсэн болно.

ХҮСНЭГТ 3.1. МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН ТОО, ҮНДЭС УГСАА, ХУВИАР, 2010, 2020 ОН

Үндэс угсаа	2010		2020 ¹	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ-БҮГД	1 144 954	100.0	1 448 642	100.0
Халх	1 036 288	90.5	1 321 660	91.2
Дөрвөд	22 648	2.0	28 712	2.0
Баяд	18 368	1.6	21 606	1.5
Буриад	17 238	1.5	16 352	1.1
Захчин	8 608	0.7	10 958	0.8
Казак	9 817	0.9	10 570	0.7
Дарьганга	4 114	0.4	8 046	0.6
Урианхай	6 123	0.5	7 074	0.5
Торгууд	5 706	0.5	6 715	0.5
Өөлд	6 037	0.5	5 660	0.4
Дархад	1 972	0.2	2 398	0.2
Мянгад	1 958	0.2	2 242	0.1
Хотон	1 347	0.1	1 608	0.1
Сартуул	588	0.1	1 228	0.1
Хотгойд	1 637	0.1	786	0.0
Барга	705	0.1	602	0.0
Бусад	1 453	0.1	973	0.1
Бусад үндэстэн (Монголын харьяат гадаад)	347	0.0	1 452	0.1

¹ Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн тоо ороогүй

Монгол Улсын харьяат 1 448 642 иргэний 91.2 хувийг Халхууд эзэлж, өмнөх тооллогын үеийнхээс 285 372 хүнээр буюу 0.7 пунктээр өссөн байна. Өнгөрсөн арван жилийн хугацаанд Халхуудаас гадна өсөлт үзүүлсэн угсаатан бол Дарьгангачууд (0.2 пункт) байлаа. Харин Казах, Буриад, Баяд, Өөлд, Баргуудын нийт хүн амд эзлэх хувь 0.1-0.4 пунктээр буурсан байна. Ерөнхийдөө Монгол Улсын харьяат хүн амд үндэс угсаатны эзлэх хувь хоёр тооллогын хооронд маш бага өөрчлөлттэй байсан гэж дүгнэж болно.

Хүн амын насны бүтцийг судлах нь тухайн үндэс угсаатны цаашид өсөх, буурах талаар хамгийн эхний таамаглал дэвшүүлэх боломж олгодог.

ХҮСНЭГТ 3.2. ХҮН АМЫН ТОО, ҮНДЭС УГСАА, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 2020 ОН

Үндэс угсаа	Насны бүлэг						
	Бүгд	0-14	15-24	25-34	35-44	45-54	55+
МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ-БҮГД	100.0	32.7	11.8	18.4	14.8	10.7	11.6
Халх	100.0	33.2	12.0	18.2	14.7	10.6	11.3
Дөрвөд	100.0	26.1	10.5	21.6	15.7	12.4	13.7
Баяд	100.0	25.6	10.4	21.0	16.0	12.2	14.8
Буриад	100.0	25.4	8.9	18.7	15.6	12.5	18.9
Захчин	100.0	24.8	10.9	22.0	16.6	11.3	14.4
Казах	100.0	34.8	11.5	20.9	13.8	9.3	9.7
Дарьганга	100.0	15.2	7.7	25.8	19.9	13.8	17.6
Урианхай	100.0	26.4	9.7	21.2	15.7	11.7	15.3
Торгууд	100.0	29.2	9.5	19.5	15.7	11.5	14.6
Өөлд	100.0	27.5	9.6	19.1	16.8	11.4	15.6
Дархад	100.0	27.0	9.3	24.5	15.9	11.2	12.1
Мянгад	100.0	23.7	13.5	19.4	18.6	11.2	13.6
Хотон	100.0	32.7	11.4	23.9	12.4	10.6	9.0
Сартуул	100.0	19.7	13.3	18.6	17.5	14.2	16.7
Хотгойд	100.0	70.4	9.0	6.2	4.5	4.7	5.2
Барга	100.0	28.0	5.3	29.1	15.3	7.5	14.8
Бусад	100.0	35.8	9.8	17.5	13.3	9.2	14.4
Бусад үндэстэн (Монголын харьяат гадаад)	100.0	49.0	10.6	14.8	9.9	6.9	8.8

Хотгойд (70.4%), Казах (34.8%), Халх (33.2%), Хотон (32.7%) угсаатны дунд 0-14 настай хүүхдийн эзлэх хувийн жин өндөр байгаа нь тэдний дунд төрөлт өндөр байгаатай холбоотой юм. Мөн Мянгад (13.5%), Сартуул (13.3%), Халхуудын (12.0%) дунд 15-24 настай залуусын эзлэх хувийн жин, Барга (29.1%), Дарьганга (25.8%), Дархадчуудын (24.5%) дунд 25-29 настай залуусын хувь бусдаас өндөр байна. Энд анхаарал татсан нэг үзүүлэлт бол бусад угсаатан болон бусад Монгол Улсын харьяат үндэстнүүдийн 0-14 насны хүүхдүүдийн тоо бусдаас харьцангуй өндөр байгаа явдал юм. Түүнчлэн 55, түүнээс дээш насны иргэдийн тухайн угсаатанд эзэлж байгаа хувь Буриад (18.9%), Дарьганга (17.6%), Сартуул (16.7%)-уудын хувьд бусдаас өндөр байна.

ХҮСНЭГТ 3.3. УЛААНБААТАР ХОТЫН 10, ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ҮНДЭС УГСАА, ХУВИАР, 2020 ОН

Үндэс угсаа	10, түүнээс дээш насны хүн ам	Боловсролын түвшин						
		Дээд	Тусгай мэргэжлийн дунд	Техник мэргэжлийн	Бүрэн дунд	Суурь	Бага	Боловсролгүй
МОНГОЛ УЛСЫН ХАРЬАТ- БҮГД	100.0	36.3	5.3	3.0	32.7	9.4	9.2	4.1
Халх	100.0	36.0	5.3	2.9	32.7	9.5	9.4	4.2
Дөрвөд	100.0	37.1	5.8	3.5	34.5	9.3	6.7	3.1
Баяд	100.0	41.4	6.0	3.1	32.3	8.1	6.2	2.9
Буриад	100.0	42.1	6.2	3.1	31.3	8.3	6.2	2.8
Захчин	100.0	38.6	5.7	3.2	35.7	8.1	5.8	2.9
Казах	100.0	36.4	4.0	6.4	26.8	11.1	10.3	5.0
Дарьганга	100.0	47.0	6.5	3.0	33.0	5.4	3.4	1.7
Урианхай	100.0	32.6	6.0	4.1	37.0	10.2	6.9	3.2
Торгууд	100.0	38.6	6.5	3.0	31.3	8.0	8.9	3.7
Өөлд	100.0	44.2	6.3	3.0	29.4	7.1	7.0	3.0
Дархад	100.0	39.5	5.1	3.5	34.9	6.6	7.0	3.4
Мянгад	100.0	36.5	5.7	3.4	36.5	9.5	6.6	1.8
Хотон	100.0	33.6	4.5	4.0	32.7	12.8	8.8	3.6
Сартуул	100.0	29.9	6.6	4.5	35.8	9.7	9.3	4.2
Хотгойд	100.0	30.0	4.2	2.2	19.2	7.8	24.7	11.9
Барга	100.0	36.5	3.2	3.2	37.3	9.6	7.0	3.2
Бусад	100.0	37.7	4.0	4.4	29.9	9.6	9.6	4.8
Бусад үндэстэн (Монголын харьяат гадаад)	100.0	27.5	3.4	2.2	27.0	10.3	15.4	14.2

Улаанбаатар хотод амьдарч байгаа үндэс угсаатнуудыг боловсролын түвшнээр ангилан авч үзвэл, Дарьгангачуудын 47.0 хувь, Өөлдүүдийн 44.2 хувь, Буриадчуудын 42.1 хувь, Баядуудын 41.4 хувь нь дээд боловсролтой байгаа нь нийслэлийн дунджаас 5.1-10.7 пунктээр өндөр байна. Харин Сартуулуудын хувьд 29.9 хувь нь дээд боловсролтой байгаа нь үндэс угсаатнуудын дунд хамгийн бага үзүүлэлт байлаа. Мөн нийслэлд оршин суудаг, 10 ба түүнээс дээш насны Монгол Улсын харьяат долоон иргэн тутмын нэг нь боловсролгүй байна.


ГАДААДЫН ХАРЬАТ ИРГЭД

Монгол Улсад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэдийн тоо 17 456 болж 1.9 дахин өссөн байна.

Гадаадын харьяат иргэдийн дотор Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэн 7.1 мянга (40.8%), Оросын Холбооны Улсын иргэн 2.2 мянга (12.6%), Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэн 2.0 мянга (11.5%), Америкийн Нэгдсэн Улсын иргэн 2.1 мянга (12.0%) байгаа нь бусад орнуудаас харьцангуй олон байв. Ялангуяа 6, түүнээс дээш сарын хугацаагаар, хамгийн олон хүн оршин суугаа гадаадын харьяат иргэдийн тоог 2010 онтой харьцуулахад Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэдийн тоо 1.9 дахин, Оросын Холбооны Улсын иргэдийн тоо 1.4 дахин, Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдийн тоо 1.4 дахин, Америкийн Нэгдсэн Улсын иргэдийн тоо 5.2 дахин нэмэгджээ.

Улаанбаатар хот нь Монгол Улсын нийгэм, улс төр, хөгжлийн гол төв болон хөгжиж байгаатай уялдан дэлхийн 120 гаруй орноос оршин сууж байна.

ЗУРАГ 3.2. НИЙСЛЭЛД ОРШИН СУУГАА ГАДААДЫН ХАРЬЯАТ ИРГЭД, УЛСААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН




Нийслэл хотод тоологдсон гадаадын харьяат иргэдийн 10 198 (58.4%) нь эрэгтэй, 7 258 (41.6%) нь эмэгтэйчүүд байна. Тэднийг насны бүлгээр авч үзвэл 20.5 хувь нь 0-14 насны хүүхэд, 65, дээш насныхан дөнгөж 4.8 хувийг эзэлж байна. Мөн гадаадын харьяат иргэдийн хүйсийн харьцаа 140.5 гарчээ. Эндээс нийслэлд амьдарч буй гадаадын харьяат иргэдийн дийлэнх нь хөдөлмөрийн насны, эрэгтэйчүүд байна гэж дүгнэж болно.

ХҮСНЭГТ 3.4. НИЙСЛЭЛ ХОТЫН СУУРИН ХҮН АМ, ГАДААДЫН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	Суурин хүн амын насны бүтэц	Гадаадын харьяат иргэд			
		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	140.5
0-14	32.5	20.5	18.0	23.9	105.9
15-24	11.9	14.4	11.0	19.1	81.4
25-34	18.4	16.1	15.9	16.3	136.8
35-44	14.8	18.3	20.1	15.8	179.4
45-54	10.8	16.3	19.0	12.5	213.6
55+	11.6	14.4	15.9	12.4	180.0

Улаанбаатар хотод байнга оршин суугаа гадаадын харьяат иргэдийн 58.9 хувь нь дээд боловсролтой, 10.2 хувь нь тусгай мэргэжлийн дунд болон техникийн мэргэжлийн, 26.1 хувь нь бүрэн дунд ба түүнээс доош боловсролтой, 4.1 хувь нь боловсролгүй хүмүүс байна. Энэ үзүүлэлтийг 2010 онтой харьцуулахад дээд боловсролтой гадаадын харьяат иргэд 14.4 пунктээр өсч, бүрэн дунд ба түүнээс доош боловсролтой иргэд 16.0 пунктээр буурчээ.

ЗУРАГ 3.3. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ГАДААДЫН ХАРЬАТ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР, 2010, 2020 ОН



ШАШИН

Монгол Улсын Үндсэн хуульд "шашин шүтэх эс шүтэх эрх чөлөөг" иргэний үндсэн эрх хэмээгээд хүнийг шашин шүтлэгийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглосон ба төр, шашны үйл ажиллагаа тусдаа байх ёстойг заасан. Нийслэлийн нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрөлтэй нийт сүм хийдийн тоо 2010 онд 129 байсан бол 2019 онд 389 болон 3 дахин өссөн байна. Сүм хийдийг шашны төрлөөр авч үзвэл 29.8 хувь нь буддын, 60.2 хувь нь христийн, 1.8 хувь нь католик, 5.7 хувь нь бөөгийн, 1.0 хувь нь исламын, 1.5 хувь нь бусад сүм хийдүүд тус тус эзэлж байна. Энд хамгийн их нэмэгдсэн сүм хийдийг шашны төрлөөр 2010 онтой харьцуулахад буддын сүм хийд 2.2 дахин, христийнх 3.3 дахин нэмэгджээ.

Шашин шүтдэг эсэх талаар хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор анх удаа асуулга авч байсан бол энэ удаа тооллогын асуумжид дахин оруулсан юм. Хүн ам орон сууцны тооллогод "Та шашин шүтдэг үү, тэгвэл ямар шашин шүтдэг вэ?" гэсэн асуултыг 15, түүнээс дээш насны хүн амаас асуусан.

ХҮСНЭГТ 3.5. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ШАШИН ШҮТЛЭГИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Шашны төрөл	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Шүтдэггүй	38.6	43.1	34.5	46.3	49.9	43.2
Шүтдэг	61.4	56.9	65.5	53.7	50.1	56.8

Улаанбаатар хотын 15, түүнээс дээш насны хүн амын 46.3 хувь нь шашин шүтдэггүй, 53.7 хувь нь ямар нэгэн шашин шүтдэг гэж хариулсан ба 2010 оны тооллогын үетэй харьцуулахад шашин шүтдэг гэж хариулсан хүний хувь 7.7 пунктээр буурчээ. Хүйсээр харахад эрэгтэйчүүдийн шашин шүтдэг гэсэн хариултын хувь өмнөх тооллогоос 6.8, эмэгтэйчүүдийнх 8.7 пунктээр тус тус буурчээ.


ХҮСНЭГТ 3.6. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТДЭГ ХҮН АМЫН, ШАШНЫ ТӨРӨЛ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Шашны төрөл	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Будда	86.5	87.0	86.1	89.1	89.5	88.9
Ислам	1.1	1.3	1.0	0.9	1.0	0.8
Бөө	6.8	6.9	6.7	5.4	5.6	5.3
Христ	4.9	4.1	5.6	3.3	2.6	3.8
Бусад	0.7	0.7	0.6	1.3	1.3	1.2


Шашинтнуудын тоог шүтдэг шашных нь төрлөөр авч үзэхэд 89.1 хувь нь буддын шашинтан болох нь харагдаж байна. Мөн 2010 онтой харьцуулахад шашин шүтдэг нийт хүн амын дүнд эзлэх хувь бөөгийн шашинтан буурсан нь бусад шашны урсгал дэлгэрсэнтэй холбоотой байж болох юм. Христийн болон бусад шашны сүм хийд Улаанбаатар хотод олноор баригдаж, түүнийг даган шүтэн бишрэгчдийн тоо нэмэгдэж, хүн амын шашин шүтдэг хэсэг нь шашин шүтлэгийн хувьд нэгэн төрөл биш болж байгаа нь энэ удаагийн тооллогоор илүү тод харагдаж байна.

Тухайн насны нийт хүн амд шашин шүтдэг хүн амын эзлэх хувь нас ахих тутам нэмэгдэж байна (Зураг 3.5). Тухайлбал, 15-19 насны хүүхэд залуучуудын 35.1 хувь нь шашинтан байхад нас ахих тутам нэмэгдсээр, 70-аас дээш насны хүн амын 74.5 хувь нь шашинтан байна.

ЗУРАГ 3.4. ШАШИНТНУУДЫН НАСНЫ БҮЛЭГ ДЭХ НИЙТ ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН



ЗУРАГ 3.5. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД ШАШИНТНУУДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ДҮҮРГЭЭР 2020 ОН




15, түүнээс дээш насны нийт хүн амд шашинтнуудын эзлэх хувийг дүүргээр авч үзвэл Чингэлтэй, Баянгол, Налайх, Сонгинохайрхан дүүргийн шашинтнуудын эзлэх хувь нийслэлийн дунджаас өндөр байна. Харин Багахангай дүүрэгт хамгийн бага буюу 47.1 хувьтай байгаа нь бусад дүүргүүдтэй харьцуулахад шашингүйчүүд нийт хүн амынх нь талаас илүү хувьтай тэнцэж байгаагаараа ихээхэн ялгаатай юм.

ХҮСНЭГТ 3.7. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИНТАН, НАСНЫ БҮЛЭГ, ШАШНЫ ТӨРӨЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	Шашинтан	Будда	Христ	Ислам	Бөө	Бусад
БҮГД	100.0	89.1	3.3	0.9	5.4	1.3
15-19	100.0	84.1	5.3	1.3	7.4	1.9
20-29	100.0	86.3	3.5	1.3	7.6	1.3
30-39	100.0	87.6	3.3	1.0	6.5	1.6
40-49	100.0	89.7	3.0	0.8	5.1	1.4
50-59	100.0	90.5	3.2	0.7	4.6	1.0
60-69	100.0	93.4	2.7	0.4	2.8	0.7
70+	100.0	95.1	2.3	0.5	1.5	0.6


Шашны төрлөөр авч үзэхэд буддын шашинтны 5.7 хувь нь 15-19 насны хүүхэд залуучууд, 16.1 хувь нь 20-29 насныхан, 23.6 хувь нь 30-39 насныхан, 20.3 хувь нь 40-49 насныхан, 16.7 хувь нь 50-59 насныхан, 10.9 хувь нь 60-69 насныхан, 6.7 хувь нь 70-аас дээш насныхан байна. Харин христийн шашинтны тухайд 30-39 насныхан 24.5 хувь буюу хамгийн өндөр хувийг эзэлж байв.

ЗУРАГ 3.6. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИНТАН, ДҮҮРЭГ, ШАШНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН




ХҮН АМЫН СУУРЬШИЛ, ХОТЖИЛТ

1м² нутаг дэвсгэрт
оршин сууж буй хүн



СУУРИН ХҮН АМ
1 466 125



Суурин хүн амын тоо




ХҮН АМЫН СУУРЬШИЛ

Монгол Улсын аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээ харилцан адилгүйн зэрэгцээ газарзүйн хэд хэдэн бүсэд оршдог, байгалийн баялаг улс орны нутаг дэвсгэрт жигд бус тархсан, уур амьсгал газарзүйн бүсүүдэд ялгаатай, эрс тэс байдаг зэргээс хамааран аймаг, нийслэлийн хүн амын суурьшил нягтрал, хөгжлийн түвшин өөр өөр байгаа нь зүй ёсны асуудал билээ.

Монгол Улсын нийт хүн амын 45.9 хувь нь буюу 2 хүн тутмын нэг нь нийслэл хотод, тэр дундаа нийслэл хотын нийт хүн амын 95.2 хувь нь төвийн зургаан дүүрэгт суурьшиж байна.

Монгол Улсын нийт хүн амд Улаанбаатар хотын хүн амын эзлэх хувь 2010 онтой харьцуулахад 2.3 пунктээр нэмэгдсэн нь 2000-2010 оны шилжин ирэлт ихтэй он жилүүдээс тав дахин буурсан үзүүлэлт юм.


ЗУРАГ 4.1. МОНГОЛ УЛСЫН СУУРИН ХҮН АМД УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР



Дүүрэг, хороодын нутаг дэвсгэрийн хэмжээ, хот төлөвлөлт, эдийн засгийн хөгжил зэрэг олон хүчин зүйлсийн нөлөөллөөс үүдэн нийслэл хотын суурьшил, нягтрал харилцан адилгүй байдаг.

2020 онд нийслэлийн хүн амын 24.7 хувь нь Баянзүрх дүүрэгт, 22.3 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, нэг үгээр хэлэхэд бараг тал орчим хувь нь энэ хоёр дүүрэгт суурьшиж байна.

ЗУРАГ 4.2. НИЙСЛЭЛИЙН ХҮН АМЫН СУУРЬШИЛ, ДҮҮРГЭЭР, 2010, 2020 ОН



Дүүргүүдийн нийслэлийн нийт хүн амд эзлэх хувь 2010 онтой харьцуулахад алслагдсан гурван дүүрэг болох Багануур, Багахангай, Налайх дүүргийн нийт хүн амд эзлэх хувь өөрчлөгдөөгүй 10 жилийн хугацаанд хадгалагдан үлджээ. Харин төвийн дүүргүүдийн хувьд өөрчлөлт гарсан байна. Тухайлбал, Хан-Уул дүүрэг бусад дүүргийг бодвол хамгийн их буюу 3.2 пунктээр өссөн бол Сүхбаатар, Чингэлтэй дүүргийнх 1.3-2.5 пунктээр буурсан. Үүнийг сүүлийн жилүүдэд Хан-Уул дүүрэгт орон сууц ихээр баригдаж, Улаанбаатар хотын дүүрэг хоорондын шилжих хөдөлгөөн нэмэгдсэнээр хүн амын суурьшил нэмэгдсэн гэж тайлбарлаж болно. Түүнчлэн дүүргүүдийн хүн амын суурьшил нь газар нутгийн тэлэх боломж, байршил, байгаль орчны нөхцөл байдал зэрэгтэй салшгүй холбоотой байдаг учраас зарим дүүргийн хүн амын тэлэх боломж хязгаарлагдмал байж болох талтай.

ХҮСНЭГТ 4.1. ХҮН АМЫН ТОО, ДҮҮРЭГ, ХОРООГООР, 2010, 2020 ОН

Дүүрэг	Хорооны тоо		Хүн ам (мян.хүн)	
	2010	2020	2010	2020
БҮГД	132	169	1 154.3	1 466.1
Багануур	4	5	22.4	28.6
Багахангай	2	2	3.4	4.1
Баянгол	20	23	178.7	225.8
Баянзүрх	24	28	277.5	361.7
Налайх	6	8	30.2	37.6
Сонгинохайрхан	25	43	257.5	327.6
Сүхбаатар	18	20	127.8	144.4
Хан-Уул	14	21	110.3	187.3
Чингэлтэй	19	19	146.5	149.0

Нийслэл хот 2010 онд засаг захиргааны хувьд 9 дүүрэг, 132 хорооноос бүрдэж байсан бол 2020 оны 1 дүгээр сарын байдлаар 9 дүүрэг, 169 хороотой болсон. 2020 онд нийслэлийн нэг хороонд дунджаар 8.7 мянган хүн ногдож байгаа нь 2010 онтой ижил түвшинд байна. Учир нь өнгөрсөн хугацаанд хороодын ачааллыг бууруулах, нийгмийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх сайжруулах, ойртуулах үүднээс хороодын тоог нэмсэн нь нэг хороонд ногдох хүн амын тоо нэмэгдэхгүй байх гол шалтгаан болсон. Хамгийн их хүн амтай хороо Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо 22.7 мянга, хамгийн бага хүн амтай хороо Багануур дүүргийн 2 дугаар хороо 0.6 мянган хүн амтай.

Нийслэлийн хүн ам тоо 2020 оны тооллогоор 1 466.1 мянга болж 2010 оны хүн амаас 27.0 хувиар нэмэгдсэн ба бүх дүүргийн хүн ам өсөлттэй гарсан. Үүний дотор Хан-Уул дүүрэг хамгийн өндөр буюу 69.8 хувиар өсжээ.

ХҮСНЭГТ 4.2. ХҮН АМЫН ТОО, ДҮҮРЭГ, ӨСӨЛТ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Дүүрэг	Хүн ам (мян.хүн)		2020 / 2010 %	Дүнд эзлэх хувь	
	2010	2020		2010	2020
БҮГД	1 154.3	1 466.1	27.0	100.0	100.0
Багануур	22.4	28.6	27.7	1.9	1.9
Багахангай	3.4	4.1	22.6	0.3	0.3
Баянгол	178.7	225.8	26.4	15.5	15.4
Баянзүрх	277.5	361.7	30.3	24.0	24.7
Налайх	30.2	37.6	24.9	2.6	2.6
Сонгинохайрхан	257.5	327.6	27.2	22.3	22.3
Сүхбаатар	127.8	144.4	13.0	11.1	9.8
Хан-Уул	110.3	187.3	69.8	9.6	12.8
Чингэлтэй	146.5	149.0	1.7	12.7	10.2

ХҮН АМЫН НЯГТРАЛ


Улаанбаатар хот 4.7 мянган километр квадрат газар нутагтай бөгөөд Монгол Улсын бүх нутаг дэвсгэрийн дөнгөж 0.3 хувийг эзэлдэг. Нэг үгээр хэлбэл Монгол Улс нэг хүнд ногдох газар нутгийн хэмжээгээр дэлхийд тэргүүлдэг хэрнээ хүн амын хамгийн их хувь нь нийслэл хотдоо төвлөрснөөрөө мөн адил тэргүүлэх хэмжээнд байна гэж хэлж болно.

2020 оны байдлаар Нийслэл хотод нэг квадрат километр талбайд 312 хүн ногдсон нь 2010 оноос 33.4 хувиар өсжээ. Нутаг дэвсгэрийн хэмжээгээр Баянзүрх дүүрэг хамгийн их 1 244.1 километр квадрат буюу 26.4 хувь, Баянгол дүүрэг хамгийн бага 29.5 километр квадрат буюу 0.6 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 4.3. ХҮН АМЫН ТОО, НЯГТРАЛ, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2010, 2020 ОН


Дүүрэг	2010 он			2020 он		
	мян.хүн	Дүнд эзлэх хувь	Хүн/км ²	мян.хүн	Дүнд эзлэх хувь	Хүн/км ²
БҮГД	1 154.3	100.0	245	1 466.1	100.0	312
Багануур	22.4	1.9	36	28.6	1.9	46
Багахангай	3.4	0.3	22	4.1	0.3	26
Баянгол	178.7	15.5	7 325	225.8	15.4	9 254
Баянзүрх	277.5	24.0	224	361.7	24.7	293
Налайх	30.2	2.6	44	37.6	2.6	55
Сонгинохайрхан	257.5	22.3	215	327.6	22.3	273
Сүхбаатар	127.8	11.1	606	144.4	9.8	685
Хан-Уул	110.3	9.6	220	187.3	12.8	373
Чингэлтэй	146.5	12.7	1 598	149.0	10.2	1 625

ЗУРАГ 4.3. ХҮН АМЫН НЯГТРАЛ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГЭЭР, 2020 ОН



Дүүргүүд байршлын хувьд ялгаатай байгаагаас гадна нягтралын хувьд ч харилцан адилгүй. Ялангуяа алслагдсан гурван дүүргийн хувьд хүн амын нягтрал харьцангуй бага нэг квадрат километр газарт 26-55 хүн суурьшиж байхад төвийн Баянгол (9 254), Чингэлтэй (1 625), Сүхбаатар (685) дүүрэгт хүн амын нягтрал хамгийн их буюу нийслэлийн дунджаас харьцангуй дээгүүр байна.

ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН



ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлийн 18 дахь хэсгийн “Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй”¹ гэсэн заалт нь иргэд шилжих хөдөлгөөнд сайн дураараа чөлөөтэй оролцох эрх зүйн боломжийг бүрдүүлсэн.

Шилжих хөдөлгөөн нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хүн амын тоо, бүтэц бүрэлдэхүүний өөрчлөлтөд голлон нөлөөлдөг хүчин зүйл учраас хүн амын тооллогоор тодорхой цаг хугацаа, нутаг дэвсгэрт, засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид хувь хүмүүс болон өрхийн хэмжээнд тодорхойлон авч үздэг.

Монгол Улсын хувьд дотоод шилжих хөдөлгөөнийг аймаг, нийслэл хоорондынх, аймаг доторх шилжих хөдөлгөөн гэж 2 ангилдаг бөгөөд тооллогоор зөвхөн аймаг, нийслэл хоорондын шилжих хөдөлгөөнийг авч үзсэн.

Байнга оршин сууж байсан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс өөр газар руу 6 ба түүнээс дээш сарын хугацаагаар шилжин суурьшсан хүн амыг шилжих хөдөлгөөнд оролцсон гэж үзээд, тооллогын товын үед:

- төрсөн нутгаасаа өөр газар амьдарч байгаа;
- таван жилийн өмнө байнга оршин сууж байсан газар;
- нэг жилийн өмнө байнга оршин сууж байсан газар гэсэн гурван үндсэн хугацаагаар авсан.

Төрснөөс хойших шилжих хөдөлгөөний мэдээллийг 10 хувийн түүврийн мэдээлэлд үндэслэн гаргасан бол сүүлийн 1 болон 5 жилийн шилжих хөдөлгөөний мэдээллийг бүртгэлд суурилсан аргаар буюу Хүн ам, өрхийн мэдээллийн санд үндэслэн тооцсон болно.

Шилжих хөдөлгөөнийг тухайн хүн дээрх хугацаанд хэдэн удаа шилжсэнийг үл харгалзан хамгийн сүүлд шилжсэн нутаг дэвсгэрийн байдлаар тодорхойлов. Шилжих хөдөлгөөнд оролцогчдын шинж төрхийг тодорхойлохдоо эхний аргаар нь төрсөн газрын асуултад үндэслэсэн. (Зураг 5.1)

- “Төрснөөсөө хойш сууж байгаа” гэдэгт төрсөн аймаг, нийслэлдээ төрснөөсөө хойш амьдарч байгаа буюу амьдралынхаа туршид байнга оршин суудаг нэгжээс өөр аймаг, нийслэлд шилжин суурьшиж байгаагүй тохиолдлыг оруулсан.
- Тооллогын товын үед төрсөн аймаг, нийслэлээсээ өөр газар байнга оршин сууж байгаа болон өөр аймаг, нийслэлд амьдарч байгаад буцаад төрсөн аймаг, нийслэлдээ ирсэн хүмүүсийг “Төрснөөсөө хойш шилжигсэд” гэж үзэв. Төрснөөс хойших шилжих хөдөлгөөнийг тухайн хүний хамгийн сүүлд шилжиж ирсэн аймаг, нийслэлийг үндэслэв.

Төрснөөс хойших шилжих хөдөлгөөний үндсэн агуулга нь аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа хүн амын хэдэн хувь нь уугуул нутагтаа амьдарч байгааг илэрхийлэхэд оршино.

¹ Монгол Улсын үндсэн хууль. Монгол Улсын хуулийн эмхэтгэл I боть, Улаанбаатар хот, 2008 он, хуудас 5

ЗУРАГ 5.1. ТӨРСНӨӨС ХОЙШИХ ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, 2020 ОН




Улаанбаатар хотын суурин хүн амын 947 117 (64.6%) хүн төрснөөсөө хойш нийслэлд амьдарч байгаа бол 519 008 (35.4%) хүн шилжин ирж суурьшсан, үүний дотор 511 678 (34.9%) хүн өөр аймаг хотоос, 7 330 (0.5%) нь гадаадаас шилжин иржээ.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллоготой харьцуулахад төрснөөс хойш Улаанбаатарт амьдарч байгаа хувь 17.4 пунктээр нэмэгдэж, эсрэгээр шилжин ирсэн хүн амын нийт хүн амд эзлэх хувь мөн хэмжээнд буурсан дүн гарчээ. Дотор нь задалж үзвэл, өөр газраас буюу хөдөө орон нутгаас ирэгчдийн тоо 15.7 пункт, гадаадаас ирэгчид 1.7 пунктээр тус тус буурсан байна.


Сүүлийн жилүүдэд хот байгуулалт, төлөвлөлт, байгаль орчин, экологийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, төлөвлөлтгүй суурьшил бий болох, гэмт хэрэг, зөрчил ихсэх, замын хөдөлгөөнд хэт түгжрэл үүсэх, хүн амын эрүүл мэнд, нийгмийн халамж, үйлчилгээний салбар доголдох зэргээр эдийн засаг, нийгмийн бүх талын харилцаанд хүндрэл учруулах болсон. Тиймээс нийслэлийн оршин суугч, иргэдийн Үндсэн хуулийн 16-р зүйлийн 2-т заасан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг ноцтой хөндөж байгаагаас үүдэн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2017 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн захирамжаар хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод байнга оршин суухаар ирэх иргэдийн шилжилт хөдөлгөөнийг 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл түр хугацаанд зогсоосон шийдвэр гаргасан, мөн энэ шийдвэр 2020 оны 1 дүгээр сарын 1 хүртэл сунгагдсантай холбоотойгоор шилжин ирэгчдийн тоо буурсан гэж үзэж байна. Гэхдээ захирамж гарсан ч шилжин ирсэн бүртгэлгүй “түр оршин суугаа” иргэдийн тоо нэмэгдсээр байгааг анхаарах хэрэгтэй.

ЗУРАГ 5.2. ШИЛЖИГЧДИЙН ТОО, ХУГАЦААГААР, 2010, 2020 ОН



Улаанбаатар хотод сүүлийн 5 жилд 72.9 мянган хүн шилжин ирсэн бөгөөд 2010 оны тооллоготой харьцуулахад 2.5 дахин, сүүлийн нэг жил шилжин ирэгчдийн тоо 55.3 мянгад хүрч, өмнөх тооллогоос 6 мянган хүнээр тус тус буурчээ. Энэ нь нийслэлд шилжин ирэх хөдөлгөөнийг түр хязгаарласантай холбоотой.

ЗУРАГ 5.3. ШИЛЖИН ИРСЭН ХҮН АМЫН ТОО, ШИЛЖИН ИРЭЭД СУУЖ БУЙ ХУГАЦАА, ХУВИАР, 2020 ОН



Улаанбаатар хотод нийт шилжин ирэгчдийн 13.1 хувь нь 20, түүнээс дээш жилийн өмнө, 14.1 хувь нь 10-19 жилийн өмнө, 8.2 хувь нь 2020 оны тооллогоос өмнөх 9 жилийн хугацаанд ирж суурьшжээ. Шилжин ирж суурьшигчдын 45.0 хувь нь эрэгтэй, 55.0 хувь нь эмэгтэйчүүд ба шилжин ирсэн бүх хугацаанд эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдийнхээс 0.9-14.6 пунктээр өндөр байна. Эндээс нийслэл хотын хүн амын хүйсийн харьцаанд шилжин ирэгчдийн хүйс нөлөөлдөг болох нь харагдаж байна.

ХҮСНЭГТ 5.1. ХҮН АМЫН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦСОН БАЙДАЛ, СУУРЬШСАН ХУГАЦАА, ХҮЙС, ХУВИАР 2020 ОН

	Дүнд эзлэх хувь	Үүнээс хүйсээр		Бүгдэд эзлэх хувь	Үүнээс хүйсээр		
		Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй	
ХҮН АМ- БҮГД	100.0	100.0	100.0	100.0	48.5	51.5	
Нийслэлд төрснөөс хойш сууж байгаа	64.6	66.6	62.9	100.0	49.1	50.9	
Шилжиж ирсэн	35.4	33.4	37.1	100.0	45.0	55.0	
Суурьшсан хугацаагаар	1 жил хүртэл	0.6	0.6	100.0	44.9	55.1	
	1-3 жил	1.5	1.5	100.0	47.1	52.9	
	4 жил	0.6	0.6	100.0	42.7	57.3	
	5-6 жил	2.1	1.9	2.2	100.0	44.6	55.4
	7-9 жил	3.4	3.3	3.5	100.0	46.1	53.9
	10-12 жил	3.2	3.1	3.3	100.0	45.8	54.2
	13-15 жил	3.8	3.6	3.9	100.0	46.0	54.0
	16-19 жил	7.1	6.8	7.3	100.0	45.9	54.1
	20, түүнээс дээш жил	13.1	12.0	14.1	100.0	43.6	56.4

ТӨРСНӨӨС ХОЙШИХ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН


Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор нийт хүн амын 64.6 хувь нь Улаанбаатар хотод төрөөд, төрснөөсөө хойш шилжих хөдөлгөөнд ороогүй, өөрөөр хэлбэл уугуул иргэд байгаа нь өмнөх тооллоготой харьцуулахад 17.4 пунктээр өссөн байна. Нэг үгээр хэлэхэд, 2010 онд нийслэл хотод амьдарч байгаа хоёр хүний нэг нь шилжин ирэгч байсан бол 2020 онд гурван хүний нэг нь шилжин ирэгч болсон байна. Энэ нь нэг талаар 1990-ээд оны сүүл үеэс эхэлсэн “их нүүдэл”, нийслэл рүү чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгалаас үүдэн хотжих үйл явц эрчимжиж, үүний үр дүнд шилжин ирэгчдийн дараагийн үе нөхөн үржихүйн насанд хүрснээр хотын уугуул иргэдийг төрүүлсэн, нөгөө талаар сүүлийн үед шилжин ирэгчдийн тоо буурч байгаа зэрэгтэй холбоотой.

ХҮСНЭГТ 5.2. ХҮН АМЫН ТОО, ТӨРСӨН ГАЗАР, ХУВИАР, 2010, 2020 ОН

Төрсөн аймаг, нийслэл	Суурин хүн амын дүнд эзлэх хувь	
	2010	2020
Улаанбаатар	47.2	64.6
Бусад аймаг, хот	52.8	35.4


Нийслэл хотын гурван иргэн тутмын нэг нь өөр аймагт төрсөн байгааг бүс нутгаар авч үзвэл, 10.8 хувь нь хангайн бүсэд, 11.0 хувь нь баруун бүсийн аймагт төрсөн нь бусад бүсээс өндөр байна. Өөрөөр хэлбэл, дээрх бүс нутгийн иргэд нийслэлд илүү олноороо ирж суурьшиж байгаатай холбоотой. Нийт хүн амд шилжин ирж суурьшсан иргэдийн эзлэх хувийг 2010 оны үетэй, бүс нутгаар харьцуулахад хангайн бүс 4.6 пункт, баруун бүс 3.7 пункт, төвийн бүс 5.2 пункт, зүүн бүс 2.2 пунктээр тус тус буурсан байна.

ЗУРАГ 5.4. ХҮН АМ, ТӨРСӨН БҮС НУТГААР, ХУВИАР, 2010, 2020 ОН




Улаанбаатар хотод нийт шилжин ирэгчдэд эзлэх хувийг аймгаар авч үзвэл Төв (9.3%), Завхан (9.0%), Архангай (8.1%), Увс (7.7%), Өвөрхангай (7.2%) аймгуудаас хамгийн олон хүн шилжин ирсэн бол Өмнөговь (1.7%), Баян-Өлгий (1.0%), Говьсүмбэр (0.5%) аймгаас хамгийн бага хүн шилжин иржээ.

ЗУРАГ 5.5 ШИЛЖИН ИРЭГЧИД, ШИЛЖИН ИРСЭН АЙМГААР, 2020 ОН



ЗУРАГ 5.6 ШИЛЖИН ЯВАГЧИД, АЙМГААР, ШИЛЖИН ОЧСОН 2020 ОН



Шилжин явсан хүн амын тоо шилжин ирэгчдээс бага байгаагаас харахад нийслэлд төрсөн хүмүүс орон нутаг руу шилжих сонирхолгүй, нөгөөтэйгүүр шилжин ирээд суурьшсан бол буцах шилжих хөдөлгөөнд тун бага ордог ажээ.

Шилжин явагчдын дүнд эзлэх хувийг аймгаар авч үзвэл Орхон (15.3%), Дархан-Уул (14.4%), Төв, (13.0%), Сэлэнгэ (11.2%), Дорноговь (8.6%) аймгууд руу хамгийн олон хүн шилжин явсан. Харин Баян-Өлгий, Говь-Алтай, Увс аймаг руу хамгийн цөөн хүн шилжин явжээ. Эндээс шилжин явагчид ихэвчлэн томоохон хотууд, мөн дэд бүтэц сайн хөгжсөн, төмөр зам дагуух аймгууд руу шилждэг гэж дүгнэж болно.

ТАВАН ЖИЛИЙН ӨМНӨХТЭЙ ХАРЬЦУУЛСАН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Хүн ам орон сууцны 2020 оны тооллогоор 5 жилийн шилжих хөдөлгөөнийг 2015 оны нэг дүгээр сард байнга оршин сууж байгаа аймаг, нийслэлээр гаргасан.

ХҮСНЭГТ 5.3. ТАВАН ЖИЛИЙН ӨМНӨ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧДЫН ТОО, 2010, 2020 ОН

2005 болон 2015 оны 1 дүгээр сард байнга амьдарч байсан газар	Он	5, түүнээс дээш насны хүн ам	5 жилийн өмнөх шилжих хөдөлгөөний байдал			Цэвэр шилжих хөдөлгөөн
			Шилжих хөдөлгөөнд ороогүй	Шилжин ирэгчид	Шилжин явагчид	
Улаанбаатар	2010	1 020 148	834 691	185 457	49 716	135 741
	2020	1 285 786	1 212 899	72 887	43 478	29 409


Улаанбаатар хотод 2010 оны тооллогын дүнгээр 2005-2010 онд 185 457 хүн шилжин ирж байсан бол 2015-2020 онд 72 887 хүн шилжин ирж, өмнөх тооллогын дүнгээс 2.5 дахин буурсан байна.

Улаанбаатар хотын нийт хүн амын 87.7 хувийг 5, түүнээс дээш насны хүн ам эзэлж байгаа нь 2010 оноос 26.0 хувиар өсжээ.


Нийслэлд 2020 оны тооллогоор байнга оршин суугаа 5, түүнээс дээш насны хүн амын 94.3 хувь нь сүүлийн 5 жилийн хугацаанд шилжих хөдөлгөөнд ороогүй бол үлдсэн 5.7 хувь нь бусад аймгаас шилжин ирсэн байна.

Сүүлийн 5 жилд Улаанбаатар хот руу шилжин ирсэн урсгалыг бүс нутгаар харахад нийт шилжин ирэгчдийн 30.8 хувь нь төвийн бүсээс, 29.2 хувь нь Хангайн бүсээс иржээ.

ЗУРАГ 5.7. СҮҮЛИЙН ТАВАН ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧИД, ЯВАГЧДЫН ТОО БУС, ХУВИАР, 2020 ОН




ЗУРАГ 5.8. УЛААНБААТАР ХОТОД СҮҮЛИЙН ТАВАН ЖИЛИЙН ЦЭВЭР ШИЛЖИЛТ, 2020 ОН (ШИЛЖИН ИРСЭН БОЛОН ЯВСАН ХҮНИЙ ЗӨРҮҮ), БҮС НУТГААР




НЭГ ЖИЛИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Улаанбаатар хотод 2020 оны хүн ам, орон сууцны тооллогын товоос өмнөх нэг жилд нийт 69.2 мянган хүн шилжих хөдөлгөөнд оролцсон нь 2010 оны тооллогын үеэс 32.0 мянган хүнээр буурсан байна. Энэ нь бүлгийн эхэнд хэлсэнчлэн шилжин ирэх хөдөлгөөнийг түр хязгаарлаж байгаатай холбоотой. Сүүлийн нэг жилд шилжин ирэгчдийн 51.6 хувь нь эрэгтэй, 48.4 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь нэлээд анхаарал татаж байна. Учир нь сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд нийслэл хот руу аймаг орон нутгаас шилжин ирэгчдийн дунд эмэгтэйчүүд илүү давамгайлдаг байв.

ЗУРАГ 5.9 СҮҮЛИЙН НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ТОО, АЙМГААР, 2020 ОН




ЗУРАГ 5.10. СҮҮЛИЙН НЭГ ЖИЛД ШИЛЖИН ЯВАГЧДЫН ТОО, АЙМГААР, 2020 ОН



Нийслэлд сүүлийн нэг жилд шилжин ирэгчдийг аймгаар авч үзвэл Төв, Өвөрхангай, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Архангай аймгаас хамгийн олон хүн, Баян-Өлгий, Говьсүмбэр, Сүхбаатар аймгаас хамгийн цөөн хүн шилжин иржээ.

Улаанбаатар хотоос сүүлийн нэг жилд шилжин явагчдын 51.4 хувь нь эрэгтэй, 48.6 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байв. Шилжин очсон аймгаар нь авч үзвэл Орхон, Төв, Сэлэнгэ аймаг руу илүү олон хүн явсан ажээ.

ЗУРАГ 5.11. СУҮЛЧИЙН НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧИД, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН




Улаанбаатар хотын суурин хүн амын 3.8 хувь нь сүүлийн 1 жилд шилжин ирсэн байна. Шилжин ирэгчдийг нас, хүйсийн бүтцээр авч үзвэл аль ч хүйсийн хувьд ялгаагүй 15-20 насанд шилжин ирэгчдийн тоо огцом өсч байна. Түүнчлэн 25-29 насны эрэгтэйчүүд, 20-29 насны эмэгтэйчүүд бусад насны бүлгээс түлхүү иржээ. Ер нь залуучууд нийслэл хотод улсын хэмжээний их, дээд сургуулиудын дийлэнх нь төвлөрдөг учраас суралцахаар, мөн амьдралаа дээшлүүлж, ажилтай, орлоготой болох зорилгоор шилжин ирдэг. Хотод шилжин ирэгчдийн тоо 30-44 насанд огцом, цаашид нас ахих тусам алгуур буурч байв. Энд тэмдэглэн хэлэхэд 15-24 насанд эмэгтэйчүүд, 25-54 насанд эрэгтэйчүүд давамгайлж байна.

ХҮСНЭГТ 5.4 СУҮЛИЙН НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН СУУРИН ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН

	Шилжин ирэгчдийн хүн амд эзлэх хувь					
	2010			2020		
	Бүгд	Үүнээс		Бүгд	Үүнээс	
эрэгтэй		эмэгтэй	эрэгтэй		эмэгтэй	
БҮГД	5.3	5.4	5.2	3.8	4.0	3.5
0-4	4.0	4.0	4.0	3.1	3.1	3.1
5-9	3.0	3.0	3.0	2.8	2.8	2.8
10-14	3.0	3.0	3.0	2.5	2.4	2.5
15-19	13.6	12.6	14.5	4.0	3.7	4.4
20-24	7.9	8.1	7.8	8.1	7.2	8.9
25-29	5.1	5.5	4.7	7.0	7.5	6.5
30-34	4.0	4.5	3.5	3.9	4.7	3.2
35-39	3.5	4.0	3.0	3.2	3.8	2.5
40-44	3.5	4.1	2.9	3.0	3.6	2.4
45-49	3.2	3.6	2.8	3.2	3.8	2.6
50-54	3.0	3.2	2.8	3.3	3.9	2.7
55-59	3.6	3.6	3.6	3.3	3.7	2.9
60-64	3.2	3.3	3.1	3.3	3.9	2.9
65-69	3.4	3.1	3.7	3.1	3.6	2.7
70-74	3.7	3.2	4.1	2.5	2.8	2.3
75-79	3.5	2.8	3.9	2.4	2.4	2.4
80-84	3.6	3.4	3.8	2.2	2.3	2.1
85+	4.1	5.1	3.6	2.4	2.6	2.3

БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

10, түүнээс дээш насны хүн амын
боловсролын түвшин



БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Боловсрол бол нийгмийн оюуны амьдрал, улс үндэстний иргэншлийн гол үзүүлэлт, нийгмийн хөгжлийн шийдвэрлэгч гол хүчин зүйл юм. Тооллогоор хүн амын боловсролыг тодорхойлох нь хүн ам зүйн үндсэн үзүүлэлтүүд, ажиллах хүч, шилжих хөдөлгөөн, байршил, орон сууц зэрэг үндэстний болон бүс нутаг, аймаг, нийслэлийн хэмжээний бодлого, төлөвлөлтийг боловсруулахад чухал хэрэглүүр болдог.

Хүн амын үзүүлэлтүүдээс боловсрол, бичиг үсэг тайлагдалт нь хүний хөгжлийн явцыг илтгэдэг.

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 10 дугаар зүйлд “Боловсролын агуулга нь суралцагчийн нас, сэтгэхүйн онцлог, авьяас, сонирхол, хувийн болон нийгмийн хэрэгцээ, үндэстний өв, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ”² гэж заасан үндсэн агуулгад сүүлчийн тооллогуудын асуулга, аргачлал, заавар, үр дүн нийцэж байгаа.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого нь бүртгэл болон уламжлалт хосолмол аргаар явагдсан ба энгийн санамсаргүй түүвэрт сонгогдсон өрхийн гишүүдээс бичиг үсэг тайлагдалтын талаарх мэдээллийг авсан. Тиймээс 2020 оны тооллогын бичиг үсэг тайлагдалтын талаарх тоо мэдээллийг 2010 оны тооллогын дүнтэй хувийн жингээр харьцуулна.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын асуулгын хуудсанд боловсролын түвшний холбогдох асуултыг 6, түүнээс дээш насны бүх хүнээс асуудаг байсан бол 2020 оны тооллогоор 5, түүнээс дээш насны хүнээс, 2-39 насны хүнээс сургуульд сурдаг, цэцэрлэгт хүмүүждэг эсэхийг асуусан.

БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойшхи хугацаанд боловсролын тогтолцоог шинэчилж, хөгжингүй орны боловсролын стандартыг нэвтрүүлж байна. Тиймээс тооллого хоорондын хүн амын боловсролын түвшинг зэрэгцүүлэн жишиг өөрчлөлтийг харах нь чухал юм. Хүн амын боловсролын түвшинг НҮБ-ын зөвлөмж, олон улсын нийтлэг жишгийг харгалзан 10, түүнээс дээш насныханд тодорхойлов.

Монгол Улсын хэмжээнд 2019 оны байдлаар сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын нийт 2 259 байгууллага үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд 943 (41.7%) нь нийслэл Улаанбаатар хотод байрладаг. Тодруулбал, улсын хэмжээний нийт цэцэрлэгийн 47.6 хувь, ерөнхий боловсролын сургуулийн 31.5 хувь нь Улаанбаатарт байна.

Монгол Улсын хэмжээнд 10, түүнээс дээш насны хүн амын 95.1 хувь нь ямар нэгэн боловсрол эзэмшсэн бол Улаанбаатар хотод энэ үзүүлэлт 95.9 хувь байгаа нь өмнөх тооллогын үеэс 0.4 пунктээр буурсан байна. Боловсролын түвшин өмнөх он жилүүдэд, өөрөөр хэлбэл, 2010 оны хүн ам орон сууцны тооллого хүртэл тасралтгүй өсч байсан бол энэ удаагийн тооллогоор анх удаа буурсан нь нэлээд анхаарал татсан асуудал болж байна. Учир нь боловсрол нь хүн бүрийн өдөр тутмын амьдрал, насан туршид нь нөлөөлөх үндсэн эрх, хүний хөгжлийн түлхүүр үзүүлэлт, мөн Монгол Улсын өнгөрсөн хугацаанд олсон амжилт юм.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор 10, түүнээс дээш настай хүн амын дотор бага боловсролтой хүн 9.2 хувь, суурь боловсролтой хүн 9.4 хувь, бүрэн дунд боловсролтой хүн

² Боловсролын тухай хууль. Монгол Улсын хуулийн эмхэтгэл III боть, Улаанбаатар хот, 2008 он, хуудас 369

32.7 хувь, техникийн болон мэргэжлийн дунд боловсролтой хүн 3.0 хувь, тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн 5.3 хувь, дээд боловсролтой хүн 36.3 хувь байна. Дээрх үзүүлэлтийг 2010 онтой харьцуулахад суурь боловсролтой хүн амын эзлэх хувь 1.9 пункт, бүрэн дунд боловсролтой хүн амын эзлэх хувь 8.1 пункт, тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн амын эзлэх хувь 1.1 пунктээр тус тус буурсан бол бага боловсролтой хүн амын эзлэх хувь 0.6 пункт, техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн амын эзлэх хувь 0.9 пункт, дээд боловсролтой хүний эзлэх хувь 9.2 пунктээр өсжээ. Эндээс хоёр тооллогын хооронд дээд боловсролтой хүний тоо хамгийн их өссөн нь харагдаж байна. Монгол Улсын “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт” Монгол Улс дэлхийн хөгжлийн өрсөлдөөн дунд өөрийн байр сууриа эзлэхийн тулд технологийн салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх тодорхой зорилтуудыг дэвшүүлж, хэрэгжүүлж байгаа билээ. Гэхдээ энэ ажлын үр дүн амьдралд тодорхой хугацааны дараа үр дүнгээ өгөх нь лавтай.

Ажилгүй иргэдийн дунд дээд боловсролтой залуучуудын эзлэх хувь өндөр боловч ажлын байрны эрэлт бага, эсрэгээр техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн амын эрэлт их байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт алдагдсаны нэг илрэл юм.

ХҮСНЭГТ 6.1. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН

Боловсролын түвшин	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Боловсролгүй	3.7	4.0	3.5	4.1	4.5	3.8
Боловсролтой	96.3	96.0	96.5	95.9	95.5	96.2
Дээд	27.1	23.8	30.2	36.3	31.3	40.9
Тусгай мэргэжлийн дунд	6.4	5.4	7.3	5.3	4.7	5.9
Техникийн болон мэргэжлийн	2.1	2.4	1.8	3.0	3.4	2.6
Бүрэн дунд	40.8	42.3	39.4	32.7	35.8	30.0
Суурь	11.3	13.3	9.5	9.4	10.6	8.2
Бага	8.6	8.8	8.4	9.2	9.7	8.6

Хүн амын боловсролын түвшинг хүйсээр нь авч үзэхэд нэлээд ялгаатай байна. Дээд боловсролтой хүн амыг хүйсээр нь ангилж үзэхэд 2010 оны хүн амын тооллогоор 10, түүнээс дээш насны эрэгтэй хүн амын 23.8 хувь нь, эмэгтэйн 30.2 хувь нь дээд боловсролтой байсан бол 2020 оны хүн амын тооллогоор харгалзан 31.3 хувь, 40.9 хувь болж, дээд боловсролтой эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс 9.6 пунктээр илүү болжээ. Ерөнхийдөө дээд боловсролтой эрэгтэй, эмэгтэйчүүдийн зөрүү тооллогоос тооллогод арилахгүй хэвээр хадгалагдсаар байна.

2020 оны тооллогын дүнгээр техникийн болон мэргэжлийн боловсрол, түүнээс доош бүх шатлалын боловсролын түвшинд эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байгаа юм.

10, түүнээс дээш насны нийт хүн амд боловсролгүй хүн амын эзлэх хувь 2020 онд өмнөх тооллогоос эрэгтэйчүүд 0.5 пункт, эмэгтэйчүүдийн 0.3 пунктээр өсөв.

ХҮСНЭГТ 6.2. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2020 ОН

Дүүрэг	Бүгд	Боловсролгүй	Боловсролтой	Үүнээс: Боловсролын түвшин					
				Дээд	Тусгай мэргэжлийн дунд	Техникийн болон мэргэжлийн	Бүрэн дунд	Суурь	Бага
БҮГД	100.0	4.1	95.9	36.3	5.3	3.0	32.7	9.4	9.2
Багануур	100.0	4.1	95.9	26.8	7.7	4.6	32.4	13.7	10.7
Багахангай	100.0	3.6	96.4	24.1	8.2	5.9	30.0	16.5	11.7
Баянгол	100.0	3.8	96.2	47.7	5.2	1.9	26.4	6.6	8.4
Баянзүрх	100.0	4.1	95.9	38.5	5.3	2.6	32.3	8.3	8.9
Налайх	100.0	5.0	95.0	21.3	5.7	8.6	33.3	15.0	11.1
Сонгинохайрхан	100.0	4.3	95.7	26.0	5.6	3.6	39.2	11.5	9.8
Сүхбаатар	100.0	3.9	96.1	41.3	5.0	2.7	29.7	8.6	8.8
Хан-Уул	100.0	4.2	95.8	43.8	4.4	2.4	27.6	8.5	9.1
Чингэлтэй	100.0	4.0	96.0	29.2	6.1	3.1	37.8	10.7	9.1

10, түүнээс дээш насны суурин хүн амын боловсролын түвшнийг дүүргээр авч үзэхэд дээд боловсролтой хүн амын хувийн жин 2010 оны тооллоготой нэгэн адил Баянгол, Сүхбаатар, Хан-Уул дүүрэгт бусад дүүргээс өндөр байна. Тодруулбал, Хан-Уул дүүрэгт дээд боловсролтой хүн амын эзлэх хувь өмнөх тооллогын үеэс 14.6 пункт, Сүхбаатар дүүрэгт 10.6 пункт, Баянгол дүүрэгт 9.7 пунктээр өссөн нь дүүргүүд дотроо хамгийн өндөр хувьтай, мөн өмнөх тооллогоос хамгийн их өссөн үзүүлэлт байв. Боловсролгүй хүн амын эзлэх хувь Налайх дүүрэгт (5.0 хувь) бусад дүүргээс өндөр, мөн техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн амын эзлэх хувиар ч дүүргүүдээс 2-3 дахин өндөр байгаа юм.

Боловсролын түвшнийг насны бүлгээр ангилж үзэхэд дээд боловсролтой хүний эзлэх хувь 25-39 насанд хамгийн өндөр, тухайн насны хүн амын талаас дээш хувийг эзэлж, нас ахих тусам аажимдаа буурч байна. Эндээс өнгөрсөн тооллогын үеийн өндөр өсөлт нас дэвшин хүн амын эзлэх хувийг улам нэмэгдүүлж байна. Хүснэгтээс харахад тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн амын эзлэх хувь 55 ба түүнээс дээш насанд бусад насны бүлгээс харьцангуй өндөр байна. Энэ нь 30, түүнээс дээш жилийн өмнө манай оронд “техникум” нэртэйгээр иргэдийн тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн амыг олноор бэлтгэж байсантай холбоотой. Аль ч насны бүлэгт мэргэжлийн боловсролтой хүний эзлэх хувь бага, ялангуяа нас залуужих тутам буурч байгаа нь ойрын жилүүдэд үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллах мэргэжилтэй ажилчдын хүрэлцээ хангамж дутагдсаар байхыг харуулж байна.


Нийслэлд дээд, тусгай мэргэжлийн дунд болон мэргэжлийн боловсролтой хүний харьцаа харилцан адилгүй. Жишээлбэл, 12 дээд боловсролтой хүнд нэг техник болон мэргэжлийн боловсролтой хүн, 7 дээд боловсролтой хүнд нэг тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн ногдож байна. Нэг талаар боловсролтой хүн амын түвшин өндөр сайхан харагдаж байгаа боловч хөгжлийг тодорхойлогч баялаг бүтээх салбарт хэн ажиллах вэ гэсэн асуулт нээлттэй хэвээр байна.

ХҮСНЭГТ 6.3. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	Бүгд	Дээд	Тусгай мэргэжлийн дунд	Техник болон мэргэжлийн	Бүрэн дунд	Суурь	Бага	Боловсролгүй
2010 он								
БҮГД	100.0	27.1	6.4	2.1	40.8	11.3	8.6	3.7
10-14	100.0	0.0	0.0	0.0	0.0	9.6	60.0	30.4
15-19	100.0	1.0	1.3	1.2	59.1	30.0	6.3	1.1
20-24	100.0	27.4	2.7	1.6	60.2	5.8	1.4	0.9
25-29	100.0	48.9	2.6	1.2	36.9	7.2	2.0	1.2
30-34	100.0	41.9	3.6	1.3	41.1	9.4	1.7	0.9
35-39	100.0	34.0	8.4	3.2	44.1	8.8	0.9	0.7
40-44	100.0	28.4	13.0	4.1	43.4	8.7	1.7	0.7
45-49	100.0	30.4	13.8	4.0	39.3	9.7	1.9	0.9
50-54	100.0	31.6	15.5	4.1	33.4	11.5	3.1	0.8
55-59	100.0	30.7	17.2	3.6	30.6	11.7	5.1	1.0
60 +	100.0	28.9	13.7	2.4	22.3	10.2	18.1	4.4
2020 он								
БҮГД	100.0	36.3	5.3	3.0	32.7	9.4	9.2	4.1
10-14	100.0	0.0	0.0	0.0	0.0	0.9	69.0	30.1
15-19	100.0	0.4	0.9	1.2	29.9	59.6	5.4	2.6
20-24	100.0	28.7	2.7	2.7	53.5	9.0	2.1	1.4
25-29	100.0	57.0	3.1	3.1	31.9	3.6	0.6	0.7
30-34	100.0	58.4	2.9	2.3	31.6	3.5	0.7	0.6
35-39	100.0	52.7	3.1	2.3	35.6	4.5	1.0	0.8
40-44	100.0	44.2	4.6	2.8	41.1	5.9	0.8	0.6
45-49	100.0	37.6	8.9	4.8	41.9	5.5	0.7	0.6
50-54	100.0	32.9	11.9	6.0	41.4	6.3	0.9	0.6
55-59	100.0	34.2	13.1	5.7	38.0	7.1	1.2	0.7
60 +	100.0	35.6	14.5	4.6	29.4	8.9	5.8	1.2

Зах зээлийн шилжилтийн үеэс хойш Монгол Улсад эмэгтэйчүүдийн дээд боловсрол эзэмших нь эрэгтэйчүүдээс илүү байсаар байна. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед улс оронд ямар төрлийн мэргэжлээр, хэдэн хүний эрэлт байгааг тодорхойлж, нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх богино болон урт хугацааны төлөвлөгөөтэйгээр дээд боловсролтой хүмүүсээ бэлтгэж байсан. Харин сүүлийн 30 жилд хувийн их, дээд сургуулийг олноор байгуулж, нийгмийн шинжлэх ухааны чиглэлээр маш олон дээд боловсролтой хүнийг бэлтгэн гаргасан нь дээд боловсролтой хүний тоо, чанартай холбоотой олон асуудлыг дагуулсан билээ. Энэ бэлтгэгдсэн боловсон хүчний дийлэнх нь эмэгтэйчүүд байгаа нь өнөөдрийн дээд боловсролтой хүн амын хүйсийн харьцаа алдагдахад хүрсэн. Харин 55-аас дээш насанд дээд боловсролтой эрэгтэй, эмэгтэй хүн амын хүйсийн харьцаа тэнцвэржиж аажмаар эрэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдэж байгааг зургаас харж болно.


ЗУРАГ 6.1. ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ ХҮН АМЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, УЛСЫН ДУНДАЖ, НАСНЫ БҮЛГЭЭР, 2020 ОН



БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Бичиг үсгийн мэдлэгийн тодорхойлолтын талаарх НҮБ-ын зөвлөмжийг 2000 оноос хойших гурван удаагийн тооллогод баримталсан. Арга зүйн хувьд аль нэг хэлээр энгийн өгүүлбэрийг уншиж ойлгодог, бичиж чаддаг хүнийг бичиг үсэг мэддэг гэж үзсэн.

ЗУРАГ 6.2. ХҮН АМЫН ТОО, БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГЭЭР*, 2020 ОН



Тайлбар:*Монголд суугаа гадаадын харьяат иргэн болон харьяалалгүй иргэн ороогүй дүн

6, түүнээс дээш насны боловсролгүй хүнээс бичиг үсэг мэддэг эсэхийг тодруулж асуусан. Харин хүн амын бичиг үсгийн мэдлэгийн түвшнийг олон улсын хэмжээнд зэрэгцүүлэх үүднээс 15, түүнээс дээш насаар тодорхойлов.


ХҮСНЭГТ 6.4. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН

Боловсролын түвшин	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Бичиг үсэг мэддэг	99.4	99.4	99.5	99.5	99.5	99.6
Бичиг үсэг мэддэггүй	0.6	0.6	0.5	0.5	0.5	0.4

Монгол Улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны хүн амын 98.7 хувь нь бичиг үсэг тайлагдсан бол нийслэлд энэ үзүүлэлт 99.5 хувьтай байгаа нь улсын дунджаас 0.8 пунктээр өндөр, өмнөх тооллогоос 0.1 пунктээр нэмэгджээ.


Арван тав, түүнээс дээш насны хүн амын 0.5 хувь нь бичиг үсэг мэдэхгүй байгаа нь нийслэл хотынхон маань бүгд бичигтэн болсныг харуулж байна. Хэдийгээр бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувь бага байгаа ч насны бүлгээр авч үзэхэд 15-24 насанд хамгийн бага хувьтай байгаа бол 30-34 насанд өндөр байна. Нийслэлийн хэмжээнд 15-24 насныхны бичиг үсэг мэддэггүй хувь бага байгааг сургууль завсардалт багассан, техник технологийн хурдацтай хөгжлийн эрин үед бичиг үсэггүйгээр амьдрах боломж улам хумигдаж байгаатай холбон тайлбарлаж болох юм.

ЗУРАГ 6.3. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД БИЧИГ ҮСЭГ МЭДДЭГГҮЙ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛГЭЭР, 2020 ОН



15, түүнээс дээш насны хүн амын бичиг үсгийн мэдлэгийн түвшинг дүүргээр ангилан үзэхэд өндөр нь Баянгол (99.8%), Баянзүрх (99.6%), Хан-Уул (99.6%) дүүргүүд байна. Нийслэлийн бүх дүүргүүдэд хүн амын бичиг үсгийн мэдлэг улсын дунджаас дээгүүр үзүүлэлттэй байна. (Зураг 6.4.)

ЗУРАГ 6.4. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2020 ОН



СУРГУУЛЬ, СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогод сургуульд суралцаж байгаа болон цэцэрлэгт хүмүүжиж байгаа эсэхийг 2-39 насныхнаас асуусан.

Манай улсын боловсролын шинэ тогтолцооны дагуу хүүхдийг 6 наснаас эхлэн сургуульд элсүүлэх болсонтой холбогдуулан сургуульд хамрагдалтыг 6-29 насаар тодорхойлов.

ХҮСНЭГТ 6.5. ЗУРГААГААС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, НАС, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН


Нас	Сургуульд суралцаж байгаа			Сургуульд суралцаагүй		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
2010 он						
6-29	59.4	57.9	60.9	40.6	42.1	39.1
6	96.1	95.8	96.5	3.9	4.2	3.5
7	98.4	98.3	98.5	1.6	1.7	1.5
8	98.8	98.8	98.7	1.2	1.2	1.3
9	98.7	98.5	98.9	1.3	1.5	1.1
6-9	98.0	97.9	98.2	2.0	2.1	1.8
10	98.4	98.4	98.5	1.6	1.6	1.5
11	98.2	97.9	98.4	1.8	2.1	1.6
12	97.8	97.5	98.1	2.2	2.5	1.9
13	97.2	96.9	97.5	2.8	3.1	2.5
14	96.6	95.8	97.3	3.4	4.2	2.7
10-14	97.6	97.3	98.0	2.4	2.7	2.0
15	95.7	94.6	96.9	4.3	5.4	3.1
16	92.6	90.7	94.4	7.4	9.3	5.6
17	89.2	86.4	91.9	10.8	13.6	8.1
6-17	96.3	95.6	97.0	3.7	4.4	3.0
18	83.7	79.7	87.4	16.3	20.3	12.6
19	75.9	70.4	80.7	24.1	29.6	19.3
20-24	41.6	38.4	44.6	58.4	61.6	55.4
25-29	8.4	7.1	9.6	91.6	92.9	90.4
2020 он						
6-29	74.0	74.4	73.6	26.0	25.6	26.4
6	90.8	90.7	91.0	9.2	9.3	9.0
7	96.8	96.5	97.1	3.2	3.5	2.9
8	98.4	98.4	98.4	1.6	1.6	1.6
9	98.1	98.0	98.2	1.9	2.0	1.8
6-9	95.8	95.6	95.9	4.2	4.4	4.1
10	99.1	99.1	99.0	0.9	0.9	1.0
11	99.2	99.1	99.2	0.8	0.9	0.8
12	99.2	99.2	99.2	0.8	0.8	0.8
13	99.2	99.2	99.2	0.8	0.8	0.8
14	99.2	99.1	99.3	0.8	0.9	0.7
10-14	99.2	99.2	99.2	0.8	0.8	0.8
15	98.8	98.7	98.8	1.2	1.3	1.2
16	98.3	98.0	98.7	1.7	2.0	1.3
17	97.6	97.3	98.0	2.4	2.7	2.0
6-17	97.5	97.4	97.6	2.5	2.6	2.4
18	89.8	87.5	92.2	10.2	12.5	7.8
19	84.2	79.8	88.7	15.8	20.2	11.3
20-24	57.7	57.1	58.3	42.3	42.9	41.7
25-29	22.2	21.9	22.5	77.8	78.1	77.5

Улаанбаатар хотын сургуульд хамрагдалтын хувийг авч үзэхэд 2010 онд 6 настай бүх хүүхдийн 96.1 хувь нь сургуульд сурч байсан бол 2020 онд 90.8 хувь болж 5.3 пунктээр, найман настай хүүхдийн сургуульд хамрагдалт 2010 онд 98.8 хувь (тухайн үеийн сургуульд хамрагдалтын хамгийн өндөр хувь) байсан бол 2020 онд 98.4 хувь болж 0.4 пунктээр тус тус буурчээ. Тэгвэл арван настай хүүхдийн сургуульд хамрагдалт 2010 онд 98.4 хувь байсан бол 2020 онд 99.1 хувь болж нэмэгдэв. Сургуульд хамрагдалтын түвшин 14 нас хүртэл тогтвортой өндөр хувьтай байснаа аажмаар буусаар 17 насанд 97.6 хувьтай болж байна. Энэ нь хүүхдүүдийн бүрэн дунд боловсрол эзэмшээд төгсөх үе юм. 2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад 10-аас дээш бүх насанд сургуульд хамрагдалт нэмэгджээ. Ялангуяа 25-29 насны сургуульд хамрагдалтын түвшин өмнөх тооллогоос 2.6 дахин нэмэгдсэн байна. Үүнийг залуучууд бакалаврын сургалтын дараа магистрын сургалтад хамрагдах болсонтой холбоотой.

Энэ үзүүлэлтийг хүйсээр авч үзвэл 6-9 хүртэлх насанд охидын сургуульд хамрагдалт хөвгүүдийнхээс өндөр байснаа цаашилбал, 10-14 нас хүртэл ойролцоо түвшинд, 15, түүнээс дээш бүх насанд эмэгтэйчүүдийн сургуульд хамрагдалт эрэгтэйчүүдийнхээс өндөр байв. Эндээс цаашид дээд боловсролтой эмэгтэйчүүдийн тоо өндөр хэвээр хадгалагдаж, дараагийн тооллоготой золгох магадлалтай байна.

Нийслэлийн хэмжээнд 6 настай сургуульд хамрагдаагүй 3 513 хүүхэд байгаагийн 52.2 хувь нь хөвгүүд, 47.8 хувь нь охид байна.

ЗУРАГ 6.5. НИЙСЛЭЛИЙН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, УЛСЫН ДУНДАЖ, НАСНЫ БҮЛГЭЭР, 2020 ОН



Нийслэлийн сургуульд суралцагчдын хүйсийн харьцаа (тухайн насны 100 охидод ногдох хөвгүүдийн тоо) 100-тай тэнцүү байхад ижил тооны эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд сургуульд суралцаж байна гэсэн үг юм. Улсын хэмжээнд 6-9, 10-14 настай суралцаж буй хүүхдүүдийн хүйсийн харьцаа харгалзан 104.1, 103.9, өөрөөр хэлбэл, ойролцоогоор 100 охид тутам 104 хөвгүүд ногдож байхад нийслэлд ижил түвшинд, хүйсийн харьцаа 6-9 насанд 104.4, 10-14 насанд 104.1 байна. Нийслэлд 15-19 насанд хүйсийн харьцаа 100-гаас дээш хэмжээнд байгаа бол улсын хэмжээнд 97.0 байгаа юм. Ерөнхийдөө нийслэл хотноо нас нэмэгдэх тусам хүйсийн харьцаа (20-24 нас 93.1, 25-29 нас 90.0) буурч, эмэгтэйчүүдийн үргэлжлүүлэн суралцах байдал нь эрэгтэйчүүдээс өндөр байна.

2010 оны тооллогоор 6-29 насныхны сургуульд хамрагдалт нийслэлийн дүүргүүдэд нэлээд ялгаатай байсан бол энэ удаагийн тооллогоор энэ ялгаа бараг арилсан эерэг үр дүн гарчээ. Зургаагаас хорин есөн насны хүн амын сургуульд хамрагдалт нийслэл хотод 74.0 хувь болж 2010 онтой харьцуулахад 14.6 пунктээр нэмэгдсэн байна. Баянгол, Сүхбаатар, Хан-Уул дүүргүүдийн

зургаагаас хорин есөн насны хүн амын сургуульд хамрагдалт нийслэлийн дунджаас 2.2-2.6 пунктээр өндөр байна.

ХҮСНЭГТ 6.6. ЗУРГААГААС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2020 ОН

Нас	Бүгд	Бага-нуур	Бага-хангай	Баян-гол	Баян-зүрх	Налайх	Сонгино-хайрхан	Сүх-баатар	Хан-Уул	Чингэл-тэй
2010 он										
6-29	59.4	60.0	58.1	62.5	59.9	56.3	56.2	62.7	61.0	57.0
6	96.1	99.0	100.0	97.8	95.2	95.1	95.5	96.4	97.3	95.7
7	98.4	99.1	100.0	98.8	98.2	98.4	98.2	98.8	98.3	98.3
8	98.8	99.2	98.1	99.0	98.1	98.6	98.8	99.1	99.4	98.7
9	98.7	99.3	100.0	99.2	98.6	97.6	98.5	98.4	98.8	98.7
6-9	98.0	99.1	99.6	98.7	97.6	97.5	97.8	98.2	98.4	97.9
10-14	97.6	98.4	95.8	98.4	97.4	97.3	97.4	97.7	97.8	97.6
15-17	92.4	92.3	89.9	95.5	92.2	90.3	90.3	93.7	93.4	91.1
15	95.7	95.7	94.8	97.7	95.4	96.1	94.4	97.0	96.5	94.7
16	92.6	92.7	93.3	95.4	92.7	91.4	90.5	92.7	93.3	92.2
17	89.2	86.9	80.0	93.9	89.3	82.9	86.1	91.8	90.7	86.6
6-17	96.3	97.1	95.7	97.7	96.0	95.5	95.6	96.7	96.8	95.9
18	83.7	56.7	68.0	89.4	84.5	71.5	78.3	89.6	87.6	77.9
19	75.9	40.5	62.9	84.4	77.8	51.4	68.8	83.5	78.6	68.6
20-24	41.6	18.5	30.5	48.5	43.9	25.3	35.5	48.5	41.5	37.7
25-29	8.4	5.1	6.0	10.5	9.1	4.5	6.3	9.5	8.6	8.5
2020 он										
6-29	74.0	71.8	70.1	76.6	74.0	71.4	71.7	76.2	76.2	72.3
6	90.8	92.7	97.1	91.3	88.9	93.4	89.6	92.6	92.2	92.9
7	96.8	97.4	97.9	97.2	96.9	97.8	96.4	96.7	96.6	97.0
8	98.4	99.2	98.9	98.3	98.5	99.2	98.4	98.3	98.0	98.2
9	98.1	98.7	100.0	98.3	98.1	99.6	98.2	97.6	97.8	97.5
6-9	95.8	96.8	98.4	96.0	95.2	97.4	95.4	96.1	95.9	96.3
10-14	99.2	99.3	99.1	99.0	99.2	99.5	99.3	99.1	99.2	98.9
15-17	98.2	97.8	96.6	98.8	98.3	97.9	98.0	98.5	98.6	97.6
15	98.8	99.0	98.3	98.9	98.6	99.2	98.6	99.3	98.9	98.5
16	98.3	97.5	97.8	98.7	98.8	97.4	98.0	98.5	98.8	97.4
17	97.6	96.8	93.3	98.8	97.4	97.1	97.4	97.8	98.1	96.7
6-17	97.5	98.0	98.4	97.6	97.3	98.3	97.3	97.7	97.6	97.5
18	89.8	84.9	90.3	94.5	91.7	78.5	87.3	91.2	91.7	86.4
19	84.2	78.4	68.1	90.3	86.9	71.0	81.0	86.0	87.2	78.4
20-24	57.7	53.2	49.0	64.4	59.0	45.1	54.3	61.7	59.1	52.8
25-29	22.2	15.4	17.9	27.3	22.2	14.3	18.8	26.4	25.3	18.5

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах нас буюу 2-5 насны нийт 123.2 мянган хүүхдийн 82.2 хувь нь цэцэрлэгт хүмүүжиж байгаа нь 2010 оны тооллогоос 16.1 пунктээр өсжээ. Тооллого хооронд нийслэлд цэцэрлэгийн хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор олон цэцэрлэг шинээр барьж ашиглалтад оруулсан нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын хувь нэмэгдэх гол шалтгаан нь болсон. Хүснэгтээс хүүхдийн нас ахих тусам хамрагдалтын хувь нэмэгдэж байгаа нь харагдаж байна. Тухайлбал, 2 настай хүүхдийн 61.6 хувь нь сургуулийн өмнөх боловсролд

хамрагдсан бол 5 настай хүүхдүүдийнх 92.8 хувьтай байна. Энэ үзүүлэлтийг хүйсийн ялгаатай байдлаар авч үзэхэд бүх насанд эмэгтэй хүүхдийн хамралтын хувь эрэгтэй хүүхдийнхээс өндөр байлаа.

ХҮСНЭГТ 6.7. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ, НАС, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН

Нас	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	мян.хүн	хувь*	мян.хүн	хувь	мян.хүн	хувь
БҮГД	123.2	82.2	63.0	81.8	60.2	82.6
2	21.3	61.6	11.0	61.3	10.3	62.0
3	31.1	82.9	15.9	82.4	15.2	83.4
4	34.4	89.2	17.6	88.8	16.8	89.6
5	36.4	92.8	18.5	92.6	17.9	93.0


* - Тухайн насны хүүхдийн тоонд харьцуулав

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын хувь Налайх, Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүрэгт нийслэлийн дунджаас 0.9-6.9 пунктээр доогуур байв. Иймээс сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын түвшнийг нэмэгдүүлэх үүднээс дээрх дүүргүүдэд түлхүү анхаарал хандуулах шаардлагатай.

ХҮСНЭГТ 6.8. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ, НАС, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2020 ОН

Дүүрэг	Бүгд	Насаар			
		2	3	4	5
БҮГД	82.2	61.6	82.9	89.2	92.8
Багануур	89.9	75.0	92.2	94.6	95.5
Багахангай	87.2	68.7	93.5	97.6	93.5
Баянгол	86.7	67.4	89.0	93.3	94.8
Баянзүрх	79.6	57.5	79.7	87.3	91.8
Налайх	75.3	50.4	74.2	81.0	91.8
Сонгинохайрхан	81.0	61.0	81.4	87.6	91.4
Сүхбаатар	83.1	63.5	84.6	89.7	92.3
Хан-Уул	83.9	62.2	84.7	92.0	94.8
Чингэлтэй	81.3	62.2	81.0	87.5	92.0

ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ




ӨРХИЙН ТОО, БҮТЭЦ

Өрх, гэр бүл нь хүний хөгжил, төлөвшлийн анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж, соёл, зан заншил, уламжлал өвлөгдөн шинэчлэгдэх, аж төрөх ёсны бичил ахуй мөн. Ийм учраас манай оронд өрх, гэр бүлийн асуудлыг төрийн хэмжээнд ихээхэн анхаарч, гэр бүлийг төрөөс хамгаалах, түүний хөгжлийн таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх талаар хууль эрх зүй, бодлогын цөөнгүй баримт бичгүүд батлагдан мөрдөгдөж байна.

Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрх гэдэг ойлголт нь гэр бүл гэдэг ойлголтоос ялгаатай. Нэг өрхөд хэд хэдэн гэр бүл амьдарч байж болно.

Хүн амыг өмнөх тооллогын нэгэн адил өрхөд, өрх үүсгээгүй нэгжид тоологдсон гэж 2 ангилсан. Өрх үүсгээгүй нэгж гэж нийтээрээ буюу хэсэг бүлгээрээ амьдарч байгаа, хоорондоо ураг, төрөл, хамаатан садны ямар нэг холбоогүй хүмүүсийг хэлнэ. Өрх үүсгээгүй нэгжийн хүмүүс ихэвчлэн цэрэг, хоригдол, оюутан сурагчид болон ажиллагчдын нийтийн байр, эмнэлэг, сувилал, зочид буудлын нэг өрөөнд хамт амьдарч байгаа болон орон сууцны нэг өрөө буюу бүхэлд нь хөлслөн сууж байгаа мөн байшингийн дээвэр хонгил, орц, дулааны шугам сүлжээний сувагт хамт амьдардаг, ураг төрөл, хамаатан садны холбоогүй хүмүүс юм.

ЗУРАГ 7.1. ӨРХ, ӨРХӨД ХАМААРАЛГҮЙ ТООЛОГДСОН ХҮН АМЫН ТОО, 2020 ОН



Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр 411.4 мянган өрхөд суурин хүн амын 97.3 хувь буюу 1 426 085 хүн, өрх үүсгээгүй нэгжид 2.7 хувь буюу 40 040 хүн тус тус тоологдов.

ХҮСНЭГТ 7.1. ӨРХ, ӨРХ ҮҮСГЭЭГҮЙ НЭГЖИД ТООЛОГДСОН ХҮН АМЫН ТОО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

	2010		2020		2020 2010 %
	мян.хүн	дүнд эзлэх хувь	мян.хүн	дүнд эзлэх хувь	
БҮГД	1 154.3	100.0	1 466.1	100.0	127.0
Өрхөд	1 114.9	96.6	1 426.1	97.3	127.9
Өрх үүсгээгүй нэгжид	39.4	3.4	40.0	2.7	101.7

Өрхөд тоологдсон хүний тоо өмнөх тооллогын үеийнхээс 311.2 мянган (27.9%) хүнээр, өрх үүсгээгүй нэгжид тоологдсон хүний тоо 0.6 мянган (1.7%) хүнээр өссөн байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр Монгол Улсад амьдарч байгаа нийт 897.4 мянган өрхийн 411.4 мянга (45.8%) нь нийслэл хотод амьдарч байна. Энэ нь өмнөх тооллогын дүнгээс 109.2 мянган (36.1%) өрхөөр өсжээ.

ХҮСНЭГТ 7.2. ӨРХИЙН ТОО, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Дүүрэг	2010		2020		2020 2010 %
	өрхийн тоо	дүнд эзлэх хувь	өрхийн тоо	дүнд эзлэх хувь	
БҮГД	302 242	100.0	411 420	100.0	136.1
Багануур	6 430	2.1	8 133	2.0	126.5
Багахангай	952	0.3	1 131	0.3	118.8
Баянгол	47 507	15.7	62 976	15.3	132.6
Баянзүрх	73 376	24.3	104 764	25.5	142.8
Налайх	8 093	2.7	10 248	2.5	126.6
Сонгинохайрхан	65 866	21.8	93 521	22.7	142.0
Сүхбаатар	33 513	11.1	40 061	9.7	119.5
Хан-Уул	28 782	9.5	51 241	12.5	178.0
Чингэлтэй	37 723	12.5	39 345	9.5	104.3

2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад Хан-Уул (78.0%), Баянзүрх (42.8%), Сонгинохайрхан (42.0%) дүүрэгт өрхийн тоо хамгийн их өсжээ. Энэ нь нэг талаар орон нутгаас шилжин ирсэн өрхүүд дийлэнхдээ Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт суурьшдаг, нөгөө талаар Хан-Уул дүүрэгт орон сууцжилт ихээр явагдаж байгаагаас үүдэн нийслэлийн бусад дүүргүүдээс шилжин ирж амьдарч байгаатай холбоотой. Энд онцлоход Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдийн өрхийн өсөлт бусад дүүргүүд болон нийслэлийн дунджаас 16.6-31.8 пунктээр доогуур байна.

НҮБ-ын аргачлалын дагуу өрхийг хэлбэрээр нь ангилахдаа өрхийн тэргүүлэгчтэйгээ ямар хамааралтай болохыг харгалзан үзэж тодорхойлдог. Өрхийн талаарх мэдээлэл нь тухайн орны ёс заншил, өрх гэр бүлийн өөрчлөлтийг судлахад ач холбогдолтойгоос гадна хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн бодлого төлөвлөлтийн үндсэн гол мэдээлэл болж өгдөг.

ЗУРАГ 7.2 ӨРХИЙН ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН



Тооллогоор нийслэлийн нийт өрхийн 52.4 хувийг ам бүлээрээ байгаа өрх, 28.9 хувийг нийлмэл өрх, 14.6 хувийг ганц бие өрх, 4.1 хувийг холимог өрх эзэлж байна.

Өмнөх тооллогын дүнгээс ам бүлээрээ байгаа өрх 52.8 мянга (32.4%), нийлмэл өрх 15.9 мянга (15.4%), ганц бие өрх 31.4 мянга (2.1 дахин), холимог өрх 9.2 мянгаар (2.2 дахин) тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 7.3. ӨРХИЙН ТОО, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Өрхийн хэлбэр	2010		2020		2020 2010 %
	өрхийн тоо	дүнд эзлэх хувь	өрхийн тоо	дүнд эзлэх хувь	
БҮГД	302 242	100.0	411 420	100.0	136.1
Ганц бие	28 835	9.5	60 208	14.6	208.8
Ам бүлээрээ	162 736	53.8	215 510	52.4	132.4
Нийлмэл	102 976	34.1	118 840	28.9	115.4
Холимог	7 695	2.6	16 862	4.1	219.1

2010 оны тооллогын дүнгээс нийт өрхөд ганц бие өрх, холимог өрхийн эзлэх хувь 1.5-5.1 пунктээр өссөн бол ам бүлээрээ байгаа өрх, нийлмэл өрхийн эзлэх хувь 1.4-5.2 пунктээр буурсан байна.

Гэр бүл судлаачдын үзэж байгаагаар орчин үеийн хотын нийлмэл өрхийн хэв шинж сүүлийн хорь орчим жилд нэлээд өөрчлөгдөж, өмнө нь залуучууд эцэг эхээ асран тэтгэдэг байсан бол одоо залуучууд эцэг эхийнхээ халамжинд амьдардаг болсон гэж дүгнэсэн байдаг. Ерөнхийдөө Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод байрны олдоц, үнэ, иргэдийн боломж зэрэг олон хүчин зүйлээс үүдэн залуу гэр бүл эцэг, эхтэйгээ хамт амьдарч нийлмэл өрхийг үүсгэдэг байна. Энэ удаагийн тооллогоор нийт өрхөд нийлмэл өрхийн эзлэх хувь буурч байгаа нь нэлээд эерэг үзүүлэлт юм. Үүнийг төрөөс залуу гэр бүлийг дэмжиж урт хугацааны ипотекийн зээл олгож байгаа нь нийлмэл өрхийн хувь багасахад гол нөлөө үзүүлсэн гэж үзэж байна. Энд анхаарал татаж байгаа зүйл бол ганц бие өрхийн тоо болон хувь нэмэгдэж байгаа явдал юм.

ХҮСНЭГТ 7.4. ӨРХИЙН ТОО, ДҮҮРЭГ, ӨРХИЙН ХЭЛБЭР, ХУВИАР, 2020 ОН

Дүүрэг	Бүгд		Ганц бие өрх		Ам бүлээрээ байгаа өрх		Нийлмэл ам бүлтэй өрх		Холимог ам бүлтэй өрх	
	өрх	хувь	өрх	хувь	өрх	хувь	өрх	хувь	өрх	хувь
БҮГД	411 420	100.0	60 208	14.6	215 510	52.4	118 840	28.9	16 862	4.1
Багануур	8 133	100.0	1 255	15.4	4 574	56.2	2 128	26.2	176	2.2
Багахангай	1 131	100.0	150	13.2	623	55.1	331	29.3	27	2.4
Баянгол	62 976	100.0	8 952	14.2	29 789	47.3	20 657	32.8	3 578	5.7
Баянзүрх	104 764	100.0	16 987	16.2	56 676	54.1	27 095	25.9	4 006	3.8
Налайх	10 248	100.0	1 307	12.8	5 938	57.9	2 807	27.4	196	1.9
Сонгинохайрхан	93 521	100.0	14 916	16.0	49 785	53.2	25 550	27.3	3 270	3.5
Сүхбаатар	40 061	100.0	5 441	13.6	20 261	50.6	12 490	31.2	1 869	4.6
Хан-Уул	51 241	100.0	6 743	13.2	28 856	56.3	13 889	27.1	1 753	3.4
Чингэлтэй	39 345	100.0	4 457	11.3	19 008	48.3	13 893	35.3	1 987	5.1

Өрхийн хэлбэрийг дүүргээр харахад нэлээд сонирхолтой дүр зураг харагдаж байна. Тодруулбал, нийлмэл өрхийн тухайн дүүргийн нийт өрхөд эзлэх хувь Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Багахангай дүүрэгт нийслэлийн дунджаас 0.4-6.4 пунктээр дээгүүр байна. Эдгээр дүүргүүдэд орон сууцны хуучин барилгууд нэлээд их, оршин суугчид нь ч хотод олон жил амьдарсан хүмүүс байдаг, мөн орон нутгаас шилжин ирэгчид харьцангуй багатай, тэгэхээр нийслэлд олон жил суурьшсан иргэдийн хувьд эцэг эхтэйгээ хамт амьдрах тохиолдол элбэг байдаг ажээ.

Улаанбаатар хотын хэмжээнд ам бүлийн дундаж тоо 3.6 болсон нь улсын дүнтэй ижил, өмнөх тооллогоос 0.1-ээр буурчээ.

ХҮСНЭГТ 7.5. ӨРХИЙН ТОО, ДҮҮРЭГ, АМ БҮЛИЙН ТОО, ХУВИАР, 2020 ОН

Дүүрэг	Бүгд		1-2		3-4		5-6		7+		Өрхийн ам бүлийн дундаж тоо
	өрх	хувь	өрх	хувь	өрх	хувь	өрх	хувь	өрх	хувь	
БҮГД	411 420	100.0	126 324	30.7	156 987	38.2	94 349	22.9	33 760	8.2	3.6
Багануур	8 133	100.0	2 615	32.1	3 168	39.0	1 849	22.7	501	6.2	3.5
Багахангай	1 131	100.0	346	30.6	421	37.2	256	22.6	108	9.6	3.6
Баянгол	62 976	100.0	18 499	29.4	23 612	37.5	14 634	23.2	6 231	9.9	3.6
Баянзүрх	104 764	100.0	34 362	32.8	40 571	38.7	22 716	21.7	7 115	6.8	3.5
Налайх	10 248	100.0	2 961	28.9	3 912	38.2	2 577	25.1	798	7.8	3.7
Сонгинохайрхан	93 521	100.0	29 759	31.8	35 307	37.8	21 417	22.9	7 038	7.5	3.5
Сүхбаатар	40 061	100.0	12 349	30.8	15 219	38.0	8 940	22.3	3 553	8.9	3.6
Хан-Уул	51 241	100.0	14 807	28.9	20 062	39.1	12 229	23.9	4 143	8.1	3.7
Чингэлтэй	39 345	100.0	10 626	27.0	14 715	37.4	9 731	24.7	4 273	10.9	3.8

Нийт өрхөд эзлэх хувийг ам бүлийн тоотой харьцуулж үзэхэд өнгөрсөн арван жилийн хугацаанд ихээхэн өөрчлөгджээ. Тухайлбал, 1-2 ам бүлтэй өрхийн эзлэх хувь 5.8 пункт, 5-6 ам бүлтэй өрх 0.8 пункт, долоо, түүнээс дээш ам бүлтэй өрх 2.5 пунктээр тус тус өссөн бол 3-4 ам бүлтэй өрх 9.1 пунктээр буурсан байна. Үүнийг шилжих хөдөлгөөн өөрөөр хэлбэл, хотод их, дээд сургуульд суралцагчид болон ажил хөдөлмөр хийхээр шилжин ирсэн хүмүүс тусдаа өрх болж тоологдсонтой холбон тайлбарлаж болох юм.

Өрхийн ам бүлийн дундаж тоо Чингэлтэй, Хан-Уул, Налайх дүүрэгт нийслэлийн дунджаас 0.1-0.2-оор өндөр байгаа бол Багануур, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт 0.1-ээр доогуур байна. 1-2 ам бүлтэй өрхийн тухайн дүүргийн нийт өрхөд эзлэх хувь Багануур, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт, 3-4 ам бүлтэй өрхийнх Хан-Уул, Багануур, Баянзүрх дүүрэгт, 5-6 ам бүлтэй өрхийнх Налайх, Чингэлтэй, Хан-Уул дүүрэгт, 7, түүнээс дээш ам бүлтэй өрхийнх Чингэлтэй, Баянгол, Багахангай дүүрэгт тус тус өндөр байв.

ХҮСНЭГТ 7.6. ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙС, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХУВИАР, 2020 ОН

Гэр бүлийн байдал	Бүгд		Эрэгтэй тэргүүлэгчтэй		Эмэгтэй тэргүүлэгчтэй	
	өрх	дүнд эзлэх хувь	өрх	дүнд эзлэх хувь	өрх	дүнд эзлэх хувь
БҮГД¹	411 308	100.0	273 106	100.0	138 202	100.0
Огт гэр бүл болоогүй	52 536	12.8	24 383	8.9	28 153	20.4
Гэр бүлтэй ²	304 392	74.0	238 362	87.3	66 030	47.8
Цуцалсан ³	17 117	4.2	4 531	1.7	12 586	9.1
Бэлэвсэн	37 263	9.0	5 830	2.1	31 433	22.7

¹ гадаад өрхийн тэргүүлэгчтэй өрх ороогүй.
² батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.
³ тусгаарласан хүмүүсийг оруулсан.

Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн 8.9 хувь нь огт гэр бүл болоогүй өрх байхад эмэгтэй тэргүүлэгчтэй өрх 20.4 хувьд хүрч байна. Мөн эмэгтэй тэргүүлэгчтэй нийт өрхийн 47.8 хувь нь гэр бүлтэй, 9.1 хувийг гэрлэлтээ цуцалсан болон тусгаарласан, 22.7 хувийг бэлэвсэн эмэгтэйчүүд эзэлж байна. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн гэрлэлтээ цуцалсан болон тусгаарласан хувь 2010 оноос 7.5 пункт, бэлэвсэн эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо 6.8 пунктээр буурчээ.

ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Монгол Улсын “Гэр бүлийн тухай” хуулиар манай оронд 18 нас хүрсэн хүн гэрлэх боловч гэрлэгчид хоёулаа эсхүл хэн нэг нь 18 нас хүрээгүй хүнийг иргэний хуульд заасны дагуу “иргэний эрх зүйн бүрэн чадамжтай (хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүх 16-18 хүртэлх насны иргэнийг, түүний хүсэлт, түүний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжтай гэж тооцно.)” гэж зарласан тохиолдолд гэрлэлтийг хүчинтэйд тооцно. Гэр бүлийн байдлын тухай асуултыг Нэгдсэн Үндэсний Байгууллагын (НҮБ) зөвлөмжийн дагуу олон улсын хэмжээнд харьцуулагдахуйц байхын тулд тооллогоор 15, түүнээс дээш настай хүн бүрээс асуусан юм.

Иргэний бүртгэлийн мэдээллээр гэрлэлт түүнтэй харьцах цуцлалтын тоо жил ирэх тутам нэмэгдэж байна. Монгол Улсын хэмжээнд 2019 оны байдлаар өдөрт 12 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 55 хос гэрлэлтээ бүртгүүлсэн байна. Харин энэ үзүүлэлт Улаанбаатар хотод харгалзан цуцлалт 7, гэрлэлт 29 байна. 1000 хүн амд ногдох гэрлэлт нийслэл хот улсын хэмжээнээс 1.6 пунктээр (Улаанбаатар 11.4, улсын хэмжээнд 9.8), гэр бүл цуцлалт 0.8 пунктээр (Улаанбаатар 2.9, улсын хэмжээнд 2.1) тус тус өндөр байна. Гэрлэлтээ бүртгүүлж буй насыг авч үзвэл 70 гаруй хувь нь 20-29 насныхан байгаа бол гэрлэлтээ цуцлуулж байгаа 3 хос тутмын хоёр нь 10 ба түүнээс дээш жил хамт амьдарсныхаа эцэст гэр бүлээ цуцлуулсан байна.

Хүн амын төрөлт, өсөлтөд шууд нөлөөлдөг хүчин зүйл бол гэр бүлийн байдал юм. Гэрлэх нь үндэсний соёл, уламжлалтай нягт холбоотой явагддаг нийгмийн үзэгдэл тул түүний үндсэн төрх тооллого хоорондын жилүүдэд төдийлөн өөрчлөгдөөгүй байна.

ХҮСНЭГТ 7.7. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН

Гэр бүлийн байдал	2000		2010		2020	
	мян.хүн	дүнд эзлэх хувь	мян.хүн	дүнд эзлэх хувь	мян.хүн	дүнд эзлэх хувь
БҮГД	531.2	100.0	871.9	100.0	975.4	100.0
Огт гэр бүл болоогүй	189.3	35.6	303.8	34.8	300.8	30.8
Гэр бүлтэй ¹	291.2	54.9	494.1	56.7	598.8	61.4
Цуцалсан ²	19.3	3.6	32.5	3.7	26.0	2.7
Бэлэвсэн	31.4	5.9	41.5	4.8	49.8	5.1

¹ батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.

² тусгаарласан хүмүүсийг оруулсан.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор Улаанбаатар хотын арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын дотор гэр бүлтэй хүн амын эзлэх хувь 61.4 болж 2010 оныхоос 4.7 пунктээр өсжээ. Хүснэгтээс харахад ч 2000 оноос хойш гэр бүлтэй хүний тоо тогтмол нэмэгдэж байна. Өнгөрсөн 10 жилд арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын дотор гэр бүл цуцалсан хүний эзлэх хувь 1.0 пунктээр буюу 6.5 мянган хүнээр буурчээ. Харин бэлэвсэн хүний тоо 8.3 мянган хүнээр буюу 0.3 пунктээр өссөн аж.

ХҮСНЭГТ 7.8. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН

Гэр бүлийн байдал	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	мян.хүн	дүнд эзлэх хувь	мян.хүн	дүнд эзлэх хувь	мян.хүн	дүнд эзлэх хувь
БҮГД	975.4	100.0	458.2	100.0	517.3	100.0
Огт гэр бүл болоогүй	300.8	30.8	155.9	34.0	144.9	28.0
Гэр бүлтэй ¹	598.8	61.4	285.9	62.4	313.0	60.5
Цуцалсан ²	26.0	2.7	8.8	1.9	17.2	3.3
Бэлэвсэн	49.8	5.1	7.6	1.7	42.2	8.2


1 батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.

2 тусгаарласан хүмүүсийг оруулсан.

15, түүнээс дээш насны хүн амын 34.0 хувийг огт гэр болоогүй эрэгтэйчүүд эзэлж байхад эмэгтэйчүүд 28.0 хувийг буюу 6.0 пунктээр бага байна. Энэ зөрүү 2010 онд 4.7 пункт байсан бол энэ удаагийн тооллогоор 1.3 дахин нэмэгджээ. Үүнийг нэг талаас эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол харьцангуй залуудаа нөхөрт гардаг, нөгөө талаас гадаадад ажил эрхлэхээр явж байгаа хүмүүсийн дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр, түүнчлэн уул уурхайн хөгжлийг дагаад эрэгтэйчүүд олон сараар хөдөө орон нутагт суурьшиж ажилладаг гэх мэт олон хүчин зүйл нөлөөлдөг.

Хүн ам зүйн судалгааны гол үзүүлэлтийн нэг бол анхны гэрлэлтийн дундаж нас юм. Энэ үзүүлэлтийг тодорхойлсноор тухайн улсын хүн амын гэр бүлийн ерөнхий төлөв байдлыг дүгнэх боломжтой болдог. Анхны гэрлэлтийн дундаж насыг тухайн насны хүн амд эзлэх огт гэр бүл болоогүй хүн амд үндэслэн тооцдог бөгөөд өөрөөр хэлбэл, эрэгтэй, эмэгтэйчүүд дунджаар анх хэдэн насандаа гэр бүл болж байгааг илэрхийлдэг. Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллогын дүнгээр улсын дунджаар эмэгтэйчүүд 26.7 насандаа, нийслэлд 27.2 насандаа, эрэгтэйчүүд 28.6 насандаа, нийслэлд 28.5 насандаа анх гэр бүл болж байна.

ЗУРАГ 7.3. АНХНЫ ГЭРЛЭЛТИЙН ДУНДАЖ НАС, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР



Аливаа улс орны залуу үеийнхний боловсролын түвшин, ажил эрхлэлт нэмэгдэхийн хэрээр тэдний анхны гэрлэлтийн дундаж нас хойшилж, төрөлтийн түвшин буурч байгааг хүн ам зүйн онолоор тайлбарлаж, хөгжингүй орнуудын олон жишээн дээр харж болно. Өөрөөр хэлбэл, хүн төрөлхтөний хөгжлийн зүй тогтол ч гэж хэлж болно. Нийслэлийн хүн амын анхны гэрлэлтийн дундаж нас сүүлчийн гуч гаруй жилд эрэгтэй, эмэгтэйчүүдэд адилхан 7 насаар хойшилсон байна. Анхны гэрлэлтийн дундаж нас хамгийн ихээр нэмэгдэж байсан үе бол 1989-

2000 оны хооронд 4-5 насаар нэмэгдэж байсан бол 2010-2020 оны хооронд ойролцоогоор хоёр насаар хойшилжээ. Харин эрэгтэй, эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж насны ялгаа ойролцоогоор нэг нас байгаа нь сүүлчийн гуч гаруй жилд өөрчлөгдсөнгүй.

ХҮСНЭГТ 7.9. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	Бүгд	Эрэгтэй				Бүгд	Эмэгтэй			
		Огт гэр бүл болоогүй	Гэр бүлтэй ¹	Цуцалсан ²	Бэлэвсэн		Огт гэр бүл болоогүй	Гэр бүлтэй ¹	Цуцалсан ²	Бэлэвсэн
2010										
ДҮН	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-24	32.7	73.6	9.0	2.3	0.1	31.7	76.1	12.1	3.4	0.2
25-34	25.1	18.5	30.4	19.6	1.6	24.0	16.7	31.4	21.2	2.4
35-44	18.7	5.6	26.6	37.1	7.2	18.2	4.8	25.7	36.3	9.4
45-54	13.5	1.7	19.9	30.3	19.2	14.0	1.8	18.8	29.7	23.3
55-64	5.7	0.4	8.5	8.4	22.6	6.6	0.4	7.7	7.5	25.5
65+	4.3	0.2	5.6	2.3	49.3	5.5	0.2	4.3	1.9	39.2
2020										
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-24	18.7	51.6	1.7	0.4	0.0	16.7	53.1	2.9	0.6	0.0
25-34	28.1	33.6	26.4	9.3	1.3	26.6	31.5	28.7	11.3	1.1
35-44	22.5	9.4	30.1	25.0	5.0	21.5	9.4	29.0	25.8	4.9
45-54	15.7	3.9	21.5	36.1	13.4	16.1	4.0	20.8	35.0	15.4
55-64	9.8	1.2	13.6	23.5	28.5	11.7	1.6	13.1	22.6	32.1
65+	5.2	0.3	6.7	5.7	51.8	7.4	0.4	5.5	4.7	46.5

1 батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.
2 тусгаарласан хүмүүсийг оруулсан.

Хүн амын гэр бүлийн байдлыг насны бүлэг болон хүйсээр авч үзэхэд огт гэр болоогүй иргэдийн нийт хүн амд эзлэх хувь аль ч хүйсэнд нас ахих тусам буурч байна. Харин гэр бүлтэй эмэгтэйчүүд 15-34 насанд илүү, түүнээс хойших насанд эрэгтэйчүүд нь олон байна. Энэ нь дээр хэлсэнчлэн эмэгтэйчүүд илүү эрт нөхөрт гардагтай холбоотой юм.

Тэгвэл тухайн насны бүлгийн хүн амд ногдох гэрлэлтийн байдлыг хүйсээр харахад 15-24 насанд эрэгтэйчүүдийн огт гэр болоогүй хувь эмэгтэйчүүдийнхээс 4.9 пункт, 25-34 насанд эмэгтэйчүүдийнхээс 7.6 пунктээр тус тус илүүрхэж, улмаар нас ахих тусам аль аль хүйс нь ойролцоо түвшинд буурсан байна.

ХҮСНЭГТ 7.10. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН


Насны бүлэг	Эрэгтэй					Эмэгтэй				
	Бүгд	Огт гэр бүл болоогүй	Гэр бүлтэй ¹	Цуцалсан ²	Бэлэвсэн	Бүгд	Огт гэр бүл болоогүй	Гэр бүлтэй ¹	Цуцалсан ²	Бэлэвсэн
2010										
ДҮН	100.0	37.3	57.8	3.1	1.8	100.0	32.6	55.6	4.3	7.5
15-24	100.0	84.0	15.8	0.2	0.0	100.0	78.2	21.3	0.4	0.1
25-34	100.0	27.4	70.1	2.4	0.1	100.0	22.7	72.8	3.8	0.7
35-44	100.0	11.1	82.1	6.1	0.7	100.0	8.7	78.8	8.6	3.9
45-54	100.0	4.8	85.7	6.9	2.6	100.0	4.2	74.3	9.2	12.3
55-64	100.0	2.6	85.8	4.5	7.1	100.0	2.0	64.4	4.9	28.7
65+	100.0	1.8	75.8	1.7	20.7	100.0	1.0	43.9	1.5	53.6
2020										
БҮГД	100.0	34.0	62.4	1.9	1.7	100.0	28.0	60.5	3.3	8.2
15-24	100.0	94.1	5.9	0.0	0.0	100.0	89.2	10.7	0.1	0.0
25-34	100.0	40.7	58.6	0.6	0.1	100.0	33.1	65.2	1.4	0.3
35-44	100.0	14.2	83.3	2.1	0.4	100.0	12.3	81.8	4.0	1.9
45-54	100.0	8.6	85.6	4.4	1.4	100.0	7.0	78.0	7.2	7.8
55-64	100.0	4.2	86.4	4.6	4.8	100.0	3.8	67.5	6.4	22.3
65+	100.0	1.7	79.7	2.1	16.5	100.0	1.5	45.0	2.1	51.4

1 батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.

2 тусгаарласан хүмүүсийг оруулсан.

Гэр бүлтэй хүмүүсийн хувьд энэ үзүүлэлтийг авч үзэхэд 45 хүртэлх насанд хүйсийн хувьд ойролцоо түвшинд байснаа түүнээс дээш насанд тухайн насны бүлэгт эзлэх гэр бүлтэй эрэгтэйчүүдийн хувь эмэгтэйчүүдийнхээс нэмэгдсээр 65, түүнээс дээш насанд 34.8 пунктээр өндөр болж байв. Үүнийг нэгдүгээрт, эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхээс доогуур, хоёрдугаарт, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо олон байдгаар тайлбарлагдана. Мөн 65, түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн дунд бэлэвсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс ойролцоогоор 3 дахин өндөр байгаа нь дээрх тайлбарыг баталж байна.

ЗУРАГ 7.4. ГЭР БҮЛЭЭ ЦУЦАЛСАН ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН



Гэр бүлээ цуцалсан хүний тоог хүйсээр ангилж үзэхэд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс аль ч насны бүлэгт ойролцоогоор хоёр дахин их, ялангуяа 45-54 насанд хамгийн их зөрүүтэй байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, БҮТЭЦ



Улсын хэмжээнд **106.4** мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Үүний **36.7** мянга (**34.5%**) нь Нийслэлд амьдарч байна.

БУСАД
29.8%

ЯРИАНЫ
3.0%

ХАВЦАРСАН
6.4%

СОНГОЛЫН
8.6%

ХӨДӨЛГӨӨНИЙ
20.9%

СЭТГЭЦИЙН
19.9%

ХАРААНЫ
11.4%



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгэм сэтгэл зүйн хэрэгцээт үйлчилгээг авах, бусдын нэгэн адил амьдрах тэгш эрхийг хүлээн зөвшөөрч, энэхүү эрхээ эдлэх явдлыг хангах, нийгмийн харилцаанд бүрэн дүүрэн хамрагдах, оролцохыг дэмжих, соёл урлаг, спортын арга хэмжээнд тэгш хамруулах, авьяас чадварыг нь нээн хөгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүнд урлаг, соёлын бүтээл хүртээмжтэй байх асуудлыг боловсронгуй болгох зорилгоор 2016 онд Улсын Их Хурлаас Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг батлан хэрэгжүүлж байна. Тус хуулийн хүрээнд Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хамгааллын үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна.

Энэ удаагийн тооллогоор иргэдийн хөгжлийн бэрхшээлийн төрлөөр нэлээд дэлгэрэнгүй асуулт оруулж өгснөөрөө өмнөх тооллогуудаас ялгаатай. Хүн ам, орон сууцны тооллогын нэг онцлог бол хөгжлийн бэрхшээлийг тодорхойлохдоо тухайн иргэнд тулгарч байгаа хөгжлийн бэрхшээлийг нь өөрсдийн үнэлснээр тодорхойлдог бол харин эрүүл мэндийн байгууллага болон бусад бүртгэл судалгаанд эрүүл мэндийн байгууллагаар батлагдсан оношоор тодорхойлдог учраас гарах үр дүн зөрүүтэй байдаг. Үүнийг хэрэглэгчид анхаарч ашиглах нь зүйтэй.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын онцлогоос шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо мэдээллийг Хүн ам, өрхийн мэдээллийн сан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон Эрүүл мэндийн яамны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн сангуудыг уялдуулж гаргасан.


ХҮСНЭГТ 8.1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Хүний тоо	дүнд эзлэх хувь	Хүний тоо	дүнд эзлэх хувь	Хүний тоо	дүнд эзлэх хувь
БҮГД	36 685	100.0	20 198	100.0	16 487	100.0
0-4	624	1.7	351	1.7	273	1.6
5-9	1 387	3.8	794	3.9	593	3.6
10-14	1 230	3.4	686	3.4	544	3.3
15-19	1 022	2.8	594	2.9	428	2.6
20-24	1 291	3.5	734	3.6	557	3.4
25-29	2 121	5.8	1 171	5.8	950	5.8
30-34	2 932	8.0	1 634	8.1	1 298	7.9
35-39	3 430	9.3	1 853	9.2	1 577	9.6
40-44	3 639	9.9	1 874	9.3	1 765	10.7
45-49	4 389	12.0	2 277	11.3	2 112	12.8
50-54	5 115	13.9	2 658	13.2	2 457	14.9
55-59	5 008	13.7	2 955	14.6	2 053	12.4
60-64	2 568	7.0	1 632	8.1	936	5.7
65-69	932	2.5	573	2.8	359	2.2
70+	997	2.7	412	2.1	585	3.5

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 106.4 мянган хүн байгаа нь суурин хүн амын 3.3 хувийг эзэлж, 2010 оноос 0.8 пунктээр буурсан байна. Үүний 36.7 мянга (34.5%) нь Улаанбаатар хотод амьдарч байна. Нийслэл хотын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 36.7 мянган хүн байгаа нь суурин хүн амын 2.5 хувийг эзэлж байна. Энэ нь улсын дундажтай харьцуулахад 0.8 пунктээр бага үзүүлэлт юм. Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүний 20.2 мянга (55.1%) нь эрэгтэй, 16.5 мянга (44.9%) нь эмэгтэйчүүд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний 5.5 хувь нь 0-9 настай хүүхэд, 6.2 хувь нь 10-19 нас буюу өсвөр үеийнхэн, 9.3 хувь нь 20-29 насныхан, 17.3 хувь нь 30-39 насныхан, 21.9 хувь нь 40-49 насныхан, 27.6 хувь нь 50-59 насныхан, 12.2 хувь нь 60-аас дээш насныхан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийг 2010 онтой харьцуулахад 10-19 нас, 20-29 нас, 40-49 насны бүлэгт буурчээ.

ЗУРАГ 8.1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН




Хөгжлийн бэрхшээлтэй хүний нас, хүйсийн суваргаас харахад 15-19 насны бүлгээс дээш 55-59 насны бүлэг хүртэл, нас ахих тусам хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо аль ч хүйсэд өсч байснаа 60, түүнээс дээш насанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо огцом буурч байна. Энэ нь нас баралттай холбоотой. Мөн 54-69 насны хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй хүн амын тоо эмэгтэйчүүдээс илүү байгаа нь ажиглагдаж байна. Харин 70, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс олон байгаа нь эмэгтэйчүүд өндөр насалдагтай холбоотой юм.

ХҮСНЭГТ 8.2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ДҮҮРЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН

Дүүрэг	Бүгд		Хүйс				Нийт хүн амд эзлэх хувь
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Эрэгтэй	Эзлэх хувь	Эмэгтэй	Эзлэх хувь	
БҮГД	36 685	100.0	20 198	100.0	16 487	100.0	2.5
Багануур	1 092	3.0	623	3.1	469	2.9	3.8
Багахангай	168	0.4	96	0.5	72	0.4	4.1
Баянгол	5 149	14.0	2 778	13.7	2 371	14.4	2.3
Баянзүрх	7 883	21.5	4 260	21.1	3 623	22.0	2.2
Налайх	1 566	4.3	934	4.6	632	3.8	4.2
Сонгинохайрхан	8 349	22.8	4 588	22.7	3 761	22.8	2.5
Сүхбаатар	3 413	9.3	1 892	9.4	1 521	9.2	2.4
Хан-Уул	4 527	12.3	2 525	12.5	2 002	12.1	2.4
Чингэлтэй	4 538	12.4	2 502	12.4	2 036	12.4	3.0

Монгол Улсад оршин суугаа хөгжлийн бэрхшээлтэй гурван иргэн тутмын нэг нь нийслэлд амьдарч байна. Гэхдээ дүүргүүдээр авч үзэхэд харилцан адилгүй байна. Тухайлбал, нийслэл хотын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 44.3 хувь нь Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт ногдож байна. Мэдээж энэ нь тухайн дүүргүүдэд хүн амын тоо харьцангуй өндөр байдагтай холбоотой юм. Дүүргүүдийг харьцуулан дүгнэх үүднээс тухайн дүүргийн хүн амд эзлэх хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийг гаргаж үзэхэд Багануур (3.8 хувь), Багахангай (4.1 хувь), Налайх (4.2 хувь), Чингэлтэй (3.0 хувь) дүүргүүд нийслэлийн дунджаас 0.5-1.7 пунктээр өндөр байна.


ЗУРАГ 8.2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ДҮҮРГЭЭР, НИЙТ ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХЭЛБЭР

Хөгжлийн бэрхшээлийн төрлийг төрөлхийн ба олдмол гэсэн ангиллаар тодорхойлсон. Тухайн хүнд удамшлын шинжтэйгээр бий болсон хөгжлийн бэрхшээлийг төрөлхийн, амьдралын явцад бий болсон хөгжлийн бэрхшээлийг олдмол гэсэн төрөлд хамааруулсан. Харин хөгжлийн бэрхшээлийн хэлбэр нь бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согог нь тухайн иргэнд ямар байдлаар илэрч байгаатай холбоотой бөгөөд харааны, ярианы, сонсголын, хөдөлгөөний, сэтгэцийн, бусад (дээрхээс бусад) гэсэн 6 ангиллаар авч үзсэн.

ЗУРАГ 8.3. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН




Хөгжлийн бэрхшээлтэй 36.7 мянган хүний 18.3 мянга (49.9%) нь төрөлхийн, үлдсэн 18.4 мянга (50.1%) нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байна.

ХҮСНЭГТ 8.3. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХҮЙС ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭР, ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН

Төрөл	Бүгд		Хөгжлийн бэрхшээлийн төрөл			
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Төрөлхийн	Дүнд эзлэх хувь	Олдмол	Дүнд эзлэх хувь
БҮГД	36 685	100.0	18 296	100.0	18 389	100.0
Хүйс						
Эрэгтэй	20 198	55.1	9 658	52.8	10 540	57.3
Эмэгтэй	16 487	44.9	8 638	47.2	7 849	42.7
Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр						
Харааны	4 188	11.4	2 387	13.0	1 801	9.8
Ярианы	1 109	3.0	954	5.2	155	0.8
Сонсголын	3 137	8.6	2 012	11.0	1 125	6.1
Хөдөлгөөний	7 652	20.9	3 486	19.1	4 166	22.7
Сэтгэцийн	7 316	19.9	4 834	26.4	2 482	13.5
Хавсарсан	2 360	6.4	1 254	6.9	1 106	6.0
Бусад	10 923	29.8	3 369	18.4	7 554	41.1

Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 52.8 хувь, олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 57.3 хувь эрэгтэйчүүд байлаа.

ЗУРАГ 8.4. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010, 2020 ОН




Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй 36.7 мянган хүний 4.2 мянга (11.4%) нь харааны, 1.1 мянга (3.0%) нь ярианы, 3.1 мянга (8.6%) нь сонсголын, 7.7 мянга (20.9%) нь хөдөлгөөний, 7.3 мянга (19.9%) нь хүн сэтгэцийн, 2.4 мянга (6.4%) нь хавсарсан, 10.9 мянга (29.8%) нь “Бусад” төрлийн хөгжлийн бэрхшээлтэй байна. Үүнийг 2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад сэтгэцийн болон “Бусад” шалтгааны улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон хувь 1.2-8.9 пунктээр нэмэгдсэн бол үлдсэн төрлүүд, ялангуяа хөдөлгөөний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон гэсэн хувь 8.1 пунктээр буурсан нь хамгийн өндөр байв.

ХҮСНЭГТ 8.4. УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМЫН ТОО, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭРЭЭР, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН

	2010			2020		
	Хүн ам Бүгд	Хүйс		Хүн ам Бүгд	Хүйс	
		Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	1 154 290	558 247	596 043	1 466 125	710 455	755 670
Хөгжлийн бэрхшээлгүй	1 116 886	537 809	579 077	1 429 440	690 257	739 183
Хөгжлийн бэрхшээлтэй	37 404	20 438	16 966	36 685	20 198	16 487
Үүнээс:						
Харааны	5 265	2 901	2 364	4 188	2 376	1 812
Ярианы	1 891	1 042	849	1 109	600	509
Сонсголын	4 581	2 420	2 161	3 137	1 630	1 507
Хөдөлгөөний	10 855	6 094	4 761	7 652	4 412	3 240
Сэтгэцийн	6 981	3 681	3 300	7 316	3 757	3 559
Хавсарсан	-	-	-	2 360	1 386	974
Бусад	7 831	4 300	3 531	10 923	6 037	4 886

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд нийслэлийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрөлд ихээхэн өөрчлөлт оржээ. Тодруулбал, төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эзлэх хувь 2010 оноос 21.6 пунктээр өссөн бол эсрэгээр мөн тийм хэмжээгээр олдмол хөгжлийн бэрхшээл буурсан аж. Үүнд агаар, хөрсний бохирдол, хүнсний бүтээгдэхүүний чанар, иргэдийн эрүүл мэнд гэх мэт олон хүчин зүйл нөлөөлсөн нь лавтай. Иймээс цаашид үүсээд буй нөхцөл байдлыг гүнзгийрүүлэн судалж, баталгаажуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна

ЗУРАГ 8.5. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХЭЛБЭР, ХУВИАР, 2020 ОН



Хөгжлийн бэрхшээлийн төрлийг хэлбэрээр нь ангилж үзвэл ярианы бэрхшээлтэй хүмүүсийн 86.0 хувь нь, сэтгэцийн болон сонсголын бэрхшээлтэй гурван хүн тутмын хоёр нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй байна. Төрөлхийн харааны, хавсарсан бэрхшээлтэй хүмүүсийн хувь олдмол бэрхшээлтэй хүмүүсийнхээс бага зэрэг өндөр бол олдмол хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүсийн хувь төрөлхийнхөөс өндөр, харин “Бусад” хэлбэрүүдийн хувьд олдмол бэрхшээл давамгайлж байна. 2010 онтой харьцуулахад төрөлхийн хөгжлийн бэрхшээлийн ярианы бэрхшээлээс бусад бүх хэлбэр 1.3-4.3 дахин нэмэгджээ.

ХҮСНЭГТ 8.5. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ДҮҮРЭГ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН

Дүүрэг	Бүгд	Дүнд эзлэх хувь	Төрөлхийн	Бүгдэд эзлэх хувь	Олдмол	Бүгдэд эзлэх хувь
БҮГД	36 685	100	18 296	49.9	18 389	50.1
Багануур	1 092	3.0	549	50.3	543	49.7
Багахангай	168	0.4	68	40.5	100	59.5
Баянгол	5 149	14.0	2 472	48.0	2 677	52.0
Баянзүрх	7 883	21.5	4 165	52.8	3 718	47.2
Налайх	1 566	4.3	689	44.0	877	56.0
Сонгинохайрхан	8 349	22.8	4 355	52.2	3 994	47.8
Сүхбаатар	3 413	9.3	1 596	46.8	1 817	53.2
Хан-Уул	4 527	12.3	2 350	51.9	2 177	48.1
Чингэлтэй	4 538	12.4	2 052	45.2	2 486	54.8

Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүний 50.1 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байгаа бол Багахангай, Баянгол, Налайх, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт нийслэлийн дунджаас 1.9-9.4 пунктээр илүү байна.

ХҮСНЭГТ 8.6. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ДҮҮРЭГ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН

Дүүрэг	Бүгд	Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр						
		Харааны	Ярианы	Сонсголын	Хөдөлгөөний	Сэтгэцийн	Хавсарсан	Бусад
БҮГД	36 685	4 188	1 109	3 137	7 652	7 316	2 360	10 923
Багануур	1 092	104	10	81	255	227	115	300
Багахангай	168	18	5	11	40	43	16	35
Баянгол	5 149	578	108	478	977	865	302	1 841
Баянзүрх	7 883	943	237	751	1 689	1 558	387	2 318
Налайх	1 566	167	73	96	318	299	90	523
Сонгинохайрхан	8 349	941	264	728	1 918	1 664	649	2 185
Сүхбаатар	3 413	379	114	267	681	722	241	1 009
Хан-Уул	4 527	553	123	397	845	969	245	1 395
Чингэлтэй	4 538	505	175	328	929	969	315	1 317

Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоог хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр, дүүргээр авч үзвэл аль ч дүүрэгт хөдөлгөөний, сэтгэцийн болон “Бусад” хөгжлийн бэрхшээлтэй хүний нийт хөгжлийн бэрхшээлтэй хүнд эзлэх хувь өндөр байна. Хэдийгээр ялгаа бага боловч хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийг дүүрэг тус бүрээр харахад Банануур дүүрэгт хөдөлгөөний, Багахангай, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт сэтгэцийн, Баянгол, Баянзүрх, Налайх, Сонгинохайрхан дүүрэгт хөдөлгөөний хөгжлийн бэрхшээлтэй хүний хувь тус тус өндөр байна.

ҮЙЛДЛИЙН ЧАДВАР

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор НҮБ-ын Вашингтон бүлгээс боловсруулсан үйлдлийн чадварыг тодорхойлох богино багц асуултуудыг асуусан.

Богино багц асуулга нь харах, сонсох, алхах, өөртөө анхаарал тавих, харилцах, ой тогтоолт /санах/ гэсэн 6 багц үйл ажиллагааны хувьд хүндрэлийг тодорхойлдог.

Үйлдлийн хүндрэлийг Вашингтон бүлгийн богино багц асуулгын зөвлөмжийн дагуу 18, түүнээс дээш настай хүн амын хувьд тооцдог. Ингэхдээ дээрх 6 үйлдлийн чадвараас дор хаяж нэгд нь “маш их хүндрэлтэй” эсвэл “огт чадахгүй” гэж хариулсан тохиолдлыг үйлдлийн чадварын хүндрэлтэй гэж үздэг.

Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн амын 12.0 хувь нь 18-34 насны залуучууд байгаа бол 43.7 хувь нь 35-64 насны, 44.3 хувь нь 65, түүнээс дээш насны хүн ам байна. Эдгээрийн 28.6 хувь нь алхах, 18.4 хувь нь харааны бэрхшээлтэй байгаа бол хамгийн бага (10.5%) нь харилцах үйлдлийн хүндрэлтэй хүмүүс байна.

ХҮСНЭГТ 8.7. АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ХЭЛБЭР, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	Бүгд	Хүндрэлийн хэлбэр					
		Харааны	Сонсголын	Алхах	Ой тогтоолт /санах/	Өөртөө анхаарал тавих	Харилцах
Насны бүлгийн дүнд эзлэх хувиар							
Бүгд	100.0	18.4	16.1	28.6	12.6	13.8	10.5
18-19	100.0	17.7	10.4	14.6	19.8	14.6	22.9
20-24	100.0	21.4	14.4	16.3	19.1	10.7	18.1
25-29	100.0	21.3	10.0	16.8	18.4	14.5	19.0
30-34	100.0	19.8	16.3	20.4	15.6	10.3	17.6
35-39	100.0	16.7	18.1	21.1	17.0	10.8	16.3
40-44	100.0	16.3	18.5	23.2	18.3	8.6	15.1
45-49	100.0	20.2	18.3	25.2	12.4	11.2	12.7
50-54	100.0	21.4	17.8	27.1	12.2	9.9	11.6
55-59	100.0	18.7	14.4	33.5	11.8	12.4	9.2
60-64	100.0	18.1	15.3	35.7	10.5	12.5	7.9
65-69	100.0	20.0	12.7	37.9	10.1	13.7	5.6
70+	100.0	17.0	17.0	30.3	10.7	17.6	7.4

ХҮСНЭГТ 8.8. АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ХЭЛБЭР, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	Бүгд	Хүндрэлийн хэлбэр					
		Харааны	Сонсголын	Алхах	Ой тогтоолт /санах/	Өөртөө анхаарал тавих	Харилцах
Хүндрэлийн хэлбэрийн дүнд эзлэх хувиар							
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
18-19	1.1	1.1	0.7	0.6	1.8	1.2	2.5
20-24	2.5	2.9	2.3	1.4	3.9	2.0	4.4
25-29	3.7	4.2	2.3	2.1	5.4	3.9	6.7
30-34	4.7	5.1	4.8	3.4	5.8	3.5	7.9
35-39	5.4	4.9	6.0	4.0	7.3	4.2	8.4
40-44	5.5	4.9	6.3	4.5	8.0	3.4	7.9
45-49	7.7	8.5	8.7	6.8	7.6	6.3	9.4
50-54	7.7	8.9	8.4	7.2	7.5	5.5	8.5
55-59	9.1	9.3	8.1	10.7	8.6	8.2	8.1
60-64	8.3	8.1	7.9	10.3	6.9	7.5	6.2
65-69	7.8	8.4	6.1	10.3	6.2	7.7	4.2
70+	36.5	33.7	38.4	38.7	31.0	46.6	25.8


Насны бүлгээр авч үзэхэд 20-24 насны үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүсийн хамгийн их хүндрэл нь харааны хүндрэл байгаа бол 35-54 насныхны хувьд алхах, харин 55 түүнээс дээш насныхны хувьд харааны болон алхах хүндрэлүүд байна. Үйлдлийн чадварын хүндрэлийг насны ангиллаар авч үзвэл 45, түүнээс дээш насны хүн амын хүндрэл бусад насны хүн амынхаас өндөр байна.

Нийслэлийн нутаг дэвсгэрт оршин суух үйлдлийн чадварын хүндрэлтэй нийт иргэдийн 45.6 хувь нь эрэгтэй, 54.4 хувь нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 8.6. ҮЙЛДЛИЙН ЧАДВАР, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН




ЗУРАГ 8.7. АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛТЭЙ ХҮМҮҮС, ДАВХАРДЛААР, НАСНЫ БҮЛГИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



Идэр залуу буюу 18-34 насныхан болон 65, түүнээс дээш насныхны хүндрэлийн давхардал их байгаа бол дунд эргэм насныхны хувьд харьцангуй бага байна.

ЗУРАГ 8.8. АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ОГТ ХҮНДРЭЛГҮЙ ХҮМҮҮСИЙН СУУРИН ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙСЭЭР, 2020 ОН



Дээрх зургаас харахад 55, түүнээс дээш насны хүн амын үйлдлийн чадварын хүндрэл нас ахихын хэрээр их болж байна.

Үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амын суурин хүн амд эзлэх хувийн жин бүх насны бүлэгт эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс өндөр байна. Энэ нь эмэгтэйчүүд илүү хянамгай, эрүүл мэнддээ анхаардгаас шалтгаалдаг байж болох юм.

ХҮСНЭГТ 8.9. АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ХЭЛБЭР, ДҮҮРГЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	Бүгд	Хүндрэлийн хэлбэр					
		Харааны	Сонсголын	Алхах	Ой тогтоолт /санал/	Өөртөө анхаарал тавих	Харилцах
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Багануур	1.6	1.5	1.1	1.4	1.9	2.0	1.7
Багахангай	0.7	1.1	0.8	0.8	0.5	0.4	0.6
Баянгол	10.9	11.1	10.7	11.3	11.6	10.2	9.8
Баянзүрх	26.0	28.8	25.9	26.9	23.9	23.1	24.8
Налайх	3.3	2.9	3.6	3.3	3.4	3.3	3.6
Сонгинохайрхан	22.2	19.6	21.5	22.7	22.8	24.2	23.1
Сүхбаатар	11.9	11.0	11.4	11.2	12.9	13.6	13.1
Хан-Уул	12.4	13.1	13.7	11.7	12.5	12.1	11.3
Чингэлтэй	11.0	10.9	11.3	10.6	10.5	11.1	12.0

Үйлдлийн чадварын хүндрэлийн түвшнийг дүүргээр зэрэгцүүлбэл хүн амын тооноос шалтгаалан Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүдэд хамгийн их хувийг эзэлж байгаа бол хамгийн бага хувийг Багахангай, Багануур, Налайх дүүргүүд эзэлж байна.

ХҮСНЭГТ 8.10. АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ДАВХАРДЛААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Боловсролын түвшин	Бүгд	Үйлдлийн чадварын хүндрэлийн давхардлаар					
		1	2	3	4	5	6
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Боловсролгүй	8.5	4.6	11.3	16.1	20.3	11.8	20.7
Бага	4.4	2.9	5.4	5.9	7.6	11.0	9.5
Суурь	7.9	7.1	9.0	7.8	9.3	9.6	11.2
Бүрэн дунд	32.4	34.6	32.1	28.2	25.9	22.0	20.7
Техникийн болон мэргэжлийн	8.5	9.4	7.6	7.1	7.2	5.9	7.8
Тусгай мэргэжлийн дунд	14.7	15.3	13.9	15.2	11.9	13.2	12.9
Дипломын дээд	6.2	5.6	7.3	5.7	7.2	9.6	6.0
Бакалаврын дээд	15.5	18.2	11.8	12.3	8.5	15.4	11.2
Магистр	1.5	1.9	0.9	1.0	1.7	1.5	0.0
Доктор	0.4	0.4	0.7	0.7	0.4	0.0	0.0

Нийт үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүсийн 8.5 хувь нь боловсролгүй, 91.5 хувь нь ямар нэгэн түвшний боловсролтой байна. Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүсийг боловсролын түвшнээр харвал 32.4 хувь нь бүрэн дунд, 15.5 хувь нь бакалаврын дээд, 14.7 хувь нь тусгай мэргэжлийн дунд боловсролтой байгаа нь хамгийн өндөр хувь байна.


ХҮСНЭГТ 8.11. АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ЭСЭХ, ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ХЭЛБЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Боловсролын түвшин	Бүгд	Үйлдлийн чадварын хүндрэлийн давхардлаар					
		1	2	3	4	5	6
Хөдөлмөр эрхэлдэг эсэх							
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Ажилтай	20.5	27.3	15.3	7.1	4.2	2.9	5.2
Ажилгүй	79.5	72.7	84.7	92.9	95.8	97.1	94.8
Хөдөлмөр эрхлэлтийн байдал							
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Цалин хөлстэй байнгын ажиллагч	45.6	47.5	37.0	30.0	60.0	50.0	83.3
Цалин хөлстэй түр ажиллагч	29.5	28.8	35.0	30.0	20.0	-	-
Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч	3.1	3.5	1.9	-	-	-	-
Гүйцэтгэх гэрээлэгч	0.5	0.5	0.6	-	-	-	-
ААНБ-ын ажил олгогч	0.6	0.5	0.6	3.3	-	-	-
Зах зээлд чиглэсэн өрхийн ААН-ийн ажил олгогч	0.8	1.1	-	-	-	-	-
Цалин хөлстэй ажилтангүй ААНБ-ын үйл ажиллагаа эрхлэгч	0.5	0.5	0.6	-	-	-	-
Цалин хөлстэй ажилтангүй, зах зээлд чиглэсэн өрхийн ААН-ийн үйл ажиллагаа эрхлэгч	17.1	15.9	21.7	23.3	20.0	50.0	-
Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн	2.3	1.7	2.5	13.3	-	-	16.7

Тооллогоор нийт үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүсийн 20.5 хувь нь ажилтай гэж бүртгэгдсэн, хөдөлмөр эрхэлдэг ба эдгээр хүмүүсийг ажил эрхлэлтийн байдлаар нь үзэхэд 45.6 хувь нь цалин хөлстэй байнгын ажиллагч, 29.5 хувь нь цалин хөлстэй түр ажиллагч, 17.1 хувь нь өрхийн ААН-ийн үйл ажиллагаа эрхлэгч нар байна.

ГАР УТАС, ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО, БҮТЭЦ

6, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ НИЙСЛЭЛИЙН ХҮН АМЫН



Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого нь бүртгэл болон уламжлалт хосолмог аргаар явагдсан ба энгийн санамсаргүй түүвэрт сонгогдсон өрхийн 6, түүнээс дээш насны хүн амаас гар утас, интернэт хэрэглээний талаарх мэдээллийг авсан. Тиймээс 2020 оны тооллогын гар утас, интернэт хэрэглээний талаарх тоо мэдээллийг 2010 оны тооллогын дүнтэй хувийн жингээр харьцуулан танилцуулж байна.

ГАР УТАС, ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО, БҮТЭЦ

Монгол Улсын “Харилцаа холбооны тухай” хууль (2001 он), Засгийн газраас баталсан “Цахим Монгол” үндэсний хөтөлбөр (2005 он), “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (2008 он), Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд гар утас, интернэтийн хэрэглээг дэмжсэн эрх зүйн олон баримт бичгүүд гарсан. Дээрх баримт бичгүүдэд алслагдсан орон нутаг болон үйлчилгээ хүрээгүй хүн амд харилцаа холбоог хүргэх зорилго бүхий бүх нийтийн үүргийн сан, улс орныг хамарсан мэдээлэл харилцаа холбооны өндөр хурдны нэгдсэн сүлжээ байгуулах, мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг өрх бүрт хүртээмжтэй болгох асуудлыг тусгасан нь улсын хэмжээнд амжилттай хэрэгжиж байна.

Монгол Улсын хэмжээнд гар утас, интернэтийн үйлчилгээний хувийн хэвшлийн Мобиком корпораци, Скайтел, Юнител, Жи-Мобайл компани үйл ажиллагаагаа явуулж, 2019 оны эхний байдлаар давхардсан тоогоор 4.2 сая иргэнд хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг хүргэж байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор хоёр дахь удаагаа гар утас, интернэт хэрэглэдэг эсэхийг 5, түүнээс дээш насны хүнээс асуусан болно. Харин 2010 оны тооллоготой харьцуулах үүднээс энэ бүлэгт 6, түүнээс дээш насны хүн амын гар утас, интернэтийн хэрэглээг авч үзлээ.

ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО, БҮТЭЦ


Үүрэн технологид суурилсан, нийтийн телефон сүлжээнд (үүрэн холбооны оператор) холбогдсон авсаархан, зөөврийн телефон (гар утас) хэрэглэгчийг гар утас хэрэглэгч гэж үзсэн.

ЗУРАГ 9.1. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, 2020 ОН



Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллогоор Улаанбаатар хотын 6, түүнээс дээш насны хүн амын 91.2 хувь буюу 1 136.6 мянган иргэн гар утас хэрэглэж байгаа ба 2010 оны тооллогын үеэс 251.8 мянган (28.5%) хүнээр нэмэгджээ. Гар утас хэрэглэгчдийн 46.5 хувийг эрэгтэй, 53.5 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.


ЗУРАГ 9.2. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР 2010, 2020 ОН



Улаанбаатар хотын хүн амын насны бүлэг бүрд гар утас хэрэглэгчдийн эзлэх хувийг 2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад бүх насны бүлэгт нэмэгдсэн байна. 2020 оны тооллогын дүнгээр 15-59 нас хүртэлх гар утас хэрэглэгчдийн хувь харьцангуй өндөр 98-аас дээш хувьтай байна. Харин 6-9 насныхны 47.2 хувь нь гар утас хэрэглэж байгаа бол 70, түүнээс дээш насныхны 88.2 хувь нь гар утас хэрэглэдэг ажээ. Эндээс гар утас хотын иргэн бүрийн өдөр тутмын хэрэглээ болсон гэж дүгнэж болно. Хүйсийн хувьд ерөнхийдөө онцын ялгаагүй боловч аль ч насны бүлэгт гар утас хэрэглэдэг эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдийнхээс 1-6 пунктээр өндөр байна.


Нийт хүн амд 25-49 насныхны эзлэх хувь өндөр байгаатай уялдан энэ насныхны гар утас хэрэглэдэг хувь ч өндөр байна.

ЗУРАГ 9.3. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧ ХҮН АМ, ДҮҮРГЭЭР, 2020 ОН




Улаанбаатар хотын хүн амын гар утасны хэрэглээг дүүргээр авч үзвэл Баянгол (92.4%), Баянзүрх (91.9%), Хан-Уул (91.8%), Сүхбаатар (91.4%) дүүргүүдийн хэрэглэгчийн хувь нийслэлийн дунджаас 0.2-1.2 пунктээр өндөр, алслагдсан дүүргүүдээс Багахангай дүүрэгт хамгийн бага буюу 87.6 хувьтай байна.

ЗУРАГ 9.4. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ СУУРИН ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ДҮҮРГЭЭР, 2020 ОН



Улаанбаатар хотод боловсролтой хүн амын 97.6 хувь нь гар утас хэрэглэж байхад боловсролгүй хүн амын 52.8 хувь нь гар утас хэрэглэж байна. Хүн амын боловсролын түвшин ахих тусам гар утасны хэрэглээ нэмэгдэж байна. Гар утасны хэрэглээг хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүдийнх эрэгтэйчүүдээс ерөнхийдөө илүү байгаа юм.


ЗУРАГ 9.5. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС НАСНЫ ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТЭЭР, 2020 ОН



Улаанбаатар хотод 15, түүнээс дээш насны 989.4 мянган хүн байгаагийн 98.2 хувь нь гар утас хэрэглэж байгаа ба үүнийг 2010 оны тооллоготой харьцуулахад 6.0 пунктээр өсжээ.


Ажиллах хүчний 99.5 хувь нь гар утас хэрэглэж байгаа ба хүйсийн хувьд ойролцоо түвшинд байна. Мөн тооллого явагдахаас өмнөх 7 хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд нэгээс дээш цагаар оролцсон буюу ажил эрхэлдэг иргэдийн гар утасны хэрэглээний түвшин ч бүх бүлгүүдэд өндөр байв.

ЗУРАГ 9.6. ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХУВИАР, 2020 ОН



Ажил эрхэлдэг хүн амын 99.6 хувь нь гар утас хэрэглэж байгаа нь 2010 оныхоос 3.1 пунктээр өссөн байна. Хөдөлмөр эрхэлдэг хүн амын бүлэг дотроос ААНБ-ын ажил олгогч болон дагалдан мэргэшиж буй дадлагажигч нарын гар утасны хэрэглээ хамгийн өндөр байгаа нь дээрх зургаас харагдаж байна.

ЗУРАГ 9.7. АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХГҮЙ БАЙГАА ШАЛТГААН, ХУВИАР, 2010, 2020 ОН



Хөдөлмөр эрхлэх чадвартай хэдий ч сургуульд сурдаг, гэрийн ажилтай, ажиллах сонирхолгүй, тэтгэвэрт суугаа болон бусад шалтгааны улмаас хөдөлмөр эрхэлдэггүй, хөдөлмөр эрхлэх чадваргүй 15, түүнээс дээш насны хүн амыг ажиллах хүчнээс гадуурх хүнд хамааруулж авч үзсэн.

Ажиллах хүчнээс гадуурх хүн амын 96.0 хувь нь гар утас хэрэглэж байгаа нь 2010 оны тооллогоос 7.4 пунктээр өсжээ. Үүнийг хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаанаар ангилж үзэхэд хөдөлмөр эрхлэх чадваргүй иргэдийн 81.6 хувь, ажиллах сонирхолгүй хүн амын 85.7 хувь нь гар утас хэрэглэхгүй байгаа нь бусдаас бага үзүүлэлт байв. Гар утас хэрэглэж байгаа гэрийн ажилтай хүмүүсийн хувьд хүйсээр нэлээд зөрүүтэй байлаа (эрэгтэй 95.7 хувь, эмэгтэй 99.5 хувь).


ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО, БҮТЭЦ

Интернэт гэдэг нь дэлхий даяар тархсан мэдээллийн нэгдсэн сүлжээ юм. Энэ нь дэлхийн өргөн сүлжээ (World Wide Web)-г багтаасан харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх боломжийг олгодог бөгөөд төхөөрөмжөөс үл хамааран цахим шуудан болон бусад мэдээллийг авч болдог. Монгол Улсад сүүлийн жилүүдэд интернэт холболт эрчимтэй өсөж 2019 оны байдлаар суурин интернэт хэрэглэгчдийн тоо 303.2 мянгад хүрч, 2015 оныхоос 1.5 дахин нэмэгдсэн байна. Өдгөө Улаанбаатар хотод интернэтийн үйлчилгээ эрхэлдэг 44 аж ахуйн нэгж байгууллага ажиллаж байна.

Улаанбаатар хотод 2020 оны хүн ам, орон сууцны тооллогоор 6, түүнээс дээш насны нийт хүн амын 76.0 хувь буюу 947.2 мянган хүн интернэт хэрэглэж байгаа нь 2010 оноос 26.7 пунктээр өсжээ. Интернэт ашигладаг хэрэглэгчид хүйсийн хувьд нэлээд ялгаатай байна. Өөрөөр хэлбэл, интернэт хэрэглэгчийн 46.4 хувь нь эрэгтэйчүүд бол эмэгтэйчүүд 53.6 хувь буюу эрэгтэйчүүдээс 7.2 пунктээр өндөр байна. Энэхүү ялгааг 2010 оны тооллоготой харьцуулахад 0.8 пунктээр буурсан нь нэлээд сайшаалтай үр дүн юм. Учир нь интернэт хэрэглэх нь хувь хүнээс гадаад хэл, компьютерын тодорхой түвшний мэдлэг, чадвар шаарддаг. Тэгэхээр өнгөрсөн арван жилд эрэгтэйчүүдийн интернэт хэрэглэх чадавхад ахиц гарсан гэж үзэж болно.


Интернэт хэрэглэдэггүй хүн амын тоо 15 наснаас дээш, нас ахих тутам нэмэгдэж байна.

ЗУРАГ 9.8. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, 2010, 2020 ОН




Нийслэлийн интернэт хэрэглэдэг иргэдийн 95.4 хувь нь төвийн 6 дүүргийн иргэд байна. Хүн амын интернэтийн хэрэглээгээр нийслэлийн Баянзүрх (25.3 хувь), Сонгинохайрхан (22.2 хувь), Баянгол (16.0 хувь) дүүрэг тэргүүлж, өөрөөр хэлбэл, нийслэлийн интернэт хэрэглэдэг 4 хүн тутмын нэг нь Баянзүрх дүүрэгт, 5 хүн тутмын нэг нь Сонгинохайрхан дүүрэгт амьдарч байна.

ЗУРАГ 9.9. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧ ХҮН АМ, ДҮҮРГЭЭР, 2020 ОН




Ажиллах хүчний 90.5 хувь нь интернэт хэрэглэж байгаагаас хүйсийн хувьд эрэгтэйчүүдийн интернэт хэрэглээний хувь эмэгтэйчүүдийнхээс 3.4 пунктээр доогуур байна.

ЗУРАГ 9.10. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТЭЭР, 2020 ОН



Ажиллах хүчнээс гадуурх хүн амын 70.8 хувь нь интернэт хэрэглэж байгаа ба хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаанаар интернэт хэрэглээг авч үзэхэд сургуульд сурдаг хүн амын 96.3 хувь, тэтгэвэрт байгаа хүмүүсийн 44.6 хувь, хөдөлмөр эрхлэх чадваргүй иргэдийн 46.3 хувь, гэрийн ажилтай хүн амын 85.6 хувь, тохирох ажил олдохгүйн улмаас хөдөлмөр эрхлэхгүй байгаа хүн амын 73.1 хувь, ажиллах сонирхолгүй байгаа хүмүүсийн 51.8 хувь нь интернэт хэрэглэж байна. Гэрийн ажилтай хүмүүсийн хувьд эрэгтэй 66.0%, эмэгтэй 87.2% байгаа нь интернэт хэрэглээний хувь хамгийн их зөрүүтэй байв.

ЗУРАГ 9.11. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ДҮҮРГЭЭР, 2010, 2020 ОН



Улаанбаатар хотын хүн амын интернэт хэрэглээг дүүргээр авч үзвэл Баянгол (83.2%), Хан-Уул (79.5%), Баянзүрх (77.6%), Сүхбаатар (77.3%) дүүрэгт нийслэлийн дунджаас 1.3-7.2 пунктээр өндөр, алслагдсан дүүргүүдээс Налайх дүүрэгт хамгийн бага буюу 66.0 хувьтай байна. Энд онцолж хэлэхэд Багануур дүүргийн интернэт хэрэглээ 2010 оны мөн үеэс 2.4 дахин нэмэгдсэн.

ХҮСНЭГТ 9.1. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН

Боловсролын түвшин	Интернэт хэрэглэдэг			Интернэт хэрэглэдэггүй		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Боловсролгүй	6.3	6.9	5.7	40.0	41.1	38.9
Боловсролтой	93.7	93.1	94.3	60.0	58.9	61.1
Дээд	43.2	37.6	48.1	9.7	9.0	10.3
Тусгай мэргэжлийн дунд	7.4	7.0	7.6	8.9	6.9	10.8
Техникийн болон мэргэжлийн	5.1	6.2	4.2	5.8	6.4	5.3
Бүрэн дунд	24.2	27.0	21.8	21.3	22.3	20.3
Суурь	6.6	7.4	6.0	5.4	5.6	5.3
Бага	7.2	7.9	6.6	8.9	8.7	9.1


ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС
ГАДУУРХ ХҮН АМ
40.7%

АЖИЛЛАХ ХҮЧ
59.3%

Ажил эрхэлдэг
85.5%

Ажил хайж
байгаа
14.5%



Хүн ам, орон сууцны тооллогоор хүн амын эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг гаргах нь хэд хэдэн шалтгаантай байдаг. Хүн амын эдийн засгийн талаарх мэдээлэл нь тухайн улс орны эдийн засгийн бүтэц, хөдөлмөрийн хэв маяг, зах зээлийн оролцоо, хөдөлмөр эрхлэлтийн цар хүрээ зэргийг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Мөн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн гол үзүүлэлтүүдийг тооллогоор цуглуулан хувь хүний болон өрх, орон сууцны нөхцөлийн үзүүлэлтүүдтэй холбосноор нийгэм, эдийн засгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашдын чиг хандлагыг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

Хүн ам, орон сууцны тооллогоор эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг засаг захиргааны хамгийн бага нэгжийн түвшинд гаргах боломжтойгоороо бусад төрлийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаануудаас давуу талтай.

Хүн амын асуулгын эдийн засгийн үзүүлэлтүүдийн ойлголт, тодорхойлолтыг боловсруулахдаа НҮБ-ын “Хүн ам, орон сууцны 2020 он орчмын тооллогод баримтлах зарчим, зөвлөмж- III”-ийг үндэслэсэн.

Энэ удаагийн тооллого нь бүртгэл болон уламжлалт хосолсон аргаар явагдсан ба энгийн санамсаргүй түүвэрт сонгогдсон өрхийн 15, түүнээс дээш насны хүн амаас хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуултуудыг асуусан.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын уламжлалт асуулгын эдийн засгийн идэвхийн үзүүлэлтүүдийг Хөдөлмөрийн статистикчдын олон улсын 19-р бага хурлаар шинэчлэн баталсан аргачлалын дагуу тооцсон. Уламжлалт тооллогын асуулгаар “Тооллогын товын үед ажил эрхэлж байгаа эсэх, товоос өмнөх 7 хоногт ядаж нэг өдөр цалин хөлстэй ажил эрхэлсэн болон тухайн хугацаанд ажил эрхлээгүй боловч ер нь ажилтай хүнийг “Ажил эрхэлдэг” гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн идэвхийг долоо хоногийн байдлаар тухайн үеийн идэвх гэсэн ойлголтоор тодорхойлсон. Өвчтэй, жирэмсний болон төрсний дараах чөлөөтэй, ээлжийн амралттай зэрэг шалтгаанаар тооллогын товын өмнөх 7 хоногт ажил эрхлээгүй боловч үндсэн байгууллага, аж ахуйн нэгжтэйгээ хөдөлмөрийн гэрээгээ цуцлаагүй, тодорхой хугацааны дараа ажилдаа эргэн орох хүмүүсийг ажил эрхэлдэг гэж үзсэн.

Харин бүртгэлд суурилсан мэдээлэл боловсруулалтад Хүн ам, өрхийн мэдээллийн санг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгал төлөгчдийн мэдээллийн сан болон Гадаадын иргэн харьяатын газрын гадаад, харьяалалгүй иргэдийн мэдээллийн сантай уялдуулан ажил эрхэлдэг хүнийг гаргасан.

Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуултыг 15, түүнээс дээш насны бүх хүнээс асуусан.

ЗУРАГ 10.1. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮВЧ, 2020 ОН




15, түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдлыг тооллогод тухайн үеийн ажил эрхлэлтээр авсан учир ажиллах хүч, ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж 2 ангилж тодорхойлов. /Зураг 10.1/. Ажиллах хүчинд ажил эрхэлж байгаа хүн ам болон ажилгүй иргэдийг хамруулдаг. Энэ нь цаашдаа улс орны нийгэм, эдийн засаг ялангуяа ажиллах хүчний бодлого боловсруулахад суурь мэдээлэл болдог.

Уламжлалт тооллогоор тухайн үед ажиллаж байгаа гэдэг ойлголтод байнгын болон улирлын чанартай ажилтай, тооллогын үед ажил эрхлэхгүй байгаа ч ер нь ажил эрхэлдэг хүн амыг болон бүртгэлд суурилсан тооллогоор нийгмийн даатгал төлөгчдийн мэдээллийн сан болон гадаад, харьяалалгүй иргэдийн мэдээллийн санд бүртгэлтэй ажил эрхэлдэг бүх хүн амыг ажил эрхэлдэг гэж үзсэн.

Харин ажиллах хүчнээс гадуурх хүн амд хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчээ нийлүүлээгүй хүмүүсээс гадна тохирох ажил олдохгүй байгаагийн улмаас хөдөлмөр эрхлээгүй хүмүүсийг оруулдаг.

Ажиллах хүчийг 15, түүнээс дээш насны хүн амд харьцуулж ажиллах хүчний оролцооны түвшнийг тодорхойлдог.

ЗУРАГ 10.2. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХУВИАР, 2020 ОН



Улаанбаатар хотод арван тав, түүнээс дээш насны хүн амын 59.3 хувь буюу 587.2 мянган хүн ажиллах хүчинд багтаж байгаагийн дотор 85.5 хувь нь ажил эрхлэгчид, 14.5 хувь ажил хайж буй хүн ам эзэлж байна. Ажиллах хүчний оролцооны түвшнийг 2010 оны мөн үетэй харьцуулахад 7.4 пунктээр өсжээ.

ХҮСНЭГТ 10.1. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ДҮҮРЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН

Дүүрэг	Ажиллах хүчний оролцооны түвшин			Ажиллах хүчнээс гадуурх хүн амын эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	59.3	64.6	54.7	40.7	35.4	45.3
Багануур	56.3	61.5	51.4	43.7	38.5	48.6
Багахангай	56.0	59.6	52.3	44.0	40.4	47.7
Баянгол	62.6	67.0	58.9	37.4	33.0	41.1
Баянзүрх	60.9	65.9	56.5	39.1	34.1	43.5
Налайх	51.0	57.0	45.4	49.0	43.0	54.6
Сонгинохайрхан	58.9	65.4	52.8	41.1	34.6	47.2
Сүхбаатар	56.7	61.5	52.5	43.3	38.5	47.5
Хан-Уул	62.1	66.7	58.2	37.9	33.3	41.8
Чингэлтэй	53.7	59.0	48.8	46.3	41.0	51.2

Ажиллах хүчний оролцооны түвшин байршил, хүйсээр нэлээд ялгаатай байна. Тодруулбал, Баянгол (62.6%), Хан-Уул (62.1%) дүүрэгт хамгийн өндөр буюу нийслэлийн дунджаас 2.8-3.3 пунктээр өндөр, Налайх дүүрэгт (51.0%) хамгийн бага буюу нийслэлийн дунджаас 8.3 пунктээр доогуур байгаа юм. Энд онцолж хэлэхэд, дээрх үзүүлэлтийг 2010 оны тооллогын дүнтэй харьцуулж үзэхэд дүүргүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин бүгд нэмэгдсэн боловч хоёр тооллогын хооронд дүүргүүдийн нийслэлийн дунджаас хэр зөрүүтэй байгааг авч үзэхэд харилцан адилгүй байна. Жишээлбэл, Налайх дүүргийн ажиллах хүчний оролцооны түвшин 2010 онд нийслэлийн дунджаас 3.4 пунктээр доогуур байсан бол 2020 онд 8.3 пункт болж, 2.4 дахин нэмэгдсэн байна. Үүнийг өнгөрсөн арван жилийн хугацаанд уг дүүрэгт ажлын байр шинээр бий болгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа бусад дүүргүүдээс хангалтгүй зохион байгуулагдсан гэж дүгнэж болохоор байна.

Хүйсийн хувьд эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо бүх дүүрэгт эмэгтэйчүүдийнхээс өндөр байна. Ялангуяа, Налайх дүүрэгт эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 57.0 хувь байгаа нь эмэгтэйчүүдийнхээс 11.6 пунктээр илүү байв.

Нийслэлийн ажиллах хүчний оролцооны түвшнийг насны бүлгээр авч үзэхэд 15-24 насанд хамгийн бага (15-19 насны бүлэгт 6.0 хувь, 20-24 насны бүлэгт 41.4 хувь) байгаа нь хүүхэд, залуучуудын сургуульд хамрагдалттай, мөн их, дээд сургууль төгссөний дараа залуучуудад ажлын байрны олдоц хангалтгүй байдагтай холбон тайлбарлаж болох юм.


ХҮСНЭГТ 10.2. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	Ажиллах хүч				Ажиллах хүчнээс гадуурх хүн ам							
	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	мян. хүн	хувь*	мян. хүн	хувь*	мян. хүн	хувь*	мян. хүн	хувь*	мян. хүн	хувь*	мян. хүн	хувь*
БҮГД	587.2	59.3	301.2	64.6	286.0	54.7	402.2	40.7	165.4	35.4	236.8	45.3
15-19	5.1	6.0	3.4	7.7	1.7	4.1	80.2	94.0	40.0	92.3	40.3	95.9
20-24	36.8	41.4	20.2	46.7	16.6	36.4	52.1	58.6	23.1	53.3	29.0	63.6
25-34	203.8	75.6	106.0	81.3	97.8	70.3	65.6	24.4	24.4	18.7	41.2	29.7
35-44	173.5	79.8	88.0	83.6	85.5	76.2	44.0	20.2	17.2	16.4	26.7	23.8
45-54	121.4	76.8	57.6	78.1	63.8	75.6	36.6	23.2	16.1	21.9	20.5	24.4
55-59	33.3	52.6	18.2	65.4	15.1	42.6	30.0	47.4	9.6	34.6	20.4	57.4
60+	13.3	12.4	7.8	18.3	5.5	8.5	93.7	87.6	35.0	81.7	58.7	91.5

*тухайн насны бүлгийн хүн амд эзлэх хувь

Ажиллах хүчийг насны бүлгээр ангилахад мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаж байна. Эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо бүх насны бүлэгт эмэгтэйчүүдийнхээс өндөр байна. Үүний дотор 20-34 насанд эрэгтэйчүүдийнх эмэгтэйчүүдийнхээс 10.3-11.0 пунктээр их байгаа нь тухайн насны их, дээд сургуульд суралцагч эмэгтэйчүүд илүү байдагтай холбоотой. Хүн амын ажиллах хүчний оролцоо эрэгтэйчүүдийн хувьд 25-44 насанд, эмэгтэйчүүдийн хувьд 35-54 насанд хамгийн өндөр байна. Ялангуяа, 35-54 насанд эрэгтэй, эмэгтэйчүүдийн хоорондын зөрүү хамгийн бага байгаа нь энэ насны бүлгүүдэд ажиллах хүчний оролцоо хамгийн өндөр байгааг харуулж байна. Харин 55 наснаас дээш насанд эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо огцом буурч байгаа нь тэд 55 наснаас эхлэн өндөр насны тэтгэвэрт гардагтай холбоотой.

ЗУРАГ 10.3. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН




АЖИЛЛАХ ХҮЧ

Тооллогын товын өмнөх 7 хоногт ядаж нэг цагаас илүү хугацаагаар цалин орлоготой ажил эрхэлсэн, ажил хайж байгаа хүнийг ажиллах хүчинд хамааруулсныг дээр тэмдэглэсэн. Бид ажил эрхлэлтийг богино хугацаагаар тодорхойлж байгаа болохоор НҮБ-ын зөвлөмжийг үндэслэн ажиллах хүч гэдэг ойлголтыг хэрэглэж байна.

Тооллогоор тухайн тоолуулагч аж ахуйн нэгж, байгууллагаасаа хөдөлмөрийн гэрээгээ цуцлаагүй бол хөдөлмөр эрхэлсэн гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, тухайн тоолуулагч тооллогын өмнөх долоо хоногт ажил эрхлээгүй байвал түүний ажил эрхлэлтийг үнэн зөв тодорхойлохын тулд ер нь ажилтай эсэхийг тодруулан асууж хөдөлмөр эрхлэлтийн шинэчилсэн аргачлалын дагуу тодорхойлсон.

Ажилгүй хүн гэдгийг тодорхойлоход хүн амын тооллогын асуулгын хөдөлмөр эрхлэхгүй байгаа үндсэн шалтгаан гэсэн асуултыг ашигласан. Энэ нь ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоог гаргахад түлхүүр үзүүлэлт болж өгсөн. “Ажил хайж байгаа” гэдэгт “тооллогын товын өмнөх 7 хоногт ажил эрхлээгүй бөгөөд хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй болон бүртгэлгүй, ажил идэвхтэй хайж байгаа” хүнийг хамааруулж, ажилгүйчүүдийг тодорхойлов.

ЗУРАГ 10.4. ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХУВИАР, 2020 ОН



Арван тав, түүнээс дээш насны хүн амд эзлэх ажилгүй иргэдийн хувь 8.6 болж, өмнөх тооллогын үеэс 1.6 пунктээр буурчээ. Ажилгүй иргэдийн хувь улсын дунджаас 2.7 пункт, ажиллах хүчнээс гадуурх хүн ам 0.4 пунктээр тус тус өндөр, ажил эрхлэгчдийн хувь 3.1 пунктээр доогуур байна.

АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ

Ажил эрхэлдэг бүх хүмүүсийн эрхэлдэг ажил болон ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагынх нь үндсэн үйл ажиллагааны чиглэл, хөдөлмөр эрхлэлтийн байдал гэсэн үзүүлэлтүүдийг тодорхойлсон.

Улаанбаатар хотод ажил эрхэлдэг хүн амын тоо 501.9 болж 2010 оноос 110.4 мянган хүнээр буюу 28.2 хувиар өсжээ. Хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн хувь өмнөх тооллогоос 34.0 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 10.3. АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН

Хүйс	2010 он		2020 он		2020 2010 %
	мян.хүн	хувь*	мян.хүн	хувь*	
БҮГД	391.5	44.9	501.9	50.7	128.2
Эрэгтэй	207.5	50.0	255.4	54.7	123.1
Эмэгтэй	184.0	40.3	246.5	47.2	134.0

* 15, түүнээс дээш насны хүн амд эзлэх хувь

Улаанбаатар хотод арван тав, түүнээс дээш насны хүн амын 50.7 хувь нь ажил эрхэлж байгаа нь улсын дунджаас 3.1 пунктээр доогуур байна. Энэ нь нэгдүгээрт, нийслэлд их, дээд сургууль олноор төвлөрч, суралцагсдын тоо байнга нэмэгдэж байгаа, хоёрдугаарт, хүн ам хэт төвлөрснөөс үүдэн ажлын байрны олдоц ховор байгаа, гуравдугаарт, хэдийгээр сүүлийн гурван жилд Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгалыг тодорхой хэмжээгээр хязгаарласан боловч өмнөх он жилүүдэд шилжин ирэгчдийн тоо өндөр байсан зэрэгтэй холбоотой.

ХҮСНЭГТ 10.4. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ДҮҮРЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН

Дүүрэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	мян.хүн	хувь*	мян.хүн	хувь*	мян.хүн	хувь*
БҮГД	501.9	50.7	255.4	54.7	246.5	47.2
Багануур	9.8	49.5	5.1	53.6	4.7	45.8
Багахангай	1.5	53.3	0.8	56.6	0.7	49.9
Баянгол	76.5	50.4	36.9	53.7	39.6	47.7
Баянзүрх	123.5	50.6	62.3	54.1	61.2	47.5
Налайх	12.0	47.3	6.4	52.2	5.6	42.6
Сонгинохайрхан	109.0	49.5	58.0	54.4	51.0	44.9
Сүхбаатар	51.4	51.4	26.0	55.5	25.4	47.8
Хан-Уул	67.2	54.6	33.4	58.4	33.8	51.3
Чингэлтэй	51.0	49.8	26.5	54.4	24.5	45.6

* 15, түүнээс дээш насны хүн амд эзлэх хувь

Улаанбаатар хотод Монгол улсын суурин хүн амын 45.9 хувь нь оршин сууж, хувийн жин нь жилээс жилд нэмэгдэж байгаа боловч ажил эрхэлдэг хүний хувийн жин хүн амын өсөлтөө даган төдийлөн хурдацтай нэмэгдэж чадахгүй байна. Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын хувийг дүүргүүдээр харахад ойролцоо түвшинд 47.3-54.6 хувийн хооронд хэлбэлзэж байгаа боловч 2010 онтой харьцуулахад энэ үзүүлэлт ялгаатай байна. Тодруулбал, Багахангай (12.0 пункт), Хан-Уул (9.8 пункт) дүүргүүдийн өмнөх тооллоготой харьцуулсан хувь бусад дүүргүүдээс өндөр байгаа бол Баянгол дүүрэгт арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын хувь дөнгөж 2.3 пунктээр өссөн байв.

ХҮСНЭГТ 10.5. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН (МЯН.ХҮН)

Насны бүлэг	2010 он			2020 он			2020 2010 %
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	391.5	207.5	184.0	501.9	255.4	246.5	128.2
15-19	7.3	4.7	2.6	4.9	3.2	1.7	67.9
20-24	58.6	33.6	25.0	34.9	19.1	15.8	59.7
25-34	135.6	74.0	61.6	178.9	92.2	86.7	131.9
35-44	107.0	52.8	54.2	145.8	72.4	73.4	136.2
45-54	69.5	33.4	36.1	99.3	46.4	52.9	142.8
55-59	9.4	6.1	3.3	25.1	14.5	10.6	267.0
60+	4.1	2.9	1.2	13.0	7.6	5.4	314.7

15, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын тоог насны бүлгээр авч үзэхэд 2010 оноос 15-19 насанд 32.1 хувь, 20-24 насанд 40.3 хувиар тус тус буурч, бусад насны бүлэгт өссөн ба ялангуяа 60, түүнээс дээш насанд ойролцоогоор 3 дахин өссөн байна. Өнгөрсөн гурван тооллогын дүнгээс харахад 15-19 насны ажил эрхэлдэг хүний тоо тогтмол буурч байна. Үүнийг энэ насныхны сургуульд хамрагдалтын түвшин нэмэгдсэнтэй холбон тайлбарлаж болно.

Хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн ажил (байгууллага)-ын үндсэн үйл ажиллагааны чиглэл, эрхэлдэг ажлын төрөл буюу албан тушаал, хөдөлмөр эрхлэлтийн байдлын талаар мэдээллийг цуглуулахдаа тухайн хүний ажилладаг байгууллагын эдийн засгийн үндсэн үйл ажиллагааны чиглэлийг “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ISIC-4.0), эрхэлдэг ажлын төрлийг “Үндэсний ажил мэргэжлийн ангилал (ISCO-08)”-аар ангилан гаргасан.

Хүн амын эрхэлдэг ажил мэргэжлийн онцлогоос хамаарч эрэгтэй, эмэгтэйчүүдийн ялгаа ангилал тус бүрт өөр өөр байна. Эрхэлдэг ажил мэргэжил хүйсийн хувьд хамгийн бага зөрүүтэй байгаа нь менежер, техникч болон туслах/дэд мэргэжилтэн, энгийн ажил мэргэжил ажээ. Харин машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагчийн ажил мэргэжлийн 90.9 хувийг, мөн зэвсэгт хүчний алба болон үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан зэрэг биеийн хүч шаардсан ажил мэргэжлийн 71.3-78.6 хувийг эрэгтэйчүүд бүрдүүлж байна. Гэтэл мэргэжилтэн, контор, үйлчилгээний ажилтан, худалдаа үйлчилгээний ажилтай 3 хүн тутмын 2 нь эмэгтэйчүүд байна.

Энд сонирхол татсан нэг үр дүн бол 2010 онд зэвсэгт хүчний албанд ажилладаг эмэгтэйчүүд 12.3 хувь эзэлж байсан бол 2020 онд 21.4 хувь болж 9.1 пунктээр өссөн явдал юм.

ХҮСНЭГТ 10.6. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН

Ажил мэргэжил	Бүгд	Эрэгтэй Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй Эмэгтэй	
		Мян.хүн			Хувь-А	
БҮГД	501.9	255.4	246.5	100.0	100.0	100.0
Менежер	79.5	40.0	39.5	15.8	15.6	16.1
Мэргэжилтэн	133.7	51.3	82.4	26.6	20.1	33.4
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	26.9	14.0	12.9	5.3	5.4	5.2
Контор, үйлчилгээний ажилтан	24.4	7.6	16.8	4.9	3.0	6.8
Худалдаа үйлчилгээний ажилтан	74.7	28.5	46.2	14.9	11.2	18.7
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	6.4	4.0	2.4	1.3	1.6	1.0
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	49.7	35.5	14.3	9.9	13.9	5.8
Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч	44.6	40.5	4.0	8.9	15.9	1.6
Энгийн ажил мэргэжил	51.5	25.8	25.8	10.3	10.1	10.5
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	10.5	8.2	2.2	2.1	3.2	0.9

ХҮСНЭГТ 10.7. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН

Ажил мэргэжил	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
		Мян.хүн			Хувь-Б	
БҮГД	501.9	255.4	246.5	100.0	50.9	49.1
Менежер	79.5	40.0	39.5	100.0	50.3	49.7
Мэргэжилтэн	133.7	51.3	82.4	100.0	38.4	61.6
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	26.9	14.0	12.9	100.0	52.0	48.0
Контор, үйлчилгээний ажилтан	24.4	7.6	16.8	100.0	31.2	68.8
Худалдаа үйлчилгээний ажилтан	74.7	28.5	46.2	100.0	38.2	61.8
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	6.4	4.0	2.4	100.0	63.0	37.0
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	49.7	35.5	14.3	100.0	71.3	28.7
Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч	44.6	40.5	4.0	100.0	90.9	9.1
Энгийн ажил мэргэжил	51.5	25.8	25.8	100.0	50.0	50.0
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	10.5	8.2	2.2	100.0	78.6	21.4

Ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд хэрэглэгддэг дараагийн чухал үзүүлэлт бол хөдөлмөр эрхлэлтийн байдал (статус) юм. Тоолуулж байгаа хүний эрхэлдэг ажил болон ажилладаг аж ахуйн нэгж байгууллагадаа гүйцэтгэж байгаа үүрэг, байгуулсан гэрээ хэлцэл, тухайн хүний байгууллага, хувь хүнтэй харилцах эрх мэдэл, ажил үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж өгдөг учраас энэ үзүүлэлт ихээхэн чухал ач холбогдолтой.

Олон улсын хөдөлмөрийн статистикчдийн 19-р бага хурлаар хөдөлмөр эрхлэлтийн статусыг шинэчлэн баталсан байдаг ба хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогод уг шинэчилсэн хөдөлмөр эрхлэлтийн статусыг ашигласан болно. 2010 болон 2020 оны тооллогын хөдөлмөр эрхлэлтийн хоёр өөр статусыг ашигласан учир дараах байдлаар харьцуулсан болно. Үүнд:

ЗУРАГ 10.5. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХУУЧИН БОЛОН ШИНЭ СТАТУСЫГ
ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ



2020 онд цалин хөлстэй ажиллагч нийт ажил эрхэлдэг хүн амын 87.7 хувийг эзэлж 2010 оныхоос 15.2 пунктээр өсжээ. Харин ажил олгогчийн эзлэх хувь 1.0 хувь болж өмнөх тооллоготой

харьцуулахад 3.1 пунктээр, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувь 10.4 болж 17.3 пунктээр тус тус буурчээ. Цалин хөлстэй ажиллагчийн хувийн жин өсөх нь хөдөлмөрийн аюулгүй байдлаа хангах, нийгмийн хамгаалалд хамрагдаж, хөдөлмөрлөх эрхээ бүрэн дүүрэн эдлэх бололцоог нэмэгдүүлдгээрээ сайн талтай ч хувиараа хөдөлмөр эрхлэгч болон ажил олгогчийн хувийн жин буурсан нь үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжиж чадахгүй байгааг илэрхийлж болох юм.

ХҮСНЭГТ 10.8. АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН

	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
2010			
БҮГД	100.0	100.0	100.0
Цалин хөлстэй ажил олгогч	72.5	69.0	76.4
Ажил олгогч	4.1	5.1	3.0
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	21.7	24.7	18.3
Нөхөрлөл, хоршооллын гишүүн	0.1	0.1	0.1
Өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч	1.2	0.6	1.9
Бусад	0.4	0.5	0.3
2020			
БҮГД	100.0	100.0	100.0
Цалин хөлстэй байнгын ажиллагч	76.8	73.1	80.6
Цалин хөлстэй түр ажиллагч	9.4	10.3	8.5
Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч	1.5	2.0	0.9
Цалин хөлстэй дагалдан, мэргэшиж буй дадлагажигч	0.0	0.0	0.0
Гүйцэтгэх гэрээлэгч	0.6	0.9	0.3
ААНБ-ын ажил олгогч	0.7	0.9	0.5
Зах зээлд чиглэсэн өрхийн ААН-ийн ажил олгогч	0.3	0.3	0.2
ААНБ-ын үйл ажиллагаа эрхлэгч	0.3	0.4	0.3
Өрхийн ААН-ийн үйл ажиллагаа эрхлэгч	9.5	11.3	7.7
Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн	0.9	0.8	1.0

Тооллогоор хөдөлмөр эрхэлдэг буюу товын өмнөх 7 хоногт ажил эрхэлсэн гэж хариулт өгсөн хүмүүсээс ажилладаг байгууллага эсвэл эрхэлдэг ажлынх нь үндсэн үйл ажиллагааны чиглэлийг тодруулж асуусан.

15, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын 18.3 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 10.5 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн, 10.0 хувь нь боловсролын салбарт ажиллаж байгаа нь бусад салбараас хамгийн өндөр юм. Энэ үзүүлэлтийг 2010 онтой харьцуулахад бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт ажилладаг хувь 1.6 пунктээр, боловсруулах үйлдвэрийнх 0.2 пунктээр буурсан ч үйл ажиллагааны салбар дундаа хүн амын тоогоор тэргүүлсэн хэвээр байна. Харин боловсролын салбарт ажиллагчдын хувь 1.3 пунктээр өсөж, гуравт оржээ. Өмнөх тооллогоор гуравт бичигдэж байсан барилгын салбарт ажиллагчдын хувь 1.4 пунктээр буурсан байв.

Ажил эрхэлдэг хүн амыг хүйсээр ангилж үзэхэд эдийн засгийн үйл ажиллагааны салбарын онцлогоос хамаарч нэлээд ялгаатай байна. Тухайлбал, уул уурхай, олборлолт, цахилгаан хий, уур агааржуулалтын хангамж, барилга, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт ажиллагчдын 70, түүнээс илүү хувь нь эрэгтэйчүүд байхад эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагааны салбарт ажиллагчдын 81.0 хувь, боловсролын салбарт ажиллагчдын 75.9 хувь, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх салбарт ажиллагчдын 68.0 хувь нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 10.9. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, ЭДИЙН
ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН

Ажил мэргэжил	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
	Мян.хүн			Хувь-А		
БҮГД	501.9	255.4	246.5	100	100	100
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	10.6	6.3	4.3	2.1	2.5	1.8
Уул уурхай, олборлолт	20.3	16.2	4.1	4.0	6.3	1.7
Боловсруулах үйлдвэрлэл	53.0	26.4	26.6	10.5	10.3	10.8
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	7.8	5.5	2.3	1.6	2.2	0.9
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	4.4	2.3	2.1	0.9	0.9	0.8
Барилга	44.5	33.1	11.5	8.9	12.9	4.7
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	92.0	45.1	46.9	18.3	17.7	19.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	32.6	24.6	8.0	6.5	9.6	3.3
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	16.4	5.3	11.2	3.3	2.1	4.5
Мэдээлэл, холбоо	12.7	6.7	6.0	2.5	2.6	2.4
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	19.1	7.2	11.9	3.8	2.8	4.8
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	3.7	1.7	1.9	0.7	0.7	0.8
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	14.5	7.1	7.4	2.9	2.8	3.0
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	16.8	10.2	6.7	3.4	4.0	2.7
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	43.0	24.5	18.5	8.6	9.6	7.5
Боловсрол	50.3	12.1	38.2	10.0	4.8	15.5
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	25.5	4.8	20.6	5.1	1.9	8.4
Урлаг, үзвэр, тоглоом наадам	4.9	2.4	2.5	1.0	0.9	1.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	27.8	13.0	14.8	5.5	5.1	6.0
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0.6	0.3	0.3	0.1	0.1	0.1
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1.4	0.6	0.7	0.3	0.2	0.3

**ХҮСНЭГТ 10.10. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, ЭДИЙН
ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН**

Ажил мэргэжил	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
	Мян.хүн			Хувь-Б		
БҮГД	501.9	255.4	246.5	100.0	50.9	49.1
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	10.6	6.3	4.3	100.0	59.3	40.7
Уул уурхай, олборлолт	20.3	16.2	4.1	100.0	79.7	20.3
Боловсруулах үйлдвэрлэл	53.0	26.4	26.6	100.0	49.8	50.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	7.8	5.5	2.3	100.0	70.6	29.4
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	4.4	2.3	2.1	100.0	52.9	47.1
Барилга	44.5	33.1	11.5	100.0	74.2	25.8
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	92.0	45.1	46.9	100.0	49.0	51.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	32.6	24.6	8.0	100.0	75.4	24.6
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	16.4	5.3	11.2	100.0	32.0	68.0
Мэдээлэл, холбоо	12.7	6.7	6.0	100.0	52.8	47.2
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	19.1	7.2	11.9	100.0	37.5	62.5
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	3.7	1.7	1.9	100.0	47.2	52.8
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	14.5	7.1	7.4	100.0	48.9	51.1
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	16.8	10.2	6.7	100.0	60.5	39.5
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	43.0	24.5	18.5	100.0	57.0	43.0
Боловсрол	50.3	12.1	38.2	100.0	24.1	75.9
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	25.5	4.8	20.6	100.0	19.0	81.0
Урлаг, үзвэр, тоглоом наадам	4.9	2.4	2.5	100.0	49.2	50.8
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	27.8	13.0	14.8	100.0	46.7	53.3
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0.6	0.3	0.3	100.0	48.9	51.1
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1.4	0.6	0.7	100.0	45.6	54.4

АЖИЛГҮЙЧҮҮД

Ажилгүй иргэдийн тоог ажиллах хүчид харьцуулж ажилгүйдлийн түвшинг тодорхойлов.


Улаанбаатар хотын хэмжээнд 2020 онд ажилгүйчүүдийн тоо 85.2 мянгад хүрч, өмнөх тооллогын үеэс 24.5 мянган (40.3%) хүнээр нэмэгджээ. Ажилгүйдлийн түвшин 14.5 болж, улсын дүнгээс 4.6 пунктээр өндөр, өмнөх тооллогын үеийнхээс 1.1 пунктээр өссөн дүн гарлаа. Ажилгүйдлийн түвшин нийслэлд улсын дүнгээс өндөр байгаа нь нэг талаас хот суурин бараадсан шилжих хөдөлгөөн их байгаа, нөгөө талаас тэдэнд хотод шилжин ирээд ажлын байр олох боломж муу байдагтай холбоотой. Энэ үзүүлэлтийг дүүргээр авч үзэхэд Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт нийслэлийн дунджаас 1.4-4.9 пунктээр өндөр байгаа бол Багахангай, Налайх, Чингэлтэй дүүрэгт 2-3 дахин бага байна.

ХҮСНЭГТ 10.11. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ДҮҮРЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН

Дүүрэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Ажилгүйчүүд	Ажилгүйдлийн түвшин	Ажилгүйчүүд	Ажилгүйдлийн түвшин	Ажилгүйчүүд	Ажилгүйдлийн түвшин
БҮГД	85 198	14.5	45 739	15.2	39 459	13.8
Багануур	1 338	12.0	764	12.9	574	10.9
Багахангай	75	4.8	42	5.0	33	4.6
Баянгол	18 446	19.4	9 207	19.9	9 239	18.9
Баянзүрх	25 198	16.9	13 613	17.9	11 585	15.9
Налайх	941	7.3	587	8.4	354	6.0
Сонгинохайрхан	20 670	15.9	11 731	16.8	8 939	14.9
Сүхбаатар	5 283	9.3	2 784	9.7	2 499	9.0
Хан-Уул	9 244	12.1	4 745	12.5	4 499	11.7
Чингэлтэй	4 003	7.3	2 266	7.9	1 737	6.6


Ажилгүйдлийн түвшин хүйс, дүүргээр бага зэрэг ялгаатай байна. Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн аль ч хүйсийн ажилгүйдлийн түвшин бусад дүүргээс өндөр байлаа.

ЗУРАГ 10.6. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ДҮҮРГЭЭР, 2020 ОН



Улсын хэмжээнд аль ч хүйсийн хувьд ажилгүйдлийн түвшин 25-аас дээш насанд аажмаар нэмэгдэн 60 хүртэлх насанд тогтвортой хэмжээнд байхад нийслэлд нас ахих тусам ажилгүйдлийн түвшин байнга нэмэгдсээр байна

ЗУРАГ 10.7. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, ХУВИАР, 2020 ОН



Өнгөрсөн 10 жилийн хугацаанд ажилгүйдлийн түвшин Улаанбаатар хотын хэмжээнд 1.1 пунктээр буурсан байна. Насны бүлгээр ангилан харвал 15-24 насанд 46.8 пунктээр буурсан байна. Энэ нь тухайн насны залуучуудын сургуульд хамрагдалт өмнөх тооллогын үеийнхээс 3.1-15.9 пунктээр нэмэгдсэнтэй холбоотой юм. Харин 45, түүнээс дээш насанд ажилгүйдлийн түвшин нэмэгдсэн нь ажил олгогчдын зүгээс шинээр ажлын байранд насны хязгаар заадаг, түүнчлэн энэ насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хөтөлбөр дутмаг байгаатай холбоотой байж болох юм.

АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ

Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэггүй хүн амаас ажил эрхлэхгүй байгаа шалтгааныг асуусан. Тухайлбал, сургуульд сурдаг хүн амд 15-аас дээш настай бүх шатны сургуульд суралцагчдыг, хөдөлмөрлөх чадваргүй хүн амд хөдөлмөрийн насны боловч хөдөлмөрлөх чадвараа байнга буюу удаан хугацаагаар бүтэн болон хэсэгчлэн алдсан бөгөөд сэргээгдэх боломжгүй хүнийг, гэрийн ажилтайд хүүхэд, өндөр настан, өвчтөн асардаг, гэр бүлийн бусад хүний ажлын онцлог зэргээс хамааран ажиллаж чадахгүй байгаа хүнийг тус тус хамааруулав. Тохирох ажил олдохгүй байгаа гэдэг ойлголтод “Ажил хийхийг хүсэж байгаа, ажил хийхэд бэлэн, урьд нь ажил идэвхтэй хайж байгаад тохирох ажил олдохгүй итгэл алдарсны улмаас тооллогын товын өмнөх 7 хоногт ажил идэвхтэй хайгаагүй эсвэл тохирох ажил хаанаас хайхаа мэдэхгүй байгаа хүмүүсийг” оруулав.

Улаанбаатар хотод 2020 оны тооллогоор ажиллах хүчнээс гадуурх 402.2 мянган хүн тоологдож, 2010 онтой харьцуулахад 4.1 хувиар буурсан эерэг үр дүн гарчээ. Эдгээрийн 41.1 хувь нь эрэгтэй, 58.9 хувь нь эмэгтэй байв.

ХҮСНЭГТ 10.12. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМЫН ТОО, АЖИЛ ЭРХЛЭХГҮЙ БАЙГАА ШАЛТГААН, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН /МЯН.ХҮН/

Ажил эрхлээгүй шалтгаан	2010 он			2020 он			2020 / 2010 %
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	419.6	171.7	247.9	402.2	165.4	236.8	95.9
Сургуульд сурдаг	178.0	80.4	97.6	144.2	67.9	76.3	81.0
Тэтгэвэрт	85.3	29.7	55.6	111.7	36.7	75.0	131.0
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	22.6	12.7	9.9	20.3	11.6	8.7	89.7
Гэрийн ажилтай	58.0	6.3	51.7	52.9	5.5	47.4	91.2
Ажиллах сонирхолгүй	1.6	1.1	0.5	1.7	1.2	0.5	104.6
Тохирох ажил олдохгүй байгаа	47.2	27.9	19.3	38.1	24.0	14.1	80.7
Бусад	26.9	13.6	13.3	33.3	18.5	14.8	124.2

Ажиллах хүчнээс гадуурх хүн амын шалтгааныг 2010 онтой харьцуулахад тэтгэвэрт гарсан хүний тоо 31.0 хувь, бусад шалтгаанаар ажил эрхлээгүй хүн 24.2 хувь, ажиллах сонирхолгүй хүний тоо 4.6 хувиар тус тус өсөж, бусад шалтгаан бүгд буурсан байна.

ХҮСНЭГТ 10.13. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, АЖИЛ ЭРХЛЭЭГҮЙ ШАЛТГААНААР, 2020 ОН

Насны бүлэг	Ажиллах хүчнээс гадуурх хүн ам							
	Бүгд	Сургуульд сурдаг	Тэтгэвэрт	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Ажиллах сонирхолгүй	Тохирох ажил олдохгүй байгаа	Бусад
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-19	20.0	53.9	-	0.9	1.4	2.1	1.6	2.7
20-24	12.9	29.4	-	3.1	6.3	4.3	7.9	7.8
25-34	16.3	14.4	-	15.0	38.6	23.5	29.5	29.2
35-44	10.9	2.0	0.3	24.2	31.0	28.4	26.3	26.9
45-54	9.1	0.2	3.3	33.0	16.8	31.2	23.7	22.7
55-59	7.5	0.0	16.3	16.3	4.6	8.3	8.7	7.7
60+	23.3	0.1	80.1	7.5	1.3	2.2	2.3	3.0

ХҮСНЭГТ 10.14. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, АЖИЛ ЭРХЛЭЭГҮЙ ШАЛТГААНААР, 2020 ОН

Насны бүлэг	Ажиллах хүчнээс гадуурх хүн ам							
	Бүгд	Сургуульд сурдаг	Тэтгэвэрт	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Ажиллах сонирхолгүй	Тохирох ажил олдохгүй байгаа	Бусад
БҮГД	100.0	35.8	27.8	5.0	13.2	9.5	0.4	8.3
15-19	100.0	96.9	-	0.2	1.0	0.8	0.0	1.1
20-24	100.0	81.4	-	1.2	6.5	5.8	0.1	5.0
25-34	100.0	31.7	-	4.6	31.1	17.1	0.6	14.9
35-44	100.0	6.5	0.7	11.2	37.3	22.8	1.1	20.4
45-54	100.0	0.7	10.0	18.3	24.3	24.6	1.4	20.7
55-59	100.0	0.2	60.7	11.0	8.0	11.1	0.5	8.5
60+	100.0	0.1	95.5	1.6	0.7	1.0	0.0	1.1

Сургуульд сурах шалтгаанаар ажил эрхлэхгүй байгаа 144.2 мянган хүний 53.9 хувь нь 15-19 насны, тэтгэвэрт байгаа 111.7 мянган хүний 80.1 хувь нь 60, түүнээс дээш насны, хөдөлмөр эрхлэх чадваргүй 20.3 мянган хүний 33.0 хувь, ажиллах сонирхолгүй 1.7 мянган хүний 31.2 хувь нь 45-54 насны, гэрийн ажилтай 52.9 мянган хүний 38.6 хувь, тохирох ажил олдохгүй 38.1 мянган хүний 29.5 хувь нь 25-34 насны хүн ам эзэлж байгаа нь тухайн шалтгаан доторх хамгийн өндөр үзүүлэлтүүд байлаа.


ХҮСНЭГТ 10.15. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМЫН ТОО, ДҮҮРЭГ, НАСНЫ БҮЛГЭЭР, 2020 ОН

Дүүрэг	Бүгд	15-24	25-34	35-44	45-54	55+
БҮГД	402 245	132 320	65 618	43 966	36 647	123 694
Багануур	8 691	2 921	1 089	837	967	2 877
Багахангай	1 236	404	175	150	112	395
Баянгол	56 854	19 159	9 176	5 370	4 386	18 763
Баянзүрх	95 332	33 198	15 868	10 255	8 401	27 610
Налайх	12 406	3 732	1 948	1 554	1 426	3 746
Сонгинохайрхан	90 537	30 172	14 908	10 041	8 368	27 048
Сүхбаатар	43 201	13 517	6 920	4 855	3 976	13 933
Хан-Уул	46 529	15 139	7 678	4 945	3 936	14 831
Чингэлтэй	47 459	14 078	7 856	5 959	5 075	14 491

ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД

ГАДААДАД ОРШИН СУУГАА
НИЙСЛЭЛИЙН ИРГЭД

91 168



31.8% ӨМНӨД СОЛОНГОС

19.1% АНУ

7.8% ЯПОН

5.0% ЧЕХ

4.9% АВСТРАЛИ

4.0% ХЯТАД

3.7% GERMAN

3.3% ШВЕД

2.9% ФРАНЦ

2.0% ОХУ

1.9% ТУРК

1.5% АВСТРИ

1.4% КАНАД

1.4% ИХ БРИТАН

1.3% УНГАР

1.3% ШВЕЙЦАР

0.8% КАЗАКСТАН

БУСАД УЛСАД 4.3%

0.6% ПОЛЬШ

0.6% ИРЛАНД

0.4% ЭНЭТХЭГ

ГАДААДАД 6, ТҮҮНЭЭС ДЭЭШ САРЫН ХУГАЦААГААР ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТОО

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр хүн амын гадаад улс орнууд руу хийх шилжилт хөдөлгөөн нэмэгдсэн. “Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй” гэсэн Үндсэн хуулийн заалт нь иргэдийг гадаадад зорчих, сурах, ажиллах, эх орондоо дуртай цагтаа эргэн ирэх эрх зүйн үндэс болдог.

Монгол Улсын “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуульд гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж, ажиллаж амьдарч, сурч байгаа иргэдийнхээ талаар бодитой тоо мэдээллийг тодорхойлох асуудлыг хуульчилсан байдаг.

Сурч боловсрох, хөдөлмөр эрхэлж, амьжиргаагаа дээшлүүлэх, бизнес эрхлэх, эрүүл мэндийн үйлчилгээ авах, гэр бүл болох зэрэг олон шалтгааны улмаас манай улсын иргэд гадаадын улс орнуудад зорчих хөдөлгөөн улам бүр нэмэгдэж байна. Энэ талаарх бүртгэл, албан ёсны тоо мэдээлэл өнөө хэр байхгүй байсныг шийдвэрлэх үүднээс 2018 оны 3-р улирлаас Үндэсний Статистикийн Хороо, Гадаад харилцааны яамтай хамтран гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэдийг бүртгэх маягтыг боловсруулж www.citizen.gov.mn цахим системийг нэвтрүүлсэн. Гэвч иргэдэд мэдээлэл хүргэх, бүртгэлийг идэвхжүүлэх, бүртгэлийн үйл ажиллагааг тогтворжуулах зэрэг нөхцөл байдлаас үүдэн энэ удаагийн гадаадад суугаа Монгол Улсын иргэдийн тооллогын дүнг Хил, хамгаалах ерөнхий газар (ХХЕГ), Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ)-ын мэдээллийн сангууд болон хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийн санг уялдуулах, өрхөөс асуусан тооллогын асуулгын мэдээллийг нэгтгэн гаргалаа. Тооллогын мэдээлэл цуглуулалт Монголд байх гэр бүлээс асуух, нөгөө талаас гадаадад оршин суугаа иргэд өөрсдөө интернэтээр (www.citizen.gov.mn) тоолуулахаар зохион байгуулсан юм.

Мэдээлэл боловсруулалтын явцад гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа иргэдийн тоог холбогдох байгууллагуудын мэдээллийг нарийн уялдуулан нягталж гаргах шаардлага зүй ёсоор тавигдсан.

ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТОО, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын дүнгээр гадаадад оршин суугаа 91 168 иргэн тоологдож 2010 оноос 6.3 хувиар өсжээ. Гадаадад тоологдсон иргэдийн 2 хүний 1 нь буюу 53.1 хувь нь Ази, Номхон далайн бүс нутагт, 4 хүн тутмын 1 нь Европ тивд суугаагаар тоологдсон байна.


Гадаадад оршин суугаа иргэдийн насны бүтцийг харвал 0-14 насны хүн ам 12.9 хувь, 15-44 насныхан 70.8 хувь, 45-64 насныхан 15.7 хувь, 65, түүнээс дээш насны хүн ам 0.6 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, гадаадад удаан хугацаагаар суугаа хүн амын 10 хүн тутмын 9 нь хөдөлмөрийн насны хүн ам байна.

ХҮСНЭГТ 11.1. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН

Насны бүлэг	2020			
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа ¹
БҮГД	91 168	40 956	50 212	81.6
0-4	2 613	1 317	1 296	101.6
5-9	4 891	2 517	2 374	106.0
10-14	4 282	2 175	2 107	103.2
15-19	4 839	2 472	2 367	104.4
20-24	10 468	5 430	5 038	107.8
25-29	14 142	7 007	7 135	98.2
30-34	15 142	7 071	8 071	87.6
35-39	11 084	4 642	6 442	72.1
40-44	8 890	3 318	5 572	59.5
45-49	7 093	2 461	4 632	53.1
50-54	4 208	1 399	2 809	49.8
55-59	2 159	711	1 448	49.1
60-64	847	280	567	49.4
65-69	280	94	186	50.5
70+	230	62	168	36.9


Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн нас, хүйсийн бүтцийг суваргаар харвал гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн ихэнх хувийг хөдөлмөр эрхлэх насныхан эзэлж байгаа нь харагдаж байна (Зураг 11.1).

ЗУРАГ 11.1. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2020 ОН



Зуун эмэгтэйд ногдох эрэгтэй хүн ам буюу хүйсийн харьцаа 81.6 байгаа (44.9 хувь эрэгтэй, 55.1 хувь эмэгтэйчүүд) нь гадаадад оршин суугаа эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдээсээ олон байгааг илтгэж байна. 0-24 насныхны хувьд дийлэнх нь эрэгтэйчүүд байхад хөдөлмөрийн насны болон ахмад настнуудын хувьд эмэгтэйчүүд илүү байна.

ЗУРАГ 11.2 ГАДААДАД ОРШИН СУУГАА НИЙСЛЭЛИЙН ИРГЭД БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН ДҮҮРГЭЭР, 2020 ОН



Гадаадад оршин суугаа Улаанбаатар хотын иргэдийн тоог байнга амьдарч байсан дүүргээр нь задалж харвал 22.8 хувь нь Баянзүрх, 19.9 хувь нь Баянгол, 16.6 хувь нь Сонгинохайрхан, 12.9 хувь нь Сүхбаатар дүүргээс гадаад улсад оршин суухаар явжээ.

ХҮСНЭГТ 11.2. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, БАЙНГА СУУЖ БАЙСАН ДҮҮРЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	2020			
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Дүнд эзлэх хувь
БҮГД	91 168	40 956	50 212	100.0
Багануур	1 199	549	650	1.3
Багахангай	200	94	106	0.2
Баянгол	18 205	7 851	10 354	19.9
Баянзүрх	20 772	9 516	11 256	22.8
Налайх	1 722	816	906	1.9
Сонгинохайрхан	15 110	6 966	8 144	16.6
Сүхбаатар	11 773	5 115	6 658	12.9
Хан-Уул	11 629	5 239	6 390	12.8
Чингэлтэй	10 558	4 810	5 748	11.6

Монголчууд гадаадад чөлөөтэй зорчих болсноос хойш 30 гаруй жил өнгөрчээ. Иргэдийн гадаадад оршин суугаа хугацааг авч үзэхэд 26.5 хувь нь 1 жил хүртэлх, дийлэнх буюу 42.2 хувь нь 2-5 жил, 16.8 хувь нь 6-10 жил, үлдсэн 14.5 хувь нь 11, түүнээс дээш жил гадаадад амьдарч байна. Гадаадад оршин суугаа иргэдийн дотор 11, түүнээс дээш жилээр суугаа иргэд Их британи, Ирланд, Польш, Герман, Унгар гэх мэт Европ тивийн улсуудад өндөр байна. Харин ОХУ, БНХАУ, Япон болон БНСУ-д суугаа иргэдийн ихэнх нь 1 хүртэлх жилийн хугацаагаар оршин сууж байна. Энэтхэг, Турк, Австрали улсуудад амьдарч байгаа иргэдийн ойролцоогоор 50 орчим хувь нь 2-5 жил, Казахстан, Франц, Канад улсуудад суугаа иргэдийн 30 орчим хувь нь 6-10 жил оршин суугаа иргэд байна.

ХҮСНЭГТ 11.3. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ТОО, ОРШИН СУУГАА УЛС, ОРШИН СУУГАА ХУГАЦАА, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Оршин суугаа улс	Тоо	Бүгд	2020			
			0-1 жил	2-5 жил	6-10 жил	11-ээс дээш жил
БҮГД	91 168	100.0	26.5	42.2	16.8	14.5
Солонгос /Өмнөд/	28 908	100.0	31.2	45.4	13.7	9.7
Америк	17 421	100.0	17.0	40.6	21.5	20.9
Япон	7 145	100.0	36.8	41.3	11.7	10.2
Казахстан	764	100.0	35.4	42.5	15.8	6.3
Чех	4 598	100.0	23.6	39.3	15.7	21.4
Австрали	4 486	100.0	32.0	46.5	13.6	7.9
Хятад	3 692	100.0	37.2	45.0	10.8	7.0
Герман	3 407	100.0	19.9	39.0	18.9	22.2
Швед	3 027	100.0	23.5	41.8	22.5	12.2
Франц	2 602	100.0	15.5	35.4	28.5	20.6
Орос	1 831	100.0	37.2	43.5	10.9	8.4
Турк	1 717	100.0	33.4	46.3	13.6	6.7
Австри	1 357	100.0	21.0	42.7	19.2	17.1
Швейцар	1 193	100.0	24.8	35.5	21.1	18.6
Их британи	1 308	100.0	9.6	34.2	22.9	33.3
Унгар	1 155	100.0	30.3	33.0	15.5	21.2
Канад	1 238	100.0	17.0	37.8	28.0	17.2
Энэтхэг	336	100.0	31.6	47.6	11.9	8.9
Польш	565	100.0	15.7	42.3	18.1	23.9
Ирланд	586	100.0	24.4	36.3	13.7	25.6
Бусад	3 962	100.0	20.3	38.0	21.5	20.2

Энэ удаагийн тооллогоор нийт өрхийн 10 хувиас уламжлалт асуулгаар мэдээлэл цуглуулахдаа гадаадад оршин суугаа иргэдээс анх явсан зорилго болон тооллогын үед сууж байгаа зорилгыг тодруулсан. Уг дүнгээр гадаадад оршин суугаа нийт иргэдийн 45.4 хувь нь анх суралцахаар гадаад улс руу явсан байна.


Тооллогын үед гадаадад суурьших зорилготой байгаа иргэдийн 26.2 хувь нь анх суралцах зорилгоор явж байсан байна. Харин тооллогын үед хувиараа хөдөлмөрлөхөөр гадаадад байгаа иргэдийн 21.1 хувь нь анх суралцахаар явж байсан байна. Үүнээс үзэхэд суралцах, ажиллах болон бусад зорилгоор гадаад руу явсан хүмүүсийн дийлэнх нь тухайн улсдаа суурьших хандлагатай байна.

ХҮСНЭГТ 11.4. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, ЯВСАН БОЛОН ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Тооллогын үед сууж байгаа зорилго								
Явсан зорилго	Бүгд	Суралцах	Суурьших	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах	Албан томилолтоор ажиллах	Хувиараа хөдөлмөрлөх	Гэр бүлийн шалтгаанаар оршин суух	Бусад
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Суралцах	45.4	94.7	26.2	6.1	15.9	21.2	9.4	21.9
Суурьших	8.0	0.5	51.3	0.9	3.8	1.0	2.2	3.7
Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах	13.4	0.9	4.6	92.5	1.3	3.4	2.3	9.1
Албан томилолтоор ажиллах	2.2	0.1	1.0	0.0	74.5	0.6	0.4	1.8
Хувиараа хөдөлмөрлөх	14.9	0.8	6.9	0.1	2.6	70.8	3.2	11.4
Гэр бүлийн шалтгаанаар оршин суух	13.6	2.6	7.2	0.4	1.9	2.0	81.5	1.4
Бусад	2.5	0.4	2.8	0.0	0.0	1.0	1.0	50.7

Тооллогын үед гадаадад байнга оршин суугаа хүмүүсийн 45.4 хувь нь суралцахаар, 8.0 хувь нь суурьшихаар, 13.4 хувь нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллах, 2.2 хувь нь албан томилолтоор, 14.9 хувь нь ажиллахаар, 13.6 хувь нь гэр бүлийн шалтгаанаар, 2.5 хувь нь бусад шалтгаанаар гадаадад оршин сууж байна. Тооллогын үед гадаадад байнга суугаа зорилгыг 2010 оны тооллогын дүнтэй харьцуулбал хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийн хувь 7.9 пунктээр, хувиараа хөдөлмөр эрхэлж буй иргэдийн хувь 1.5 пунктээр, суралцах зорилгоор суугаа иргэдийн хувь 0.1 пунктээр, албан томилолтоор ажиллаж буй иргэдийн хувь 1.7 пунктээр тус тус буурсан байна.

ЗУРАГ 11.3. ГАДААДАД ОРШИН СУУГАА НИЙСЛЭЛИЙН ИРГЭД, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ХУВИАР, 2010, 2020 ОН



Явсан зорилгыг оршин суугаа улсаар авч үзвэл Энэтхэг, БНХАУ, ОХУ, Казахстан, Япон, Герман, Ирланд руухамгийн олон хүн суралцахаар, Польш, Их Британи, Америк руухамгийн олон хүн суурьшихаар, БНСУ, БНЧУ, Унгар луу хамгийн их хүн хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар, Турк, БНСУ, Швед, БНЧУ, Швейцар, Польш руу хамгийн их хүн хувиараа хөдөлмөрлөхөөр явсан байна.

ХҮСНЭГТ 11.5. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, ЯВСАН БОЛОН ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Оршин суугаа улс	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Суралцах	Суурьших	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах	Албан томилолтоор ажиллах	Хувиараа ажиллах	Гэр бүлийн шалтгаанаар оршин суух	Бусад
БҮГД	91 168	100.0	35.8	11.5	10.0	1.1	18.5	13.1	10.0
Солонгос /Өмнөд/	28 908	100.0	29.9	5.7	19.2	0.7	25.0	9.1	10.4
Америк	17 421	100.0	37.0	17.7	3.4	0.9	14.8	14.9	11.3
Япон	7 145	100.0	48.1	9.4	6.9	1.8	12.9	12.9	8.0
Казахстан	764	100.0	48.6	17.5	4.3	1.6	8.2	16.1	3.7
Чех	4 598	100.0	21.1	12.2	18.7	1.0	23.5	16.1	7.4
Австрали	4 486	100.0	42.1	12.7	2.8	0.6	13.3	14.6	13.9
Хятад	3 692	100.0	61.6	7.1	3.9	1.4	9.0	10.6	6.4
Герман	3 407	100.0	41.7	16.4	3.8	0.9	13.6	14.4	9.2
Швед	3 027	100.0	25.5	16.6	6.9	1.0	23.6	20.4	6.0
Франц	2 602	100.0	28.9	15.2	4.0	0.7	16.8	22.1	12.3
Орос	1 831	100.0	57.8	9.6	3.4	2.6	8.8	11.5	6.3
Турк	1 717	100.0	37.1	8.5	8.9	1.1	25.7	11.5	7.2
Австри	1 357	100.0	36.7	12.5	4.2	0.7	17.1	15.3	13.5
Швейцар	1 193	100.0	33.3	15.1	5.1	2.3	19.7	14.1	10.4
Их британи	1 308	100.0	32.9	19.6	2.9	0.5	14.4	18.5	11.2
Унгар	1 155	100.0	35.8	10.9	13.2	1.4	19.2	11.7	7.8
Канад	1 238	100.0	34.7	16.8	4.4	1.9	14.1	16.1	12.0
Энэтхэг	336	100.0	65.2	6.0	2.7	1.5	7.1	14.3	3.2
Польш	565	100.0	28.5	22.8	5.1	2.5	19.7	12.7	8.7
Ирланд	586	100.0	39.6	16.0	2.6	1.0	16.4	16.7	7.7
Бусад	3 962	100.0	31.0	15.9	5.8	3.5	15.9	15.9	12.0

ХҮСНЭГТ 11.6. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	Хүний тоо	Суралцах	Суурьших	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах	Албан томилолтоор ажиллах	Хувиараа ажиллах	Гэр бүлийн шалтгаанаар оршин суух	Бусад
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
0-4	2.9	0.6	2.3	0.0	0.0	0.0	16.2	2.5
5-9	5.4	2.7	4.2	0.0	0.0	0.0	27.2	3.5
10-14	4.7	3.5	3.0	0.0	0.0	0.0	19.3	5.7
15-19	5.3	9.2	2.1	1.1	0.2	0.7	7.8	5.1
20-24	11.5	23.9	2.7	6.5	9.2	4.3	2.2	7.8
25-29	15.5	24.6	7.4	16.0	30.6	13.0	3.4	10.7
30-34	16.6	19.2	11.6	21.2	20.8	20.8	5.4	15.1
35-39	12.1	10.5	10.6	16.4	10.0	18.6	4.8	13.5
40-44	9.8	3.4	14.7	17.8	11.7	16.9	4.6	12.1
45-49	7.8	1.5	15.2	14.3	8.2	13.4	3.4	10.5
50-54	4.6	0.6	13.5	4.4	4.5	7.6	2.3	6.5
55-59	2.4	0.2	7.4	1.6	3.7	3.3	1.6	4.0
60-64	0.9	0.1	3.1	0.5	0.9	1.0	0.9	1.9
65-69	0.3	0.0	1.1	0.1	0.2	0.3	0.5	0.6
70+	0.2	0.0	1.1	0.1	0.0	0.1	0.4	0.5

Гадаадад оршин суугаа иргэдийн тооллогын үед оршин сууж байгаа зорилгоор авч үзвэл 0-14 насныхан гэр бүлийн шалтгаанаар оршин суух (62.7%), 15-34 насныхан суралцах (76.9%), албан томилолт (60.8%-оор ажиллах, 35-54 насныхан суурьших (53.9%), хөдөлмөрийн гэрээгээр ажиллах (53.0%), хувиараа хөдөлмөрлөх (56.6%), 55, түүнээс дээш насныхан суурьших (12.7%-аар оршин сууж байгаа нь тухайн насны бүлгийн хувьд хамгийн өндөр үзүүлэлт байна.


ЗУРАГ 11.4. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, НАСНЫ БҮЛЭГ, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



ӨРХИЙН ОРОН СУУЦНЫ ТӨРӨЛ, НӨХЦӨЛ



ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦ
141 690



Монгол Улсын төр засгаас ард иргэдийнхээ орон сууцны хүрэлцээ хангамж, тав тухтай байдал хэрхэн хангагдаж байгаа, цаашдын хэрэгцээ хангамжийг сайжруулах, бодлого төлөвлөлтөд ашиглах зорилгоор сүүлийн 40 гаруй жил хүн ам, орон сууцны 5 удаагийн тооллогоор иргэдийн орон сууцны нөхцөлийн талаар мэдээлэл цуглуулж байна.

Монгол Улсын төр засгаас сүүлийн жилүүдэд хүний хөгжлийг хангах, амьдралын чанарыг сайжруулахын тулд орон байрны асуудлыг шийдвэрлэхийн чухлыг анхаарч, хүн амын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулахад чиглэсэн эдийн засаг, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн. Монгол Улсын төрөөс орон сууцны талаар баримтлах бодлогод “Орон сууцны асуудал нь улсын хөгжил, нийгмийн амьдралын түвшинг тодорхойлох гол үзүүлэлт, хүн амын эрүүл амьдрах нөхцөл болохын хувьд Монгол Улсын төрийн бодлогын салшгүй хэсэг юм” гэж тодорхойлсон байдаг.

Монгол Улс хүн ам, орон сууцны тооллогоор орон сууц, тэдгээрийн дэд бүтцийн хангамжийн байдлыг нэлээд өөр өөр аргачлалаар тоолж ирсэн. Улс, хоршооллын байгууллагын орон сууцны сан хөмрөгийн тооллогыг 1969 онд анх удаа зохион байгуулж байжээ. Харин хүн ам, орон сууцны 2000, 2010 оны тооллогуудад орон сууцны сан хөмрөгийн тооллого явуулаагүй, хүн амын амьдарч буй орон сууцны төрөл, өмчлөл болон эзэмшлийн хэлбэр, дэд бүтцийн хангамжийг хүн амын тооллоготой хамтатган явуулж байсан.

Энэ удаа хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор хүн амын амьдарч буй орон сууцны төрөл, түүний нөхцөлийн талаарх үзүүлэлтүүдийг цуглуулахаас гадна хүн амьдран суух зориулалттай бүх төрлийн орон сууц, түүний насжилт, хана болон дээврийн материал, дэд бүтцийн талаарх мэдээллийг цуглуулах зорилготой Байшин, орон сууцны тооллогыг 2019 онд улс орон даяар зохион байгуулж явуулсан.

Зуслангийн суурьшлын бүс харгалзахгүйгээр улирлын чанартай амьдардаг байшин, орон сууцыг урьдчилсан бүртгэлээр бүртгэж, харин хүн амьдран суух зориулалттай үндсэн сууцны мэдээллийг тооллогоор цуглуулсан ба дараах орон сууцыг хамруулсан. Үүнд:

1. Бүх төрлийн гэр
2. Сууцны тусдаа байшин
3. Бие даасан тохилог сууц
4. Нийтийн зориулалттай орон сууцны байшин
5. Нийтийн байр

Мөн Байшин, орон сууцны тооллогод хамрагдсан бүх орон сууцнаас хүн байнга амьдардаг эсэхийг тодруулж, хүн байнга амьдардаг орон сууцны насжилт, хана, шал, дээврийн материал, дэд бүтэц зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулж тоолсон.

Харин хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор тоологдсон өрхийн амьдарч буй сууцны нөхцөлийн мэдээллийг хүн ам, өрхийн мэдээллийн сан болон уламжлалт тооллогоор өрхийн орон сууцны нөхцөлийн талаарх мэдээллийг цуглуулсан. Ингэхдээ эхлээд өрх ямар төрлийн сууцанд амьдарч байгааг асууж, дараа нь сууцны ахуйн нөхцөлийн үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Тоолох үед өрхийн амьдарч буй сууцыг ерөнхийдөө хүн амьдрах зориулалтаар нь гэр, байшин, бусад сууц (зориулалтын бус) гэж ангилсан.


Байшин, орон сууцны болон Хүн ам, орон сууцны тооллогын мэдээллийг хослуулан ашиглахад онцлон тэмдэглэх нэг асуудал бол нэг сууцанд нэгээс олон өрх амьдрах боломжтой учир өрхийн тоо сууцны тооноос өндөр гарах боломжтой, мөн орон сууцны байшингийн мэдээллийг Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар, Сууц өмчлөгчдийн холбооноос цуглуулсан учир доторх сууцны тоо буюу хэдэн айлын орон сууц гэдгийг асууж тодруулахдаа үйлчилгээ эрхэлж байгаа, түрээслэх болон өөр шалтгаанаар эзгүй байгаа хаалгыг ялгаж тодорхойлоогүй. Иймд орон сууцны байшингийн доторх сууцны тоо орон сууцны байшинд амьдардаг өрхийн тоо хоорондоо зөрөх боломжтой юм.

СУУЦНЫ ТӨРӨЛ

Байшин, орон сууцны тооллогоор нийт 226 960 сууц тоологдсоноос 80 044 (35.3%) гэр, 146 916 (64.7%) байшин сууц байсан бол гэр сууцны 58 039 (72.5%) нь үндсэн гэр, 22 005 (27.5%) нь илүү гэр байна. Харин байшин сууцны 107 415 (73.1%) үндсэн байшин (үүний 77.9 хувь нь хүн байнга амьдардаг байшин), 39 501 (26.9%) нь улирлын чанартай хүн амьдардаг зуслангийн байшин байна.

Тооллогоор хүн байнга амьдардаг сууцны дэлгэрэнгүй мэдээллийг амьдарч буй өрхөөс асууж цуглуулсан. Харин хүн байнга амьдардаггүй байшин, илүү гэр, зуслангийн байшин зэргийн сууцны дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулаагүй болно. Тиймээс энэ бүлэгт хүн байнга амьдардаг 141 690 гэр, байшин, орон сууцны байшингийн доторх сууцыг оруулаад 387 834 сууцны дэлгэрэнгүй үр дүнг танилцуулах болно.


ЗУРАГ 12.1 ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ НИЙТ СУУЦ БОЛОН ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, ТӨРЛӨӨР, 2019 ОН (БАЙШИН ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН ДҮН)



Хүн байнга амьдардаг сууцыг төрлөөр нь авч үзвэл 41.0 хувь нь гэр сууц, 54.9 хувь нь сууцны тусдаа байшин, 2.9 хувь нь нийтийн зориулалттай орон сууцны байшин, 0.6 хувь нь бие даасан тохилог сууц, 0.6 хувь нь нийтийн байр тоологдсон байна. Нийтийн зориулалттай 4 077 орон сууцны байшинд 250 221 сууц тоологдсон байна. Улсын хэмжээнд тоологдсон хүн байнга амьдардаг сууцны 32.0 хувь нь Улаанбаатар хотод тоологдсон байна.

Цаашид Байшин, орон сууцны тооллогоор тоологдсон хүн байнга амьдардаг гэр, байшин сууцны мэдээллийг Хүн ам, орон сууцны тооллогоор тоологдсон нийт өрхийн сууцны нөхцөлтэй холбон тайлбарлах болно. Ингэхдээ байшин болон Монголын ард түмний уламжлалт сууц – гэрийн талаарх мэдээллийг тус тусад нь авч үзэв.

ЗУРАГ 12.2. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2020 ОН



Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр нийт өрхийн 22.2 хувь нь монголын ард түмний уламжлалт сууц болох гэрт, 77.3 хувь нь байшинд, 0.5 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Улсын дунджаас гэрт амьдардаг өрхийн хувь 16.0 пунктээр доогуур бол байшинд амьдардаг өрхийн хувь 16.4 пунктээр дээгүүр байна.

Байшин, орон сууцны тооллогоор хүн байнга амьдардаг 141.7 мянган сууц, орон сууцны байшингийн доторх сууцыг оруулбал 387.8 мянган сууц тоологдлоо.

ХҮСНЭГТ 12.1. ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦ, ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019, 2020 ОН

Сууцны төрөл	Хүн байнга амьдардаг сууц		Өрхийн тоо	
	Сууцны тоо	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	387.8	100.0	411.4	100.0
Гэр	58.0	15.0	91.3	22.2
Байшин	329.8	85.0	317.9	77.3
Бусад сууц	-		2.2	0.5

Тайлбар: Орон сууцны байшингийн доторх сууцыг нэмж оруулав.

Монгол Улсад хүн ам орон сууцны тооллогоор нийт 897.4 мянган өрх тоологдсоноос 411.4 мянган өрх буюу нийт өрхийн 45.8 хувь нь нийслэл Улаанбаатар хотод амьдарч байгаа нь өмнөх үеийн тооллоготой харьцуулахад 109.2 мянган өрхөөр буюу 36.1 хувиар нэмэгджээ.

ХҮСНЭГТ 12.2. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Сууцны төрөл	2010		2020	
	мян. өрх	Дүнд эзлэх хувь	мян. өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	302.2	100.0	411.4	100.0
Гэр	87.5	29.0	91.3	22.2
Бусад	4.1	1.4	2.2	0.5
Байшин	210.6	69.6	317.9	77.3
Орон сууцны байшин	108.3	35.8	199.3	48.4
Бие даасан тохилог сууц	2.1	0.7	2.3	0.6
Сууцны тусдаа байшин	90.8	30.0	112.7	27.4
Нийтийн байр ¹	9.4	3.1	3.6	0.9

¹ оюутан, сурагчдын нийтийн байр, ажиллагчдын нийтийн байр, нийтийн зориулалтын бусад байрыг хамт авч үзэв.

Гэрт амьдардаг өрхийн хувь өмнөх тооллогын үеийнхээс 6.8 пунктээр буурсан бол байшинд амьдардаг өрхийнх 7.7 пунктээр нэмэгджээ. Энэ нь сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотод гэр хорооллыг дахин төлөвлөх, орон сууцжуулах ажил хийгдэж байгаа, мөн өнгөрсөн арван жилд шинээр орон сууцны хорооллууд ихээр баригдаж байгаатай холбоотой юм. Энд тэмдэглэн хэлэхэд Нийслэлийн Засаг дарга 2017 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн А/17 дугаар

захирамжаар хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод байнга оршин суухаар ирэх иргэдийн шилжилт хөдөлгөөнийг түр хугацаанд зогсоох шийдвэр гаргаж, энэхүү шийдвэр өнөөг хүртэл сунгагдсаар байгаа билээ. Гэхдээ энэхүү хязгаарлалтад Улаанбаатар хотод орон сууц худалдан авч байгаа иргэдэд хамаарахгүй юм. Иймд энэхүү хязгаарлалтын үр нөлөө гэр хороололд амьдардаг өрхийн бууралтад тодорхой хэмжээгээр нөлөөлөл үзүүлсэн байж болох талтай.

Тооны хувьд байшинд амьдардаг өрхийн тоо тооллого хооронд 107.3 мянган (50.9%) өрхөөр өссөн бол үүнээс орон сууцанд амьдардаг өрхийн тоо 84.0 хувь, бие даасан тохилог сууцанд амьдардаг өрхийн тоо 9.5 хувь, сууцны тусдаа байшин 24.1 хувь тус тус өсжээ. Эндээс байшинд амьдардаг өрхийн өсөлтийн дийлэнхийг орон сууцанд амьдардаг өрхийн өсөлт бүрдүүлж байгааг харж болно. Тооллого хооронд нийтийн байранд амьдардаг өрхийн тоо 2.6 дахин буурчээ. Мөн сууцны тусдаа байшин багагүй өссөн нь иргэд өөрсдөө байшин барьж суух хандлагатай болсны нэг илрэл юм. Харин гэрт амьдардаг өрхийн тоо тооллого хооронд 3.8 мянгаар (4.3%) өссөн байна.

ХҮСНЭГТ 12.3. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2020 ОН

Дүүрэг	Бүгд		Байшин		Гэр		Бусад сууц ¹	
	Өрх	Дүнд эзлэх хувь	Өрх	Дүнд эзлэх хувь	Өрх	Дүнд эзлэх хувь	Өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	411 420	100.0	317 944	77.3	91 249	22.2	2 227	0.5
Багануур	8 133	100.0	5 460	67.1	2 624	32.3	49	0.6
Багахангай	1 131	100.0	760	67.2	366	32.4	5	0.4
Баянгол	62 976	100.0	58 961	93.6	3 809	6.1	206	0.3
Баянзүрх	104 764	100.0	80 083	76.4	24 146	23.1	535	0.5
Налайх	10 248	100.0	6 701	65.4	3 504	34.2	43	0.4
Сонгинохайрхан	93 521	100.0	61 986	66.3	30 983	33.1	552	0.6
Сүхбаатар	40 061	100.0	31 795	79.4	7 984	19.9	282	0.7
Хан-Уул	51 241	100.0	43 548	85.0	7 434	14.5	259	0.5
Чингэлтэй	39 345	100.0	28 650	72.8	10 399	26.4	296	0.8

1 – Зориулалтын бус сууцыг хамт авч үзэв.

Сууцны төрлийг дүүрэг бүрээр авч үзэхэд нийслэлийн алслагдсан дүүргүүдэд, болон хотын төвийн дүүргээс Сонгинохайрхан дүүрэгт гэрт амьдардаг өрхийн хувь бусдаас өндөр, нэг үгээр хэлэхэд гурван өрх тутмын нэг нь гэрт амьдарч байна. Харин Баянгол дүүргийн нийт өрхийн 93.6 хувь, Хан-Уул дүүргийнх 85.0 хувь нь байшинд амьдарч байгаа нь дүүргүүдийн хувьд хамгийн өндөр түвшинд байна.

ӨРХИЙН СУУЦНЫ ӨМЧЛӨЛ

Сууцны өмчийн хэлбэрийг тооллогод тодорхойлохдоо төрийн болон хувийн гэж 2 ерөнхий ангилалд хуваасан бөгөөд хувийн өмчийг дотор нь иргэний, аж ахуй нэгж байгууллагын гэж өмнөх тооллоготой ижил ангилсан.

ХҮСНЭГТ 12.4. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ӨМЧИЙН ХЭЛБЭР, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН

Сууцны төрөл	Бүгд		Төрийн өмчийн		Хувийн өмчийн			
	мян. өрх	Бүгд	мян. өрх	Дүнд эзлэх хувь	ААНБ-ын		Иргэний	
					мян. өрх	Дүнд эзлэх хувь	мян. өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	411.4	100.0	2.4	0.6	1.8	0.4	407.2	99.0
Гэр	91.3	100.0	0.1	0.1	0.3	0.3	90.9	99.6
Байшин	317.9	100.0	2.3	0.7	1.5	0.5	314.2	98.8
Бусад сууц	2.2	100.0	0.0	0.6	0.1	2.4	2.2	97.0

Улаанбаатар хотын нийт өрхийн 99.4 хувь нь хувийн өмчийн (99.0 хувь нь иргэний, 0.4 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын) сууцанд амьдарч байгаа нь 2010 оныхоос 0.7 пунктээр нэмэгджээ. Гэрт суудаг өрхийн 99.9 хувь нь (99.6 хувь нь иргэний, 0.3 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын) хувийн өмчийн сууцанд байгаа нь 2010 оныхоос 0.4 пунктээр өсжээ. Байшинд суудаг өрхийн 0.7 хувь нь төрийн өмчийн сууцанд, 99.3 хувь нь (98.8 хувь нь иргэний, 0.5 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын) хувийн өмчийн сууцанд амьдарч, 2010 оны тооллогын дүнгээс төрийн өмчийн байшинд суудаг өрхийн хувь 0.8 пунктээр буурч, хувийн өмчийн байшинд амьдардаг өрх 0.8 пунктээр өссөн байна.


ХҮСНЭГТ 12.5. ӨРХИЙН ТОО, ӨМЧИЙН ХЭЛБЭР, СУУЦНЫ ТӨРӨЛ, ДҮҮРГЭЭР, 2020 ОН

Дүүрэг	Бүгд	Гэр			Байшин			Бусад сууц		
		Төрийн өмчийн	Хувийн		Төрийн өмчийн	Хувийн		Төрийн өмчийн	Хувийн	
			ААНБ-ын	Иргэний		ААНБ-ын	Иргэний		ААНБ-ын	Иргэний
БҮГД	100.0	0.0	0.1	22.1	0.6	0.3	76.4	0.0	0.0	0.5
Багануур	100.0	0.0	0.0	32.2	0.4	0.1	66.7	0.0	0.0	0.6
Багахангай	100.0	0.0	0.0	32.4	0.3	4.1	62.7	0.1	0.1	0.3
Баянгол	100.0	0.0	0.0	6.0	0.1	0.3	93.3	0.0	0.0	0.3
Баянзүрх	100.0	0.0	0.0	23.0	0.7	0.4	75.4	0.0	0.0	0.5
Налайх	100.0	0.0	0.0	34.2	1.2	0.2	64.0	0.0	0.0	0.4
Сонгинохайрхан	100.0	0.1	0.1	33.0	0.2	0.2	65.8	0.0	0.0	0.6
Сүхбаатар	100.0	0.0	0.1	19.9	1.1	0.4	77.8	0.0	0.0	0.7
Хан-Уул	100.0	0.1	0.2	14.2	1.2	0.7	83.1	0.0	0.0	0.5
Чингэлтэй	100.0	0.0	0.0	26.4	0.2	0.3	72.4	0.0	0.0	0.7

Дүүргүүдээр өрхийн сууцны өмчлөлийг гэр, байшин, бусад сууц гэсэн ангиллаар тус тусд нь ангилж байгаа учраас тухайн дүүргийн гэр болон байшин хорооллын хэмжээнээс хамааран өрхийн сууцны өмчлөлийн үр дүн харилцан адилгүй байна. Тухайлбал, Баянгол дүүргийн нийт өрхийн 93.3 хувь, Хан-Уул дүүргийн нийт өрхийн 83.1 хувь нь иргэний хувийн өмчийн байшинд амьдарч байгаа нь бусад дүүргээс өндөр, нийслэлийн дунджаас 6.7-16.9 пунктээр илүү байгаа бол Багахангай, Налайх дүүргүүдэд хамгийн бага буюу нийслэлийн дунджаас 12.4-13.7 пунктээр доогуур байна.

Өрхийн сууцны өмчлөлийн, ялангуяа монголын ард түмний уламжлалт сууц болох гэрийн өмчлөлийн байдлыг харахад төр болон аж ахуйн нэгж байгууллагын өмчлөлийн гэрт амьдрах хувь жил ирэх тутам багассаар байна.

ЗУРАГ 12.3. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН



Өрх, хүн амын хэдэн хувь нь өөрийн гэсэн орон сууцтай вэ гэдгийг тодорхойлох нь аль ч орны хот суурин газрын хувьд чухал шаардлагатай, хэрэгцээтэй асуудлын нэг юм. Учир нь ирээдүйд хот төлөвлөлтөд тусгах, орон сууцны хангамжийн асуудлыг иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, эрэлт нийлүүлэлтэд тулгуурлан төлөвлөхөд чухал ач холбогдолтой.

Улаанбаатар хотын нийт хүн амын 63.8 хувийг 0-35 хүртэлх насны хүүхэд, залуучууд эзэлдэг, залуужсан насны бүтэцтэй хот билээ. Үүнийг онцолдгийн учир нь дэлхийн аль ч оронд, ялангуяа залуу насны бүтэцтэй оронд тохиолддог гол хүндрэлийн нэг бол орон сууцны асуудал байдаг. Өөрөөр хэлбэл, гэрлэх нас руу шилжиж, гэрлэж байгаа залуусын орон сууцны эрэлтийг хангана гэдэг хотын хамгийн тулгамдсан асуудал байдаг аж. Иймээс эрэлт нийлүүлэлтийг хангах, шийдэл олохын тулд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, орон сууцжуулахаас гадна, тооллого, судалгаанд суурилан хотын бүсүүдийг тэнцвэртэй хөгжүүлэх шаардлагатай болдог. Нийслэлд сүүлийн жилүүдэд гэр бүл болсон залуучуудын нэлээд хувь нь бусдын сууцанд түрээстэй амьдрах эсвэл ипотекийн зээлээр орон сууцтай болох сонголтыг хийж байна.

Нийслэлийн хэмжээнд амьдарч байгаа нийт 411.4 мянган өрхийн 10.3 хувь буюу 42.3 мянган өрх өөрийн гэсэн сууцгүй байна. Үүнээс 5.5 хувь нь бусдын сууцанд түрээстэй, 4.4 хувь нь бусдын сууцанд түрээсгүй амьдарч байна. Энэ үзүүлэлтийг 2010 оны үзүүлэлтэд харьцуулахад өөрийн гэсэн сууцгүй өрхийн хувь 8.0 пунктээр буурсан аж. Нарийвчлан авч үзвэл бусдын байранд түрээстэй амьдарч байгаа өрхийн хувь ойролцоогоор 2 дахин буурчээ.

ХҮСНЭГТ 12.6. ӨӨРИЙН ЭЗЭМШЛИЙН СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ХУВЬ, СУУЦНЫ ТӨРӨЛ, ДҮҮРГЭЭР, 2020 ОН

Дүүрэг	Бүгд	Сууцны төрөл		
		Гэр	Байшин	Бусад сууц ¹
БҮГД	89.7	89.7	89.8	78.5
Багануур	91.6	94.5	90.2	95.9
Багахангай	80.5	91.5	75.4	60.0
Баянгол	92.4	91.9	92.5	76.7
Баянзүрх	88.7	87.9	89.1	76.1
Налайх	91.4	93.5	90.3	88.4
Сонгинохайрхан	88.4	90.0	87.6	82.4
Сүхбаатар	87.8	90.2	87.4	66.3
Хан-Уул	93.5	92.1	93.8	86.9
Чингэлтэй	87.7	87.9	87.7	77.4

1 – Зориулалтын бус сууцыг хамт авч үзэв.

Өөрийн эзэмшлийн сууцанд амьдардаг өрхийн хувийг дүүргээр авч үзвэл Хан-Уул (93.5%), Баянгол (92.4%), Багануур (91.6%), Налайх (91.4%) дүүргүүд нийслэлийн дунджаас 1.7-3.8 пунктээр өндөр байна. Багахангай дүүргийн хувьд хамгийн бага хувьтай буюу нийслэлийн дунджаас 9.2 пунктээр доогуур байна.

ӨРХИЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖ

Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн айл өрхийн цахилгаан хангамжийн хэрэгцээг оновчтой тодорхойлж, цахилгаан хангамжийг ухаалгаар тогтвортой сайжруулах, цаашид төсөл, хөтөлбөр, бодлого боловсруулахад хүн ам, орон сууцны тооллогын суурь мэдээлэл чухал ач холбогдолтой юм.

ХҮСНЭГТ 12.7. ӨРХИЙН ТОО, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2020 ОН

Дүүрэг	Нийт	Төвлөрсөн систем	Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	Бага оврын цахилгаан үүсгүүр	Цахилгааны эх үүсвэргүй
БҮГД	100.0	99.5	0.2	0.1	0.2
Багануур	100.0	97.0	2.4	0.4	0.2
Багахангай	100.0	98.0	0.8	1.1	0.1
Баянгол	100.0	99.9	0.0	0.0	0.0
Баянзүрх	100.0	99.4	0.3	0.1	0.2
Налайх	100.0	98.4	0.7	0.5	0.4
Сонгинохайрхан	100.0	99.1	0.1	0.2	0.6
Сүхбаатар	100.0	99.9	0.0	0.0	0.1
Хан-Уул	100.0	99.7	0.1	0.1	0.1
Чингэлтэй	100.0	99.8	0.0	0.0	0.2

Улаанбаатар хотын нийт өрхийн 99.5 хувь нь төвлөрсөн систем, 0.3 хувь нь сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж болон бага оврын цахилгаан үүсгүүрээр цахилгааны хэрэгцээгээ хангаж байна. Үүнийг 2010 оны тооллоготой харьцуулахад төвлөрсөн системээс цахилгаан хангамжаа авдаг өрхийн хувь 1.1 пунктээр өсөж, сэргээгдэх эрчим хүч болон бага оврын цахилгаан үүсгүүрээр цахилгаан хангамжаа авдаг өрхийн хувь 0.2 пунктээр буурчээ. Нийслэлийн хэмжээнд 1 046 өрх цахилгаангүй байгаа нь нийт өрхийн 0.2 хувь бөгөөд өмнөх тооллогын үеийнхээс 2 261 өрхөөр буюу 0.9 пунктээр буурсан. Нийт цахилгаан хэрэглэдэггүй өрхийн 54.8 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, 25.0 хувь нь Баянзүрх дүүрэгт байгаа нь дүүргүүд дотроо хамгийн өндөр байгаа юм. Энэ нь хөдөө орон нутгаас зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй шилжин ирэгсэд ихэвчлэн дээрх хоёр дүүрэгт суурьшдаг, мөн айл амьдрахыг хориглосон,


цахилгаан шугам татагдаагүй, төлөвлөлтөд ороогүй байршлууд тухайлбал, уул, гуу жалга, өндөр хүчдэлийн шугамын ойролцоо, голын ай сав газар гэх мэт газруудад суурьшдагтай холбоотой.

ГЭР СУУЦ БОЛОН ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ

Улаанбаатар хотын хэмжээнд үндэсний уламжлалт 58.0 мянган гэр сууцанд 91.3 мянган өрх тоологдсон нь нийт өрхийн 22.2 хувийг эзэлж, 2010 онтой харьцуулахад өрхийн тоо 3.7 мянган (4.2%) өрхөөр нэмэгдэж, гэр сууцны тоо 6.8 пунктээр буурчээ.

Байшин, орон сууцны тооллогоор хүн байнга амьдардаг ашиглагдаж байгаа гэр сууцны дээвэр, туурга, шалны материалыг тодруулан асуусан. Хүн байнга амьдардаг гэр сууцны 29.3 хувь нь шалгүй, 58.1 хувь нь модон шалтай, 11.8 хувь нь цементэн шалтай, 0.8 хувь нь бусад төрлийн шалтай байна.

ЗУРАГ 12.4. ГЭРИЙН ДЭЭВЭР, ТУУРГА, ШАЛНЫ ҮНДСЭН МАТЕРИАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН



Гэрт амьдардаг өрхийн 83.0 хувь нь 5 ханатай гэрт амьдарч байна. Эндээс монголчууд таван ханатай гэрт түгээмэл амьдардаг нь харагдаж байна.

ХҮСНЭГТ 12.8. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТОО, ГЭРИЙН ХАНЫН ТОО, ХУВИАР, 2010, 2020 ОН

Ам бүлийн тоо	Бүгд		Ханын тоо							
	мян. өрх	бүгдэд эзлэх хувь	5-аас цөөн		5		6		6-аас дээш	
	мян. өрх	бүгдэд эзлэх хувь	мян. өрх	бүгдэд эзлэх хувь	мян. өрх	бүгдэд эзлэх хувь	мян. өрх	бүгдэд эзлэх хувь	мян. өрх	бүгдэд эзлэх хувь
2010 он										
БҮГД	87.5	100.0	24.5	28.0	57.1	65.3	4.9	5.6	1.0	1.1
1-2	20.7	100.0	8.0	38.6	11.7	56.5	0.8	3.9	0.2	1.0
3-4	42.0	100.0	11.5	27.4	27.9	66.4	2.2	5.2	0.4	1.0
5-6	19.8	100.0	4.1	20.7	14.0	70.7	1.5	7.6	0.3	1.5
7+	5.0	100.0	0.9	18.0	3.5	70.0	0.4	8.0	0.1	2.0
2020 он										
БҮГД	91.3	100.0	11.1	12.2	75.8	83.0	3.4	3.7	1.0	1.1
1-2	31.3	100.0	4.5	14.4	25.5	81.7	1.0	3.0	0.3	0.9
3-4	34.1	100.0	4.0	11.8	28.3	83.0	1.4	4.0	0.4	1.2
5-6	19.6	100.0	2.0	10.1	16.6	84.6	0.8	4.1	0.2	1.2
7+	6.3	100.0	0.6	9.5	5.3	84.9	0.3	4.4	0.1	1.2

Улаанбаатар хотод 2020 оны тооллогоор нэг өрхийн дундаж ам бүлийн тоо 3-4 хүн байна. Өрхийн ам бүлийн тоог гэрийн ханын тоогоор авч үзвэл ханын тоо хүний тоотой шууд хамааралтай байгаа нь харагдаж байна. Мэдээж энэ нь гэрийн багтаамжтай холбоотой юм. Жишээлбэл, 5-аас цөөн ханатай гэрт амьдардаг өрхийн хувь ам бүлийн тоо нэмэгдэх тусам буурч байна.

ХҮСНЭГТ 12.9. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АХУЙН НӨХЦӨЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Ахуйн нөхцөл	2010		2020	
	Гэрт амьдардаг өрхийн тоо-Бүгд	Дүнд эзлэх хувь	Гэрт амьдардаг өрхийн тоо-Бүгд	Дүнд эзлэх хувь
БҮГД	87 537	100.0	91 249	100.0
БИЕ ЗАСАХ ГАЗРЫН ТӨРӨЛ				
Сайжруулсан	-	-	2 582	2.8
Энгийн	-	-	88 140	96.6
Био жорлон	-	-	246	0.3
Задгай	2 254	2.6	281	0.3
ХАТУУ ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАЛТ				
Үйлчилгээний байгууллагаар	76 808	87.7	88 178	96.6
Зөвшөөрөгдсөн цэгт	3 497	4.0	1 246	1.4
Шатаадаг	-	-	61	0.1
Булдаг	-	-	25	0.0
Тогтсон цэг байхгүй	7 232	8.3	1 739	1.9
БОХИР ЗАЙЛУУЛАЛТ				
Цооног	72 626	83.0	78 904	86.5
Задгай	14 911	17.0	12 345	13.5

Гэрт амьдардаг 91.2 мянган өрхийн 96.6 хувь нь энгийн нүхэн жорлон хэрэглэж байна. Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотын гэр хорооллын хөрсний бохирдол нэмэгдэж байгаагаас үүдэн гэр хорооллын өрхүүдэд стандарт модон жорлон хэрэглэх талаар төрийн болон төрийн бус байгууллагуудын “Жорлонгоо өөрчилъе” үүсгэл санаачилга их байгаа боловч өрхүүд энэ үйл ажиллагааг дэмжиж, өөрсдийнхөө ахуй нөхцөлийг сайжруулах идэвх хангалтгүй байна. Тооллогын дүнгээс харахад бүх өрхийн дөнгөж 3.1 хувь нь л сайжруулсан, био жорлонтой болжээ.

Энд сэтгэл эмзэглүүлсэн нэг асуудал бол бие засах тодорхой цэггүй 281 өрх улсын нийслэл Улаанбаатар хотод амьдарч байна.

Нийт өрхийн 96.6 хувь нь хатуу хог хаягдлыг үйлчилгээний байгууллагаар зөөвөрлөдөг гэсэн хариулт өгсөн ба энэ хариултын хувь өмнөх тооллогоос 8.9 пунктээр нэмэгдсэн эерэг үр дүн гарчээ. Гэхдээ хатуу хог хаягдлаа хаях тогтсон цэггүй өрх 1.9 хувь, шатаадаг болон булдаг 86 өрх (0.1 хувь) байна.

Нийслэлийн гэрт амьдардаг өрхийн 86.5 хувь нь зориулалтын цооногт бохир усаа асгадаг бол 13.5 хувь нь задгай асгадаг аж. Бохир усаа задгай асгадаг өрхийн эзлэх хувь 2010 оноос 3.5 пунктээр буурчээ. Дээрхээс үзэхэд хотын агаар, хөрсний бохирдол нэмэгдэх, улмаар орчны эрүүл ахуйн нөхцөл доройтоход гэрт амьдарч байгаа өрхүүд анхаарлаа хандуулах шаардлагатай, мөн холбогдох байгууллагууд ч тодорхой арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй байна.

Ундны усны баталгаат эх үүсвэрт төвлөрсөн систем, төвлөрсөн системд холбогдсон болон холбогдоогүй ус түгээх байр, хамгаалагдсан худаг, булаг, шанд, цэвэршүүлэн савласан усыг оруулдаг бол хамгаалагдаагүй худаг, булаг, шанд, зөөврийн ус, гол, мөрөн, нуур зэрэг гадаргуугийн усыг сайжруулсан ундны усны эх үүсвэрт оруулдаггүй.

Гэрт амьдардаг өрхийн 99.8 хувь нь шаардлага хангасан ундны эх үүсвэрээс ундны усаа авч байгаа нь 2010 оны тооллогын дүнгээс 6.7 пунктээр нэмэгджээ. Нийслэлд шаардлага хангаагүй ундны ус хэрэглэдэг 192 өрх байгаагийн 66.7 хувь нь зөөврийн ус, үлдсэн нь гол, мөрөн, нуур тойром, хамгаалагдаагүй булаг шандын ус хэрэглэж байна. Улаанбаатар хот өнгөрсөн арван жилийн хугацаанд өрхийг шаардлага хангасан усаар хангах ажлыг бараг шийдэж чадсан гэж дүгнэж болохоор байна.

БАЙШИНГИЙН ТОО, БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ, СУУЦНЫ БАГТААМЖ


Байшин, орон сууцны болон Хүн ам, орон сууцны тооллогод байшинд дараах сууцуудыг хамруулсан ба Хавсралт Б-д байгаа “Тооллогод хэрэглэсэн ойлголт тодорхойлолт” хэсгээс дэлгэрэнгүй ойлголтуудыг үзнэ үү. Үүнд:

1. Орон сууцны байшин
 - 1.1. Орон сууцны байшингийн доторх сууц
2. Сууцны тусдаа байшин
3. Бие даасан тохилог сууц
4. Нийтийн байр

Улаанбаатар хотын хэмжээнд 83.7 мянган байшин, орон сууцны байшингийн доторх сууцыг оруулаад 329.8 мянган байшин сууц тоологдсон байна. Эдгээр байшингийн хийц, ашиглалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулсан ба үр дүнг нэгтгэвэл дараах байдалтай байна.

Байшинд амьдардаг өрхийн сууцны нөхцөл, сууцны талбайн хэмжээ, өрөөний талбайг тооцох нь дэлхийн бусад оронтой өөрийн орны иргэдийн амьдралын нөхцөл байдлыг харьцуулан судлах, улмаар нөхцөл байдлын үнэлгээ гаргах, орон сууцны зах зээлийн судалгаа гаргах, цаашид төр, засгаас бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх, хотын төлөвлөлт зэрэг олон асуудлын шийдлийг гаргахад ашиглах боломжтой юм.

ЗУРАГ 12.5. БАЙШИН СУУЦНЫ АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОН, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН



Тоологдсон нийт байшин сууцны 78.9 хувь нь сүүлийн 20 жилд ашиглалтад орсон сууцууд байна. Байшин сууцыг төрлөөр нь ангилан харвал нийтийн зориулалттай орон сууцны байшингийн 21.0 хувь нь их бүтээн байгуулалтын жилүүд болох 1960-1989 онуудад ашиглалтад орсон бол 70.4 хувь нь сүүлийн 20 жилд ашиглалтад оржээ. Харин бие даасан тохилог сууцны 90.1 хувь нь сүүлийн 20 жилд, үүний 47.3 хувь нь сүүлийн 10 жилд ашиглалтад оржээ. (Зураг 12.4).

ХҮСНЭГТ 12.10. БАЙШИН СУУЦНЫ ТОО, ХАНЫН ҮНДСЭН МАТЕРИАЛ, ХАНЫН ӨНГӨЛГӨӨ-НИЙ МАТЕРИАЛ, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, МЯНГА, 2019 ОН


	Бүгд		НЗОСБ*		Сууцны тусдаа байшин		Бие даасан тохилог сууц		Нийтийн байр	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Ханын үндсэн материал	83.7	100.0	4.1	100.0	77.8	100.0	0.9	100.0	0.9	100.0
Цутгамал төмөр бетон	3.9	4.6	1.4	35.4	2.3	2.9	0.2	19.8	0.03	3.7
Угсармал төмөр бетон	1.1	1.3	0.8	18.9	0.3	0.3	0.1	5.2	0.01	0.7
Блок	21.8	26.0	0.4	8.9	20.9	26.9	0.2	27.1	0.2	25.7
Тоосго	13.8	16.6	0.9	22.8	12.4	16.0	0.2	20.9	0.3	26.8
Мод	38.6	46.1	-	-	38.1	48.9	0.2	16.5	0.3	36.0
Сэндвич хавтан	0.4	0.5	-	-	0.4	0.6	0.0	0.5	0.01	0.9
Холимог	2.2	2.6	0.5	11.7	1.6	2.1	0.1	8.4	0.03	3.9
Бусад	1.9	2.3	0.1	2.3	1.8	2.3	0.0	1.6	0.02	2.3
Ханын өнгөлгөө, гадна фасадны материал	83.7	100.0	4.1	100.0	77.8	100.0	0.9	100.0	0.9	100.0
Цементэн шавардлага	20.9	25.0	2.0	47.9	18.4	23.6	0.3	35.8	0.2	28.2
Мод	4.1	4.9	-	0.0	4.0	5.1	0.05	5.5	0.08	9.6
Металл хавтан	0.5	0.6	0.05	0.8	0.4	0.6	0.04	4.0	0.01	0.5
Хуванцар хавтан	0.7	0.8	0.05	0.7	0.6	0.8	0.01	1.4	0.0	0.1
Чулуун хавтан	0.4	0.5	0.2	6.0	0.2	0.2	0.03	2.9	0.0	0.1
Тоосго	39.7	47.5	0.7	17.3	38.4	49.5	0.3	29.1	0.3	35.9
Шар шавар	9.0	10.7	0.3	6.6	8.4	10.8	0.03	3.6	0.2	16.8
Плита	0.3	0.4	0.1	3.6	0.2	0.2	0.01	0.6	0.0	0.2
Бусад	4.8	5.7	0.6	13.9	4.1	5.2	0.1	13.2	0.05	5.3
Байхгүй	3.3	3.9	0.1	3.2	3.1	4.0	0.03	3.9	0.03	3.3

* НЗОСБ – Нийтийн зориулалттай орон сууцны байшин

Байшин сууцны ханын үндсэн материалын дийлэнхийг буюу 88.7 хувийг блок, тоосго, мод эзэлж байгаа бол ханын өнгөлгөө, гадна фасадын материалын 72.5 хувийг цементэн шавардлага, тоосго эзэлж байна (Хүснэгт 12.9).

Сууцны төрлөөр дэлгэрүүлж харвал нийтийн зориулалттай орон сууцны байшингийн ханын үндсэн материалын 22.8 хувь нь тоосго, 35.4 хувь нь цутгамал төмөр бетон, 18.9 хувь нь угсармал төмөр бетон, харин ханын өнгөлгөөний 47.9 хувь нь цементэн шавардлага байна.

ЗУРАГ 12.6. АМИНЫ СУУЦНЫ БАЙШИНГИЙН ШАЛНЫ ҮНДСЭН БОЛОН ХУЧИЛТЫН МАТЕРИАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН



БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ

ХҮСНЭГТ 12.11. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТОО, СУУЦНЫ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, ХУВИАР, 2020 ОН

Ам бүлийн тоо	Бүгд ¹		Сууцны талбай (квадрат метр)					
			20 хүртэл		21-40		40-өөс дээш	
	мян. өрх	бүгдэд эзлэх хувь	мян. өрх	бүгдэд эзлэх хувь	мян. өрх	бүгдэд эзлэх хувь	мян. өрх	бүгдэд эзлэх хувь
БҮГД	317.8	100.0	27.5	8.7	74.1	23.3	216.1	68.0
1-2	94.2	100.0	9.3	9.9	23.5	25.0	61.3	65.1
3-4	122.1	100.0	10.4	8.5	28.2	23.1	83.5	68.4
5-6	74.2	100.0	5.9	7.9	16.2	21.8	52.1	70.3
7+	27.3	100.0	1.9	7.1	6.2	22.8	19.1	70.1

1 - Нийтийн зориулалтын бусад байр ороогүй болно

Байшинд амьдардаг 317.8 мянган өрхийн 68.0 хувь нь 40-өөс дээш квадрат метр талбайтай сууцанд амьдарч байгаа нь байшинд амьдардаг өрхийн хамгийн их хувийг эзэлж байгаа ба өмнөх тооллогын дүнгээс даруй 20.2 пунктээр өссөн байна. Харин 21-40 квадрат метр талбайтай байшинд суудаг өрхийн хувь 23.3 хувь болж өмнөх тооллогоос 15.5 пунктээр буурчээ. Эндээс хоёр тооллогын хооронд нийслэл хотын байшинд амьдардаг өрхүүдийн орон сууцны багтаамж, ахуй нөхцөл сайжирсан гэж дүгнэж болохоор байна.

Хэрэглэгчийн зах зээлийн судалгаагаар иргэд 1-ээс дээш өрөө байранд амьдрах сонирхолтой байгаа гэж гарсан нь үүнийг баталж байгаа юм. Дээрх үзүүлэлтийг ам бүлийн тоотой харьцуулан үзэхэд ам бүлийн тоо нэмэгдэх тутам 20 хүртэл квадрат метр талбайтай өрхийн хувь буурч, эсрэгээр 40-өөс дээш квадрат метр талбайтай өрхийн эзлэх хувь өсөж байна. 7, түүнээс дээш ам бүлтэй өрхийн 70.1 хувь нь 40-өөс дээш квадрат метр талбайтай байранд амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеэс 14.7 пунктээр өсжээ.

ХҮСНЭГТ 12.12. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТОО, ӨРӨӨНИЙ ТОО, ХУВИАР, 2020 ОН

Ам бүлийн тоо	Бүгд ¹	Өрөөний тоо						
		1	2	3	4	5-7	8-10	11+
БҮГД	100.0	24.9	45.5	22.1	5.4	1.9	0.2	0.0
1-2	100.0	33.2	43.6	17.3	4.3	1.5	0.1	0.0
3-4	100.0	25.4	47.7	20.4	4.7	1.6	0.2	0.0
5-6	100.0	20.3	44.7	25.7	6.7	2.4	0.2	0.0
7+	100.0	20.5	43.3	26.6	6.6	2.5	0.3	0.2

1 - Нийтийн зориулалтын бусад байр ороогүй болно

Тооллогоор байшинд амьдардаг өрхийн 70.4 хувь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байгаа нь 2010 оноос 0.8 пунктээр буурчээ. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн хугацаанд өөрчлөлт бага гарчээ.

Ам бүлийн тоогоор нь авч үзвэл нийслэлийн өрхийн ам бүлийн дундаж үзүүлэлт болох 3-4 ам бүлтэй өрхийн 73.1 хувь нь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байгаа ба өмнөх тооллогын үетэй харьцуулахад 1.3 пунктээр, 5-6 ам бүлтэй өрхийн 65.0 хувь нь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байгаа бөгөөд өмнөх тооллогоос 0.4 пунктээр, 7, түүнээс дээш ам бүлтэй өрхийн 63.8 хувь нь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 3.1 пунктээр тус тус өсөв. Харин 4, түүнээс олон өрөөнд амьдардаг өрхийн тоог нийт өрхөд харьцуулсан хувийн жинд өөрчлөлт бага гарчээ.

ХҮСНЭГТ 12.13. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ХУВЬ, ДҮҮРЭГ, ӨРӨӨНИЙ ТООГООР, 2020 ОН

Дүүрэг	Бүгд	Өрөөний тоо						
		1	2	3	4	5-7	8-10	11 +
БҮГД	100.0	24.9	45.5	22.1	5.4	1.9	0.2	0.0
Багануур	100.0	35.6	44.5	18.0	1.2	0.7	0.0	0.0
Багахангай	100.0	17.0	54.3	22.3	6.4	0.0	0.0	0.0
Баянгол	100.0	21.0	51.0	24.5	2.8	0.6	0.1	0.0
Баянзүрх	100.0	22.3	47.4	22.6	5.4	1.9	0.3	0.1
Налайх	100.0	33.6	41.2	18.6	4.9	1.6	0.1	0.0
Сонгинохайрхан	100.0	25.9	45.4	20.9	5.5	2.1	0.2	0.0
Сүхбаатар	100.0	23.7	43.2	23.4	7.1	2.4	0.1	0.1
Хан-Уул	100.0	19.5	43.4	24.2	8.7	3.8	0.4	0.0
Чингэлтэй	100.0	40.3	37.4	16.4	4.3	1.5	0.1	0.0

Энэ үзүүлэлтийг дүүргээр авч үзвэл нэг өрөөнд амьдардаг өрхийн хувь Чингэлтэй, Багануур, Налайх дүүрэгт, хоёр өрөөнд амьдардаг өрхийн хувь Багахангай, Баянгол дүүрэгт, гурван өрөөнд амьдардаг өрхийн хувь Баянгол, Хан-Уул дүүрэгт, 4, түүнээс дээш өрөөнд амьдардаг өрхийн тоо Хан-Уул дүүрэгт тус тус өндөр байна.

ДЭД БҮТЦИЙН ХАНГАМЖ

Энэхүү хэсэгт байшинд суудаг өрхийн дэд бүтцийн хангамж болох халаалтын төрөл, усан хангамж, бие засах газар, онгоц, шүршүүрийн өрөөний талаарх үр дүнг танилцуулна.

Байшинд амьдардаг өрхийн 62.5 хувь төвлөрсөн халаалтын системд холбогдсон байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 7.5 пунктээр өссөн байна. Энэ нь тооллого хооронд нийслэл хотод барилгажилт нэмэгдсэн, мөн гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд дулааны шугам сүлжээний өргөтгөл хийсэнтэй холбоотой.

Тооллогоор төвлөрсөн бусаар халаалтаа шийдсэн өрхийн хувь өмнөх тооллогоос 2.8 пунктээр өссөн. Үүнийг төвлөрсөн бус халаалтын төрлөөр авч үзвэл нам даралтын зуухаар халаадаг өрхийн хувь 0.6 пункт, цахилгаан халаагуураар халаалтаа шийдсэн өрх 2.2 пунктээр тус тус өсжээ. Өрхүүд сууцаа ердийн галлагаагаар халааж байгаа хувь нийслэлд 27.3 хувьтай байгааг 2010 онтой харьцуулахад 10.3 пунктээр буурсан байна. Энэ нь Засгийн Газраас агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хүрээнд өвлийн улиралд цахилгааны шөнийн тарифыг тэглэх, яндангийн тоог цөөлөх зорилгоор уурын зуухнуудыг цөөлж төвлөрсөн халаалтад оруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаагийн бодит үр дүн гэж хэлж болно. Нийслэлийн хэмжээнд шахмал түлш хэрэглэж эхэлсэн, шөнийн цахилгааны тарифыг тэглэсэн зэрэг арга хэмжээнүүдийн үр дүнд агаарын бохирдол урьд өмнө байгаагүйгээр буурч байна.

ХҮСНЭГТ 12.14. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ХАЛААЛТЫН ТӨРӨЛ,
ХУВИАР, 2010, 2020 ОН

Халаалтын төрөл	2010		2020	
	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	210.6	100.0	317.9	100.0
Төвлөрсөн	115.8	55.0	198.8	62.5
Төвлөрсөн бус	15.7	7.4	32.4	10.2
Нам даралтын зуух	14.0	6.6	22.9	7.2
Цахилгаан халаагуур	1.7	0.8	9.5	3.0
Ердийн галлагаа	79.1	37.6	86.6	27.3
Газрын гүний дулаан	-	-	0.0	0.0
Шатдаг хий	-	-	0.0	0.0

Дүүргүүдийн байршил болон орон сууцжуулалтын түвшин харилцан адилгүй байгаагаас халаалтын төрлийн үр дүн ялгаатай байна. Орон сууцны байшин ихтэй Баянгол, Багахангай, Хан-Уул дүүрэгт төвлөрсөн системээр сууцаа халаах нь бусад дүүргээс өндөр байхад Чингэлтэй, Налайх, Сонинохайрхан дүүрэгт төвлөрсөн бус системээр сууцаа халаадаг өрхийн хувь их байгаа нь хотын төвөөс алслагдсан өрх ихтэй бөгөөд төвлөрсөн системд холбогдох боломж муу байдагтай холбоотой.

ХҮСНЭГТ 12.15. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ХАЛААЛТЫН ТӨРӨЛ, ДҮҮРЭГ,
ХУВИАР, 2020 ОН

Дүүрэг	Нийт	Төвлөрсөн систем	Төвлөрсөн бус систем			Ердийн галлагаа	Газрын гүнийн дулаан	Шатдаг хий
			Бүгд	Нам даралтын зуух	Цахилгаан халаагуур			
БҮГД	100.0	62.5	10.2	7.2	3.0	27.3	0.0	0.0
Багануур	100.0	66.0	6.0	5.3	0.7	28.0	0.0	0.0
Багахангай	100.0	78.2	3.4	2.9	0.5	18.4	0.0	0.0
Баянгол	100.0	87.0	5.1	4.1	1.0	7.9	0.0	0.0
Баянзүрх	100.0	65.7	8.8	6.5	2.3	25.5	0.0	0.0
Налайх	100.0	40.0	9.6	8.4	1.2	50.4	0.0	0.0
Сонгинохайрхан	100.0	43.0	15.5	10.9	4.6	41.5	0.0	0.0
Сүхбаатар	100.0	66.4	10.1	6.4	3.7	23.5	0.0	0.0
Хан-Уул	100.0	72.3	8.5	5.5	3.0	19.2	0.0	0.0
Чингэлтэй	100.0	30.7	17.2	11.4	5.8	52.1	0.0	0.0

Байшинд амьдардаг өрхийг усан хангамжийн төрлөөр авч үзэхэд нийт өрхийн 62.2 хувь нь төвлөрсөн усан хангамжид холбогдсон. Үүнээс 61.6 хувь нь халуун, хүйтэн устай тохилог нөхцөлд амьдарч байна. Энэ үзүүлэлтийг 2010 оны тооллоготой харьцуулахад халуун, хүйтэн устай байшинд амьдардаг өрхийн хувь 9.0 пунктээр өсжээ.

Байшинд амьдардаг өрхийн 36.4 хувь буюу 115.8 мянган өрх зөөврийн ус хэрэглэж байна. Байшинд амьдардаг, зөөврийн ус хэрэглэдэг өрхийн хувь өмнөх тооллогоос 8.8 пунктээр буурсан байна. Энд тэмдэглэж хэлэхэд зөөврийн усан хангамжаар хэрэгцээгээ хангадаг өрхийн дийлэнх нь сууцны тусдаа байшинд амьдардаг өрхүүд юм. Иймээс цаашид өрхийг орон сууцжуулах бодлогоос гадна сууцны тусдаа байшинд амьдарч байгаа өрхийг төвлөрсөн усан хангамжаар хангах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

ХҮСНЭГТ 12.16. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН УСАН ХАНГАМЖИЙН ТӨРӨЛ, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2010, 2020 ОН

	Бүгд ¹	Орон сууцны байшин	Бие даасан тохилог сууц	Сууцны тусдаа байшин	Нийтийн байр
2010					
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0
Төвлөрсөн усан хангамж	54.4	100.0	86.8	0.7	55.0
Халуун, хүйтэн устай	52.6	97.5	81.0	0.4	49.1
Зөвхөн хүйтэн устай	1.8	2.5	5.8	0.3	5.9
Төвлөрсөн бус усан хангамж	0.4	0.0	13.2	0.5	0.1
Халуун, хүйтэн устай	0.2	0.0	10.6	0.3	0.0
Зөвхөн хүйтэн устай	0.2	0.0	2.6	0.2	0.1
Зөөврийн	45.2	0.0	0.0	98.8	44.9
2020					
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0
Төвлөрсөн усан хангамж	62.2	96.6	78.5	2.2	25.1
Халуун, хүйтэн устай	61.6	96.2	71.8	1.6	18.2
Зөвхөн хүйтэн устай	0.6	0.4	6.7	0.6	6.9
Төвлөрсөн бус усан хангамж	1.4	0.6	21.4	2.3	4.4
Халуун, хүйтэн устай	0.9	0.5	15.4	1.2	2.2
Зөвхөн хүйтэн устай	0.5	0.1	6.0	1.1	2.2
Зөөврийн	36.4	2.8	0.1	95.5	70.5

1 - Нийтийн зориулалтын бусад байр ороогүй болно

Нийслэлийн Баянгол дүүрэгт байшинд амьдардаг өрхийн усан хангамжийг бусад дүүрэгтэй харьцуулахад төвлөрсөн усан хангамжийн хувь өндөр, 86.4 хувьтай байна. Харин Чингэлтэй, Налайх болон Сонгинохайрхан дүүрэгт байшинд амьдардаг өрхүүдийн 54.4-68.4 хувь нь ундны усны хэрэглээгээ зөөврийн усаар хангаж байна.

ХҮСНЭГТ 12.17. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН УСАН ХАНГАМЖИЙН ТӨРӨЛ, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2020 ОН

Дүүрэг	Бүгд	Төвлөрсөн усан хангамж		Төвлөрсөн бус усан хангамж		Зөөврийн
		Халуун, хүйтэн устай	Зөвхөн хүйтэн устай	Халуун, хүйтэн устай	Зөвхөн хүйтэн устай	
БҮГД	100.0	61.6	0.6	0.9	0.5	36.4
Багануур	100.0	64.8	0.7	0.1	0.0	34.4
Багахангай	100.0	77.4	0.5	0.1	0.1	21.9
Баянгол	100.0	86.4	0.2	0.2	0.1	13.1
Баянзүрх	100.0	65.2	0.4	0.6	0.5	33.3
Налайх	100.0	37.4	2.4	0.4	0.2	59.6
Сонгинохайрхан	100.0	43.0	0.6	1.4	0.6	54.4
Сүхбаатар	100.0	65.1	0.6	1.0	0.9	32.4
Хан-Уул	100.0	68.8	1.5	2.1	0.6	27.0
Чингэлтэй	100.0	30.2	0.3	0.6	0.5	68.4

Байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн үндсэн үзүүлэлтийн нэг нь онгоц, шүршүүр юм. Энэхүү үзүүлэлт нь хүн амын эрүүл ахуйн нөхцөл, ариун цэврийн байгууламжийн хүртээмж ямар байгааг тодруулах, энэ төрлийн бодлого, хөтөлбөр боловсруулах суурь эх үүсвэр болно.

ХҮСНЭГТ 12.18. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ОНГОЦ ШҮРШҮҮРИЙН ТӨРӨЛ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Ахуйн нөхцөл	Орон сууцны байшин	Бие даасан тохилог сууц	Сууцны тусдаа байшин	Нийтийн байр
2010				
Онгоц, шүршүүрийн өрөө	100.0	100.0	100.0	100.0
Өрөөтэй	94.7	94.4	5.2	7.0
Байнгын суурилуулсан	94.6	93.0	4.1	6.9
Угсардаг /зөөврийн/	0.1	1.4	1.1	0.1
Нийтээрээ ашигладаг	3.7	5.6	0.6	36.3
Өрөөгүй	1.6	-	94.2	56.7
2020				
Онгоц, шүршүүрийн өрөө	100.0	100.0	100.0	100.0
Өрөөтэй	99.6	96.2	6.2	20.3
Байнгын суурилуулсан	99.4	93.1	4.6	19.5
Угсардаг /зөөврийн/	0.2	3.1	1.6	0.8
Өрөөгүй	0.4	3.8	93.8	79.7


Байшинд амьдардаг нийт өрхийн 59.7 хувь нь онгоц, шүршүүртэй байна. Байнгын суурилуулсан онгоц, шүршүүртэй сууцанд амьдардаг өрх нийт байшинд амьдардаг өрхийн 58.9 хувийг эзэлж байна.

Нийслэлийн Багахангай (81.9%), Баянгол (87.0%) дүүрэгт байшинд амьдардаг нийт өрхийн дийлэнх нь байнгын суурилуулсан онгоц шүршүүрийн өрөөг амьдрал ахуйдаа ашиглаж байгаа нь бусад дүүрэгтэй харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт Чингэлтэй (29.5%), Налайх, (34.0%), Сонгинохайрхан (39.3%) дүүргийн хувьд хангалтгүй байна. Эндээс харахад дүүргүүдийн байшинд амьдардаг өрхийн онгоц шүршүүрийн өрөөтэй гэж хариулсан хувь харилцан адилгүй байгааг харж болно.

ХҮСНЭГТ 12.19. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ОНГОЦ ШҮРШҮҮРИЙН ӨРӨӨТЭЙ ЭСЭХ, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2020 ОН


Дүүрэг	Бүгд	Өрөөтэй		Өрөөгүй
		Байнгын суурилуулсан	Угсардаг /зөөврийн/	
БҮГД	100.0	58.9	0.8	40.3
Багануур	100.0	62.9	0.3	36.8
Багахангай	100.0	81.9	0.0	18.1
Баянгол	100.0	87.0	0.5	12.5
Баянзүрх	100.0	61.5	0.8	37.7
Налайх	100.0	34.0	0.5	65.5
Сонгинохайрхан	100.0	39.3	1.0	59.7
Сүхбаатар	100.0	63.5	0.6	35.9
Хан-Уул	100.0	70.4	0.7	28.9
Чингэлтэй	100.0	29.5	1.4	69.1

ЗУРАГ 12.7. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ХАТУУ ХОГ, ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАЛТЫН ХЭЛБЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



Өрхийн хатуу, хог хаягдлыг нэгдсэн бодлогоор ангилан ялгаж, тогтсон газар зайлуулах, бохир усыг нэгдсэн шугам сүлжээгээр зайлуулж, цэвэрлэх байгууламжид цэвэршүүлэх нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, хөрсний бохирдолд ихээхэн нөлөөтэй. Ялангуяа хүн ам ихээр төвлөрсөн газруудад хатуу хог, хаягдлыг дахин боловсруулах, иргэдэд хогоо ялгаж зайлуулах ухамсрыг төлөвшүүлэх зэрэг олон асуудалд энэхүү үзүүлэлтүүд тодорхой хариулт өгнө. Байшинд амьдардаг өрхийн 98.0 хувь нь үйлчилгээний байгууллагаар хог хаягдлаа зайлуулж байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 3.2 пунктээр өссөн байна. 2010 онд байшинд суудаг өрхийн 5.2 хувь нь хатуу хог хаягдлаа зайлуулах тодорхой цэггүй байсан бол 2020 онд 0.02 хувь болтлоо буурсан байна.

ЗУРАГ 12.8. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН БОХИР УС ЗАЙЛУУЛТЫН ХЭЛБЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



Байшинд амьдардаг өрхийн 61.7 хувь нь төвлөрсөн системээр, 0.9 хувь нь бие даасан системээр шингэн хог хаягдлаа зайлуулж, 37.1 хувь нь цооногт, үлдсэн 0.3 хувь нь задгай асгаж байна. Цооногт асгаж байгаа хувь өндөр байгаа нь сууцны тусдаа байшинд амьдардаг өрх байшинд амьдардаг өрхийн дийлэнхийг бүрдүүлж байгаатай холбоото



ХАВСРАЛТ



ХАВСРАЛТ А

УЛААНБААТАР ХОТ



Улаанбаатар нь Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу улсын нийслэл, хуулиар тусгайлан олгосон онцлог чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор бөгөөд тусгай статус бүхий хот юм.

Нийслэл Улаанбаатар хот хууль ёсны “Хангарди” сүлд тэмдэг, өөрийн тугтай.

Нийслэл нь мөрөвчит дугуй дүрсны төвд байрласан Богдхан уулын уламжлалт шүтээн Хангарьд бүхий сүлд тэмдэгтэй. Нийслэлийн сүлд

тэмдэг Хангарьд нь магнайдаа төрт ёс, эрдэм мэдлэгийн бэлгэдэл соёмботой, баруун гартаа түмэн олондоо үүд хаалгаа цэлгэр сайхнаар нээж өөдлөн дэвшихийн санааг илэрхийлсэн очир бариулт түлхүүртэй, зүүн гартаа энэлэн үгүй ариун тэгш оршихуйн баталгаа бадам цэцгийг нандигнан барьж, аливаа хорын үндсийг эгнэгт устган дарах санааг гишгэн зогсож буй могойгоор илэрхийлсэн байна. Хангарьд нь бат түвшин, эрэмгий байдлыг илэрхийлж нийслэл хот өргөжиж алдар нэр нь тив дэлхийд мандан бадрахын утга санааг агуулдаг.

Нийслэлийн тугийг мөнх хөх тэнгэрийн өнгөтэй, өргөн, урт нь 1:1,5-ын харьцаатай, голд нь нийслэлийн сүлд тэмдгийг цагаан торгоор дүрслэн алтлаг мөнгөн утсаар зээглэн урласан. Нийслэлийн туг нь нийслэлчүүд ариун цагаан сэтгэлээр төрт ёсоо дээдлэн, мандан бадрахын утга санааг бүхэлдээ агуулна.



ГАЗАР ЗҮЙН БАЙРШИЛ, БАЙГАЛИЙН НӨХЦӨЛ

Улаанбаатар хот Монгол орны физик газар зүйн мужлалаар Хангай, Хэнтийн уулархаг их мужийн хэсэгт, тухайлбал Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд шувтрага үзүүрт, Туул голын өргөн хөндий, ай сав цутгал голуудын бэлчирт байрладаг.

Улаанбаатар хот далайн төвшнөөс дээш 1350 метр өндөрт, Номхон далайгаас 1600 орчим км алсад, дэлхийн экватороос хойш 5310 км, хойд туйлаас урагш 4690 км зайтай буюу дэлхийн хойд өргөрөгийн 47°55', зүүн уртрагийн 106°55'-ын солбицолд, дэлхийн цагийн 7 дугаар бүсэд Лондон хотоос 7 цаг 08 минутын зөрөөтэй оршиж байна. Улаанбаатар хот урдуураа Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг, баруунаараа тус аймгийн Алтанбулаг, Аргалант, Баянцогт, Баянчандмань хойгуураа тухайн аймгийн Батсүмбэр, зүүн хойгуур, зүүн талаараа мөн аймгийн Эрдэнэ сумтай хиллэн нийт 470444 га талбай бүхий нутаг дэвсгэрийг эзэлдэг.

Нийслэлийн нутаг дэвсгэрийн хамгийн өмнө захын цэг нь Төв аймгийн Сэргэлэн сумтай хиллэж байгаа хойд өргөрөгийн 47° 37' 30", зүүн уртрагийн 107° 18' 54"-ын солбицолд, баруун

захын цэг нь Төв аймгийн Баянчандмань, Батсүмбэр сумтай хиллэж байгаа зүүн уртрагийн $107^{\circ}23'12''$, хойд өргөрөгийн $48^{\circ}16'42''$ -ын солбицолд, хойд захын цэг нь Төв аймгийн Батсүмбэр сумтай хиллэж байгаа хойд өргөрөгийн $48^{\circ}16'00''$, зүүн уртрагийн $106^{\circ}27'$ -ын солбицолд, зүүн захын цэг нь Төв аймгийн Эрдэнэ сумтай хиллэж байгаа зүүн уртрагийн $107^{\circ}37'24''$, хойд өргөрөгийн $47^{\circ}53'$ -ын солбицолд оршино.

Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайн баруун урд захад Монгол Улсын автозамын сүлжээний эхлэх 00 цэгийн тэмдэг багана оршдог.

Улаанбаатар хотын нутгийн хүйс буюу төв цэгийг дээр дурдсан захын цэгүүдээр тооцвол хойд өргөрөгийн $47^{\circ}56'45''$, зүүн уртрагийн $107^{\circ}00'18''$ -ын солбицолд буюу Шархадны хясаанаас баруун хойш 1.8 км зайтай уулын нэг оройн зүүн хажууд оршиж байна. Харин Улаанбаатар их хотын төв цэг хүйсийг Сүхбаатарын талбайд хойд өргөрөгийн $47^{\circ}55'07''$, зүүн уртрагийн $106^{\circ}55'04''$ -ын солбицолд далайн төвшнөөс 1300 метр өндөрт тавьсан Төв цэгийн тэмдгээр тооцдог.

Улаанбаатар хотын өмнүүр орших Богдхан уул нь зүүнээс баруун тийш чиглэсэн 40 орчим км үргэлжилсэн нуруу юм. Богд Хан Уулын хамгийн өндөр оргил нь далайн түвшнээс дээш 2268 метр өндөрт өргөгдсөн Цэцээ Гүн, 2256 метр өндөрт орших Түшээ гүн хэмээх оргилууд болно. Ер нь Богд Хан Ууланд 2000 метрээс дээш өргөгдсөн эртний тэгшрэлийн гадарга голлоно. Их Тэнгэрийн аманд байгаа хадны сүг зураг тэргүүтнийг үзэхэд лавтайяа аль хүрэл зэвсгийн үеэс энэ ууланд хүн суурьшиж байсан ул мөр бий.

Богд Хан Уул эртнээс бөө мөргөлийн шүтээн, тайлга тахилгын газар байсан бөгөөд 13-р зууны үед Хэрэйдийн Ван Хан Тоорил Туулын Хар шугуйд нутаглаж байхдаа Хан Ууланд ан гөрөө хийх, гал хөс түлэхийг хориглодог байжээ.

Богдхан уулыг 1778 онд дархалсан нь дэлхийн анхны дархан цаазтай уул болжээ. Манжийн хаан Тэнгэрийг тэтгэсний 43-р он буюу нийтийн тооллын 1778 онд Их Хүрээний сайд ван Юндэндорж, харьяа түшмэл Санжаадорж нарын айлтгал бичгээр Богд Хан Уулыг зарлигаар тахиж байх болсон байна. Энэ уулын хоёр ноён оргилд Цэцээ гүн, Түшээ гүн гэсэн цол олгож, жил бүр улсын сангаас цалин пүнлүү олгодог байжээ. Богд Хан Ууланд Өмнийг Тэтгэгч Цагаан Лавай Дүнжингарав гэдэг нэрийг өгч, Богд уулын бараа харагдах газар хүн цаазаар авдаггүй байсан гэдэг.

Тэнгэрийг тэтгэгч хааны зарлиг гарсны дараанаас 1779 оны шарагчин гахай жил Халх дөрвөн аймаг, шавь таваараа нийлэн тахиснаас хойш зарлигаар жилд хоёр удаа зун, намарт тахьдаг болсон гэдэг. 1921 оноос хойшхи жилүүдэд Хан Уулын тахилга тасалдсан ч 1995 онд Улаанбаатар хот үүсгэн байгуулагдсаны 365 жилийн ойгоор Цэцээ гүний оргилыг тахиж, 1995 онд Монгол Улсын ерөнхийлөгч П.Очирбат Богд Хан Уулыг тахих санаачлагыг дэмжсэн зарлиг гаржээ.

Богдхан уулыг Монголын их тахилгатай уулынх нь хувьд ЮНЕСКО “Дэлхийн гайхамшигт үнэт зүйл болох нь” зэрэглэлээр үнэлэн дэлхийн байгалийн өв гэж “Дэлхийн хүн ба шимс мандлын нөөц газрын сүлжээ”-нд 1996 онд бүртгэн авсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 2004 оноос Богдхан уулыг төрийн тахилгатай уулсын нэг болгож 5 жилд нэг удаа төрийн тахилга үйлдэх болов.

Хэнтийн нурууны голлох амьтны аймгийг бүрдүүлэгч хөхтөн амьтдын нутагшлын хамгийн урд хил нь Богд Хан Уул болно. Тарвага, зурам, зараа, мануул, булга, шилүүс, буга, бор гөрөөс, аргаль, янгир тэргүүтэн 54 зүйлийн хөхтөн амьтан бүртгэгдсэн. Жигүүртэн шувуудаас бөднө, болжмор, хараацай, хайруулдай, тогоруу, өрөвтас, харцага, шонхор, бүргэд зэрэг 194 зүйлийн шувуу бүртгэгджээ.

Ургамлын аймгийн хувьд нийт талбайн 55.8 хувийг шинэс, гацуур, хуш, нарс, хус, бут сөөгнөөс бүрдсэн ой мод эзлэнэ. Уулын оройн хэсэг, баруун, баруун хойд талын зарим газарт хушин ой зонхилох бол баруун урд ба өмнөд хэсгээр гацуурын ой, баруун урд хэсгээр нарсан ой, хойд ба зүүн хэсгээр шинэсэн ой зонхилдон тархсан байна. Энд 70 овгийн, 256 төрлийн, 587 зүйлийн ургамал ургадаг.

Улаанбаатар хотын нутгийн зүүн урд захад Налайхаас зүүн урагш Хэнтийн нурууны баруун урд захад орших 1854 метр өндөр Цогтчандмань уул нь Хойд мөсөн далайн сав, Номхон далайн сав, Төв Азийн дотоодын гадагш урсгалгүй ай савын усны хагалбар болно. Энэ нь зөвхөн Монголын төдийгүй дэлхийн усны ай сав хагалбар болж байгаа чухал газар билээ.

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэрт Цэрдийн галавын үед үүссэн нүүрсний орд газар бий. ХХ зууны эхэн үеэс эхлэн эндээс нүүрс олборлож эхэлсэн байна.

Улаанбаатар хотын дэвсгэрт Аржанчивлангийн орчимд алт, цагаан тугалганы орд бий бөгөөд гянт, алт, хайлуур жоншны илрэл, Сэлбийн голд алт, төмрийн илрэлүүд бий. Элстийн голд шилний элс, бусад газраар шаврын баялаг нэлээд бий.

Улаанбаатар хотын уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай. Өвөл нь хүйтэн, үнэмлэхүй бага температур нь -49°C хүрдэг, үнэмлэхүй их температур нь 38.6°C , үнэмлэхүй их бага температурын агууриг нь 87.6°C болдог энэ эрс тэс ялгаатай бөгөөд ийм их зөрөө дэлхийн аль ч улсын нийслэлд гардаггүй.

Жилийн дундаж температур нь -3°C , хамгийн хүйтэн 1-р сарын температур нь -26°C байх бөгөөд -30°C -аас бууж хүйтрэх өдрийн тоо жилд 40 орчим байна.

Улаанбаатарт хүйтрэлтгүй үргэлжлэх хугацаа 5-р сарын 29-ны орчмоос 9-р сарын 2 орчим хүртэл буюу 90 хоног байна. Энэ хугацаанд агаарын температур 0°C -аас доош буухгүй. Жилийн хамгийн дулаан сар нь 7-р сар бөгөөд дундаж температур нь 17°C , хамгийн халуун болсон нь 38°C хүрсэн. Зундаа 30°C -аас давж халуун болох өдрийн тоо 10 орчим, ган болох магадлал 30 орчим хувь байдаг.

Улаанбаатар хот нь дэлхийн хамгийн цэлмэг хөх тэнгэрт хотуудын нэг бөгөөд жилдээ 250-иад хоног цэлмэг байдаг. Улаанбаатар хот манай орны салхи багатай газрын тоонд орно. Жилдээ салхигүй өдөр 100 орчим байх бөгөөд салхины хурд 4-6 м/с, баруун хойд зүгийн салхи голлоно. Өвөл салхи багатай, хавар нь салхи ихтэй.

Монгол орны уур амьсгалын мужлалын хувьд авч үзвэл Улаанбаатар хот нь хуурайдуу сэрүүн зунтай, хахир өвөлтэй нутагт багтана. Улаанбаатарт жилд дунджаар 233 мм тунадас унаж, ууршилт нь 648 мм болдог. Чийгшлийн байдал 0.36 байдаг. Агаарын харьцангуй чийг 1-р сард 70 орчим хувь, 7-р сард 60 орчим хувь байдаг.

Улаанбаатар хотын нутаг нь Хойд мөсөн далайн савд багтана. Бараг бүх гол нь Туул голын ай сав гол юм. Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт Туул голын хөвөөнд нүүрсхүчлэлт магнийн исэглэн давст цацраг идэвхит бодистой гидрокарбонат кальцит рашаан бий. Гацуурт тосгонд Цагаан эрэгний, Сэлбийн дамбадаржаад, Их тэнгэрийн аманд рашаан бий. Налайх дүүргийн нутаг дэвсгэрт гидрокарбонат, каль-магнит, нүүрсхүчлийн хийтэй, радонтай Аржанчивлангийн рашаан бий. Налайхын Бүст нуурыг ардууд рашаан гэж ашигладаг.

Улаанбаатарын орчмын голуудын ус химийн найрлагын хувьд гидрокарбонатлаг ангилалд багтах бөгөөд голын сүлжээний нягтшилт $0.01-0.05 \text{ км}^3/\text{км}^2$ байна.

Ул хөрсний цэвдэг Улаанбаатарын дэвсгэрт толбо байдлаар тархсан байна. Нутгийн хойд захаар Ширэгт тайгын гүндээ цэвдэгтэй хөрс, хотын хойд захын уулсаар уулын нунтаг карбонатлаг хар хүрэн хөрс, Туул голын хөндийгөөр нугат намгийн цэвдэгт хөрстэй.

УЛААНБААТАР ХОТЫН ТҮҮХ

Монголчууд болон тэдний өвөг дээдэс оршин суусан нутаг орныхоо байгаль цаг уур, хүрээлэн буй орчноос хамааран нүүдлийн мал аж ахуйг амин зуулгын гол хэлбэр болгон эрхэлсээр ирсэн боловч тодорхой хугацаанд суурьшин сууж түүхэнд нэрээ мөнхөлсөн хот суурины дурсгалыг ч цогцлон бүтээж байжээ.

Монголчуудын байгуулсан хот сууринаас оршин тогтнож байсан богинохон хугацаандаа хол ойрд ихэд нэрд гарч, Ази, Европын олон орны улс төр, түүх, эдийн засаг, шашин соёлын амьдралд багагүй нөлөөтэй байсан нь XIII-XV зууны Монголын эзэнт гүрний анхны нийслэл Хар хорум хот юм. Хархорум хот их эзэн Чингэс хааны үед эхлэл нь тавигдаж, Өгэдэй, Гүюг, Мөнх хаадын үед цэцэглэн хөгжиж байсан бөгөөд тухайн цагтаа дэлхийн талыг эзлэн захирсан эзэнт гүрний төв нийслэл болж, өрнө дорнын харилцаанд чухал үүрэг гүйцэтгэж байсан түүхтэй.

Хар хорум хотыг Их хааны зарлигаар 1220 онд төвлөж 15 жилийн турш барьж байгуулсан бөгөөд 1235 онд Өгөөдэй хаан Монгол Улсын Нийслэл гэж зарлан зарлигдсан ажээ.

Их Монгол Улсын анхны нийслэл Хархорум хот нь Орхон голын хөндийд цогцолсон ба Юань улс нуран унасны дараа Мин улсын довтолгоонд хоёронтой (1380, 1410 он) галдан шатаагджээ. Түүнээс хойш Монголчууд нэгдмэл байдалгүй болоод нүүдлийн иргэншилд бүрэн шилжиж, хот байгуулах задалгүй дотоод, гадаадад тэмцэлдэн байлдацгааж байв.

Түүхэнд тэмдэглэсэнээр Их хүрээ нь анх Өргөө нэртэй 1639 онд үүсгэн байгуулагдсан бурхны шашны сүм хийд юм. Манж чин улсын ноёрхолын үед халхын ноёдууд Түшээт хан Гомбодоржийн хүү Занабазарыг анхны Богд Жибзундамба хутугтаар өргөмжлөн 1639 онд одоогийн Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутаг дахь Ширээт цагаан нуур гэдэг газар Өргөө цогцлоожээ. Ингэхдээ Эрдэнэ зуу хийдийн доторх мөнхийн галтай Баруун өргөөг нүүлгэн гаргаж Занабазарын өргөөтэй нэгдүүлж Ширээ цагаан нууранд аваачжээ. Баруун өргөө нь төрийн гал голомтын бэлгэдэл өргөө байжээ. Эрдэнэ зуу хийдийг анхлан Халхын Абутай сайн хаан (1534-1589) бурхны шашинд сүсэглэж 1586 онд Хархорум хотын бууринд босгосон юм. Ингэж төр, шашны гол үнэт зүйлсүүдийг нэгдүүлсэнээр нийслэл үүссэн гэж зарим түүхчид үздэг. Өргөө 1639 онд цогцолж шашны төв байсаар 1778 онд одоогийн Сэлбэ голийн эрэгт нүүдэллэн ирж хөдөлгөөнгүй суурьшин, шашин ба улс төр, худалдааны хот болон тэлсээр өнөөгийн Улаанбаатар хот буй болсон юм.

Өргөө Орхон, Тамир, Туул голуудын хөндий дагуу 29 удаа нүүдэллэсний эцэст 1778 онд одоогийн Улаанбаатар хот байгаа газар суурьшиж Их хүрээ нэртэй болжээ. 1756 онд анхны шашны сургууль болох "Цаниг" байгуулагдсан бөгөөд 1786 оноос манж амбанд Сэцэн хан, Түшээт хан хоёр аймгийг хариуцуулах болсон зэрэг олон шалтгаанаас Их хүрээ суурьших шаардлагатай болжээ. 1780-1870 оны хооронд 70 гаруй суурин сүм, дуган, ялангуяа өнөөгийн Гандантэгчлэн хийд 1809 онд баригджээ. 1861 онд Оросын консулын газар байгуулагджээ.

Анх Жибзундамба хутугтийн өргөө цогцолсон, олон сүсэгтний цугларсан нүүдлийн хүрээ байсан ба одоогийн хот цогцлоход олон түүхэн үеүүдийг туулснаар хэд хэдэн удаа нэр өөрчлөгдөж байжээ. 1639-1778 оны хооронд Өргөө, 1778-1911 оны хооронд Их Хүрээ (Хятадчилсан Да Хүрээ, эсвэл энгийнээр Хүрээ гэх мэтээр ярианы хэллэгүүд байсан) нэртэй байсан

1911 онд харь гүрний олон зуун жилийн ноёрхол эцэс болж, бидний өвөг дээдэс үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаж, Монгол төрийн гал голомт бадран гийсэн Олноо

Өргөгдсөний тэргүүн оны өвлийн сүүл сарын хоринь билэгт сайн өдөр буюу аргын 1912 оны 2 дугаар сарын 7-нд Богд хааны зарлигаар Их хүрээг “Нийслэл хүрээ” хэмээн зарласнаар Монголын ард түмний тусгаар тогтнолын илэрхийлэл, төрийн төвөөр албан ёсоор тооцогдсон түүхтэй.



Зураг 1. Нийслэл хүрээний зохион байгуулалт

Нийслэл хүрээг оршин суугчдаар үндэслэн гурван хэсэгт хуваан голчлон оршин сууж байсныг тодруулан үзэж болно. Үүнд Хүрээний монголчууд (хотын харчууд, лам нар), хятадууд, оросууд ба бусад. Нийслэл хүрээнд амьдарч байсан монголчуудын олонх нь лам нар байв.

Тэд Зүүн Хүрээ, Гандан, Дамбадаржаа, Дашчойнхорлин, Шадублин, Чойжин ламын сүм, Богд хааны өвөл, зуны орд, Гэсэрийн хоёр сүм болон хотын ойр орчмын бурхан шүтээний дагуу оршин амьдарч байв.

Хүрээний лам нарын гол хэсэг нь Зүүн хүрээ, Гандан хийдэд сууж байсан бөгөөд тэднийг 200.0 мянга орчим байсан хэмээн И.М.Майский¹ тооцоолжээ.

Зүүн Хүрээ нь Гандангаас зүүн тийш хотын зүүн талд байрлана. Зүүн хүрээнд гол төлөв эрх ямбатны сүм дуган, орд өргөө байрладаг байв. Энд нийт 14.0 мянга орчим хүн амьдарч байсан гэх тоо баримт бий.

Зүүн хүрээний гол хийдийн өмнө талд цамын том талбай, хүрээг тойрон Майдар эргэхэд зориулсан тусгай зам, хийдийн өмнө ёслолын хаалга байсны дэргэд олон тооны модон хүрд эгнүүлж, мөргөлчин сүсэгтэн олон түмэн сунаж мөргөхөд зориулсан модон тавцантай байжээ.

Гол талбайн хойно Дэчингалавын сүм, Их Цогчин дуган, баруун талд нь 1833 онд бариулсан Майдар сүм, Абтай хааны Өргөө буюу Баруун Өргөө байрлаж байв. Зүүн хүрээний баруун, зүүн жигүүрт зурхайн дацан, Жүдийн дацан, эмчийн дацан, Маналын дуган зэрэг бурхан шашны болон аж ахуйн засаг, захиргааны барилга, байгууламжууд байрлаж байв. Гандан хийдэд нийтдээ 6000 лам нар шавилан сууж байв.

¹ Пунсалдулам.Б, “Нийслэл хүрээ ба нийгмийн хөгжлийн зарим асуудал”, ШУА, Түүхийн хүрээлэн

Оросын судлаач И.Майский ХХ зууны эхэн үеийн монголчуудын нийт хүн амын тоо 647 мянга, үүний 140 мянга буюу 21.6 хувийг хотын хүн ам эзэлж буйгаас 62.0 хувийг хятадууд, 36.0 хувь монголчууд, 2.0 хувь оросууд эзэлнэ хэмээн бичжээ².

Үүнээс үзвэл монголчуудын 10 хүний нэг нь хотод оршин суудаг гэсэн тооцоог О.Пүрэв хийсэн байна.³

Дээрх хот суурин газар амьдарч буй 140.0 мянган иргэдийн 100.0 мянга буюу 71.4 хувь нь Нийслэл хүрээнд амьдарч байжээ. Харин Нийслэл хүрээнд амьдарч буй иргэдийн ихэнх нь гадаадын буюу хятад иргэд байжээ.

Нийслэл хүрээ 1919 онд Сю Шүженээр толгойлуулсан хятад цэрэгт эзлэгдсэн ба 1921 оны 2-р сард Барон Унгернээр толгойлуулсан цагаан цэргүүд хятад цэргээс Нийслэл хүрээг чөлөөлж, Богдыг дахин хаан ширээнд залсан юм. 1921 оны 3-р сард монгол цэргүүд улаан оросын цэргүүдтэй хамтран Хиагтыг, 6-р сард Нийслэл хүрээнээс цагаантнуудыг цохин дутаалгаснаас хойш нийслэл нь гадаадын цэргийн түрэмгийллээс чөлөөлөгдсөн.

Дотоод явдлын яам 1921 оны хувьсгалын дараа нийслэлийн амьдралыг удирдан зохион байгуулах үүргийг эрхэлж байжээ. Нийслэл хүрээний үндсэн барилга байгууламж гэвэл хэдхэн тооны модон дуган, мод, шавар байшин, шургааган хашаа, эсгий гэр байлаа.

Нийслэл хотын захиргаа 1923 оны 10 дугаар сард байгуулагдаж, хотын захиргааны дүрэм боловсруулах комисс томилогдож, “Монгол Улсын хотын түр захиргааны дүрэм”-ийг боловсруулж 1924 оны 3 дугаар сарын 7-нд Засгийн газрын хурлаар хэлэлцүүлэн батлуулжээ. Энэхүү дүрэм батлагдсанаар “өргөө”, “хүрээ” гэсэн нэрийг өөрчилж “хот” гэх болж, зүй тогтол, дэг жаягаараа хөгжихөд эерэгээр нөлөөлөх нэг алхам хийгдсэн байна. Уг дүрэмд хотын түр захиргаа нь хотын амьдралыг зохицуулах, хотын байдлыг сайжруулах үүрэгтэй гэж заажээ. Түүнчлэн 1924 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн Засгийн газрын хурлаар Хотын түр захиргааг бие даасан төсөв санхүүтэй болгосны зэрэгцээ Улаанбаатар хот өөрийн мэдлийн нутаг дэвсгэртэй, түүхэндээ анх удаа засаг захиргааны нэгж байгууллагатай болсон нь хотын хөгжилд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн.

Хотыг сайжруулах санал боловсруулах комиссыг 1924 онд байгуулж, уг комисс хотыг сайжруулах хэдэн чухал санал бэлтгэсэн байна. Улаанбаатар хотод оршин суугчдыг 1925 он хүртэл хотын иргэд гэж тооцох журам байсангүй. Харин уул нутаг хошуу аймагтаа хамаарах заншилтай байжээ.

Бүгд найрамдах засаг тогтоон явуулсан 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Анхдугаар Үндсэн хууль баталсны дараахан “Нийслэл хүрээ”-г Улаанбаатар хот хэмээн нэрлэсэн билээ.

Эндээс хуулийн ёсоор “Улаанбаатар” гэсэн шинэ нэртэй, дахин сэргээсэн “нийслэл” гэх статустай Монгол Улсын нийслэлийн шинэхэн түүх эхэлсэн юм.

Хотын захиргаа 1925 оноос хотын доторх бүх хашаа байшингийн зургийг гаргуулж, тэдгээрийн хэмжээнээс нь хамааруулан ялгавартай байдлаар татвар авах санал бэлтгэсэн байна. Энэ үеэс хотын оршин суугчдыг “харьяат” болон “түр” гэж ангилан бүртгэж, хотын хур хогийг арилгах, гудамж талбайг цэгцтэй болгох, өнгө үзэмжийг сайжруулах, хотын нутаг дэвсгэрийг тодорхойлон батлуулах ажлыг зохион байгуулжээ.

Улсын хоёрдугаар их хурал 1925 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр “Улаанбаатар хотын захиргааны газрын дагаж мөрдөх дүрэм”-ийг 49 зүйлтэйгээр баталж, хотын захиргаа нь

² Майский.И, “Орчин үеийн Монгол”, 127 дугаар тал

³ Пүрэв.О, Монгол улсын түүхэн газар зүй, УБ, 2004, 64 дүгээр тал

хотын хурал, түүнээс байгуулагдсан хотын захиргааны хэрэг эрхлэх газар, түүнд захирагдах газруудаас бүрдэнэ гээд хотын хурлын гүйцэтгэх үүргийг нарийвчлан тодорхойлсны дотор "... хотын зураг зохиох, өөрчлөх ..., хот сайжруулах арга хэмжээг Засгийн газарт мэдүүлэх ..." гэж тусган хэрэгжүүлж байжээ. Мөн Засгийн газар "хотын төв дундаас эргэн тойрон найман зүгт цөм 15 газраар хэмжээ болгон" хотын нутаг дэвсгэрийг тогтоож өгснөөр Улаанбаатар нь өөрийн мэдлийн нутаг дэвсгэртэй болов.

Улаанбаатар хот улсын засаг захиргааны нэгж болсноос эхлэн хотын харьяат иргэний асуудал гарч ирсэн байна. Хот байгуулалтын хувьд энэ үед хэрэгжүүлсэн нэг чухал арга хэмжээ нь хотын жинхэнэ харьяат нарыг бүртгэх ажлыг эхлүүлсний зэрэгцээ бүх хашаа, байшинг тоолж, дугаартай болгосон явдал байлаа.

Хотод 1925 оны байдлаар монголчуудын хашаа 2368 (Гандан, Хүрээ, Богд хааны ордны хашаа ороогүй), Орос, Хятад, Төвд, Англи, Америк зэрэг гадаад улсын харьяат нарын хашаа 1019 тоологдсон байна.

Энэ үед Улаанбаатар хот ихэвчлэн мод, шавар байшин, эсгий гэрээс бүрдэж байлаа. Бүрэн бус мэдээгээр 1927 онд Улаанбаатар хотын жинхэнэ харьяат гэсэн үнэмлэхтэй өрх 510, хүн ам 1497, түр захирагдан суугч өрх 4321, хүн ам нь 11533 байжээ. Тухайн үеийн хотын хүн амын тоо мэдээ БНМАУ-ын Их хурлуудын материалд байхаас 1925 оны 11 дүгээр сарын 6-20-нд хуралдсан Улсын хоёрдугаар их хуралд Улаанбаатар хотын захиргааны төлөөлөгч М.Баярын тавьсан илтгэлд "... хотын доторх бүгд гадаад, дотоодын хүмүүсийн амын тоо 61 мянга байсан гэж дурджээ.

1910-1920-иод оны сүүл хүртэл 20 гаруй улсын иргэд сууж байсан бол БНМАУ-ын Засгийн газраас гадаад худалдааны онц эрх тогтоосон үеэс хорогдон цөөрч, нутгийн орос, хятад иргэд голдуу үлдсэн байна.

1930-аад он хүртэл Монгол Улсын төрөөс өрнө, дорнын олон улстай улс төр, худалдаа эдийн засаг, соёл, боловсролын өргөн харилцаа тогтоохыг эрмэлзсэн, бие даасан, чигч гадаад бодлогыг зоримгоор хэрэгжүүлж, үүний үр дүнд Улаанбаатар хотноо Европ, Америк, Азийн орнуудын хөрөнгө оруулалттай олон пүүс ажиллаж, гадаад иргэд олноор суурьшин хотын соёлын бие даасан шинэ өнгө төрх бүрэлдэж байв. Гэвч тухайн үеийн олон улсын байдал, БНМАУ дахь улс төрийн дотоод байдлаас шалтгаалан энэ байдал удаан үргэлжлээгүй.

Мөн Зөвлөлтийн мэргэжилтэн, сургагч зэрэг хүмүүс янз бүрийн хугацаагаар нэлээд амьдарч байсан бөгөөд 1950-иад онд хятад барилгачид орж иржээ. Улмаар 1960-аад онд Зөвлөлт-Хятадын харилцаа муудсанаар тэдний ихэнх нь нутаг буцаж, 1960-аад оны дунд үеэс социалист орнуудын мэргэжилтэн, ажилтнууд, нэн ялангуяа Зөвлөлт Холбоот Улсын иргэд олноор ажиллах болсон. Харин 1990-ээд оноос хойш манай улсын нийслэлд өрнө, дорнын олон орны иргэд бүрмөсөн болон түр хугацаагаар оршин сууж байна.

ЗАСАГ ЗАХИРГАА

Улаанбаатар нь Монгол Улсын Нийслэл хот бөгөөд засаг захиргааны хуваариар аль нэгэн аймагт харьяалагдахгүй тусгай нэгж юм. Нийслэл хот нь Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул, Налайх, Багануур, Багахангай гэсэн 9 дүүрэгт хуваагддаг. Дүүрэг бүр нь хороодод хуваагдана.

Нийслэл Улаанбаатар хот нь 2020 оны байдлаар засаг захиргааны хувьд 9 дүүрэг, нийт 169 хороогоор дамжуулан үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хотын захиргааг анх 1925 онд байгуулсан бөгөөд 1992 онд баталсан Монгол Улсын шинэ Үндсэн хуулиар нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах

болж, энэ үеэс эхлэн Улаанбаатар хотын удирдлага нь Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчид, Засаг дарга, Улаанбаатар хотын Захирагчаас бүрэлдэн тогтов.

Нийслэл хотыг 4 жил тутамд хотынхоо нийт иргэдээс сонгогддог Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал удирдах бөгөөд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хотын даргын нэрийг дэвшүүлж Монгол Улсын Ерөнхий сайдад өргөн барьснаар Ерөнхий сайд бүрэн эрхийн хүрээнд хотын даргыг 4 жилийн хугацаатайгаар томилдог. Хотын дарга нь Улаанбаатар хотын нийт газар нутагт Монгол улсын хуулийг хэрэгжүүлж Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаа ажлаа тайлагнадаг.

Нийслэл хотын захиргаа нь хотын нутаг дэвсгэрт төр засгийн тогтоол, шийдвэр хууль дүрмийг мөрдүүлэх, хотыг хөгжүүлэх зураг төлөвлөгөө гаргах, хотын гудамж талбай, зам, гүүр, цэцэрлэг, хамгаалалт барих, тохижуулах, хотыг гэрэл, ус, хоол хүнсээр хангах, худалдаа, зах зээлийн асуудлыг ард олны эрх ашигт нийцүүлж зохион байгуулах, ард олны амгалан тайван байдлыг хангах, соёлжих гэгээрэх, эрүүл мэндийг хамгаалах ажлыг үүсгэн зохион байгуулах зэрэг чухал арга хэмжээг авч хэрэгжүүлэх салбар чиглэлийн ажил үүрэг хариуцсан байгууллагуудыг байрлуулж өөрийн харьяанд ажиллуулж ирсэн.

Эдүгээ хүртэл Улаанбаатар хотын даргаар нийт 32 хүн ажиллаж байжээ.

Улаанбаатар хот 1923 онд засаг захиргааны хувьд 27 хороодтой байж, эдгээр хороодын харьяат оршин суугчдын хурлаас 45 хүнийг Нийслэл хотын цаг зуурын хурлын гишүүдэд сонгожээ. Нийслэл хотын цаг зуурын хурлаас хотын түр захиргааг дарга 1, гишүүн 3, нарийн бичгийн дарга 1, жинхэнэ бичээч 2, морьтой зарлага 2, ажилчид 11 бүгд 20 орон тоотой, дөрвөн хэлтэстэй байхаар 1924 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр ёсоор болгон баталжээ. Хотын түр захиргааны даргаар М.Баярыг сонгон баталсан байна.

Нийслэл хотын анхны захиргаа 1923 оны 10 дугаар сард байгуулагдсанаас хойш нэр нь өнөөг хүртэл дараах байдлаар өөрчлөгджээ.

УЛААНБААТАР ХОТЫН ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭР

1924 он Нийслэл хотын түр захиргаа

1925 он Улаанбаатар хотын захиргааны хэрэг эрхлэх газар

1932 он Улаанбаатар хотын аймгийн захиргаа

1933 он Улаанбаатар хотын захиргаа

1938 он Улаанбаатар хотын захирах яам

1941 он Улаанбаатар хотын захиргаа

1948 он Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн бага хурал

1953 он Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн ардын хурлын гүйцэтгэх захиргаа

1961 он Улаанбаатар хотын Ардын депутатуудын хурлын Гүйцэтгэх захиргаа

1992 он Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

Хороодын тоог 1924 оны 5 дугаар сард цөөтгөж 13 хороо, 1925 онд 15 хороо, 1926 онд 9 хороо, 1928 онд хороодын тоог дахин цөөрүүлж 6 хороотой байхаар зохион байгуулжээ.

Улаанбаатар хотын хурлын төлөөлөгчдийн тавдугаар их хурал 1928 оны 10 дугаар сард хуралдаж, хотын захиргааны илтгэлийг авч хэлэлцжээ. Энэ хуралд хороо тус бүр хийсэн ажлаа тайлагнаж, илтгэл тавьсан байна. Эдгээр илтгэлд хотын хүн ам, өрхийн талаар дурдсныг сонирхуулъя. Үүнд: 1-р хороонд хотын жинхэнэ харьяат өрх 181, хүн ам 664, 2-р хороонд хотын жинхэнэ харьяат өрх 31, хүн ам 74, түр захирагсад 472, 3-р хороонд нийт өрх 1646, хүн ам 3111, үүнээс жинхэнэ харьяат өрх 445, 4-р хороонд хотын жинхэнэ харьяат болсон ба болохыг хүсч

өргөдөл гаргасан нийт 87 өрх, 5-р хороонд хотын жинхэнэ харьяат өрх 198, түр захирагдагсад өрх 901, хүн ам нь 2544, 6-р хороо буюу одоогийн Амгаланбаатар хотын бүр өрх 556, үүнээс түр захирагдах өрх 29 байжээ.

Хотын төв хэсгийг шинэчлэн байгуулах анхны зураг төлөвлөгөөг 1930-аад оны сүүлчээр гаргаж, зарим хуучин хашаа байшинг буулган чөлөөлж, дан, давхар барилга барих, гудамж талбайг засварлах, цардмал зам тавих зэрэг ажлууд хийгдэж эхэлсэн байна. 1935 онд Сайд нарын Зөвлөл Хотын захиргааны 1934 оны тайланг хэлэлцээд хотын доторх барилга, засварын ажлын явц удаан, чанар муу, хэтийн бодлого, төлөвлөгөөгүй байсныг зааж, үүнийг засч залруулахын тулд хот байгуулалтын хөдөлшгүй төлөвлөгөө маш чухал гэсэн дүгнэлт хийжээ.

Сайд нарын зөвлөлөөс 1936 онд дээрх асуудлаар 1937 оноос Улаанбаатар хотод баригдах барилгын зураг төлөвлөгөөг Худалдаа үйлдвэрийн яамны инженерийн ангиар гүйцэтгүүлэх, үүний тулд хотыг цаашид шинээр сайжруулах төлөвлөгөөг зохиох, Зүүн Сэлбийн усны урсацыг ихэтгэх, үерийн аюулаас сэргийлэх төлөвлөгөө зураг гаргах, байгууллага, оршин суугчдын байршлыг зохистой тодорхойлох, барилга гүүрний архитектурыг болон гудамж, замыг төлөвлөх, орон сууцны барилга барих зэрэг 12 асуудалд анхаарахыг даалгасан байна. Хотыг зураг төлөвлөгөөний дагуу хөгжүүлэх үзэл санаа ийнхүү 1930-аад оны сүүлч үеэс түгэн дэлгэрч, хэсэгчилсэн хэлбэртэй төлөвлөгөө зохиох анхны оролдлого хийгдсэн нь хот төлөвлөлт, хот байгуулалтад гарсан шинэ хандлага байлаа.

Дэлхийн II дайны дараа БНМАУ энх цагийн бүтээн байгуулалтад эрчимтэй шилжиж, 1946 онд Улаанбаатар хотын төвийн хэсгийг шинэчлэн байгуулах урьдчилсан ерөнхий төлөвлөгөө Сайд нарын Зөвлөлийн 47 дугаар хуралдаанаар батлагдаж, улмаар 1954 оноос ЗХУ-ын дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотын Анхдугаар төлөвлөлтийг хийсэн нь Нийслэлийн хот байгуулалт, төлөвлөлтийн түүхэнд шинэ үе эхлүүлсэн.

Улаанбаатар хот хөгжлийнхөө явцад боловсруулсан ерөнхий төлөвлөгөөг авч үзье.

Хотын хөгжлийн анхны ерөнхий төлөвлөгөөг 1954 онд боловсруулж батлуулжээ. Энэ үед хотын төв хэсгээр хүртэл гэр хороололтой байсан үе. Хотын анхны ерөнхий төлөвлөгөөний хэрэгжих хугацааг 20 жилээр тооцож, хүн ам нь 1954-1974 оны хооронд 125 мянга хүрэхээр тооцоолсон байна.

Энэхүү төлөвлөгөө нь хотыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулалт, эмх цэгцтэй байгуулах боломжийг бүрдүүлж өгчээ. Энэ хугацаанд хотын төв хэсэг Бага тойруу, Их тойруугийн зарим хэсэг баригджээ. Гэвч 1960 онд хотын хүн ам 180 мянгад хүрсэн тул ерөнхий төлөвлөгөөг дахиж шинэчлэхээс өөр аргагүйд хүрсэн юм.

Хоёр дахь ерөнхий төлөвлөгөө нь 1961 онд батлагдсан бөгөөд хугацаа нь 20-25 жилээр, хүн ам 230-250 мянга байхаар тооцсон. Энэ ерөнхий төлөвлөгөө нь өмнөх төлөвлөгөөний алдааг залруулан шинэчлэх зорилготой байсан. Энэхүү баримт бичгийг үндэслэн Туул голын хөндий дагуу барилгажуулж эхэлсэн ба орон сууцны хэд хэдэн хорооллыг үйлчилгээ, олон нийтийн барилга байгууламжтай иж бүрнээр нь барьсан бөгөөд орон сууцны фонд 70 гаруй хувиар нэмэгдсэн байна. 1975 он гэхэд хотын хүн ам 300 мянгад хүрч гурав дахь ерөнхий төлөвлөгөөг боловсруулах шаардлага гарчээ.

Улаанбаатар хотыг хөгжүүлэх 2 дахь ерөнхий төлөвлөгөө буюу 1961-1975 онд III цахилгаан станц, Авто засварын завод, Архи пиво, Хивс, Биокомбинат, Мах консервийн комбинат, Оёдлын үйлдвэрүүд, Улсын клиникийн 1-р эмнэлэг, Улсын цирк, телевизийн төв, орон сууцны 5, 12, 15, 19-р хорооллууд зэрэг соёл ахуйн үйлчилгээний иж бүрэн барилга байгууламжуудыг ашиглалтад оруулжээ. Ингэснээр хотын түлш, эрчим хүч, дулаан, цахилгаан, усан хангамж, радио телефон, шугам сүлжээ зэрэг инженерийн барилга байгууламж, зам гүүр, гэрлэн

чимэглэл, цэцэрлэгт хүрээлэнг өргөтгөн хөгжүүлэх хэтийн шинэ, шинэ төлөвлөгөөнүүд ээлж дараалан батлагдан хэрэгжсэн байна.

Гурав дахь ерөнхий төлөвлөгөөг 1975 онд боловсруулж батлуулсан бөгөөд хүн амыг 2000 онд 400 мянга байхаар тооцоолж цаашид хотын хүн амын механик өсөлтийг хязгаарлах хандлагатай төлөвлөжээ.

Хотыг тойрон байгаа суурьшлуудыг дагуул хотын хэмжээнд хүргэх замаар хот руу чиглэсэн хүн амын урсгалыг сааруулах нь тухайн ерөнхий төлөвлөгөөний шийдвэрлэх зорилтуудын нэг байсан. Гурав дахь ерөнхий төлөвлөгөө хэрэгжих хугацаанд хүн амыг тухайн үеийнхээсээ 50-80 мянгаар нэмэгдэнэ гэсэн тооцоотой байсан боловч нийслэлийн хүн ам 500 мянга буюу 2 дахин өссөн юм.

Энэ төлөвлөгөө нь хотыг үндсэн 3 том дүүрэг, орон сууцны 21 хороололд хуваажээ. Ерөнхий төлөвлөгөөний дагуу 3 дугаар цахилгаан станцыг шинээр барьсаны үр дүнд олон арван орон сууц, соёл, ахуйн үйлчилгээний барилгууд баригдаж, хүн амын 50 орчим хувь нь орон сууцанд амьдрах болсон байна. Энэ төлөвлөгөөгөөр орон нутгаас шилжин ирэгчдэд хязгаарлалт тавихаар төлөвлөж байсан боловч хүн ам тооцоолсноос хэд дахин өссөн учир гурав дахь ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх шаардлагыг дахин бий болгосон юм.

Орон сууцны III. IV. VI. X. XIII хорооллуудыг 1976 оноос хойш соёл ахуйн үйлчилгээний барилга байгууламжийн хамт иж бүрнээр, IV станц, Барилга Угсралтын контор, Гутал, Ээрмэл, Тэмээ, ямааны ноолуурын үйлдвэр, нийт 40 гаруй сургууль цэцэрлэг, бусад олон барилга байгууламжийг барьжээ.

Их барилгад 1953-1980 оны хооронд нэг тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, 1, 2 дугаар 40, 50 мянгатын орон сууцны хороолол, Засгийн газрын ордны өргөтгөл, Улаанбаатар зочид буудал, Төв цэнгэлдэх хүрээлэн, Улсын их дэлгүүр, Гурилын комбинат, 1, 2 дугаар цахилгаан станц, чихэр боовны үйлдвэр, олон сургууль, цэцэрлэг, яслийг барьжээ.

Дөрөв дэх ерөнхий төлөвлөгөөг хотын хүн ам 1986 онд 500 мянгад хүрч хөгжлийн явцад гурав дахь ерөнхий төлөвлөгөөний зарим үзүүлэлтүүд өөрчлөгдсөн учир боловсруулсан байна. Энэ төлөвлөгөө нь 2010 он хүртэл байхаар тооцжээ. Үүнийг 1986 онд боловсруулсан бөгөөд гол зорилго нь Улаанбаатар хотын хүн амын бөөгнөрлийг сааруулж хот орчмын суурин газруудад шилжүүлэн бүлэг суурьшлын системээр хөгжүүлэх асуудал байсан юм.

Дөрөв дэх ерөнхий төлөвлөгөөний орон сууцны 21 хорооллыг 30 болгон нэмэгдүүлж, хотын бүтцийг суурьшлын 6 том бүс, үйлдвэрийн 8 хэсэг бүсэд хуваан, цэнгэлдэх хүрээлэнг хотын төвийн урд хэсэгт төлөвлөсөн байна.

Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Тав дахь ерөнхий төлөвлөгөө нь хотын архитектур, орон зайн зохиомжийг “Хот байгуулалтын нээлттэй систем”-д үндэслэн, дэлхийн томоохон хотууд түвшинд хүргэх хэтийн төлөвийг тодорхойлсон болно. Хотын хүн амын суурьшлын хөгжингүй системийг бүрдүүлж, инженерийн хангамж, дэд бүтцийг оновчтой шийдвэрлэж, хотын нутаг дэвсгэрийг зохион байгуулалтын Төвийн, Зүүн, Баруун, Шинэ гэсэн үндсэн 4 бүсэд хувааж, харилцан уялдаатайгаар төлөвлөлтийн дагуу бие даан хөгжих боломжийг нээж өгсөн. Дээрх бүсүүдэд байрлаж буй гэр хорооллыг нийтийн болон амины орон сууцны хороолол болгон, инженерийн иж бүрэн хангамжтайгаар хөгжүүлэх зорилтыг ерөнхий төлөвлөгөөнд дэвшүүлж, ахуйн ба нийтийн үйлчилгээний иж бүрэн цогц төвийг тухайн гэр хороолол бүрт төлөвлөснөөс гадна Улаанбаатар хотын барилгажсан хэсгийн нягтралыг нэмэгдүүлэх замаар инженерийн шугам сүлжээний ашиглалтыг сайжруулж хотыг цаашид тэлж хөгжих нөөц талбайг тогтоосон нь шинэ ерөнхий төлөвлөгөөний нэг онцлог болсон.

Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хүн амын шилжих хөдөлгөөн эрчимтэй нэмэгдэн хотод замбараагүй суурьшил, тэлэлт бий болж эдийн засаг, газрын харилцаанд өөрчлөлт гарч, хот байгуулалтын үйл ажиллагаанд шинэ нөхцөл байдал үүссэн зэргээс шалтгаалан ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болж “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичгийг боловсруулж Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлуулж Нийслэлийн хэмжээнд мөрдөн ажиллаж байна.

“Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичигт нийслэлийн хүн амын тоог 1650 мянга, үүнээс Улаанбаатар хотод 1150 мянга байх, Улаанбаатар хотыг 15 дагуул, хаяа хот тосгодтой эдгээр нь тус тусын чиг үүргийн дагуу хөгжихөөр тусгасан байна.

Улаанбаатар хотод хотын чанартай 2 шинэ, 6 дэд нийт 8 төвүүдийг шинээр бий болгон төвлөрлийг сааруулах, гэр хороололд онцгой анхаарал хандуулан төвийн, дундын, захын гэсэн хэсэгт хуваан дахин төлөвлөн барилгажуулах, газар шинэчлэн зохион байгуулах замаар хөгжүүлэхээр тооцсон байна. Мөн ашиглалтын шаардлага хангахгүй болсон барилгуудыг буулган шинэчлэн барилгажуулах Улаанбаатар хотын суурьшлын 35 мянган га газрыг 47 нэгж хороолол болгон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулан хөгжүүлэхээр тусган хэрэгжүүлж байна.

Дээрх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хугацаа дуусаж байгаатай холбогдуулан холбогдох хууль тогтоомжид заасны дагуу дараагийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө буюу Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах шаардлага бий болсон.

Одоогоор бид Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажил болох суурь судалгаа, төлөвлөлтийн үндсэн концепц боловсруулах ажилд салбарын эрдэмтэн судлаачид, төрийн байгууллагаас санал авч холбогдох мэргэжлийн зөвлөлийн хурлуудаар хэлэлцүүлэн батлуулах ажил хийгдэж байна.

ХАВСРАЛТ Б

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМЫН ТООЛЛОГЫН ТҮҮХЭЭС

Монголчуудын хувьд эрт дээр үеэс хүн амын тооллого явуулж ирсэн боловч түүхийн урт хугацаанд тооллогын талаарх ойлголт тодорхойлолт өөрчлөгдөн хөгжсөөр ирсэн билээ.

Монгол Улс XX зуунд 9 удаа, XXI зуун гарсаар 2020 онд хоёр дахь тооллогоо хийж, нийт 11 удаа хүн амын тооллого явуулсан. 1969 оноос өмнөх тооллогууд нь тодорхой давтамжгүй явагдаж байжээ. Монгол Улс 1961 онд НҮБ-д, 1962 онд Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөл (ЭЗХТЗ)-ийн гишүүн болж, хүн амын тооллогыг НҮБ-ын зарчим зөвлөмжийн дагуу 10 жил тутамд явуулдаг болсон.

Хүн амын 1918 оны тооллого нь зөвхөн халхын 4 аймгийг бүхэлд нь хамарч, Хөвсгөл хавийн Богдын шавь, Ховдын хязгаарын хүн амын тоог тооцоолон оруулсан боловч тухайн үедээ хамгийн магадлал сайтай гаргасан анхны арга хэмжээ байснаараа түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн юм.

Монгол Улсын хүн амын үе үеийн тооллогын онцлогийн талаар товч авч үзье. Энд нэг зүйлийг тэмдэглэн хэлэхэд Монгол Улсын хүн амын тооллогын нэг онцлог бол эрт үеэс хүн ам, малыг хамтад нь тоолж ирсэн түүхэн уламжлалтай. Харин хүн амын 1944 оны тооллогоос эхлэн хүн амыг дангаар нь, 1969 оноос хүн ам, орон сууцны тооллого явуулж ирсэн байна.

Монгол Улсын хүн ам, хөрөнгө, малын 1935 оны бүртгэл (тооллого) нь хүн нэг бүрийн, өрх гэр бүл, хүн ам зүйн болон эдийн засаг, нийгмийн талаарх мэдээллийг улсын хэмжээгээр болон тодорхой нутаг дэвсгэр, хот суурингаар нь гаргаж, судалж болохуйц тооллогын ерөнхий зарчимд тулгуурласан анхны тооллого байв.

Монгол Улсын хүн амын 1944 оны тооллого нь тус улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн ихээхэн онцлогтой үед явагдсан. Монголын нийгэм нийтээр хоморголон хэлмэгдүүлэлт, Халх голын дайн зэрэг улс орны хувьд тун бэрхшээлтэй үед явагдсан. Хүн амын 1944 оны тооллогоос өмнөх хүн ам, хөрөнгө, малын бүртгэлийн хөтөлбөрөөс энэ удаагийн тооллогын ялгаатай нь хүн амаа дангаар нь тоолсноороо ихээхэн онцлогтой юм. Хүн амын 1944 оны тооллогын бас нэг онцлог нь өмнө нь бүртгэл тооллогод ордоггүй байсан цэрэг, хоригдол, гадаадын харьяат нарыг тоолсон явдал байлаа.

Монгол Улсын хүн амын тооллогод холбогдох түүхэн баримтуудыг судалж байхад хүн амын тооллого гэж нэрлээгүй боловч бүх нийтээр нь бүртгэж тоолсон 1947, 1950 онуудад 2 удаа хүн амын тооллоготой дүйцэхүйц чухал бүртгэл явуулсан байдаг.

Монгол Улсын хүн амын 1956 оны тооллого явагдах үед тус улс эх орны болон чөлөөлөх дайны хор уршгийг арилгаж, улмаар нийгэм, эдийн засгаа энх тайван замаар хөгжүүлэх талаар нэлээд амжилт олж, анхдугаар таван жилийн төлөвлөгөөт зорилтуудыг хэрэгжүүлж, улмаар 2-р таван жилийн төлөвлөгөөт зорилтуудыг хэрэгжүүлж дуусах шатандаа орж, дараагийн гурван жилийн төлөвлөгөөг боловсруулах үед болжээ. Хүн амын 1956 оны тооллогоор Монгол Улсын түүхэнд анх удаа тооллогын товыг цаг, минутаар тогтооноороо онцлогтой. Мөн уг тооллогод өмнөх хүн амын тооллого, бүртгэлээс зохион байгуулалтын хувьд нэлээд онцлогтой, аймаг, сум, багт “тооллогын улсын товчоо”-г байгуулж, тэдгээрийн гүйцэтгэх үүргийг тооллогын зааварт тодорхой тусгаж өгсөн нь өмнөх тооллогуудаас илүү давуу талтай. Монгол Улсын хүн амын тооллогын түүхэнд тэмдэглүүштэй нэг асуудал нь тус улсын аймаг, нийслэлээс ганцхан Улаанбаатар хот 1957 онд хүн амаа тоолсон байдаг.

Монгол Улсын хүн амын 1963 оны тооллого нь улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх хэтийн төлөвлөлтөд ашиглах талаар анх удаа төр засгийн шийдвэрт үндэслэн хийгдсэнээрээ онцлогтой. Тооллогын хөтөлбөрийн хувьд орчин үеийн олон улсын тооллогын хөтөлбөртэй бүрэн нийцсэнээс гадна тооллогын хөтөлбөр, үүний тооллогод хамрагдах хүн амын бүртгэл, тооллогын газрын зураглалыг анх хэрэглэсэн, мөн хяналтын тооллого явуулсан. Энэ утгаараа олон улсын хүн амын тооллогын талаарх үзүүлэлт, аргачлалд нийцсэн, өөрийн орны онцлогийг тусгасан анхны тооллого гэж үзэх бүрэн үндэстэй.

Монгол Улсын хүн ам, орон сууцны 1969 оны тооллого явагдах үед тус улсын нийгэм, эдийн засгийн хөгжил өмнөх үеүдээс хурдацтай хөгжиж байсны дотор хүн амын эрүүл мэндийг сайжруулах талаар томоохон амжилтуудыг олж, улмаар хүн амын төрөлт нэмэгдэн, нас баралт буурч, хүн ам зүйн тааламжтай үе тохиож байсан. Хүн ам, орон сууцны 1969 оны тооллогын хөтөлбөрийн хувьд нэлээд онцлогтой тооллого болсон гэж үзэх үндэстэй. Энэ нь Монгол Улс социалист орнуудын хамтын ажиллагааны байгууллага болох Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөл (ЭЗХТЗ), түүний бүтцийн Статистикийн салбарт хамтран ажиллах байнгын комиссын гишүүн болсонтой холбоотойгоор “Хүн ам, орон сууцны тооллогын үзүүлэлт аргачлал” -ыг НҮБ-ынхтай нийцүүлэн баталж, мөрдүүлсэн анхны тооллого юм. Энэхүү тооллогоор анх удаа орон сууцны холбогдох асуултууд цоо шинээр нэмж оруулснаараа ихээхэн онцлогтой.

Хүн ам, орон сууцны 1979 оны тооллого явагдах үед тус улс нийгэм, эдийн засгийн хөгжил үүний дотор эрүүл мэндийг сайжруулах талаар олсон ололт амжилтын үр дүнд хүн амын өсөлт тус улсын түүхэнд хамгийн өндөр түвшинд хүрсэн үед явагдсан байна. Хүн ам, орон сууцны 1979 оны тооллогын хөтөлбөр нь өмнөх тооллогын хуудасны асуултыг үндсэнд нь оруулсан боловч тооллогын хуудасны зохиомжийн хувьд өмнөх тооллогуудаас нэлээд ялгаатай, тухайн үедээ ихээхэн дэвшилттэй, хүн бүрийг тооллогын нэг хуудсанд бүртгэхээр зохиогдохын хамтад өрхийн тэргүүлэгчийн тооллогын хуудсанд орон сууцны асуултуудыг оруулж өгснөөрөө нэг өрхөд олон цөөн хүн тоологдох, нийтийн байр, цэргийн хүрээний нэг өрөөнд хэдэн хүн байхаас хамаарч тооллогын төрөл бүрийн үргэлжлэл хуудас хэрэглэх, түүнтэй холбогдсон заавар аргачлал гаргахгүй байх, тооллогын урьчилсан дүн гарахад давуу талтай болжээ. Энэ тооллогын дүнг анх удаа тооцоолох электрон машинаар боловсруулсан.

Хүн ам, орон сууцны 1989 оны тооллого явагдах үед төрөөс хүн амын ажил эрхлэлт, нийгмийн асуудалд нэлээд анхаарч байсны дотор хүн ам зүйн хөгжилд анхаарах хандлага улам нэмэгдэж байсан түүхэн чухал үе байсан юм. Үүнтэй уялдуулан тооллоготой хамт “Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай, ажилгүй иргэдийн судалгаа”, “Төрөх насны (15-49) эмэгтэйчүүдийн судалгаа”-г анх удаа явуулсан.

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллого нь тус улсын түүхийн нэлээд өвөрмөц онцлогтой үед болж өнгөрсөн. Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцаанаас зах зээлийн харилцаанд шилжиж, улс орны нийгэм, эдийн засгийн байдал богино хугацаанд хурдан өөрчлөгдсөн үе байлаа. Хүн ам, орон сууцны тооллогыг олон улсын стандарт зөвлөмжийн дагуу 1999 онд явуулах байсан боловч тухайн үеийн төр засгийн бодлого, хөрөнгө санхүүгийн байдлаас шалтгаалан 11 жилийн дараа тооллого явуулах талаар Улсын Их Хурал, Засгийн газрын холбогдох шийдвэрүүд гарсан. Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын хөтөлбөр өмнөх тооллогын үеийнхээс нэлээд олон зүйлүүдээр ялгаатай байлаа. Үүнд: нэгд, тооллогын үзүүлэлт, аргачлал, ойлголтуудыг НҮБ-ын зарчим, зөвлөмжийг удирдлага болгосон тул олон улсын жишигт нийцсэн арга зүйгээр хийгдсэн, хоёрт, хүн амын таван жилийн болон нэг жилийн шилжих хөдөлгөөний талаар анх удаа мэдээлэл цуглуулсан, гуравт, хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн түүвэр судалгаагаар төрөлт, нялхас, хүүхдийн нас баралтын талаар мэдээлэл цуглуулсан учир ээлжит тооллогын асуулгад энэ талаарх мэдээллийн асуултыг оруулаагүй, дөрөвт, Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжиж байгаатай холбогдуулан ажил эрхлэлтийн

байдлыг тодорхойлох аргачлалыг олон улсынхтай нийцүүлснээрээ онцлогтой. Тооллогын материалыг анх удаа тооцоолох “персонал компьютер”-ээр боловсруулсан юм. Тооллогын дүнг олон нийтэд тархаах талаар өмнөх тооллогуудад байгаагүй ихээхэн өргөн хүрээтэй, үр дүнтэй ажил зохион байгуулсан.

Монгол Улсын хүн ам, орон сууцны 2010 оноос өмнөх бүх тооллогыг “Хүн амын тооллого явуулах тухай” Засгийн газрын шийдвэрээр зохицуулагдаж байсан. Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого нь өмнөх тооллогоос ялгагдах гол онцлог нь тус улсын түүхэнд анх удаа хуулийн хүрээнд явагдсанд оршино. Улсын Их Хурал 2008 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийг баталсан. Энэ бол түүхэн чухал шийдвэр байлаа. Энэхүү хуулиар тооллого явуулах эрх зүйн болоод эдийн засгийн баталгааг хангах, тооллого явуулах хугацаа, арга, зохион байгуулах байгууллага, институт, төрийн байгууллага, засаг захиргааны нэгжийн удирдлага болон хувь хүний тооллогод оролцох үүрэгтэй холбоотой эрх зүйн харилцааг зохицуулсан юм. Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын өмнөх тооллогуудад байгаагүй нэг онцлог үйл ажиллагаа бол НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр тооллого явуулах арга, аргачлал, удирдлага, зохион байгуулалт, үе шат, төсвийн асуудлыг цогцоор нь тусгасан мастер төлөвлөгөө боловсруулсан. Мөн Монгол Улсын харьяат иргэдийн мэдээллийг цуглуулах программ хангамж, техник, нууцлалын асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэж, иргэдээ интернэтээр тоолсон нь энэ удаагийн тооллогын бас нэг онцлог байлаа. Түүнчлэн хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын үед дэлхийн олон улс орон газар зүйн мэдээллийн системийг тооллогын төлөвлөлт, тоолох ажиллагаа, үр дүнг тархаахад түгээмэл ашиглаж, тооллогын үр дүнгийн хэрэглээг нэмэгдүүлэх, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, судалгааны байгууллага, судлаачид болон олон нийтэд мэдээллийг хамгийн энгийн, ойлгомжтой тархаах зорилгоор газар зүйн мэдээллийн системийг үүсгэж ашигласан нь тус тооллогын бас нэгэн онцлог юм.

Харин 2015 онд зохион байгуулж явуулсан завсрын тооллогыг өмнө зохион байгуулсан туршлага байхгүй бөгөөд дээрх зөвлөмж, хуульд заасны дагуу анх удаагаа зохион байгуулсны сацуу “Хүн амын регистрийн бүртгэлд суурилсан бүртгэлийн аргаар” хийсэн. Өөрөөр хэлбэл, засаг захиргааны анхан шатны нэгж болох баг, хороонд хөтлөгддөг “Хүн ам, өрхийн мэдээллийн сан”-г төрийн захиргааны бусад байгууллагын мэдээллийн сантай уялдуулан завсрын тооллогын үр дүнг гаргасан юм. Түүнчлэн гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэдээ интернэтээр тоолон, гадаадын олон орны туршлагад тулгуурлан орон зайн газарзүйн мэдээллийг тооллогын үр дүнтэй холбон ашигласан тооллого болсон.

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГЫН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС, ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хүн амын тооллого явуулах хууль, эрх зүйн бусад үндсийг бүрдүүлэх нь тооллого явуулах үндсэн баталгаа юм. Монгол Улсын хүн ам, орон сууцны 2010 оноос өмнөх бүх тооллогыг “Хүн амын тооллого явуулах тухай” Засгийн газрын шийдвэрээр зохицуулж ирсэн.

Харин Хүн ам, орон сууцны 2010, 2015 (завсрын тооллого), 2020, Байшин, орон сууцны 2019 оны улсын тооллогыг 2008 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр батлагдсан Монгол Улсын “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн дагуу явууллаа. Уг хуулиар тооллого явуулах эрх зүйн болоод эдийн засгийн баталгааг хангаж, тооллого явуулах хугацаа, арга зүй, зохион байгуулах байгууллага, институт, төрийн байгууллага, засаг захиргааны нэгжийн удирдлага болон хувь хүний тооллогод оролцох үүрэгтэй холбоотой харилцааг зохицуулсан юм.

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллогыг дараах хууль, эрх зүйн зохицуулалтын хүрээнд зохион байгуулан явуулсан. Үүнд:

Монгол Улсын хууль:

- Монгол Улсын “Статистикийн тухай” хууль, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг;
- Монгол Улсын “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хууль;
- Монгол Улсын “Зөрчлийн тухай” хууль;

Монгол Улсын Их Хурлын тогтоолууд:

- Монгол Улсын Их Хурлын “Тооллогын тов тогтоох тухай” 2017 оны 76 дугаар тогтоол;
- Монгол Улсын Их Хурлын “Улсын комисс байгуулах тухай” 2017 оны 77 дугаар тогтоол;

Монгол Улсын хүн ам, орон сууцны тооллогын Улсын комиссын тогтоолууд:

- “Хүн ам, орон сууцны ээлжит тооллогын улсын комиссын ажиллах журам”
2018 оны 2 дугаар сарын 22-ны өдөр
- “Төлөвлөгөө батлах тухай”
2018 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 01 дүгээр тогтоол
- “Аймаг, нийслэлийн тооллогын комиссын бүрэлдэхүүнийг томилох тухай”
2018 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 02 дугаар тогтоол
- “Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын хүрээнд Байшин орон, сууцны туршилтын тооллогыг зохион байгуулах тухай”
2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоол;
- “Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын мастер төлөвлөгөө”
2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоол;
- “Хүн ам, орон сууцны ээлжит тооллогыг зохион байгуулж явуулах Улсын комиссын Нарийн бичгийн даргыг томилох тухай”
2018 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн Б/20 дугаар тушаал;
- “Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай”
2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоол;
- “Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын төсвийн эрх нээх тухай”
2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 07 дугаар тогтоол
- “Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын дүнг нийтэд зарлах тухай”
2020 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 01 дүгээр тогтоол

Үндэсний Статистикийн Хорооны даргын тушаалууд:

- “Ажлын хэсэг байгуулах тухай”
2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тушаал;
- “Хүн ам, орон сууцны туршилтын тооллого явуулах тухай”
2018 12 дугаар сарын 25-ны өдрийн А/150 дугаар тушаал;
- “Аймаг, нийслэлийн тооллогын комисс, түр товчооны үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах тухай”
2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/36 дугаар тушаал;

- “Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийн маягт, нөхөх заавар шинэчлэн батлах тухай”
2019 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн А/44 дүгээр тушаал;
- “Байшин, орон сууцны тооллогын асуулга, гарын авлага батлах тухай”
2019 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн А/81 дүгээр тушаал

Энэ тушаалаар баталсан маягтууд:

- Байшин сууцны асуулга (БОСТ-1-1)
- Гэр сууцны асуулга (БОСТ-1-2)
- Нийтийн зориулалттай орон сууцны асуулга (БОСТ-2)
- Урьдчилсан бүртгэлийн маягт (БОСТ-3)
- Явцын мэдээний маягт (БОСТ-4)
- Байшин орон, сууцны тооллогын гарын авлага
- “Статистикийн зорилгоор ашиглах улс, нутаг дэвсгэрийн ангилал, код батлах тухай”
2019 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн А/104 дүгээр тушаал;
- “Баг, хорооны нэр, кодыг засварлаж, шинэчлэн батлах тухай”
2019 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн А/117 дугаар тушаал;
- “Статистикийн зорилгоор “Дээд боловсролын мэргэжлийн ангилал, код”-ыг батлах тухай”
2019 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн А/118 дугаар тушаал;
- “Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын асуулга, гарын авлага, нөхөх заавар батлах тухай”
2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/151 дүгээр тушаал;

Энэ тушаалаар баталсан маягт, зааврууд:

- Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын асуулга (ХАОСТ-1)
- Тооллогын асуулгын нэмэлт хуудас- Хүн амын асуулга (ХАОСТ-1а,1б)
- Тооллогын асуулгын нэмэлт хуудас- Гадаадад 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа иргэдийн мэдээлэл (ХАОСТ-1в)
- Хүн ам, орон сууцны тооллогын явцын мэдээ (ХАОСТ-2)
- Хүн ам, орон сууцны тооллогын урьдчилсан дүн (ХАОСТ-3)
- Хүн ам, орон сууцны тооллогын нөхөгдсөн асуулга хүлээлцэх баримт (ХАОСТ-4)
- Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого - Хяналтын тооллогын асуулга (ХАОСТ-11)
- Хяналтын тооллогын асуулгын нэмэлт хуудас (ХАОСТ-11а)
- Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын асуулга, нэгтгэлийн маягтын нөхөх заавар, гарын авлага

Нийслэлийн Засаг даргын захирамж

- Нийслэлийн Засаг даргын 2018 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн А/477 тоот захирамж
- Нийслэлийн Засаг даргын 2019 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн А/442 тоот захирамж

ТООЛЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ

Тооллого нь статистикийн мэдээллийн томоохон эх сурвалжуудын нэг юм.

Нийслэл хотод хүн ам, орон сууцны ээлжит тооллогыг амжилттай явуулах чухал урьдчилсан нөхцөл нь тооллогын үйл ажиллагаа бүрийг бүрэн хамарсан оновчтой төлөвлөгөөг боловсруулах, түүнийг нийслэл, дүүрэг, хорооны түвшинд хэрэгжүүлэх удирдлагын бүрэлдэхүүнийг байгуулах явдал юм.

Нийслэлийн Статистикийн газраас өмнөх тооллогуудын удирдлагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны ололт, дутагдалтай байдлыг сайтар судалж, тооллогын комисс, түр товчооны бүрэлдэхүүн, тооллогын бэлтгэл ажил, тоолох үе, тооллогын үр дүнг нэгтгэх зэрэг бүх үе шатыг хамарсан “Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого”-ыг нийслэлд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө, “Нийслэлийн тооллогын комиссын ажиллах журам”, зардлын төслийг боловсруулан Нийслэлийн тооллогын комиссын хуралдаанаар хэлэлцүүлэн гарсан чиглэлийн дагуу холбогдох газруудаас санал авч эцэслэн үйл ажиллагаа хэрэгжүүлсэн.

ТООЛЛОГЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 76 дугаар тогтоолоор “Тооллогын тов”-ыг 2020 оны 01 дүгээр сарын 08-наас 09-нд шилжих шөнийн 00 цагаар, 77 дугаар тогтоолоор Хүн ам, орон сууцны ээлжит тооллогыг зохион байгуулж явуулах Улсын комиссыг томилсон. Монгол Улсын Хүн ам, орон сууцны тооллогын улсын комиссын 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 02 дугаар тогтоолоор нийслэлийн тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулав.

Нийслэлийн ХАОСТ-ын комиссын дарга

Нийслэлийн Засаг дарга

Нийслэлийн ХАОСТ-ын комиссын орлогч дарга, Тооллогын түр товчооны дарга

Нийслэлийн Статистикийн газрын дарга

Нийслэлийн ХАОСТ-ын комиссын гишүүд:

НЗД-ын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч

НЗД-ын Хүний хөгжил, нийгмийн бодлогын орлогч

Хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга

НИТХ-ын нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга

Нийслэлийн ЗДТГ-ын дарга

НЗДТГ-ын Цэргийн штабын дарга

Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч

Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын дарга

Нийслэлийн Боловсролын газрын дарга

Нийслэлийн Автозамын хөгжлийн газрын дарга

Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга

Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газрын дарга

Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга

Нийслэлийн Бүртгэлийн газрын дарга

Нийслэлийн Нийгмийн халамжийн газрын дарга

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын дарга

Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газрын дарга

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга

Нийслэлийн Нийгмийн даатгалын газрын дарга

Нийслэлийн Спортын хорооны дарга

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын дарга

Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга

Нийслэлийн Байгаль орчны газрын дарга

Нийслэлийн ХАОСТ-ын комиссын нарийн бичгийн дарга:

Нийслэлийн Статистикийн газрын Ахлах мэргэжилтэн

Нийслэлийн Засаг даргын 2018 оны 05-р сарын 24-ний өдрийн А/477 тоот захирамжаар дүүргийн тооллогын комиссыг дүүргийн засаг даргаар удирдуулан байгуулав.

Нийслэл, дүүргийн тооллогын комисс нь хариуцсан засаг захиргааны нэгжийн хэмжээнд, нийслэлийн түр товчооноос өгсөн удирдамжийн дагуу тооллогыг удирдан зохион байгуулан явуулсан бөгөөд тооллогын материалын нууцлал, хадгалалт, бүрэн бүтэн байдлыг чандлан хангаж, Нийслэлийн тооллогын комисст хүлээлгэн өгөх үндсэн чиглэлтэйгээр ажиллав. Түүнчлэн шаардагдах хөрөнгө, хүч, байр, унаа, шатахуунаар хангах, тооллогын ажилтныг сургаж бэлтгэх, тооллогод бүрэн хамруулах үүрэгтэйгээр ажилласан.

Нийслэлийн ХАОСТ-ын комисс төлөвлөгөөний дагуу хуралдаанаа тогтмол зохион байгуулж байснаас гадна шаардлагатай үед нэмэлт хурал зарлан хуралдуулах, яаралтай хийгдэх нэмэлт ажлын зааварчилгааг дүүргийн тооллогын комисст хүргүүлэх, мөн дүүргийн тооллогын комиссын үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөх, асуудлыг хамтран шийдвэрлэх зарчмаар үйл ажиллагаагаа явуулсан.

Тооллогын комиссыг зөвхөн нийслэл, дүүргийн түвшинд, харин тооллогын түр товчоог нийслэл, дүүрэг, хорооны түвшинд зохион байгуулан ажиллав.

Нийслэлийн Засаг даргын “Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын бэлтгэл ажлыг хангах” тухай 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/19 тоот захирамжаар нийслэл хотод Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын бэлтгэл ажлыг эртнээс хангаж, тооллогын комиссыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий нийслэлийн тооллогын түр товчоог байгуулан ажиллуулсан.

Тооллогын түр товчоог нийслэлийн түвшинд Нийслэлийн Статистикийн газрын дарга, дүүргийн түвшинд статистикийн хэлтсийн дарга, хорооны түвшинд хорооны Засаг даргаар ахлуулж, нийслэл, дүүргийн газар, хэлтэс, хорооны ажлын албадын хүрээнд байгуулав.

Тооллогын түр товчоод нь тооллогын комиссын удирдлага дор тооллогын бэлтгэл ажлыг хангах, сургалт зохион байгуулах, тооллогын явцын мэдээг гаргах, хяналтын тооллого явуулах, тооллогын баримт бичиг, урьдчилсан дүнг шалгаж хүлээн авах, түүнийг тухайн түвшинд нэгтгэн дүгнэж, дээд шатны тооллогын комисст хүлээлгэн өгөх зэрэг үндсэн үүргийг гүйцэтгэв.

“Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын бэлтгэл ажлыг хангах тухай” Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/442 дугаар захирамжаар шинэчлэн батлав. Тус захирамжийн нэг, хоёрдугаар хавсралтаар “Нийслэлийн нутаг дэвсгэрт Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогыг зохион байгуулах үйл ажиллагааны нарийвчилсан

төлөвлөгөө”, “Нийслэлийн тооллогын комиссын гишүүдийн ажил үүргийн хуваарь”-ийг тус тус баталсан.

Тооллогын ажлын гүйцэтгэлд хяналт тавих, өдөр тутмын ажлыг зохион байгуулж, зохицуулахыг нийслэлийн ХАОСТ-ын түр товчоо хариуцан ажиллаж, үүссэн асуудлыг цаг алдалгүй шуурхай шийдвэрлэж байв.

Нийслэлийн тооллогын комиссын дарга, гишүүд, дүүргийн тооллогын комиссын дарга нарт зориулж, ээлжит тооллогын хууль эрх зүйн үндэслэл, удирдлага зохион байгуулалт, тооллоготой холбоотой эрх зүйн баримт бичгүүд, нийслэл, дүүргийн тооллогын комиссын бүтцийн зурагт схем зэргийг агуулсан нийт 43 хуудас бүхий гарын авлага материалыг Нийслэлийн Статистикийн газраас эмхэтгэн гаргаж, 38 ширхэгийг хэвлүүлж хавтаслан, тооллогын комиссын гишүүдэд хүргэж ажиллав.

Нийслэлийн тооллогын комиссоос Хүн ам, орон сууцны ээлжит тооллогын бэлтгэл ажлыг хангах, тооллого зохион байгуулахад зориулан 2019 онд нийслэлийн төсвөөс 738.7 сая төгрөг, 2020 онд улсын нэгдсэн төсвөөс 417.0 сая төгрөгийг тус тус баталж, нийтдээ 1155.7 сая төгрөг зарцуулсан.

ТООЛЛОГЫН АЖИЛТНЫ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ ЯВУУЛСАН БАЙДАЛ

Хүн ам, орон сууцны тооллогын ажил сайтар зохион байгуулалттай, чанартай явагдах эсэх нь тооллогын шат бүхэнд ажиллаж байгаа ажилтнуудын боловсрол, мэргэжил, мэдлэгийн түвшингээс шууд хамаарна. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын бэлтгэл ажлыг хангах, тооллогын ажлыг зохион байгуулахтай холбоотой дараах сургалтуудыг зохион байгуулж ажиллав.

ХАОСТ-ын бэлтгэл ажлын явц, тулгамдаж буй асуудал, цаашид хийх ажлын талаар мэдээлэл солилцох Хүн ам, орон сууцны тооллогын товчоо, Нийслэлийн тооллогын түр товчооны хамтарсан уулзалтыг 2019 оны 08 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулж, тус уулзалтаас өгөгдсөн үүрэг чиглэлийн дагуу 2019 оны 08 дугаар сарын 21-ний өдөр нийслэл, дүүргийн түр товчооны гишүүдэд зориулсан сургалтыг зохион байгуулав. Сургалтад нийт 39 хүн хамрагдсан.

ХАОСТ-д зориулсан хүн ам, өрхийн урьдчилсан бүртгэлийг хийх зорилгоор нийслэл, дүүрэг, хорооны түр товчоодод ажиллах 367 гэрээт ажилтанг сонгон шалгаруулж, 10 удаагийн сургалтыг 2019 оны 09 дүгээр сарын 4-6-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус сургалтаар ХАОСТ, ХАӨМС-гийн баяжилт, ХАӨБ-ийн дэвтэр хөтлөлтийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, ажил гүйцэтгэх гэрээ байгуулав.



Нийслэлийн 9 дүүргийн тооллогын түр товчооны дарга, нарийн бичгийн дарга нарт зориулсан сургалтыг 2019 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулсан. Тус сургалтаар тооллогын явцын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, ойрын хугацаанд хийгдэх болон цаашид анхаарч ажиллах ажлуудын талаар ярилцав.

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын бэлтгэл ажлын хүрээнд Нийслэлийн Баянгол, Хан-Уул, Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан, Сүхбаатар, Налайх, Багануур дүүргийн хороодын түр товчооны дарга (Засаг дарга), нарийн бичгийн дарга (зохион байгуулагч) нарт “Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого” болон “Байшин орон сууцны тооллого”-ын зохион байгуулалт, ХАӨМС-ийн сайжруулалтын талаар болон цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар уулзалт, хэлэлцүүлгийг 2019 оны 10 дугаар сарын 10-21-ний өдрүүдэд зохион байгууллаа.

ҮСХ-ны ХАОСТТ-ноос 2019 оны 11 дүгээр сарын 22-24-ны өдрүүдэд зохион байгуулсан сургагч багш бэлтгэх сургалтад ХАОСТТ-ноос тогтоосон тоо, шалгуурын дагуу нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсээс 25 хүн хамрагдсан.

Нийслэлийн хэмжээнд ХАОСТ-ын ажилтан бэлтгэх сургалтыг 2 үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөсний дагуу эхний ээлжинд 2020 оны 01 дүгээр сарын 02-ноос 03-ны өдрүүдэд дүүрэг, хорооны түр товчооны 250 ажилтнуудад зориулсан сургалтыг, 01 дүгээр сарын 05-наас 08-ны өдрүүдэд 628 тоологч, шалгагч нарт зориулсан сургалтыг хуваарийн дагуу зохион байгуулж явуулсан. Сургалтын сүүлийн өдрийг дадлага ажил хийхээр зохион байгуулсан нь хүмүүсийг хийх ажилдаа түргэн дадлагажихад шууд нөлөөлж байв.



Тоологч нарын сургалтад бүрэн хамрагдаж, сургалтын төгсгөлд шалгалт өгсөн хүмүүсийг онооны дарааллаар байр эзлүүлэн хамгийн өндөр оноо авснаас нь эхлэн шалгагчаар, дараагийн оноог авсан хүмүүсээс тоологчоор сонгон авч ажиллуулахыг дүүргийн түр товчооны дарга нарт зөвлөмж болгосон. Уг зөвлөмжийн дагуу дүүргийн түр товчооны дарга нар шалгагч, тоологч нартай гэрээ байгуулан ажилласан.

СУРТАЛЧИЛГАА ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ

Тооллогыг амжилттай явуулах, ялангуяа ард иргэдийг тооллогод идэвхтэй бүрэн оролцуулах нь ухуулга сурталчилгааны ажлын үндсэн зорилт байв. Нийслэлийн тооллогын түр товчооноос ХАОСТ-д зориулсан урьдчилсан бүртгэлд идэвхтэй хамрагдахыг олон нийтэд уриалсан 30 секундын видео шторкыг анимейшн-инфографик бүтэцтэйгээр бэлтгэн гаргаж, 09 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн дараах хэлбэрээр нийслэлчүүддээ хүргэсэн болно. Үүнд:

- MNB, UBS, Eagle, TV5, TV9 телевизүүд болон 14 сайт, фэйсбүүк, твиттер хуудсуудаар дамжуулан видео хэлбэрээр нийслэлийн иргэд, олон нийтэд түгээсэн.
- TV5, TV9, Eagle телевизээр өдөрт 2-3 удаа, 7-10 хоногийн хугацаанд эфирээр цацсан бөгөөд UBS телевиз өдөрт 2 удаа, үндэсний олон



нийтийн MNB телевиз өдрийн 3 удаагийн давталтаар тооллого явагдах хугацаанд олон нийтэд хүргэсэн.

- Дээрх анимейшныг “Зурагт хуудас” хэлбэрээр бэлтгэн 7000 ширхгийг хэвлүүлж, нутгийн захиргааны байгууллагууд болон томоохон худалдаа үйлчилгээний цэгүүд, орон сууцны хороолол, гудамж талбайд байршуулсан.

ҮСХ-ноос бэлтгэн ирүүлсэн БОСТ (20 сек)-д идэвхтэй хамрагдахыг уриалсан видео шторкыг нийслэлийн иргэд, олон нийтэд түгээх ажлыг Нийслэлийн статистикийн газрын page хуудас болон нийтдээ 22 сайт, фэйсбүүк, твиттер хуудсуудаар дамжуулан хийж, нөлөөллийн арга хэмжээг авч ажиллав.

Хүн ам, орон сууцны тооллого”-ын бэлтгэл ажил, Байшин, орон сууцны 2019 оны тооллогын үйл ажиллагааны талаар шуурхай мэдээлэл хүргэх зорилгоор Газрын дарга Ц.Заяхүү Eagle телевизэд 30 минутын, MNB телевизэд 15 минутын ярилцлага өгч, иргэдийг тооллогод идэвхтэй хамрагдахыг уриаллаа.

Тооллогын үндсэн мэдээлэл болох ХАӨМС-д иргэн өөрийн мэдээллээ шалгах боломжтой <http://registration.nso.mn> веб систем болон ДАН системд нэвтэрч ажиллах горим, дэс дарааллыг харуулсан зурагт схем, тайлбартай товч гарын авлагыг бэлтгэж, хэвлэмэл болон цахим хэлбэрээр нийслэлийн иргэдэд хүргэсэн.

Үүрэн холбооны оператор 4 компанид албан тоот явуулж, үүнээс Жи-Мобайл, Скайтел болох 2 оператор компани 160 тэмдэгт бүхий зурвасыг 38791 хэрэглэгчдийн гар утас руу 10 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд илгээж, ХАӨМС-д бүртгэгдсэн өөрийн өрх, хүн амын мэдээллийг иргэд шалгаж, баталгаажуулах боломжтой талаар нэгдсэн мэдээлэл хүргэж ажилласан.

2 дахь видео сурталчилгааг Хүн ам, орон сууцны тооллогын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх, нийслэлийн иргэдэд тооллогын мэдээлэл хүргэж, хууль эрх зүйн холбогдох заалтыг таниулах зорилгоор (17 секунд) бэлтгэж гаргасан. Тус видео шторкийг “НАРРУ” ХХК-тай гэрээ байгуулан 2019 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл 1 сарын хугацаанд албан байгууллага (10), хотхон, хорооллын (97), нийт 835 лифтний сурталчилгааны дэлгэцээр гаргаж “Хүн ам, орон сууцны тооллогын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх, нийслэлийн иргэдэд тооллогын мэдээлэл хүргэж, хууль эрх зүйн холбогдох заалтыг таниулах” нөлөөллийн арга хэмжээг авсан. 2019 оны 11 дүгээр сард дээрх видео сурталчилгааг өдөрт дунджаар 15 удаагийн давтамжтайгаар нийслэлийн төвийн 5 дүүргийн орон сууцны 835 лифтний дэлгэцээр 42542 өрхийн 212710 хүн амд (үүнээс, 73053 нь хөдөлмөр эрхэлдэг) хүргэсэн. Мөн нийслэлийн гол цэгүүдэд байршуулсан сурталчилгааны 3 том дэлгэцээр тогтмол давтамжтайгаар видео шторкийг тооллого явагдах хугацаанд үнэ төлбөргүй дамжуулсан.

“Хүн ам, орон сууцны тооллого”-д идэвхтэй хамрагдахыг нийслэлийн иргэдэд уриалсан видео шторкийг Нийтийн тээврийн үйлчилгээний шугаманд ажиллаж байгаа төр, хувийн хэвшлийн их багтаамжийн 25 автобусны сурталчилгааны дэлгэцээр түгээж, зорчигчдод тооллогын мэдээлэл хүргэх ажлыг “Хотын хэмнэл” ХХК-тай хамран зохион байгуулав. Мөн UB info аппликейшнд тооллогын сурталчилгааны баннерыг 2 сарын туршид байршуулж, “push notification” үйлчилгээг ашиглан иргэдийн гар утсанд зурвас мэдээлэл 4 удаа илгээх ажлыг гүйцэтгэсэн.



ХААН банк, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банкны удирдлагуудад үйлчилгээний танхимаар нь дамжуулан реклам сурталчилгааг иргэдэд хүргэх хүсэлт хүргүүлсний дагуу ХААН банкны 70 салбарт, Худалдаа хөгжлийн банкны 68 салбарт иргэдийг тооллогод идэвхтэй хамрагдахыг уриалсан зурагт хуудас байршуулсан.

3 дахь видео сурталчилгааг иргэдийг тооллогодоо хэрхэн хамрагдах талаар мэдээлэл өгөх зорилгоор (43 секунд) бэлтгэн гаргаж фэйсбүүк, твиттер хуудсуудаар дамжуулан видео хэлбэрээр түгээж, нийслэлийн иргэд, олон нийтэд нөлөөллийн арга хэмжээг авч ажилласан.

Тус видео уриалгыг “Зурагт хуудас” хэлбэрээр бэлтгэн нийтийн тээврийн хэрэгслийн бариуланд, А4 хэмжээтэй 4000 ширхэг зурагт хуудсыг дүүрэг, хорооны түр товчоо, сургууль, цэцэрлэг, томоохон зах худалдааны төвүүдэд байршууллаа.

Нийслэлд нийтийн тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг 11 аж ахуйн нэгж байгууллагын 106 том оврын автобусны 1840 реклам, сурталчилгаа байрлуулах зориулалттай зорчигчийн бариул дээр байршуулсан.



ХҮН АМ, ӨРХИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГ САЙЖРУУЛСАН ТУХАЙ

Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилтийг сайжруулах, алдааг засварлах ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын бэлтгэл ажлыг хангах” тухай Нийслэлийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/19 тоот захирамжийг батлуулан, Нийслэлийн ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч, Нийслэлийн Засаг даргын орлогч Д.Энхтөрийн баталгаажуулсан албан бичгийн хамт 9 дүүргийн Засаг дарга нарт хүргүүлсэн. Тус захирамжаар ХАӨМС-ын чанарыг сайжруулахад онцгой анхаарч ажиллахыг үүрэг болгосон.

Энэхүү ажлын хүрээнд Нийслэлийн Статистикийн газар дүүргүүдийн статистикийн хэлтсийн хүн ам, өрхийн мэдээлэл хариуцсан мэргэжилтнүүдэд заавар зөвлөмж өгсний дагуу хугацаатай үүрэг өгч, ХАӨМС-гийн алдааны протоколыг 7 хоног бүр уншуулан хяналт тавьж, алдааг тогтмол засуулж ажиллав.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын бэлтгэл ажлыг хангах, “Хүн ам, өрхийн мэдээллийн сан”-гийн бүртгэл, мэдээллийг сайжруулахаар “Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр маягтыг шинэчлэн хөтлөх нь” сэдэвт сургалтыг үе шаттайгаар зохион байгуулсан. Үүнд:

- Эхний шатны сургалтыг 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдөр дүүргүүдийн Статистикийн хэлтсийн хүн амын мэдээлэл хариуцсан мэргэжилтнүүдэд хийв.
- Хоёр дахь шатны сургалтыг 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дүүргүүдийн тооллогын түр товчоод Нийслэлийн Статистикийн газраас өгсөн нэгдсэн заавар зөвлөмжийн дагуу хорооны тооллогын түр товчоонд болон хэсгийн ахлагч нарт зориулсан сургалтуудыг нийт 152 хороонд тус тус зохион байгуулсан.

Дээрх сургалтуудаар хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийг хэрхэн бөглөх, үзүүлэлтүүдийн ойлголт тодорхойлолт, бүртгэсэн мэдээллийг ХАӨМС-д оруулах талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.

2019 оны 03 дугаар сараас эхлэн шинэчлэгдсэн “Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр” маягтыг орон нутгийн төсвийн зардлаар хэвлүүлэх ажил хийгдэж, хэвлэн нийлүүлэх ажил гүйцэтгэх гэрээг “Ви Си Ай” ХХК-тай байгуулан 390000 ширхэг дэвтэр хэвлүүлэн, нийслэлийн 9 дүүрэгт хуваарийн дагуу хүргүүлж, нөхөх заавар, зөвлөмжийг тухай бүрт нь өгч ажиллав.

Нийслэлийн өрх нэг бүрээр 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн хороодын хэсгийн ахлагч нар биечлэн явж, мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгууллаа. “Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр” хөтлөлтийн ажил 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн байдлаар 93.2 хувьтай хийгдсэн байв.

“Хүн ам, өрхийн мэдээллийн сан”-гийн программ хангамжид өөрчлөлт оруулж, шинэчлэлт хийгдсэн бөгөөд өрхийн 2 (өмчлөлийн хэлбэр, бие засах газрын төрөл), хүн амын 5 (эзэмшсэн мэргэжил, хөдөлмөр эрхлэлт г.м) үзүүлэлт нэмэгдсэнээр 393840 өрх, 1031687 иргэний нийт 3728695 мэдээллийг шинэчлэн засварлах ажил хийгдэж эхэлсэн. ХАӨМС-г шинэчлэн засварлах ажил нийслэлийн хэмжээнд 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн байдлаар 71.8 хувь байв.

ХАОСТ-д зориулсан хүн ам, өрхийн урьдчилсан бүртгэлийг хийх зорилгоор нийслэл, дүүрэг, хорооны түр товчоодод ажиллах 367 гэрээт ажилтанг 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн ажилласан.

Нийслэлийн тооллогын түр товчооны гишүүд 2019 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн Баянгол (2), Чингэлтэй (19), Налайх (8), Багануур (5), Багахангай (2) дүүргийн нийт 36 хороонд ажиллаж, хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын бэлтгэл ажлын зохион байгуулалт, ХАӨМС-гийн баяжилт, ХАӨБ-ийн дэвтэр хөтлөлтөд хяналт тавьж, зөвлөн туслах ажил хийв. Тус ажлын явцад хэсгийн ахлагч тус бүрийн ХАӨБ-ийн дэвтэр хөтлөлтийг нэг бүрчлэн үзэж, алдаатай буюу дутуу нөхсөн үзүүлэлтүүдийг хэрхэн нөхөх талаар дэлгэрэнгүй заавар зөвлөмж өгч, хугацаатай үүрэг өгч ажилласан.

ХАОСТ-ын бэлтгэл, зохион байгуулалтыг хангах ажлын хүрээнд хороодын Засаг дарга, зохион байгуулагч нарт зориулсан хялбаршуулсан “гарын авлага”-ыг ээлжит тооллогын болон бусад хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичгийн хамаарал бүхий заалтын хүрээнд эмхэтгэж гарган, өнгөт хувилах машинаар 310 ширхгийг хэвлэн 9 дүүргийн 169 хороонд хүргүүлсэн нь 2020 оны ХАОСТ-ын суурь мэдээлэл болох ХАӨМС-г шинэчлэн сайжруулах ажлыг гардан зохион байгуулж буй анхан шатны ажилтнуудад мэдлэг олгох тустай үйл ажиллагаа болсон.

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын бэлтгэл ажлын хүрээнд хийгдэж буй иргэн өөрөө Хүн ам, өрхийн мэдээллийн сан дахь мэдээллээ шалгах систем 2019 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөс ажиллаж эхэлсэнтэй холбоотойгоор Нийслэл, дүүргийн нутгийн захиргааны 229 байгууллагад албан бичиг хүргүүлж, нийт албан хаагчдыг <http://registration.nso.mn> системээр нэвтрэн мэдээллээ шалгаж баталгаажуулах ажлыг зохион байгуулах талаар заавар зөвлөмж өгч ажиллав. Үүний үр дүнд Нийслэл, дүүргийн нутгийн захиргааны 229 байгууллагын 2946 өрх, 9711 иргэний Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн бүртгэлийг шалгаж баталгаажуулсан.

Монгол Улсад Статистикийн байгууллага үүсч хөгжсөний 95 жилийн ой, Нийслэл Улаанбаатар хот үүсгэн байгуулагдсаны 380 жилийн ойн хүрээнд статистикийн үйл ажиллагаа, Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн шинэчлэл, иргэн өөрийн мэдээллийг хянан засварлаж баталгаажуулах вэб системийг сурталчлан таниулах, Статистикийн мэдээлэл, Хүн ам, орон сууцны тооллогын талаар мэдээлэл өгөх, тооллого судалгааны үр дүнг олон нийтэд таниулах, байгууллагын үйл ажиллагааг таниулах зорилгоор “НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ”-ийг 2019 оны 10 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн Дүнжингаравт зохион байгуулав.



Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн Дүнжингаравт өдөрт 1000 орчим иргэд төрийн үйлчилгээ авах гэж үйлчлүүлдэг гэсэн албан бус судалгаа байдаг. Тус төвөөр үйлчлүүлэхээр ирсэн иргэдэд Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн ач холбогдол, хэрэглээ ашиглалтыг сурталчилж, сонирхсон 60 орчим иргэдийн мэдээллийг шалгаж, засварлаж, баталгаажуулах ажил хийгдэв.

Тооллогын ажлын гүйцэтгэлд хяналт тавих, өдөр тутмын ажлыг зохион байгуулж, зохицуулахыг Нийслэлийн ХАОСТ-ын түр товчоо хариуцан ажиллаж, үүссэн асуудлыг цаг алдалгүй шуурхай шийдвэрлэж байв.

ТУРШИЛТЫН ТООЛЛОГО

ҮСХ-ны даргын 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/150 дугаар тушаал, Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын мастер төлөвлөгөө, "Хүн ам, орон сууцны тооллого-2020" туршилтын тооллогын үзэл баримтлал, тооллогод бэлтгэх, зохион байгуулж явуулах, түүний үр дүнг гаргах ажлын нэгдсэн төлөвлөгөөний дагуу "Хүн ам, орон сууцны туршилтын тооллого"-ыг 2019 оны 01 дүгээр сарын 10-наас 16-ны өдрүүдэд Нийслэлийн Баянзүрх дүүргийн 5 дугаар хорооны 6, 9, 10, 19-р хэсэг, Хан-Уул дүүргийн 15 дугаар хорооны 4, 13, 14, 16-р хэсэг, Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хорооны 1, 2, 3, 10-р хэсэгт амжилттай зохион байгуулж явуулав. Хүн ам, орон сууцны туршилтын тооллогоор нийслэлд сонгогдсон нэгжийн 4810 (97.6%) өрхийн 16475 (97.1%) хүн амыг хамруулж мэдээлэл цуглуулсан.

Туршилтын тооллогоор сонгогдсон нэгжүүдэд тоологч (56), шалгагчаар (18) ажиллах нийт 74 хүнийг нийслэл, дүүргийн тооллогын комиссоос сонгон шалгаруулах ажил хийгдэж, ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн Статистикийн тэнхимд хүсэлт гарган, тооллогод ажиллуулахаар статистикийн I-III ангийн 27 оюутныг сонгон шалгаруулж, ажиллуулсан үр дүнтэй ажил болсон.

ТООЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогыг 01 дүгээр сарын 09-ний өглөөний 09:00 цагаас Улаанбаатар хотын хэмжээнд нэгэн зэрэг эхлүүлсэн. Тооллогын үйл ажиллагааг нийт хүн амын 10 хувийн түүвэрт сонгогдсон өрхүүдээс хамгийн өндөр настай Сүхбаатар дүүргийн иргэн 103 настай Ш.Багаажавынхаас эхэлсэн.

Тоолох үе маш богино хугацаанд явагдах байсан тул нийслэл, 9 дүүрэг, 169 хорооны тооллогын түр товчоод шуурхай ажиллагааны төлөвлөгөө, тухайн шатны түр товчоодод ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарийг гарган ажиллав.

Тооллогын хариуцлагатай жижүүрийн хуваарийг Нийслэлийн ХАОСТ-ын түр товчооны даргаар батлуулан урьдчилсан тооллого эхэлсэн өдөр буюу 01 дүгээр сарын 09-нээс хяналтын тооллого дууссан өдөр буюу 01-р сарын 19-нийг дуустал өдөр бүр 08.00-24.00 цагийн хороонд нийслэлийн ХАОСТ-ын түр товчооны гишүүд хуваарийн дагуу хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэсэн. Тооллогын хариуцлагатай жижүүрүүд 322783, 327946, 328787 дугаарын утсаар иргэдийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авч, гомдол гаргасан тохиолдолд шуурхай арга хэмжээ авч, гомдлыг барагдуулсан талаар хариу мэдэгдэн ажиллаж байлаа.

Тооллогын хариуцлагатай жижүүрүүд иргэдийн санал, хүсэлт, гомдлыг авахаас гадна ҮСХ, ХАОСТТ, дүүргийн ХАОСТ-ын түр товчооны хариуцлагатай жижүүрүүдтэй байнгын холбоотой ажиллаж мэдээлэл солилцож байсан. Мөн ҮСХ болон ХАОСТТ-ноос өгсөн удирдамж, чиглэлийг дүүрэг, хорооны тооллогын түр товчоонд шуурхай хүргэх, тоологч, шалгагч болон тооллогод оролцон ажиллаж байгаа хүмүүсийн аюулгүй байдлыг ханган ажиллахад анхаарч байв. Өдөр бүр өрхөөр явж тоолох үйл ажиллагаа дууссаны дараа тоологч нарыг ажлаасаа бүрэн буусан, хорооны түр товчооны байранд эргэж ирсэн талаарх мэдээллийг хороо, дүүргийн түр товчооноос бүрэн авсны дараа хариуцлагатай жижүүрүүд ажлаа дуусгаж байлаа.

Тооллогын өдрүүдэд тоологч, шалгагч нарын ажлын ачааллыг жигдрүүлэх, тооллогод өрх, хүн амыг бүрэн хамруулах үүднээс бүх тоологч нарыг эхний өдрөөс эхлэн тооллогын үйл ажиллагаагаа эхэлж буй байдалд хяналт тавьж, эхний өрхүүдээр дүүрэг, хорооны түр товчооны ажилтнууд, шалгагч нар тоологчтой хамт өрхөөр орж иргэдийг тооллогод хамруулах ажиллагааг эхлүүлсэн.

Нийслэлд хүн ам, орон сууцны тооллого зохион байгуулж явуулах нэгдсэн удирдамжийн дагуу 11-р сарын 12-ны өдрөөс эхлэн өдөр бүр тоологч нар явцын мэдээг 9 цагаас өмнө шалгагчдаа, шалгагч нар тоологч нарын дүнгээр нэгтгэн 10 цагаас өмнө хорооны түр товчоонд, хорооны түр товчоо шалгагчийн дүнгээр нэгтгэн 12 цагаас өмнө дүүргийн товчоонд, дүүргийн түр товчоо хорооны дүнгээр нэгтгэн 14 цагаас өмнө нийслэлийн тооллогын түр товчоонд мэдээлж, программд шивж байсан. Нийслэлийн тооллогын түр товчоо дүүргийн дүнгээр явцын мэдээг шалгаж, 16 цагаас өмнө баталгаажуулж байсан.

Тооллогын өдрүүдэд тоологч нарт өдөрт дунджаар тоолох ёстой өрх, хүн амын 14 орчим хувийг тоолсон байхад тооллогын 7 хоногийн хугацаанд тоологдох өрх, хүн амыг тооллогод бүрэн хамруулах боломжтой гэсэн тооцоо байсан. Нийслэлийн хувьд тооллогын эхний өдрүүдэд түүвэрт сонгогдсон өрхүүдийн гэр орондоо байнгын хүнтэй байдаг, оройн цагаар ажлаасаа эрт тарж ирдэг айл өрхүүд бүрэн хамрагдсан бөгөөд сүүлийн өдрүүдэд гэр орондоо эзгүй байгаа, ажлаасаа оройтож тардаг хүмүүсийг тооллогод хамруулахаар айл өрхөөр олон дахин явах асуудал нэлээд гарч байсан.

Тоолох үйл ажиллагаа 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 22:00 цагт албан ёсоор дууссан ба нийслэлийн хэмжээнд түүвэрт сонгогдсон 42840 өрхийг 100 хувь хамруулсан. Тооллогын материалыг шалгах хүлээн авах ажиллагаа хуваарийн дагуу 2020 оны 02 дугаар сарын 09-ний өдөр дуусгаж, ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчоонд хүлээлгэн өгсөн.

ХЯНАЛТЫН ТООЛЛОГО

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын мэдээлэл цуглуулалтын үйл ажиллагаа явагдаж дууссаны дараа бүх аймаг, нийслэлийн сонгогдсон тооллогын нэгжийн хүрээнд үндсэн тооллогын хамралт, мэдээллийн чанарт үнэлгээ өгөх зорилгоор хяналтын тооллого явагдсан.

Хяналтын тооллогыг үндсэн тооллого дууссаны дараа 2020 оны 01 дүгээр сарын 17-19-ний өдрүүдэд түүвэрт сонгогдсон 4280 нэгжийн хамруулан зохион байгууллаа.

Хяналтын тооллогод ажиллах тоологчийг тухайн тооллогод шалгагчаар ажиллаж байсан ажилтнуудаас сонгон авсан бөгөөд нийт 103 тоологч, 26 шалгагч ажиллав.

Хяналтын тооллогын материалыг хяналтын тооллого дуусангуут дүүргийн түр товчоо битүүмжлэн авч, нийслэлийн тооллогын түр товчоонд хүлээлгэн өгсөн.

ТООЛЛОГЫН МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВСАН, ҮСХ-Д ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН БАЙДАЛ

ХАОСТ-ын тоолох үе шат дууссаны дараа тооллогын материалыг тоологчоос шалгагчид, шалгагчаас хорооны түр товчоонд, хорооны түр товчооноос дүүргийн тооллогын түр товчоонд тооллогын материалыг бүрэн гүйцэд хүлээлцэх тал дээр илүү анхаарч бүх дүүрэг, хорооны түр товчоонд холбогдох заавар, санамжийг хүргүүлсэн. Ялангуяа тооллогын материалын бүрэн, бүтэн байдал, хадгалалт хамгаалалтад бүх шатанд анхааран ажилласан болно. Нийслэлийн ХАОСТ-ын комиссоос ХАОСТ-ын ажлын удирдамжийг материал хүлээлцэх бүх шатанд хатуу чанд мөрдөн ажиллахыг анхааруулж ажилласнаар энэ талаар ямар нэг зөрчил гараагүй. Ялангуяа нөхөгдсөн асуулгын хуудсыг үрэгдүүлэхээс сэргийлж тоологч нар орой бүр нөхсөн асуулгын хуудсыг шалгагч нарт хүлээлгэн өгч, шалгагч нар тоологч тус бүрийн архивын хавтаст хийн хорооны түр товчооны архивын байранд хадгалж байсан.

Нийслэлийн тооллогын түр товчоо 01 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн хуваарь гарган дүүргийн түр товчооноос тооллогын материалыг хүлээн авч эхэлсэн. Тооллогын материалыг шалгахдаа тооллогын асуулгын үзүүлэлт хоорондын уялдаа холбоо, зөв нөхөгдсөн эсэхийг нэг бүрчлэн шалгаж илэрсэн алдаа, зөрчлийг хэрхэн залруулах, асуулгын хуудас нэг бүрийг улсад тушаахаас өмнө дахин нягтлан шалгах үүрэг өгсөн.

БАЙШИН, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН ТУХАЙ

Монгол Улсад Статистикийн байгууллагын үндэс суурь тавигдсан 1924 оноос хойш 1935, 1944, 1956, 1963 онуудад хүн амын тооллого хийсэн бол улс хоршооллын байгууллагын орон сууцны фондын тооллогыг 1960 онд анх явуулсан байдаг.

Хүн ам, орон сууцны тооллогыг олон улсын нийтлэг аргачлалын дагуу 1969 оноос хойш 10 жилийн давтамжтайгаар буюу 1979, 1989, 2000, 2010 онуудад зохион байгуулсан. Гэсэн хэдий ч улсын хэмжээнд хүн амьдрах зориулалттай сууцны нийт сан хөмрөг, ашиглалтын талаар бүрэн хэмжээний мэдээлэл хомс байсаар байв. Дэлхийн ихэнх улс орнууд тус мэдээллийг гаргахдаа байшин, орон сууцны суурь тооллогыг хаягийн бүртгэлд суурилан явуулсаар байна. Тиймээс Монгол Улс уг туршлагыг үндэслэн Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын хүрээнд энэ удаагийн “Байшин, орон сууцны тооллого”-ыг явуулав.

Монгол Улсын “Байшин, орон сууцны тооллого-2019”-ын үндсэн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа хүн амьдран суух зориулалттай бүх байшин, орон сууцны сан хөмрөгийг бүрэн тодорхойлох, орон сууцны фонд, хийц, ашиглалт, хүчин чадал, дэд бүтцийн хүртээмжийн талаар дэлгэрэнгүй мэдээллийн сантай болоход оршсон. Энэхүү

тооллого нь орон сууцны хангамжийг сайжруулах чиглэлээр төрөөс авч хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөрийг оновчтой боловсруулахад шаардагдах тоо мэдээлэл болоод Тогтвортой хөгжлийн зорилгуудын шалгуур үзүүлэлтүүдийг тооцоход хэрэгцээтэй анхдагч мэдээллийг бүрдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

Нийслэлийн Байшин, орон сууцны тооллогын мэдээлэл цуглуулалтыг төхөөрөмж (таблет) ашиглан 2019 оны 11 сарын 19-нөөс 12 дугаар сарын 22-ны өдрүүдэд нийт 12 хоногийн хугацаанд зохион байгуулсан.

ХҮСНЭГТ 1.1.1. БАЙШИН, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ ХУГАЦАА

Нийслэл, дүүрэг	Мэдээлэл цуглуулах хугацаа		Үргэлжлэх хоног	Тоологчийн тоо
	Эхлэх	Дуусах		
Улаанбаатар				
Хан-Уул	11 сарын 19	11 сарын 24	6 хоног	100
Сүхбаатар				100
Баянзүрх	11 сарын 26	12 сарын 01	6 хоног	200
Сонгинохайрхан	12 сарын 03	12 сарын 11	9 хоног	200
Чингэлтэй	12 сарын 13	12 сарын 17	5 хоног	176
Багахангай	12 сарын 14	12 сарын 15	2 хоног	13
Баянгол	12 сарын 19	12 сарын 21	3 хоног	110
Багануур				24
Налайх				66

Байшин, орон сууцны тооллогын нэгжид хүн амьдрах зориулалттай дараах байр, орон сууцыг хамруулсан.

1. Бүх төрлийн гэр
2. Сууцны тусдаа байшин
3. Бие даасан тохилог сууц
4. Нийтийн зориулалттай орон сууцны байшин
5. Нийтийн байр

СУРГАЛТ

Тооллогын бэлтгэл ажлын хүрээнд сургалтуудыг үр дүнтэй зохион байгуулах нь ээлжит тооллогыг амжилттай зохион байгуулах үндэс байдаг. Байшин, орон сууцны тооллогын хүрээнд дараах төрлийн сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:

1. Сургагч багшийн сургалт;
2. Нийслэл, дүүргийн тооллогын комисс, түр товчоодын гишүүдийн сургалт
3. Тоологч, шалгагч нарын сургалт;

Сургагч багшийн сургалт. Байшин, орон сууцны тооллогоор нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, орон сууцны асуудал хариуцсан мэргэжилтнийг сургагч багшаар бэлтгэж, сургагч багшийн сургалтыг ҮСХ-ны ХАОСТТ болон МТГ хариуцан ажилласан. Эдгээр сургагч багш нар нь нийслэл, дүүргийн тооллогын комисс, түр товчоодын сургалт, хорооны түр товчоо, тоологч нарын сургалтыг хариуцан ажиллах үүрэгтэй.

Нийслэл, дүүргийн тооллогын комисс, түр товчоодын гишүүдийн сургалт. Тооллогын комиссын гишүүд болон түр товчоодын ажилтнуудад зориулсан сургалтыг сургагч багшаар бэлтгэгдсэн нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн ажилтнууд хариуцаж сургалтыг сургагч багш нар хийв. Сургалт нь тооллогын зорилго, ач холбогдол, тооллогын комисс, түр товчоодын ажилтнуудын оролцоо, үүрэг, үндсэн тооллогын бэлтгэл ажилд хэрхэн хамтран ажиллах зэрэг агуулгыг хамарсан.

Тоологч, шалгагч нарын сургалт. Байшин, орон сууцны тооллогын тоологч нарын сургалтыг нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтэс бүхэлд нь хариуцан зохион байгуулсан. Тооллогын мэдээллийг таблет төхөөрөмжөөр цуглуулсан учир тоологч нарт асуулга, түүнд ашиглах ойлголт, тодорхойлолтоос гадна мэдээлэл цуглуулах Collector for ArcGIS болон Survey123 программууд дээр ажиллах, сууцыг газрын зурагт хэрхэн тэмдэглэх талаарх хичээлүүдийг орсон.

УРЬДЧИЛСАН БҮРТГЭЛ

Байшин, орон сууцны тооллогыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд тооллогын хүрээг тодорхойлох, тоологчийн ачааллыг жигд хуваарилах, тоолох үед сууц орхигдуулахгүй, давхардуулахгүй байх тооллогын үеийн төлөвлөлт зохион байгуулалт хийх зорилгоор сонгогдсон нэгжийн нутаг дэвсгэрт байгаа сууцаас хүн байнга амьдардаг сууцуудыг тодорхойлох урьдчилсан бүртгэлийг сум, дүүргийн тооллогын түр товчоо өөрийн харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд Collector for ArcGIS программ ашиглан бүртгэж хөтөлсөн. Урьдчилсан бүртгэлийн зураглалыг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газараас шинэчлэн боловсруулсан “Хаягийн зураг”-т үндэслэж гаргасан ба зурагт хаяг, нэгж талбар, барилга, байшингийн зураглал дүрслэгдсэн.

“Хаягийн зураг”-т дүрслэгдсэн сууцыг нийтийн зориулалттай орон сууцны байшин, орон сууцнаас бусад төрлийн сууц, зуслангийн сууц, сууцны бус байшин, барилга гэсэн үндсэн 4 ангиллаар ангилан ялгаж, “Хаягийн зураг”-т дүрслэгдээгүй буюу шинээр баригдсан сууц, гэр сууц зэргийг зурагт нэмж тэмдэглэх байдлаар урьдчилсан бүртгэлийг хийж байшин, орон сууцны тооллогоор тоологдох нийт сууцны тоог урьдчилсан байдлаар гаргасан.

Тоологдох сууцны нийт тоог гаргахдаа хүн байнга амьдардаг сууцаар, тоологчид мэдээлэл болгох үүднээс дээрхээс бусад сууц, барилгыг өнгөөр ялган гаргаж тоологчийн гар зурагт оруулав.

СУРТАЛЧИЛГАА

Улаанбаатар хотод 2019 оны 08 дугаар сараас эхлэн Байшин, орон сууцны тооллогын сурталчилгааны ажлыг эрчимжүүлэн ҮСХ-ноос ирүүлсэн сурталчилгааны шторкийг нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсүүдийн цахим сүлжээнд байршуулан олон нийтэд тархааж, нөлөөллийн арга хэмжээг авч ажиллав.



2019 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсад Статистикийн байгууллага үүсэж хөгжсөний 95 жилийн ой, Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 380 жилийн ойн хүрээнд статистикийн үйл ажиллагаа, Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого, Байшин орон сууцны тооллогын тухай мэдээлэл өгч, сурталчлан таниулах, **НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГИЙГ** зохион байгууллаа.



“Хүн ам, орон сууцны тооллого”-ын бэлтгэл ажил, Байшин, орон сууцны 2019 оны тооллогын үйл ажиллагааны талаар шуурхай мэдээлэл хүргэх зорилгоор газрын дарга Ц.Заяхүү 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Eagle телевизэд 30 минутын, MNB телевизэд 15 минутын ярилцлага өгч, иргэдийг тооллогод идэвхтэй хамрагдахыг уриалав.

Нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсүүд Байшин орон сууцны тооллого болохтой холбогдуулан сурталчилгааны материал, зурагт хуудас, инфографик мэдээлэл зэргийг бэлтгэн хэлтэс тус бүр өөрсдийн цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд мэдээлэл тархааж ажиллав. Мөн тооллогын үйл ажиллагаа, явцын талаарх мэдээллийг тухай бүрт нь цахим хуудаст байршуулан мэдээлж ажилласан.

ХАВСРАЛТ В

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГОД ХЭРЭГЛЭСЭН ЗАРИМ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

№	Ойлголт	Тодорхойлолт
ТООЛЛОГО		
1	Хүн ам, орон сууцны тооллого	Товлон тогтоосон хугацаанд тухайн улс оронд (буюу түүний нутаг дэвсгэрийн тодорхой хэсэг) оршин суугаа нийт хүн амыг хамарч, тэдний амьдарч буй сууцны талаарх суурь мэдээллийг цуглуулах, боловсруулах, хүн ам зүйн, эдийн засаг, нийгмийн дүн шинжилгээ хийх, үнэлэх, хэвлэн нийтлэх, нийтэд тархах цогц үйл ажиллагаа;
2	Тооллогын тов	Тооллого явуулах хугацааны эхний өдөрт шилжих шөнийн 00 цагийг; 2020 оны 1 дүгээр сарын 08-наас 09-нд шилжих шөнийн “00” /тэг тэг/ цаг;
3	Тоолох үе	2020 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн 08 цагаас 1 дүгээр сарын 15-ны өдрийн 22 цаг хүртэлх хугацаа;
4	Тооллогын нэгж	Хувь хүн, түүний амьдарч байгаа байр, орон сууц;
ӨРХ, ХҮН АМ		
5	Өрх	Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо хамааралтай эсвэл хамааралгүй байж болно.
6	Үндсэн өрх	Сууцны төрөл, хэлбэрээс үл хамааран тухайн сууцыг өмчлөгч өрх, сууц эзэмших эрхийн бичиг (ордер), орон сууц хөлслөх гэрээний үндсэн дээр эзэмшиж байгаа өрх, өмчлөгч нь өөр этгээд боловч уг сууцанд хамгийн удаан хугацаагаар амьдарч байгаа өрхийг хэлнэ.
7	Хамт суудаг өрх	Тухайн өрхийн өөрийн сууц биш, тухайн сууц эзэмшигчтэй хамт суудаг өрхийг хамруулна.
8	Өрхийн тэргүүлэгч	Ам бүлийн гишүүд хэнийгээ өрхийн тэргүүлэгч гэхийг сайн дураар шийдвэрлэнэ. Өрхийн тэргүүлэгч нь өрхдөө байнга оршин суугч, 16, түүнээс дээш настай, хөдөлмөр эрхэлдэг буюу өрхийн орлогод голлох хувь нэмэр оруулдаг, өрхийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд голлох үүрэгтэй оролцдог ам бүлийн аль нэг гишүүн юм.
9	Өрхийн ам бүлийн гишүүд	Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг хүмүүсийг тухайн өрхийн ам бүлийн гишүүн гэж үзнэ. Тоолох үед тухайн өрхөд гишүүдээс нь гадна өрхийн ам бүлд хамаарахгүй садан төрөл, бусад хүмүүс амьдарч болно.
10	Ам бүлээрэй байгаа өрх	Ам бүлээрэй байгаа өрх дангаараа амьдрахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, эхнэр, нөхөр, хүүхдийн (хүүхдүүдийн) хамт, мөн эцэг эсвэл эх нь хүүхдийн (хүүхдүүдийн) хамт өрх үүсгэн амьдрахыг хэлнэ.
11	Нийлмэл ам бүлтэй өрх	Нийлмэл өрхөд дараах бүтэцтэй өрх хамрагдана. Үүнд: а. Нэг ам бүл бусад хамаатан садантайгаа хамт өрх үүсгэн амьдарч байгаа өрх б. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл хамтран өрх үүсгэн амьдарч байгаа в. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл, аль нэгэнтэй нь хамааралтай хүнтэй хамт өрх үүсгэн амьдарч байгаа г. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай боловч ам бүлийн биш хүмүүс өрх үүсгэн амьдарч байгаа зэрэг өрх орно.

№	Ойлголт	Тодорхойлолт
12	Холимог өрх	Холимог өрхөд дараах бүтэцтэй өрх хамаарна. Үүнд: а. Нэг ам бүл бусад хамаатан садан хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байгаа өрх б. Нэг ам бүл, хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байгаа өрх в. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл, аль нэгнийх нь хамаатан садан, хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байгаа г. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл эдгээр ам бүлийн алинд ч хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байгаа д. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралгүй ам бүл бусад хүмүүстэй амьдарч байгаа е. Хоорондоо хамааралтай боловч ам бүлийн биш хоёр, түүнээс олон хүмүүс бусад хамааралгүй хүмүүстэй өрх үүсгэн амьдарч байгаа ё. Хоорондоо хамааралгүй хүмүүс өрх үүсгэн амьдарч байгаа өрх орно.
13	Оршин суугаа хүн ам	Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга (183 хоног буюу 6 сараас дээш хугацаагаар) оршин суугаа Монгол Улсын харьяат иргэд, гадаадын харьяат болон харьяалалгүй иргэдийг хэлнэ.
14	Бэлэн хүн ам	Тооллого явуулж буй үед тухайн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа нийт хүн амыг (байнга болон түр хугацаагаар амьдарч байгаагаас үл хамаарч) хэлнэ.
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ, ТҮҮНИЙ ТӨРӨЛ		
15	Хөгжлийн бэрхшээлтэй хүн	Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг ойлгоно.
16	Төрөлхийн	Удамшлын эмгэг, согог, жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалан бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан.
17	Олдмол	Ахуйн болон үйлдвэрлэлийн осол, гэмтэл, ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан.
18	Харааны	Харааны эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “харах” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
19	Ярианы	Хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин, эмгэгийн улмаас хүний “ярих” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
20	Сонсголын	Сонсголын болон хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “сонсох” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
21	Хөдөлгөөний	Биеийн тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
22	Сэтгэцийн	Сэтгэцийн эмгэг нь бодох сэтгэх, мэдрэх ухамсарлахуйн болон зан төлөвийн өөрчлөлтөөр илрэх бөгөөд үүнийхээ улмаас хүний нийгэмд биеэ авч явах байдал нь өөрчлөгдсөн, гадаад (төрөх үеийн хүндрэлүүдийн үлдэцийн улмаас 0-3 насанд тэнэгрэх) болон дотоод (хромосомын өөрчлөлт, бодисын солилцоо дутмагшил гэх мэт) шалтгааны улмаас ойлгох, сэтгэх, мэдрэх үйл ажиллагаа нь хязгаарлагдсан.
23	Хавсарсан	Хүнд нэгээс дээш төрлийн хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, согог тохиолдвол хавсарсан хөгжлийн бэрхшээлд тооцно.
24	Бусад	Дээрхээс бусад ямар нэгэн эмгэг болон өвчний улмаас өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх чадвараа алдсан буюу хязгаарлагдсан.
ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛ, ТҮҮНИЙ ХЭЛБЭР		
25	Хүндрэлгүй	Аливаа үйлдэл хийхдээ ямар ч асуудалгүй, мэдрэхүйн эрхтнүүдэд ямар ч хүндрэл тулгардаггүй;
26	Бага зэрэг хүндрэлтэй	Аливаа үйлдэл хийхдээ бусдын дэмжлэг эсвэл туслах хэрэгсэл хэрэглэж өдөр тутмын үйл ажиллагаанд оролцдог;
27	Их хүндрэлтэй	Аливаа үйлдлийг хийх процессын 60-90 хувьд нь туслах хэрэгслийн болон бусдын тусламжийг авдаг. (алхаж явахдаа байнга хэн нэгнийг түшиж, тулж явдаг, аливаа зүйлийг ойлгохдоо бусдаар нэмэлт тайлбар хийлгэдэг, ахуйн энгийн үйлдлүүдийг бусдын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлдэг)
28	Огт чаддаггүй	Аливаа үйлдлийг хийхэд эрүүл мэндийн асуудал нь тухайн хүний үйлдлийн чадварт 100% сөргөөр нөлөөлж ямар ч үйлдлийг өөрөө бие даан хийх боломжгүй.

№	Ойлголт	Тодорхойлолт
29	Харааны хүндрэл	Харааны бэрхшээлтэй буюу харааны шил эсвэл контакт линз зүүсэн эсвэл зүүдэггүй хүмүүсийн хувьд харахад хүндрэлтэй хүмүүсийг илрүүлэх зорилготой юм. Тухайн хүн харааны шил зүүдэг тохиолдолд Та харааны шил зүүсэнч юм харахад хүндрэлтэй байдаг уу? гэж асуух байдлаар оруулсан.
30	Сонсголын хүндрэл	Сонсголын бэрхшээлтэй, сонсголын аппарат зүүсэн эсвэл зүүдэггүй хүмүүсийн хувьд сонсоход хүндрэлтэй хүмүүсийг илрүүлэх зорилготой. Сонсголын хүндрэлд чимээ ихтэй орчин эсвэл нам гүм орчинд янз бүрийн дуу чимээг ялгаж сонсоход нэг эсвэл 2 чихээрээ сонсоход хүндрэл тулгарч байгааг ойлгоно. Тухайн хүн сонсголын аппарат зүүдэг бол Та сонсголын аппарат зүүсэн ч юм сонсоход хүндрэлтэй байдаг уу? гэж асуух байдлаар оруулсан.
31	Алхах болон шатаар өгсөх/ дээшээ авирах хүндрэл	Алхахдаа ямар нэгэн хүндрэлтэй хүмүүсийг илрүүлэх зорилготой. Ямар нэгэн дэмжлэг болох төхөөрөмж (тэргэнцэр, таяг, алхуулагч гэх мэт) эсвэл хэн нэгний туслалцаагүйгээр алхаж чадаж байвал алхаж чаддаг гэж үзнэ. Алхахад хүндрэлтэй гэдэгт алхсанаас эсвэл шатаар дээш, доош алхсанаас шалтгаалж бие сулрах, тэнцвэр алдах, эсвэл бусад тулгуур эрхтэн тогтолцооны бус хүндрэл тохиолдож байгааг оруулна.
32	Аливаа зүйлийг санах, анхаарлаа төвлөрүүлэх хүндрэл	Эргэн санах гэж нь өнгөрсөн үйл явдлыг эргэж санахыг ойлгоно. Зам харгуй олох, аливаа асуудалд анхаарлаа хандуулж чадахгүй байх, хаана байгаагаа эсвэл он сараа мартаж зэргийг бэрхшээлтэй гэж үзнэ. Мөн хэн нэгний хэлсэн ярьсныг санахгүй байх, будилах, ихэнх зүйлсээс айх зэргийг хүндрэлтэйд тооцно. Ажлын ачаалал, стресс бухимдал, эмийн нөлөөний улмаас үүссэн санах, анхаарлаа төвлөрүүлэхтэй холбоотой хүндрэлийг хүндрэлтэй гэж үзээгүй.
33	Бие даан усанд орох, хувцсаа өмсөх зэргээр өөрийгөө арчлах хүндрэл	Энэ асуулт нь бие даан өөрийгөө халамжлах, анхаарахад хүндрэлтэй хүмүүсийг илрүүлэх зорилготой.
34	Бусадтай ярилцах хүндрэл	Энэ хэсэг нь ярих, сонсох, бусдыг ойлгох, бусдад өөрийгөө ойлгуулахад ямар нэг хүндрэлтэй байдаг хүмүүсийг илрүүлэх зорилготой. Мэдээлэл солилцохдоо дохио зангаа хэрэглэдэг (дохионы хэл орно), бичгээр эсвэл дуу авиа ашигладаг бол харилцааны бэрхшээлтэй гэж үзнэ. Өөрөөр хэлбэл, бусдад өөрийгөө ойлгуулахдаа эсвэл бусдын яриаг ойлгохдоо харилцааны өөр арга хэрэглэж байгаа тохиолдлыг ойлгоно.
СУУРЬШИЛ		
35	Байнга оршин суугаа	Тооллогын товын байдлаар тухайн засаг захиргааны нэгжид 6 сар (183 хоног)-аас дээш хугацаагаар оршин суугаа хүн
36	Түр эзгүй байгаа	Тооллогын товоос өмнө үндсэн засаг захиргааны нэгжээс гадагш 6 сар (183 хоног) хүрэхгүй хугацаагаар явсан хүн
37	Түр оршин суугаа	Өөр засаг захиргааны нэгжээс ирж, тооллогын товын өмнө тухайн засаг захиргааны нэгжид 6 сар (183 хоног)-аас доош хугацаагаар сууж байгаа хүн
БОЛОВСРОЛ		
38	Боловсролгүй	ЕБС-ийн 3 дугаар ангийг 1975-1996 онуудад, 4 дүгээр ангийг 1975 он хүртэл болон 1997-2004 онуудад, 5 дугаар ангийг 2005 оноос хойш төгсөөгүй бол Боловсролгүй хүн гэнэ. Мөн 2020 онд ЕБС-ийн 1-5 дугаар ангид сурч байгаа, сурч байгаад сургуулиа орхисон хүмүүсийг Боловсролгүй гэж үзнэ.
39	Бага боловсрол	ЕБС-ийн 3 дугаар ангийг 1975-1996 онуудад, 4 дүгээр ангийг 1975 он хүртэл болон 1997-2004 онуудад, 5 дугаар ангийг 2005 оноос хойш төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн хүн
40	Бүрэн бус дунд (суурь) боловсрол	ЕБС-ийн 7 дугаар ангийг 1975 он хүртэл, 8 дугаар ангийг 1975-2004 онуудад, 9 дүгээр ангийг 2005 оноос хойш өдөр, орой эчнээгээр төгссөн, суурь боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, суурь боловсролын гэрчилгээтэй хүн
41	Бүрэн дунд боловсрол	ЕБС-ийн 10 дугаар ангийг 2005 он хүртэл, 11 дүгээр ангийг 2006-2014 онуудад, 12 дугаар ангийг 2015 оноос хойш өдөр, орой эчнээгээр төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, бүрэн дунд боловсролын аттестат ба үнэмлэхтэй хүн

№	Ойлголт	Тодорхойлолт
42	Техникийн болон мэргэжлийн боловсрол	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль-ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүн
43	Тусгай мэргэжлийн дунд боловсрол	Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүн
44	Дээд боловсрол	Гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг Дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизм оройн дээд сургууль Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг дипломын дээд боловсролтой гэж үзнэ.
45	Бичиг үсэг мэддэг	Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) өдөр тутмын амьдралын тухай хамгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаг, энэ чадвар нь тодорхой хугацаа өнгөрсөн ч хэвээр хадгалагдаж үлдсэн хүнийг Бичиг үсэг мэддэг гэж үзнэ.
